

# Хүүхдийн Хэсэг 1

Би Бурханы Хүүхэд  
Нярайн анги ба  
3 настнууд

# Хүүхдийн Хэсэг 1

## Би Бурханы Хүүхэд

Гарын авлагыг 1 ой 6 сартайгаас 3 хүртэлх  
насны хүүхдүүдэд тохируулан заахад ашиглана.

© 1994, 2000 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Printed in the United States of America

English approval: 5/00

Translation approval: 5/00

*Primary 1: I Am a Child of God*-н орчуулга

Mongolian

# Агуулга

## **Багш нарт зориулсан тусламж** **хуудас**

Гарын авлагыг ашиглан заах нь	V
Гурван настнуудын анги	V
Хичээлээ бэлтгэх нь	VII
Хичээл заах нь	VII
Ангид тоглох хөгжим	VIII
Үзүүлэн	IX
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах тусгай удирдамж	IX
Гарын авлагыг нярайн ангид тохируулан ашиглах	XI
Нярайн анги	XI
Хүүхдүүдийг нярайн ангид ороход нь бэлтгэх	XIII
Эцэг эхийн шалгах жагсаалт	XIV
Бага насны хүүхдүүдийн зан төлөв	XV
Нярайн ангид тулгарч болзошгүй бэрхшээлүүд түүнээс гарах арга замууд	XVI
Нярайн ангийн үйл ажиллагаа ба тоглоом	XVII
Нярайн ангид тоглох хөгжим	XXI
Тохируулан өөрчилсөн загвар хичээлүүд	XXIV

## **Хичээлийн дугаар болон сэдэв** **Хуудас**

1 Би Бурханы хүүхэд	1
2 Тэнгэрлэг Эцэг бие махбодтой	5
3 Бидэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө	8
4 Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна	12
5 Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү	16
6 Тэнгэрлэг Эцэг, Есүс надад хайртай	19
7 Ариун Сүнс надад тусалдаг	24
8 Өдөр болон шөнийг өгсөнд би талархдаг	28
9 Ус байгаад би талархдаг	32
10 Би модод, ургамал ногоо, цэцэгс байдагт талархдаг	35
11 Би загас байдагт талархдаг	39
12 Би амьтад байдагт талархдаг	44
13 Би шувууд болон шавьж хорхой байгаад талархдаг	48

14	Адам Ева хоёр Тэнгэрлэг Эцэгийн дүр төрхөөр бүтээгдсэн	53
15	Хүндэтгэлийн өдөр бол бишрэн шүтэх өдөр	57
16	Надад бие махбод бий	62
17	Надад гар байгаад би талархдаг	67
18	Надад чих байдагт би талархдаг	73
19	Надад нүд байдагт би талархдаг	77
20	Би үнэрлэж, амталж чаддагтаа талархдаг	81
21	Надад мэдрэмжүүд бий	84
22	Би олон зүйлийг хийж чадна	90
23	Би гэр бүлийнхээ нэгэн гишүүн	94
24	Би ах эгчдээ хайртай	99
25	Би гэр бүлийнхэндээ бүгдэд нь хайртай	103
26	Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна	107
27	Бид гэр бүлээрээ залбирч чадна	113
28	Би дуулгавартай байж чадна	117
29	Би “Намайг уучлаарай” гэж хэлж чадна	121
30	Би бусдыг уучилж чадна	125
31	Надад орон гэр байгаад би талархдаг	129
32	Хоол хүнс, хувцас байгаад би талархдаг	133
33	Би хэнтэй ч найз байж чадна	137
34	Би бусдыг хайрлаж чадна	141
35	Би амьтдад эелдэг байж чадна	146
36	Би сайн үлгэр жишээ болж чадна	151
37	Би шударга байж чадна	155
38	Би хүндэтгэлтэй байж чадна	159
39	Хөгжим намайг жаргалтай болгодог	164
40	Ариун Ёслол надад Есүсийн тухай дурсахад тусалдаг	168
41	Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд судруудыг өгсөн	172
42	Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн	176
43	Бидэнд Амьд Бошиглогч бий	180
44	Бид бүгд сүмдээ тусалж чадна	183
45	Есүс Христийн амилуулалт (Улаан өндөгний баяр)	187
46	Есүс Христийн төрөлт (Христийн Мэндэлсний баяр)	191
	Хүүхдийн хэсэг 1-ийн үйл ажиллагааны болон хөдөлгөөнт дуунуудын индекс	195
	Хүүхдийн дууны номон дахь Нярайн ангийнханд зориулсан дуунууд	196

# Гарын авлагыг ашиглан заах нь

---

Энэхүү гарын авлага дахь хичээлүүд нь энэ оны 1 сарын 1-н гэхэд 3 нас хүрсэн байх хүүхдүүдэд зориулагдсан болно. Багш нар 1 ой 6 сараас 3 насны хүүхдүүдэд зориулан уг гарын авлагыг ашиглаж болно. Хэрэв гурваас доош насны хүүхэд Хүүхдийн ангид байгаа бол тэд нярайн ангид хамрагдан, гурван настнуудын ангиас тусдаа байх ёстой. Гэвч жижиг тойрог болон салбарт энэ нь хамаарахгүй. Хэрэв танай тойргийн болон салбарын хүүхдийн ангид ижил насны 8 эсвэл 10 хүүхэд байвал ангийг хуваах шаардлагатай.

Нярайн ангийн багш нар XI-р хуудсанд буй “Гарын авлагыг нярайн ангид тохируулан ашиглах” гэсэн нэмэлт хэсгийг харна уу.

Удирдлага болон багш нар залбиралтайгаар өөрсдийн тойрог, салбар дахь хүүхдүүдийн хэрэгцээг харгалзан уг гарын авлага дахь хичээлүүд, үйл ажиллагааг хэрхэн яаж илүү сайн ашиглах вэ? гэдгээ мөн ангийг яаж зөв зохион байгуулах вэ? гэдгээ тодорхойлох хэрэгтэй.

---

## Гурван

### Настнуудын анги

Энэ оны 1 сарын 1-нээс 3 нас хүрсэн хүүхэд бүр энэ ангид хамрагдана.

### Зорилго

Гурван настай хүүхдүүдийн ангийн зорилго нь хүүхдүүдэд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн хайрыг ойлгуулан хөгжүүлэх, энэ ангидаа дур сонирхолтой байж, өөртөө итгэлтэй байх мэдрэмжийг олгох явдал юм.

### Залбирал

Анги тус бүрийн хичээлийг хүүхдээр залбирал хийлгэснээр эхэлж мөн дуусгаж байх хэрэгтэй. Ихэвчлэн нээлтийн залбирлыг хичээл эхлэхээс өмнө хийж, хаалтын залбирал ангийн үйл ажиллагаа дуусах үед хийгддэг. Энгийн, богино залбирал хэлэх аргад хүүхдүүдийг сурга. Шаардлагатай үед нь тэдэнд тусал.

### Цагийн хуваарь

Энэ анги нь нярайн ангиас үндсэн хүүхдийн хэсгийн ангид шилжих шилжилтийн онцгой үе юм. Жилийн эхний хагаст гурван насны ангийнхан өөрсдийн ангидаа хуваалцах цаг болон үйл ажиллагаануудыг түлхүү явуулах нь тохиромжтой. Харин үлдсэн хугацаанд буюу сүүлийн хагаст бусад хүүхдийн хэсгийн хүүхдүүдтэй хамтдаа хуваалцах цагт нь оролцож болно. Хүүхдүүдийг анзааран харж, тэд өөрчлөлт хийхэд бэлэн болсон эсэхийг тодорхойлж, Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн Зөвлөлтэй зөвлөлдөн

шилжилтийн хугацааг тодорхойлох хэрэгтэй. Жилийн турш гурван насныхан Хүүхдийн хэсгийн бусад хүүхдүүдтэй нээлтийн болон хаалтын ажиллагааг хамтдаа хийж болно.

Хүүхдийн Хэсгийн анги нь 1 цаг 40 минут үргэлжилдэг. Нээлтийн болон хаалтын үйл ажиллагаа нь хүүхдүүдийг ангидаа цугларах 5 минутыг оруулаад нийт 20 минут үргэлжилнэ. Харин гурван насныхан хуваалцах цагаа өөрсдийн ангидаа хийж байгаа бол ангийн үйл ажиллагаа нийт 75 минут үргэлжилнэ гэсэн үг. Доорх санал болгож буй цагийн хуваарь нь тухайн орон нутгийн шаардлагад нийцүүлэн өөрчлөгдөж болно. Үүнд:

Нээлт:	10–15 минут
Хичээлийн цаг:	25–30 минут
Хуваалцах цаг ба үйл ажиллагаа:	20–25 минут
Хаалт:	10–15 минут

Гурван насныхан Хүүхдийн Хэсгийн бусад хүүхдүүдтэй хуваалцах цаг хамт хийж байгаа үед хичээлийн цаг нээлтийн болон хаалтын үйл ажиллагааг оролцуулан нийт 40 минут байх ёстой.

*Нээлт:* Нээлтийн цагийн зорилго нь хүүхдүүдэд багш болон бие биетэйгээ чөлөөтэй харилцах боломжийг олгох явдал. Энэ хугацаанд хүүхэд чөлөөтэй байж чадвал Хүүхдийн Хэсэгт оролцох сонирхол нь өсч, илүү өөдрөг сэтгэгдэлтэй мөн итгэлтэй байх болно.

Хүүхэд бүрийг ангид байх хугацаандаа ая тухтай тааламжтай байхад нь тусал. Өөрийн үйл хөдөлгөөн болон үг хэлээр хайр, хүндэтгэл нөхөрсөг байдлаа үзүүл. Хүүхдүүдийн сонирхол хэрэгцээний талаар тэдэнтэй хэлэлцэн ярилц. Дараах зүйлүүдийг тэдэнтэй ярилцаж болно. Жишээлбэл:

- Гэр бүлээрээ хийсэн зугаалга эсвэл тэдний гэр бүлд бүл нэмсэн гэх зэрэг саяхан тэдний гэр бүлд болсон үйл явдлууд,
- Онцгой баярт өдрүүд
- Цаг агаар
- Байгалийн үзэгдлүүд
- Бусдыг сонсох, сэтгэгдлээ хуваалцах эсвэл биеэ авч явах байдал зэрэг бусадтай сайн харьцахад нь туслах чадваруудыг ашиглах.
- Сайн үйлс

Хүүхдүүдийг ядрааж чилээхгүйн тул хөдөлгөөнт дуу шүлэг, гар хөлний болон биеийн хөдөлгөөнт дасгал тоглоомуудыг энэ цагт ашиглаж болно.

*Хичээлийн цаг:* Өөрийн ангийн онцлогийг харгалзан хичээл бүрийн үндсэн зарчмын дагуу заа. Хүүхдүүдийн сонирхол, ойлгох чадвар дээр анхаар. Хичээлийн чухал зарчмыг заахад туслах түүхүүд болон үйл ажиллагааг сонго. “Баяжуулах үйл ажиллагаанууд” хэсгээс танай ангийн хүүхдүүдэд илүү тохиромжтой гэж үзэж буй үйл ажиллагааг сонго. Хичээлийн турш хүссэн үедээ эдгээр үйл ажиллагаануудыг хэрэглэж болно. Хүүхдүүд дахин давтан хийх үед илүү сайн суралцдаг тул үйл ажиллагаа, дуу, түүх буюу судруудыг нэгээс илүү дахин давтан тухайн хичээлийн турш болон дараагийн хичээлүүд дээрээ хэрэглэ.

45 ба 46 (Улаан өндөгний баяр ба Христийн Мэндэлсний баяр) дугаар хичээлүүдээс бусад хичээлүүдийг дэс дарааллынх нь дагуу заа.

*Хуваалцах цаг ба үйл ажиллагааны цаг:* Хүүхдүүд ангидаа хуваалцах цаг хийж байгаа үед “Баяжуулах үйл ажиллагаа” бүлгийн хичээлүүдэд агуулагдах үйл ажиллагаануудыг ашигла. Та түрүүчийн хичээлүүд дээр хэрэглэсэн хүүхдүүдийн дуртай үйл ажиллагаануудаас дахин хэрэглэж болно. Хүүхдийн Хэсгийн дуунуудыг дуулах цаг гаргаарай (Ангид тоглох хөгжим VIII хуудас). Бусадтай санаа бодлоо хуваалцаж идэвхтэй оролцохыг зоригжуулан дэмж.

Гурван насны ангийнхан Хүүхдийн ангийн бусад хүүхдүүдтэй хамт хуваалцах цагийн үйл ажиллагаа хийж байгаа үед заримдаа хуваалцах цаг дээр танилцуулга хийхийг урь. Сайн мэдээг энгийн байдлаар ангийн бүх хүүхдүүдийг хамруулан заах төлөвлөгөө гарга. Та дараах санаануудыг ашиглаж болно. Үүнд:

- Хичээлтэй холбоотой түүх болон үйл явдлыг харуулсан жүжигчилсэн тоглолт хийхэд тусал.
- Хичээлтэй холбоотой түүхийг ярихад нь тусалж хүүхдүүдэд зурагнуудыг ашиглуул.
- Сайн мэдээний нэг зарчмын тухай хүүхэд бүрийг судраас болон өөрсдийнх нь санал бодлоос хуваалцуул.
- Тухайн өдөр зааж буй зарчмын тухай дууг хүүхдүүдээр дуулуул.

*Хаалтын ажиллагаа:* Хичээлийн гол санаануудыг нэгтгэн дүгнэж, эргэн ярь. Ялангуяа хичээлийн нэг юм уу хоёр богино судрын хэллэгээс эргэн сануулж, хүүхдүүдийг тэдгээрийн талаар гэртээ хуваалцах боломжтой болгохоор гол санаануудыг тодруул. Хаалтын залбирал хийлгэхээр нэг хүүхдийг урь.

---

### **Хичээлээ Бэлтгэх нь**

Бага насны хүүхдүүдэд заах амжилттай аргын нэг бол тэднийг хайрлаж хүүхэд бүрийг таньж мэдэх явдал юм. Тэдэнтэй харьцахдаа хүүхэд бүрийг нэрээр нь дуудаж ярь. Тэдний амьдралын талаар мэдэж, хувь хүн бүрд хандан харьц. Хичээлд идэвхтэй оролцуулах замыг хайж, хүүхэд бүрд хүрч заа. Ангийн бүх хүүхдүүдэд өөрийн хайр болон анхаарал тавьж буйгаа үзүүл.

Хоёр дахь арга нь бэлэн байх явдал юм. Нэг долоо хоногийн өмнөөс заах хичээлдээ урьдчилан бэлтгэж эхэл. Хичээлийг бүхэлд нь уншсаны дараагаар өөрийн ангийн хүүхдүүддээ зарчмыг заах хамгийн сайн аргыг тодорхойлохын тулд залбиралтайгаар судла. Хүүхдүүд бүгд идэвхтэй оролцож, тэдний сонирхлыг төрүүлэхээр үйл ажиллагаануудыг сонгон хичээлээ баяжуул. Хэд хэдэн үйл ажиллагааг төлөвлөн бэлтгэж, тухайн үед хүүхдүүдэд илүү тохиромжтойг нь сонгон ашиглаж уян хатан бай. Хичээлийн явцад гарын авлагаас уншихгүйгээр хичээлээ өөрийн болгож мэдсэн байх. Боломжийн хирээр хүүхдүүдтэй харцаараа харилц. Хичээл бүрд бэлтгэх үедээ ойр ойрхон залбирч, хичээлийг заахад болон бэлтгэх явцадаа ариун сүнсний өдөөлтийг эрэлхийл.

---

### **Хичээл Заах нь**

Хүүхдүүдэд сайн мэдээний зарчмуудыг зааж байхдаа үүнийг хайрлан бишрэх, бие биеэ хайрлан хүндэтгэхийг дэмжин урамшуул. Дараах зөвлөмжүүд нь хүүхдийн ангийнханд тааламжтай байх нөхцлүүдийг бүрдүүлэхэд тусалж чадна:



- Хүүхдүүдэд чөлөөтэй ярьж, идэвхтэй оролцох боломжийг олго.
- Хүүхдүүдийг ярьж байх үед анхааралтай сонсож, тохиромжтой, эерэг хариултуудыг өгөхийг хичээ.
- Урам зоригтой өөдрөг бай. Хэрэв багш өөрөө хүүхдийн ангид дуртай байвал хүүхдүүд мөн тийм байх болно.
- Зөөлөн, нөхөрсөгөөр ярь.
- Ялангуяа хүүхдүүд ядарч залхсан үед тэвчээртэй, нөхөрсөг байж, хайрла.
- Боломжоороо эерэг зан чанарыг талархан дэмжиж, сөрөг зан харьцааг үл тоомсорлохыг хичээ.
- Хэд хэдэн үйл ажиллагааг бэлтгэж, хүүхдүүдийн хэрэгцээнд нийцүүлэн хэрэглэхдээ уян хатан бай. Бага насны хүүхдүүдийн анхаарал төвлөрөх хугацаа богино байдаг бөгөөд тэд үргэлж хөдөлгөөнтэй байдаг.
- Хүүхдүүд маргалдаж эхлэх үед анхаарлыг нь өөр зүйл рүү хандуул.
- Бага насны хүүхдүүд түүх, зурагт хуудас, хөгжим ба хөдөлгөөнт тоглоомонд дуртай гэдгийг сана. Тэд өөрсдийн сайн мэддэг дуугаа дахин давтан дуулж, тоглоомоо тоглох дуртай байдаг. Ялангуяа тэдгээрийг сайн мэддэг хүүхдүүд нь давтах дуртай.

---

## **Ангид тоглох хөгжим**

Энэхүү гарын авлагын хичээл бүр нь сайн мэдээний тухайн зарчмыг заахад туслах дууг багтаасан байгаа. Дууг хөгжилтэй, утга учиртай болгохын тул та заавал мэргэжлийн хөгжимчин байх албагүй. Хүүхдүүд таны сайн дуулж байна уу үгүй юу гэдгийг анзаарахгүй харин таныг дуулах дуртай байгааг чинь л анзаарах болно. Дуу бүрийг сайн суралцаж хичээлийн бэлтгэл ажлын нэг хэсэг болох дуугаа дуулж давт.

Хүүхдүүдэд дуу заах хамгийн сайн арга нь тэдэнтэй хамтдаа давтан дуулах. Хичээлийн турш нэг дуугаа хэд хэдэн удаа давтан дуулж болно. Энгийн хөдөлгөөнүүдийг ашиглах нь бага насны хүүхдүүдийг дуунд идэвхтэй оролцоход нь тусална. Хэрэв хүүхдүүд уг дууг сайн сурсан ба дуулах дуртай байвал тухайн дууг хуваалцах цаг, үйл ажиллагаа болон хичээлийн үеэр давтан дуул.

Шинэ дуу болон үйл хөдлөлтэй шүлгийн үг заахдаа:

- Анги эхлэхээс өмнө уг үгсийг цээжил.
- Шинэ дууны үг, шүлгийг хүүхдүүдэд дуулж болон хэлж өг. Үйл хөдлөлтэй бол түүнийг нь илүү тодруулан хий.
- Хүүхдүүдийг хамт дуулах буюу үгсийг нь хэлэхийг хүс. Тэд үгсийг түргэн цээжилж чадахгүй ч хэрэв та олон дахин давтан дуулж өгвөл сурах болно.
- Үг үйлдлийг хүүхдүүд ойлгож болохуйц зөөлөн удаанаар хэлж үзүүл.
- Дууны болон үйлдлийн үгсийг ойлгуулахын тулд зурагт хуудсуудыг ашигла. Учир нь тэд харсан зүйлдээ илүү анхаарал тавьж сурч авдаг.

- Хүүхдүүд залхаж эхэлбэл зааж буй үгсээ богино болго. Хэрэв зааж буй дуу болон хөдөлгөөнт үгс нь урт бол өөрөө үгсийг хэлэх буюу дуулах зуураа хүүхдүүдээр үйлдэл хийлгэн, тэдэнд тусал.

Бага насны хүүхдүүд байнга тантай хамт дуулахыг хүсэхгүй байж болох ч тэд дуулж буйг тань сонсохдоо таатай байх болно.

---

## Үзүүлэн

Бага насны хүүхдүүдэд зурагт хуудас үзүүлэн заах нь чухал. Зураг, хайчилбар, биет зүйлс мөн бусад зурагт үзүүлэнгүүд нь хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлж, зааж байгаа зүйлийг тань илүү ойлгож санахад нь тусалдаг.

Тухайн хичээлд ашиглаж болох зураг болон хайчилбарууд нь гарын авлагад багтсан болно. Хичээл бүрийн “Бэлтгэл” гэсэн хэсэгт тухайн хичээлд ашиглагдах зургуудын гарчиг болон дугаарыг жагсаасан. Хаалтанд буй дугаарууд нь Ариун сургаалын уран зургийн цуглуулга (34730)-ын дугаар юм. Эдгээрийг цуглааны байруудын номын сангаас авч болно. “Бэлтгэл” хэсэгт гарын авлагад орсон хайчилбаруудыг багтаасан Primary Visual Aids Cutouts цомгийн (33239–33250 эсвэл 08456) хайчилбаруудын дугаарыг тэмдэглэсэн болно.

Эд зүйлс нь үр дүнтэй үзүүлэн болж чаддаг. Ялангуяа хүүхэд хүрч барьж болох тэдний сайн мэдэх зүйлс байвал тохиромжтой. Та судрын түүх хуваалцаж байх үедээ хувийн болон цуглааны байруудын номын сангаас авсан судруудаа үзүүлэн маягаар ашиглаж болно.

---

## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах тусгай удирдамж

Аврагч бидэнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх хайр энэрлийн үлгэр жишээг үзүүлсэн. Тэрээр амилуулалтынхаа дараа Нифайчууд дээр ирэх үедээ:

“Та нарын дунд өвчтөнүүд байна уу? Тэднийг нааш авчрагтун. Доголон, эсвээс хараагүй, эсвээс хазгар, эсвээс тахир дутуу, эсвээс уяман өвчтэй, эсвээс татанги, эсвээс дүлий, эсвээс ямар нэгэн байдалд зовж зүдэрсэн нэгэн байна уу? Тэднийг нааш авчрагтун мөн би тэднийг эдгээх болно, учир нь та нарыг өрөвдөх сэтгэл надад бий, зүрх сэтгэл минь нигүүлслээр дүүрэн” (3 Нифай 17:7) гэжээ.

Хүүхдийн хэсгийн багшийн хувьд танд өөрийн нинжин сэтгэлээ үзүүлэх сайхан боломж бий. Хэдийгээр та мэргэжлийн туслалцаа үзүүлэхээр бэлтгэгдсэн хүн биш ч, багшийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг суралцаж сүнслэгээр өсөн хөгжихөд нь тусалж чадна. Ангийн хүүхэд бүрийн ойлголт, хүсэл эрмэлзэл болон тэдэнтэй холбоотой бүхнийг мэдэх нь чухал. Товчоор хэлэхэд хүүхэд бүртэй тулж ажилла.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь тэдний ойлгоц ямар түвшинд байгаагаас үл хамааран Ариун Сүнсний нөлөөг мэдэрч чадна. Зарим хүүхдүүд Хүүхдийн хэсгийн хичээлд бүрэн оролцох боломжгүй байж болох ч тэдэнд ариун сүнсийг мэдрэх бага ч болов боломжийг олго. Хүүхдийн хэсгийн хичээлийн дундуур тухайн хүүхдэд бусад хүүхдүүдээс түр зуур хол байх шаардлага гарсан тохиолдолд түүний хүсэл хэрэгцээг ойлгож чадах хүн хажууд нь байх хэрэгтэй.

Ангид заримдаа суралцах чадваргүй, хараа сонсгол муу, оюун ухааны хомсдолтой, хэл ярианы доголдолтой, нийгмийн болон зан чанарын дутагдалтай, тархи мэдрэлийн согогтой, хөдөлгөөн хийх болон сууж босох чадваргүй мөн эрүүл мэндийн архаг хууч өвчтэй гэх мэт хүүхдүүд байдаг. Зарим нь соёл болон хэл мэдэхгүй тул түүнд юм бүхэн танил биш байж болно. Хувийн онцлогуудаас үл хамааран хүүхэд бүр сайн мэдээг суралцах, хайрлуулах, Ариун Сүнсийг мэдрэх, бүгд жигд оролцож, бусдад үйлчлэх хэрэгтэй.

Дараах зөвлөмжүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд заахад тусална:

- Хүүхдийн бэрхшээлийг үл тоон хүнийх нь хувьд таньж мэд. Нөхөрсөг, дотно энгийн бай.
- Хүүхдийн онцгой чанаруудыг олж мэд.
- Зааж байгаа зүйл нь ангийн хүүхэд бүр бие биеэ хүндэтгэх ёстой гэдгийг мэдрүүлэхээр хий. Ангийн хөгжлийн бэрхшээлтэй гишүүнийг хайрласнаар бусад хүүхдүүдийн хувьд Христтэй адил болон төлөвшиж, суралцах туршлага бий болгоход нь тусал.
- Эцэг эхчүүд, гэр бүлийн бусад гишүүдтэй нь зөвлөлдөн хүүхдэд хамгийн хэрэгтэй заах зохистой арга барилыг ол. Тохиромжтой гэж үзвэл хүүхэдтэй өөртэй нь ярилц.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг залбирал хэлэхийг урихаасаа өмнө тэр ангийн өмнө үүнийг хийхэд бэлэн байгаа эсэхийг тодорхойл. Хүүхэд бүрийн авьяас чадварыг тодруулж, тэр өөрөө ая тавтай байж амжилт олох арга замыг эрж хай.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хичээлдээ нэмэлт материалуудыг хэрэглэж, тохируулан заа.

# Гарын авлагыг нярайн ангид тохируулан ашиглах

## Нярайн анги

### Хамрагдах хүүхдүүд

Тухайн оны 1-р сарын 1-нээс 1 ой 6 сартайгаас 3 нас хүртэлх хүүхдүүд өөрсдийн эцэг эхийн шийдвэрлэсний дагуу асрамжийн ангид хамрагдана. Нярайн анги тус бүрд доод тал нь хоёр багш дуудагдсан байх хэрэгтэй. Хоёр багш нь эхнэр нөхөр биш л бол ижил хүйсний хүмүүс байх ёстой. Багш нар нь Хүүхдийн хэсгийн бүх хичээлүүдийн турш ангид байна.

### Зорилго

Нярайн ангийн зорилго нь балчир насны хүүхдүүд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн тухай ойлголт хийгээд Тэднийг хайрлах хайраа нэмэгдүүлж, Сүмийн орчинд эерэг таатай сэтгэгдэлтэй болж, өөрийн үнэ цэнийг мэдэрч сурахад оршино. Нярайн анги ба бага насны хүүхдүүд сайн мэдээг заалгаж, бусад хүүхдүүд болон насанд хүрсэн хүмүүстэй харилцах Сүм дэх анхны алхам болдог.

### Бодит орчин

Нярайн анги нь цэвэрхэн, аз жаргал баяр баясгалангаар дүүрэн, тэднийг хүлээн авахад орчин нь бэлэн, боломжтой бол ариун цэврийн өрөөнд ойр байх хэрэгтэй. Нярайн анги дотроо тоглох (боломжтой бол хивс эсвэл дэвсгэр тавьсан байх), унших болон үйл ажиллагаа явуулах, хичээл заах гэсэн хэсгүүдэд хуваагдаж болно. Тоглоомууд нь цэвэрхэн, аюулгүй бөгөөд эвдэрч гэмтээгүй байх. Авирах үсрэх төхөөрөмж байлгах хэрэггүй.

### Цагийн хуваарь

Нярайн анги 1 цаг 40 минут үргэлжилнэ. Энэ цаг хичээлийн зорилгыг тодотгох өөр өөр жижиг хэсэгт хуваагдаж болно.

Долоо долоо хоногоор хичээлээ адилхан төлөвлөхийг хичээ. Хүүхдүүд тогтмол явагддаг дэс дараалалд дассан байдаг тул нэг үйл ажиллагаанаас нөгөө үйл ажиллагаанд шилжих арга нь адил байвал тэдэнд илүү амар байх болно. Дараах хуваарийг өөрсдийн орон нутгийн онцлогт зохицуулан хийж болно:

Урих

Тоглох цаг:	35 минут
Цугларах цаг:	10 минут
Хөгжмийн цаг:	10 минут
Хооллох цаг:	10 минут
Хичээлийн цаг:	10 минут
Үйл ажиллагааны цаг:	15 минут
Хаалт:	10 минут

Нярайн ангийнханд хуваалцах цаг болон нээлт ба хаалтын ажиллагаанууд байдаггүй.

*Урих:* Хүүхдүүд нярайн ангид орж ирэхэд хүүхэд бүрийн нэрийг нь хэлж мэндэл. Тэнгэрлэг Эцэг болон таны хайрыг хүүхэд бүр мэдрэхэд тусал. Зөөлөн намуухан хөгжим хүндэтгэлтэй, урьсан орчныг бий болгодог.

*Тоглох цаг:* Хүүхдүүдийг тоглоом, зураг, ном болон эвлүүлдэг тоглоомоор чөлөөтэй тоглуул. Тэдэнд нэг зүйлээр тоглож байгаад нөгөө зүйлийг авах үед тоглож байсан зүйлээ буцаан байранд нь тавиад нөгөөг нь авах зарчмыг зааж сурга. Хэрэв хүүхэд хэн нэгэнтэй хуваалцах хүсэлгүй байвал түүнийг бүү хүчил. Хүүхдүүдэд туслахад үргэлж бэлэн бай. Гэхдээ тэдний тоглоомонд нь хэт их оролцох хэрэггүй. Тоглоомын цагийн дараагаар тэднийг тоглоомуудаа буцаан байранд нь тавихад нь тусал.

Энэ цаг дээр онцгой үйл ажиллагаа (“Нярайн ангийн үйл ажиллагаа ба тоглоом,” XVII–XXII) явуулж болох боловч, хүүхэд заавал оролцох албагүй.

*Цугларах цаг:* Дуу дуулах, залбирал хийхэд нь бэлтгэж хүүхдүүдийг цуглуул. Залбирал хэлэх хүүхдийг урь. Хүүхдэд богино энгийн залбирал хэлэхэд зааж, сурга. Хэрэгтэй үед нь тэдэнд тусал. Залбирлын дараа хүүхдүүдийг багш нар болон бусад хүүхдүүдтэй чөлөөтэй харилцан ярилцахыг хүс. Хайр, дотно байдал болон хүндэтгэлээ үг хэл, үйлдлээрээ үзүүл. Мэдрэмтгий, уян хатан бай. Хүүхдүүдийн сонирхол болон хэрэгцээний тухай тэдэнтэй ярилц. Жишээлбэл доорх зүйлс байж болно. Үүнд:

- Тэдний гэр бүлд болсон үйл явдлууд / Гэр бүлээрээ хийсэн зугаалга эсвэл тэдний гэр бүлд бүл нэмсэн гэх зэрэг саяхан болсон үйл явдал/
- Онцгой баярын өдрүүд
- Цаг агаар
- Байгалийн үзэгдэл
- Бусдыг сонсох, сэтгэгдлээ хуваалцах эсвэл биеэ авч явах байдал зэрэг харьцааны чадвар олоход нь туслах
- Сайн үйлс

Хүүхдүүдийг чилээж ядраахгүйн тул энэ цагт үйл ажиллагааны шүлэг, хөдөлгөөнт дасгал, дуу зэргийг ашиглаж болно.

*Хөгжмийн цаг:* Нярайн ангид хөгжмийг ашиглан, баяр баясгалантай, таатай орчныг бий болгож, сайн мэдээг зааж, хүүхдүүдийг өөр зүйл хийх боломжийг олгож болно (“Нярайн ангид тоглох хөгжим,” XXII–XXIV). Хүүхдүүд мэддэг дуугаа дуулах дуртай байдаг. Нярайн ангийн удирдлагууд болон багш нарт хүүхдийн дууны ном заавал байх хэрэгтэй. Дуу хөгжимд туслуулахаар бусад хүмүүсийг нярайн ангид урьж болно.

*Зуушны цаг:* Хүүхдүүдийн хэрэгцээг харгалзан энэ цагийн хуваарийг хий. Хүнсэнд зориулсан мөнгийг Хүүхдийн хэсгийн төсвөөс гаргана. Нярайн ангийнхан долоо хоног бүр зууш иддэг тул багш нар хүүхэд юу идэж болохгүй гэдгийг эцэг эхээс нь асууж тодруул. (Сүмийн заавруудын гарын авлага 2: *Санваартан болон туслах бүлгийн удирдлагууд* [1998], 239). Хүүхдүүдийг хооллохоос өмнө нэг хүүхэд урьж зуушаа адислахыг урь.

*Хичээлийн цаг:* Энэ гарын авлага дээрх хичээлүүд нь гурван насныханд зориулан хийгдсэн болно. Гэхдээ уг хичээлүүд дээр ашиглаж болох үйл ажиллагаа болон баяжуулах үйл ажиллагаанууд нь бага насны хүүхдүүдэд тохиромжтой байхаар хийгдсэн. Хичээл бүр нь “Бага насны хүүхдүүдэд

зориулсан нэмэлт үйл ажиллагаанууд” гэсэн хэсэгтэй. (нэмэлт үйл ажиллагаанд зориулсан материалууд нь хичээл бүрт өгөгдсөн “Бэлтгэл” хэсэгт байхгүй гэдгийг анхаар. Үйл ажиллагаанд бэлтгэхдээ тайлбарыг сайн уншиж өөрт хэрэгцээтэй зүйлсээ бэлтгэсэн эсэхээ шалга)

Нярайн ангийнханд уг гарын авлаганд орсон хичээлүүдийг хэрхэн тохируулан зааж болохыг XXIV–XXVI хуудсанд жишээ болгон үзүүлсэн. Хичээлийг тохируулахын тулд өөрчлөлт хийхдээ хүүхдүүдийн сонирхол болон ойлгох чадварыг бодолцон үзэж залбиралтай байгаарай. Үйл ажиллагаа нь богино бөгөөд товчхон байх нь чухал. Учир нь энэ насны хүүхдүүдийн анхаарал төвлөрөх хугацаа богино байдаг. Хүүхдүүд дахин дахин давтах үед илүү хүлээж авдаг тул хичээлийн явцад болон дараагийн хичээл дээрээ энэ үйл ажиллагаагаа давтан хэрэглэж болно. Бага насны хүүхдүүдэд заахад туслах нэмэлт тусламжийг VII–IX хуудсанд буй “Хичээлээ бэлтгэх нь” “Хичээл заах нь” “Ангид тоглох хөгжим” ба “Үзүүлэн” -ээс үз.

*Үйл ажиллагааны цаг:* зураг будах, баримлын шавраар тоглуулах, жүжигчилсэн тоглолт хийлгэх, тоглоом тоглох зэрэг бусад олон үйл ажиллагаануудыг хийж болно (“Нярайн ангийн үйл ажиллагаа ба тоглоом” XVII–XXII). Эдгээр нь сайн мэдээг ойлгоход, хуваалцахад мөн бүтээлч туршлагатай болоход нь дэм болох болно. Бага насны хүүхдүүд эргээд тоглох сонирхолтой байвал үүнд санаа бүү зов.

*Хаалт:* Хүүхдүүдэд тоглоомнуудаа болон бусад хэрэглэсэн материалуудаа буцаан байранд нь тавихад тусал. Дараа нь хичээл дээр заагдсан сайн мэдээний зарчмын талаар цөөхөн үгээр сануул. Хаалтын залбирал хэлэх хүүхдийг урь.

---

**Хүүхдүүдийг  
Нярайн ангид  
ороход нь бэлтгэх**

Тухайн хүүхэд нярайн ангид ирж эхлэхээс хэдэн долоо хоногийн өмнө Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх нь XIV хуудсанд буй шалгах жагсаалтын хуулбарыг эцэг эхэд нь өгч, нярайн ангийн багш болон эцэг эхийн уулзалтыг зохион байгуулах хэрэгтэй.

# ЭЦЭГ ЭХИЙН ШАЛГАХ ЖАГСААЛТ

Хүүхэд нярайн ангид анх ороод үнэхээр сонирхсон, айсан, инээсэн эсвэл уйлсан байж болно. Эцэг эхчүүд хүүхдээ урьдчилан бэлтгэснээр нярайн ангид тайван тааламжтай байлгаж чадна. Ер нь хүүхэд хаашаа ямар газар очих гэж байгаагаа мэдэж байгаа үед илүү дуртайгаар явдаг. Огт бэлтгэлгүй болон бага бэлтгэлтэй ирсэн хүүхдүүд ихэвчлэн айдастай мөн үлдэх дургүй байдаг. Дараах зүйлсээс аль болох олныг хийж хүүхдүүдээ нярайн ангид бэлтгэж болно. Үүнд:

- \_\_\_\_\_ 1. Доод тал нь хоёр долоо хоногийн өмнөөс хүүхдэдээ нярайн ангийн тухай зааж өг.
- \_\_\_\_\_ 2. Нярайн ангид оролцохоос нэг юм уу хоёр долоо хоногийн өмнө нярайн ангийн багш нартай нь уулзуул.
- \_\_\_\_\_ 3. Нярайн ангийн цөөн хэдэн хүүхдүүдтэй уулзуул.
- \_\_\_\_\_ 4. Нярайн ангид орохоос нэг долоо хоногийн өмнө уг ангийн талаар сайхан зүйлс ярьж өг.
- \_\_\_\_\_ 5. Ангид хэн ч байхгүй байхад хоосон нярайн ангийг үзүүл.
- \_\_\_\_\_ 6. Нэг өдрийн өмнө маргааш нярайн ангид орох болно гэдгийг сануул.
- \_\_\_\_\_ 7. Нярайн ангийн эхний өдөр сүм рүү явах үедээ түүнийг бүү яаруул.
- \_\_\_\_\_ 8. Хүүхдийнхээ тоглоомнуудыг гэртээ орхи.
- \_\_\_\_\_ 9. Нярайн ангид оруулахаас өмнө хүүхдээ хооллож, бие засуулсан бай. Хүүхдийн живхийг солих шаардлага гарвал түүнийг эх эцэг дээр нь хүргэж өгдөг.
- \_\_\_\_\_ 10. Нярайн ангид хүүхдээ буцаан авчир.
- \_\_\_\_\_ 11. Хүүхдэдээ дараа нь ирж авна гэдгээ хэл. Нярайн анги тарах үед хүүхдээ оройтолгүй ирж ав.
- \_\_\_\_\_ 12. Хэрэв таны хүүхэд айгаад байвал, эхний үед нярайн ангид хүүхэдтэйгээ хамт үлд.
- \_\_\_\_\_ 13. Ямар нэгэн асуудал гарахад хүүхдийг эх эцэгт нь авчрах боломжтой байхын тул эх эцэг ямар ангиудад хаана байхаа нярайн ангийн багшид мэдэгд.
- \_\_\_\_\_ 14. Хүүхэд ямар нэгэн хоол хүнсний харшилтай буюу өөр бусад асуудалтай эсэхийг багшид мэдэгд.
- \_\_\_\_\_ 15. Нярайн ангид ямар байсан тухай нь эерэгээр хүүхэдтэйгээ ярь. Хүүхдийнхээ ангийн болон багшийн тухай сайн зүйлсийг ярь.
- \_\_\_\_\_ 16. Хайр болон тэвчээр нь таны хүүхэд нярайн ангид тааламжтай байхад нь тусална гэдгийг сана.

Дараах шинж тэмдгүүд илэрч байвал хүүхдээ нярайн ангид авчрахгүй байна уу:

- Халуурах
- Нус гоожих
- Ханиалгах
- Үл мэдэгдэх маажууртай байх
- Бөөлжих
- Суулган гүйлгэж байвал
- Тууралт гарсан
- Нүд нь өвдсөн
- Бөөс, хуурс үүссэн
- Сүүлийн 48 цагийн дотор халдвар болон өвчний улмаас антибиотек хэрэглэж байгаа бол
- Халдвартай үе дээрээ яваа дараах хүүхдийн өвчний үед:
  - Салхинцэцэг (долоо хоног)
  - Улаан бурхан (тууралт алга болтол)
  - Улаан эсэргэнэ (тууралт алга болтол)
  - Гахайн хавдар (хавдар буутал, ихэвчлэн долоо хоног)
  - Арьсны тууралт

Хүүхдийн нус гоожиж, ханиалган, тууралт үүссэн байх шинж тэмдгүүд нь халдварт өвчний улмаас бус харин харшлын улмаас болсон бол энэ тухай багшид мэдэгдэх хэрэгтэй.

---

**Бага насны  
хүүхдийн  
зан төлөв**

Та дараах зүйлсийг суралцсанаар танай ангийн бага насны хүүхдүүд яагаад ийм зан гаргаж байгааг илүү ойлгох болно. Энэ мэдлэгийг хичээл бэлтгэх, заах болон тэдэнтэй харьцахдаа хэрэглээрэй. Эдгээр нь ерөнхий заавар гэдгийг санаарай. Ижил насны хүүхдүүд өөр өөр зан араншинтай байдаг бөгөөд ижил түвшний хөгжилтэй байдаггүй. Бага насны хүүхдийн зан араншингийн талаар *Багшлахаас илүү агуу дуудлага гэж үгүй* (110–111) номноос дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

**Бага насны хүүхдийн оюун ухааны онцлог**

- Юмыг яг байгаагаар нь энгийн хүлээн авдаг. Далд санаа бодлыг ойлгох чадваргүй.
- Анхаарал төвлөрөх хугацаа нь богино байдаг. (1-3 минут).
- Ярьж буй зүйлээс чинь шал өөр зүйлийн тухай асуулт тавьж болно.
- Их сониуч.
- Ихэвчлэн шинэ юм сурч мэдэж, оролдож үзэх сонирхолтой.
- Давтаж хийх дуртай.
- Энгийн сонголтууд хийдэг.

**Бага насны хүүхдийн биеийн онцлог**

- Ихэвчлэн их хөдөлгөөнтэй
- Үсэрч харайж, алхах, дэвхрэх үйлдлүүд хийдэг.
- Амархан ядарч цуцдаг.
- Тэдэнд юмыг задалж, салгаж тавих нь нийлүүлж, байранд нь буцаан тавихаас илүү дээр санагддаг.

**Бага насны хүүхдийн нийгмийн харьцаа**

- Итгэмтгий
- Ихэвчлэн ганцаараа тоглох дуртай
- Ихэвчлэн өөрийгөө саатуулдаг
- Бусадтай хуваалцах, ээлжээ хүлээх дургүй
- Ихэвчлэн тоглоомоо булаацалдаж муудалцдаг

**Бага насны хүүхдийн сэтгэл хөдлөлийн онцлог**

- Ерөнхийдөө хайрлуулах, хайрлах дуртай.
- Түргэн зантай
- Амархан уйлдаг
- Зан байдал нь түргэн өөрчлөгддөг



## **Бага насны хүүхдийн сүнслэг байдал**

- Залбирах дуртай ч тусламж хэрэгтэй
- Бишрэл шүтлэгийн талаар суралцаж эхэлж чадна
- Сүнс мэдрэх өндөр мэдрэмжтэй
- Бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хайртай гэдгийг ойлгодог.
- Сүнслэг байдлын үндсэн ойлголтуудыг ойлгодог.

---

### **Нярайн ангид тулгарч болзошгүй бэрхшээлүүд түүнээс гарах арга замууд**

Маш сайн нярайн ангид ч хүүхдүүд заримдаа дүрсгүйтэж сахилгагүйтдэг. Дараах нийтлэг асуудлууд гарах үед шийдэх арга замууд.

#### **Асуудал**

Хүүхдийн эцэг эх нь тэдний хүүхэд нярайн ангид явах хүсэлгүй байгааг хэлнэ. Эх эцгийгээ орхин явах үед тэд уйлж орилдог.

Хүүхэд танаас болон бусад хүүхдүүдээс айж эмээн, нярайн ангидаа эргэлзэж тээнэгэлзсэн маягтай явж, хэнтэй ч юу ч ярихгүй байна.

Нярайн ангийн явцад хүүхэд таны хөлөөс зуурч, өвөр дээр чинь суухыг оролдоно.

Хүүхдүүд хичээлийн дундуур болон үйл ажиллагаа дуусахаас өмнө босч явна.

#### **Гарах арга замууд**

Эцэг эхчүүд хүүхдээ нярайн ангид урьдчилан бэлтгэхийг урамшуул ("Хүүхдүүдийг нярайн ангид ороход бэлтгэх нь" XIII хуудас). Хүүхдээ тайвширтал хамтдаа үлдэхийг эцэг эхчүүдээс хүс. Хүүхэд илүү аюулгүй тайван байхад нь туслуулахаар насанд хүрсэн өөр хүнийг ангидаа урих нь тус болох боломжтой.

Тэвчээртэй бай. Хүүхдийг бүү хүчил. Түүнд орчин тойрноо, ангийн хүүхдүүдээ болон багшийгаа таних цаг хугацааг өг. Яваандаа хүүхдийг нэг юм уу хоёр үйл ажиллагаанд оролцохыг урь. Хүүхдэд ямар нэгэн байдлаар тааламжтай байх нөхцлийг бүрдүүл.

Бага насны хүүхдэд анхаарал, хайр халамж хэрэгтэй. Хэсэг зуур түүнийг тэврэх, түүнтэй ярьж харьцах зэрэг нь яваандаа түүний сэтгэлд нийцдэг. Дараа нь хүүхдийг нярайн ангийн үйл ажиллагаануудад оролцохыг урамшуулан дэмж.

Хүүхэд бүрийн анхаарал төвлөрөлт, хүсэл тэмүүлэл, хэрэгцээг сайн мэдэрч, мэдэрэмтгий бай. Гэгэлзсэн, уйдсан зэрэг шинж тэмдгүүд илэрвэл хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаагаа өөрчилж болно. Үйл ажиллагаанд оролцуулах гэж хүүхдийг бүү хүчил. Хэрэв зарим хүүхэд зөвхөн тоглоомуудаар тоглох хүсэлтэй байвал түүнийг нь хийлгэ.

Хүүхэд чимээгүй сууж, сонсож чадахгүй. Тэр хажуугийн хүүхдээ түлхэж татан чангаана.

Зарим хүүхдүүд тоглоомоо булаацалдан маргалдана. Тоглоомыг авахын тулд нэг нь цохиж, хазаж өшиглөнө.

Хүүхдүүд тоглоомоо эргэн тойрондоо хөөргөн чулуудах, эвдэх эсвэл хамаагүй шидэх зэргээр эелдэг бус тоглох. Анги дотроо ийш тийшээ гүйнэ.

Тавиур дээрээс тоглоомнуудыг ээлж дараалан авч хаялах. Тоглоомуудаа буцаан байранд нь тавихгүй байх.

Хүүхэд гонгинон уйлагнана. Тэднийг тайвшруулахаар таныг оролдох үед тэрээр “Би танд дургүй” гэж бухимдана.

“Ээж хэзээ ирэх вэ? Хэзээ гэртээ харих юм бэ?” гэж байн байн асуух.

Нэг багш нь үйл ажиллагааг удирдаж, нөгөө багш нь үйл ажиллагаанд хүүхдүүдийг идэвхтэй оролцуулахад тусалж болно.

Заримдаа хүүхдүүд хоорондын маргаанаа өөр өөрсдөө шийдэх боловч, бие биенээ өвтгөж, эд зүйлсийг эвдлэхээс нь өмнө шаардлагатай үед та оролцох хэрэгтэй.

Ийм зан аашийг та болиулах хэрэгтэй. Яагаад ийм зан гаргаж болохгүй вэ гэдгийг тэдэнд тайлбарла. Дараа нь тэднийг өөр үйл ажиллагаанд урь.

Тэднээс хүсч байгаа зан араншинг зөөлөн боловч баттайгаар дахин хэлж өг. Хүүхдүүдэд тоглоомоо яаж буцааж хураахыг үзүүл. Өөр тоглоом авахын өмнө түрүүчийн тоглож байсныгаа хураах хэрэгтэй гэдгийг сурга.

Бага насны хүүхэд ихэвчлэн юманд амархан сатаардаг. Онцгой нэг тоглоом үзүүлж үүгээр тоглох гоё гэж үзүүл. Хэрэв энэ арга тус болохгүй бол түүх ярь, ном уншиж өг. Заримдаа хүүхдийн нулимсыг арчиж өгөхөд уйлахаа больдог. Уйлахаа зогсохгүй бол түүнийг эх эцэгт нь аваачиж өг.

Эх эцэг нь тэдэн дээр ирнэ гэж тэднийг тайвшруул. Гэртээ харих цаг болохоос өмнө хийх ёстой зүйлийнх нь тухай ярилц.

---

## **Нярайн ангийн үйл ажиллагаа ба тоглоом**

Энэ хэсэгт байгаа үйл ажиллагаануудыг нярайн ангийн тоглоомын цаг болон үйл ажиллагааны цагийн алин дээр нь ашиглахаа та өөрөө шийд. Та энэ хэсэгт буй үйл ажиллагааг хичээлийн цаг дээрээ уялдуулан ашиглаж болох бөгөөд мөн хичээлд буй үйл ажиллагааг тоглоомын цаг дээр ашиглаж болно. Тоглоомын цаг дээр үйл ажиллагааг ашиглаж болох ч хүүхэд бүрийг оролцохыг бүү шаард. Зарим хүүхдүүд тоглоомоор тоглохоо илүүд үзэж болно.

### **Урлагийн үйл ажиллагаа**

Урлагийн үйл ажиллагаанууд нь хүүхдүүдэд өөртөө итгэх итгэл, бүтээлч байдлыг хөгжүүлж, нүд гараа зэрэг хөдөлгөх чадваруудыг олгоход нь туслахаас гадна тэдэнд ч энэ нь их таалагддаг. Мөн урлаг нь хувь хүний зан чанараа илэрхийлэх сайхан боломжийг өгдөг. Өөрийн санаачилга төсөөллөө ашиглан зохистой урлагийн төрлүүдийг зохион байгуул.

Доорх зөвлөмжүүд нь танд бүтээлч урлагийн хөтөлбөрүүдийг төлөвлөхөд туслах болно:

- Энгийн байх.
- Бэлтгэлтэй бай. Хэрэгцээтэй бүх материалаа бэлтгэж, яаж хийхийг өөрөө мэддэг бай.
- Уян хатан бай. Хэрэв та хөрвөх чадвартай уян хатан байж чадвал төлөвлөснөөр болохгүй байгаа үед сэтгэлээр унах шаардлагагүй. Хүүхдүүд таны өгсөн материалуудыг туршиж үзэхийг илүү сонирхдогоос биш хийж дуусгахдаа нэг их анхаарахгүй гэдгийг сана.
- Хүүхдийн хийж байгаа зүйлийг илүү сонирхож, тааламжтай байж тэднийг урамшуул.
- Олон янзын зүйлс хэрэглэ. Долоо хоног бүр өөр өөр янзын материал болоод арга барил ашиглаж болох хөтөлбөрүүдийг төлөвлө.
- Эв дүйтэй бай. Бага насны хүүхдүүд хийсэн зүйлээрээ ямар нэг зүйлийг илэрхийлэхийг оролддоггүй. Өөрт нь байгаа материалаар юм хийж туршиж үзэх нь тэдэнд таалагддаг. Хэрэв та хүүхдийн хийсэн зүйлийн талаар саналаа хэлэхийг хүсвэл “Энэ юу вэ?” гэж асуухын оронд “Зургийнхаа талаар надад яриач” гэж хэлбэл дээр.
- Өөрсдийг нь чөлөөтэй байлга. Хэрэгтэй үед нь тусал. Гэхдээ хүүхдүүдийг өөрсдийнх нь дураар юмыг нь хийлгэ.

#### *Хөгжим сонсонгоо юм будах*

---

Шаардлагатай материал: Дуу хөгжмийн бичлэгтэй диск эсвэл хөгжмийн зэмсэг, цаас мөн өнгийн харандаа.

Хүүхдүүд будаж байх үед хөгжим явуул. Тэднийг хөгжим сонсоод мэдэрч байгаагаараа будахыг урь.

#### *Наамал*

---

Наамал гэдэг нь цаас, гэрэл зураг болон бусад материалыг цавуудан нааж хийсэн зураг юм.

Шаардлагатай материалууд: Бараг бүх материалаар наамал хийж болно. Бэлэг боодог цаас, салфетка, ханын цаасны тасархай, навч, элс мөн төрөл бүрийн гоймон гэх мэт. Танд цавуу, цаас буюу өөр хавтгай гадаргуутай материал (наамал хийх сууриа болгох) хэрэгтэй. Хүүхэд бүрт эдгээрийг бэлтгэ.

Наамлынхаа суурь хийх материалыг хүүхдүүдэд өөрсдөө сонгох боломжийг олго. Өөрсдийнх нь хүссэн загвараар наамлыг хийлгэ.

#### *Гоймон хэлхэх*

---

Шаардлагатай материал: Том нүхтэй түүхий гоймон (соруулны хэсгүүд буюу утсанд сүвлэхэд хялбар материалууд) болон хүүхэд бүрт цавуу, лааны тос, урт утас зэргийг бэлтгэнэ.

Утасныхаа нэг үзүүрийг нь цавуу юмуу лааны тосондоо дүрж хатуу болгоно. Хатсаны дараа утас маань сүвлэхэд бэлэн болно. Гоймонг гулсаж тараахгүйн тулд нөгөө үзүүрийг нь зангид. Хүүхдүүдээр гоймонг утсанд сүвлүүлээд дууссаны дараа нь хоёр үзүүрийг холбон зангид.

Шаардлагатай зүйлс:

2 аяга гурил

1 аяга давс

1 хоолны халбага ургамлын тос

3/4 аяга ус

Хүнсний будаг (дурын)

Гурил, давсаа хольж хутга. Тосоо нэмээд дараа нь шингэртэл хангалттай ус хийж хутга. Бага багаар ус нэмж наалдамтгай биш зуурмаг болго. Сайн хутгаж зуураад бага зэрэг нухах хэрэгтэй. (Зуурмагаа өнгөнд оруулахыг хүсвэл гурил давсан дээрээ усаа нэмэхээсээ өмнө будгаа усандаа хий.)

Урьдчилан гурилан зуурмагаа гэртээ бэлтгэ. Боломжтой бол агаар нэвтэрдэггүй тагтай саванд хадгал. Гурилан зуурмагийг хүүхдүүд хэрэглэхэд зориулж цаас (лаав нэвчүүлсэн цаас илүү тохиромжтой) авчирч ширээн дээгүүр тавь.

### **Тоглоом ба үйл хөдлөлт шүлэг**

Хүүхдүүд хөдөлгөөнт дуу шүлэг, үйл ажиллагаа энгийн тоглоомууд гэх мэт үргэлж хөдөлгөөнтэй байх дуртай. Хичээл тус бүрт олон янзын шүлэгтэй үйл ажиллагаанууд багтсан бөгөөд зарим нэг энгийн тоглоомуудыг дор тайлбарласан болно. Хэрэв хүүхдэд үйл ажиллагаа таалагдаж байвал зөвхөн тухайн хичээлд ашиглаад зогсохгүй тухайн жилийн турш олон удаа хэрэглэж болно.

Эдгээр зөвлөмжүүд нь хүүхдүүдэд шинэ үйл ажиллагааны үгсийг заахад тусална:

- Ангид ирэхээс өмнө өөрөө бүх үгээ цээжил.
- Эхлээд өөрөө хүүхдүүдэд үг, үйл хөдөлгөөнийг хийж үзүүл. Дараа нь хүүхдүүдийг хамтдаа хийхийг урь.
- Үг, үйлдлээ удаан тэдэнд ойлгогдохоор хий.
- Шинэ үгстэй холбоотой зурагт хуудаснуудыг хүүхдүүдэд үзүүл. Хүүхдүүд харж буй зүйлээ илүү тогтоож, ойлгодог.
- Хүүхдүүдийн анхаарал сарнихаар удаан болбол үгийг богино болго. Үйл ажиллагааны үг урт байвал хүүхдүүдээр үйлдлийг нь хийлгээд өөрөө ганцаараа үгийг давтан хэлж өг.

### *Хүндэтгэл бишрэлийн шүлэг*

---

Дараах шүлгийг хүүхдүүд ядарч чилсэн үед, томоотой байхад нь туслахын тулд хэрэглэ.

Нээ, Хаа [Гар]

Гараа нээ, гараа хаа;

Гараа нээ, гараа хаа;

Одоо алгаа ташаарай.

Гараа нээ, гараа хаа;

Гараа нээ, гараа хаа;

Алгаа нийлүүлээрэй.

Би гараа сэгсэрч байна  
Би гараа сэгсэрч байна  
Би хоёр гараа эргүүлж байна  
Би алгаа ташиж байна  
Би гараа өргөж байна,  
Одоо доош нь болгож байна  
Алгаа нийлүүлээрэй

Би номхон зогсож байна  
Би хөлөө амрааж байна  
Би суудал дээрээ тэгш сууж байна  
Би толгойгоо бөхийлгөж байна  
Би нүдээ аньж байна  
Би одоо залбирал хэлэхэд бэлэн боллоо.

### *Заримдаа би өндөр, заримдаа би намхан*

---

Хүүхдүүд удаан суугаад чилсэн, хөдөлгөөн хэрэгтэй үед үүнийг хий.  
Хүссэнээрээ давтаж болно.

Заримдаа би өндөр—бүр өндөр, маш өндөр, (босоод, дараа нь өлмий дээрээ зогс).

Заримдаа би намхан—бүр намхан, маш намхан (доош суу, бүр доош бол).

Заримдаа би өндөр, заримдаа би намхан (бос, дараа нь доош суу).

Одоо би ямар байна? (бос эсвэл доош суу; хүүхдүүд хүссэнээ хийг).

### *Жижиг үр*

---

Хүүхдүүдэд үрийг газарт хэрхэн суулгадаг тухай хэлж өг. Дараа нь тэднийг ургаж буй үр мэт болохыг хүс. “Одоо бид бүгдээрээ жижиг үр шиг болцгооё” гэж хэл (доошоо тонгойн бөмбөг шиг болж нүдээ ань). “Нар мандаж, үрийг дулаацуулав. Дараа нь бороо орж, ‘Жижиг үрнүүд минь сэрээрэй’ хэмээн хэллээ (нүдээ нээж, суниаж эхэл). “Газрын хөрснөөсөө гарч, жижиг үрнүүд минь урга” (босч суниагаад, гараа толгой дээрээ өргө). “Жижиг үр минь чи үзэсгэлэнтэй цэцэг болон ургалаа [эсвэл өндөр мод].”

### *Эмээ өвөөгийнхөө гэрт очигцооё*

---

“Эмээ өвөөгийнхөө гэрт очиж байна гэж төсөөлцгөөе. Эхлээд бид гадуур хувцсаа өмсөе [эсвэл хувцсаа өмсөцгөөе]” (гадуур хувцсаа өмсөж байгаа мэт эсвэл хувцсаа өмсөж байгаа мэт жүжиглэ). “Машиндаа сууцгаая [эсвэл автобусанд]” (машины хаалга онгойлгон орж, жолоодож яваагаар жүжиглэ). “Ой, энэ зам их донсолгоотой юмаа” (донсолгоон дээгүүр гарч байгаа мэт хөдөлгөөн хий). “Хар даа тэр цагдаа явж байна. Түүн рүү гараа даллая” (гараа даллаж байгаа хөдөлгөөн хий). “Бид бараг ирчихлээ. Эмээ [эсвэл өвөө] ирж байна одоо. Түүнийг чангаар тэвэрье” (эмээ эсвэл өвөөгөө тэвэрч байгаа мэт жүжиглэ).

### *Ээж аавдаа тусалъя*

---

Хүүхдүүдийг эх эцэгтээ тусалж байгаа үйлдлүүдийг хийлгэ. “За одоо шалаа шүүрдье” гэж хэл. Хүүхдүүд шал шүүрдэж байгаа мэт жүжиглэнэ. Үргэлжлүүлэн ороо засъя, тоосоо арчъя, навчис хамъя, цэцэрлэгт газар

малтъя, машинаа угаая зэрэг өөрийн орон нутгийн онцлогт тохирсон бусад олон зүйлийг хийж болно.

### Бөмбөг өнхрүүлэх

---

Шаардлагатай зүйлс: Бөмбөг

Хүүхдүүд хагас дугуй болон сууна. Та тэдний өөдөөс хараад суу. Бөмбөгөө нэг хүүхэд рүү түүний нэрийг хэлж, хичээлтэй холбоотой ямар нэгэн асуулт асуун, өнхрүүл. Хүүхэд бөмбөгийг эргүүлэн таны нэрийг хэлж, хариултаа хэлэн өнхрүүлнэ. Бүгдийг хамруулсан хэсгээ шалга. Үүнийг зогсож байгаад мөн бөмбөгөөр харилцан шидэлцэж тоглож болно.

### Дүрс нийлүүлэх

---

Шаардлагатай зүйлс: Өнгийн цаас, хайч.

Өнгийн цаасаараа дараах дүрснүүдийг нэг том, нэг жижгийг хайчил. Үүнд: дөрвөлжин, дугуй, гурвалжин, зүрхэн, найман өнцөгт мөн зуйван. Бүх дүрснүүдээ шалан дээр дэлгэн тавь. Хүүхэд бүр жижиг дүрсийг барьж яг ижил том дүрсийг олж, дээр нь тавина. Өөр хувилбар болгон өнгөөр нь нийлүүлж болно.

### Хөгжимт дүрс

---

Шаардлагатай зүйлс: Даавуу эсвэл өөр өөр өнгийн цаасаар хийсэн дугуй дүрснүүд, хөгжим, скоч (дурын).

Том тойрог болгон дугуй дүрснүүдийг шалан дээр тогтоо (скочоор эсвэл өөр зүйлээр). Хөгжмөө тавиад хүүхдүүдийг том тойрог тойруулан алхахыг урь. Харин хөгжим зогсоход мөн тэд зогсож, өөр өөрсдийн хажууд нь зогссон дугуйн өнгийг хэлнэ. Өөр хувилбар нь өөр өөр дүрс тавьж ямар дүрс болохыг хэлүүлж бас болно.

### Вандуйтай уут шидэх

---

Шаардлагатай зүйлс: Вандуйтай уут (жижиг уутанд хуурай вандуй хийгээд амыг нь сайн боо), хайрцаг, сагс эсвэл бай (нүхнүүд гаргасан хатуу самбар, зураг).

Хүүхэд вандуйтай уутыг авч хайрцаг руу, сагс эсвэл бай руу шиднэ. (вандуйтай уут юм уу байг тухайн хичээл эсвэл баярт зориулж хийж болно) Хүүхдүүд мөн уг уутыг өрж тавьсан шоонууд руу шидэж болно.

### Хөшөө

---

Шаардлагатай зүйлс: Хөгжмийн бичлэгтэй диск эсвэл хөгжмийн зэмсэг.

Хөгжим тавьж хүүхдүүд анги дотор алхана. Хөгжим зогсоход тэд бүгд хөшөө болон хөдөлгөөнгүй зогсоно. Дахин хөгжим явахад хөдөлнө. Харин хөгжим зогссон үед хөшөө болох ёстой.

---

## **Нярайн ангид тоглох хөгжим**

Нярайн анги дахь хөгжим нь дулаан сайхан, хайр баяслаар дүүрэн уур амьсгалыг бүрдүүлж, Хүүхдийн хэсгийг аз жаргал баяр баясгалантай,

хүүхэд бүр тэмүүлэх газар болгодог. Нярайн ангийн насны хүүхдүүд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ, өөрсдийнхөө болон үзэсгэлэнт ертөнцийн тухай мэдэх маш их хүсэлтэй бөгөөд үүнд ч бэлэн болсон байдаг. Юмыг сурч мэддэг нэг гол арга зам нь дуу хөгжим юм. Дуу хөгжмийн олон төрөл нь хүүхдүүдэд таалагддаг. Тэд дуу дуулж, хөгжим тоглож, хөгжимд дуртай, түүнийг сонсох дуртай байдаг. Бага насны хүүхдэд хөгжим ашиглан заах тухай нэмэлт зааврыг VIII хуудсанд буй “Ангид тоглох хөгжим” гэсэн бүлгээс үзнэ үү.

### **Дуу дуулах**

Бага насны хүүхдүүд хамт дуулахыг хүсэхгүй байж магад, (бүр бага насныхан нь хамт дуулж чадахгүй байж болно) гэхдээ тэд таны дуулахыг сонсож, дуугаар дамжуулан чухал зарчмыг суралцаж чадна. Хүүхдүүдийг дуулахыг дэмж. Гэхдээ тэд дуулахгүй бол бүү санаа зов. Тантай хамт дуулж чадахгүй байгаа хүүхдүүд нь таныг дуулж байхад өөрсдийнхөө дуртай өөр хөдөлгөөнүүдийг хийж байдаг.

Долоо хоног бүр өөр өөр үйл ажиллагаа эхлэхдээ та нэг сурсан дуугаа давтан хэрэглэж болно. Хүүхэд танил хөгжмийн ая сонсох үед тэд үйл ажиллагаа эхлэх нь гэдгийг мэднэ. Тухайн дууны үгийг нөхцөл байдал, үйл ажиллагаандаа зохицуулан өөрчилж болно. Жилийн турш тэдний дуртай дууг хэдэн ч удаа давтан дуулж болно.

Дараах дуунууд нярайн ангийнханд хэрэглэхэд зохистой. Мөн дууны үгнүүдийг өөрчлөн тохируулах зөвлөмжүүд ч багтсан болно. Эдгээр дууны үгсийг нярайн ангийнханд тохиромжтой болгон өөрчлөх өөр санаанууд ч танд байж болно.

- “Аз жаргалтай гэр бүл” (Хичээлд 23-д байгаа үгсийг үз) (© 1975 Pioneer Music Press, Inc.). Үүнд аз жаргалтай нярайн анги эсвэл Хүүхдийн хэсэг гэж үг нэмж болно. Мэндлэхдээ “Би Сюзиг харж байна. Тэр намайг харж байна . . .” гэх мэт үгс ашиглаж болно.
- “Намайг дагаад хий” (Хичээл 36-д байгаа үгсийг үз). Дараах санааг ашигла: “Нярайн ангиа цэвэрлэе; Намайг дага, намайг дага! . . .” эсвэл “Дуулахаар хамтдаа цуглая. . .” гэх мэтээр заавар өгөхдөө ашигла.
- “Хийх дуртай” (Хичээл 9-д байгаа үгсийг үз)
- “Энд бид хамтдаа” (Хичээл 23-д байгаа үгсийг үз )
- “Хэрвээ сайхан амьдарч байвал” (266-р хуудас)
- “Инээмсэглэл” (Хичээл 21-д байгаа үгсийг үз )
- “Эрдэнэ шиш үсчинэ” (Хичээл 10-д байгаа үгсийг үз )

### **Хөгжмийн зэмсэг**

Энгийн хөгжмийн зэмсэгтэй болж хүүхдүүдээр тоглуул. Эсвэл үүнийг өөрсдөө хийж болно.

*Лимбэ ба бүрээ:* Картонон цаасан хоолой хийж түүн дээрээ хэд хэдэн нүх гарга (лав нэвчүүлсэн цаас эсвэл цаасан салфеткийг ороосон картонон гол). Нэг үзүүрийг нь скочоор бөглөвөл онцгой дуу чимээ гарах болно. Дуугаргахын тулд картонон хоолой руу чиглүүлэн дуу аялах юмуу дуул.

*Элстэй шоо:* 2,5 см зузаантай мод 2 ширхэг, 5см өргөнтэй, 10см урт, 2 жижиг хэсэг мод бэлтгэ. Мөн 2.5см-ийг харьцах нь 6см хэмжээтэй арай жижиг 2 мод огтол. Том шооны төвд нь жижиг шоог болгоомжтойгоор хад. Шоо бүрийн буланд зүлгүүр бэхэл. Тоглохын тул элсэн шоог хамтад нь тогш эсвэл зүлгүүртэй талуудыг хооронд нь үр.

*Шагшуурга:* Хатаасан эрдэнэ шиш буюу вандуйг хурц үзүүргүй төмөр лааз эсвэл хайрцганд хий. Хүүхдүүдээр лааз болон хайрцгаа чимэглүүл. Онгорхой хэсгүүдийг сайн бөглөж ямар нэгэн байдлаар хүүхдүүд доторх зүйлийг авч чадахааргүй сайн бөглө. Сэгсэрч дуугарган тогло.

*Хонх:* Хонхыг нарийн даавуунд бэхлэн оёно. Сэгсэрч тоглоно.

### **Хөдөлгөөнт хөгжим**

Хөдөлгөөнт хөгжим нь хүүхдүүдийг эрч хүчээ зөв хуваарилан, сэтгэх чадварыг нь сайжруулдаг. Дуу дуулж, төгөлдөр хуур болон бусад хөгжим тоглох мөн диск тавьж хүүхдүүдийг хөгжмийн аяар чөлөөт хөдөлгөөн хийлгэ.

Хүүхдүүдийг хөгжмийн аяар хөдлөхөд туслахын тулд:

- Хүүхдүүдийг удирдан гүйх, үсрэх, бөхийх, эргэлдэх, өлмийн дээрээ алхах, дэвхрэх болон цовхрох, хөгжмийн аяст суниах зэрэг үйлдэл хий. Мөн хүүхдүүдээр ээлжлэн ангийн хүүхдүүдийг удирдуулан хөдөлгөөн хийлгэхийг урь.
- Өөр өөр хэмнэлтэй хөгжмийн хэмнэлээр хүүхдүүдийг гүйх, алхах зэрэг хөдөлгөөн хийлгэ.
- Хөгжмийн аяар өнгө өнгийн алчуур юм уу цаасан дарцагаар даллах хөдөлгөөн хийлгэ.
- Хөдөлгөөнт дуунуудыг ашиглан өөр өөр зүйл хийлгэ. Хэрэв хүүхдүүд удаан хугацаагаар суусан бол бүх биеийн чилээг гаргах хөл, гар, бүх биеийн булчинг нь ажиллуулах хөдөлгөөнт дууны хөдөлгөөнийг хийх нь зохистой. Хэрэв хүүхдүүд ядарсан бол амрааж, хөгжмийн аянд гар, толгой, нүдээ хөдөлгөх үйлдэл бүхий дууг ашигла.

### **Сонсох**

Хүүхдүүд хөгжмийг зөвхөн сонсож байгаа бол хөгжимд анхаарлаа төвлөрүүлэхэд хүндрэлтэй байж магад. Тэгвэл хөгжим сонсохдоо даган дуулж, хөдөлгөөн хийж эсвэл үйл ажиллагаа хийх нь зүгээр. Жишээ нь дараах зүйлсийг хийж болно. Үүнд:

- Хүүхдүүдийг хэвтүүлж, өөр өөр янзын хөгжим сонсго. Хөгжим тэдэнд ямар мэдрэмж өгч буй талаар ярилц. Дараа нь тэд яаж мэдэрч байгаагаа үзүүлэхийг урь.
- Марш хөгжим тавьж, хүүхдүүдийг анги дотор тойрон алхуул.
- Сонсож буй хөгжмийн хэмнэлээр алгаа ташихыг урь.



---

**Тохируулан  
өөрчилсөн загвар  
хичээлүүд**

Дараагийн жишээнүүд нь энэхүү гарын авлага дахь хоёр хичээлийг нярайн ангид хэрхэн зохицуулан, хэрэглэж болохыг үзүүлсэн болно. Жишээ болгон үзүүлсэн хичээлүүдийг уншихдаа дараах зүйлсийг анхаар:

Хичээлийн жижиг хэсэг бүр сайн мэдээний энгийн зарчмыг багтаасан байдаг. Үйл ажиллагаа болон хөгжим нь хүүхдүүдэд сайн мэдээний эдгээр үндсэн зарчмуудыг улам сайн ойлгож мэдэхэд нь туслах ёстой.

Үндсэн хичээлийн зөвхөн зарим цөөхөн хэсгийг л сонгон авсан. Энэ нь нярайн ангийг энгийн, идэвхтэй мөн тэдний насанд тохирсон байхад тусална.

Сонгосон үйл ажиллагаанууд нь үндсэн хичээлд байгаа хэлбэрээрээ буюу заавал яг тэр дэс дарааллаар байх албагүй. Харин хичээлийн явцад нярайн ангийн хүүхдүүд сайн мэдээний зарчмыг илүү ойлгоход тус болохуйцаар, зохистойгоор дарааллыг өөрсдөө сонгон зохион байгуул.

**Хичээл 6: Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ надад хайртай.**

*Урих*

Нярайн ангид хүндэтгэлтэй уур амьсгалыг бий болгох нэг арга бол намуухан, Сүмд ашиглах боломжтой дуут хуурцагийг хэрэглэх явдал юм. Энэ хичээл дэх сайн мэдээний гол зарчмыг танилцуулахын тул “Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ надад хайртай” (баяжуулах үйл ажиллагаа 6, 21-р хуудас хар) гэж бичсэн энгэрийн тэмдгийг хүүхэд бүрт зүүлгэж болно.

*Тоглох цаг*

35 минут

Тоглоомын цагийн явцад хүүхдүүдийг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн тухай бодох боломжийг хай. Жишээ нь: Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ биднийг бие биедээ эелдэг, нөхөрсөг байхад дуртай бөгөөд тэд бидэнд маш их хайртай гэдгийг заах. Мөн тэдэнд өнгөрсөн долоо хоногт заасан хичээлийг сануулж “Тэнгэрлэг Эцэгийн Хүү хэн бэ?” гэж асуу.

*Цугларах цаг*

10 минут

Энэ цагийг хүүхдүүд хичээлд бэлтгэх цаг хугацаа болгож болно. Залбирлын дуу хамтдаа дуулж, нэг хүүхдээр нээлтийн залбирал хийлгэ. Дараа нь хүүхдүүдийг хичээлд бэлтгэх асуултууд асуу. Энэ үзэсгэлэнт дэлхийг хэн бидэнд өгсөн бэ? Сайн мэдээг хэн өгсөн бэ? Бидний сүмийг хэн өгсөн бэ? (анхаарал татах үйл ажиллагаа, 19-р хуудас хар) гэх мэт.

*Хөгжмийн цаг*

10 минут

Нярайн ангийнханд хөгжим нь сургаалыг суралцахад туслах гол зүйлийн нэг. Жишээ нь: Энэ хичээл дээр “Эцэг минь амьдыг би мэднэ” (баяжуулах үйл ажиллагаа 2, 19-р хуудсыг хар) дууг дуулж Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн талаар бодож болно. Цаг байвал түрүүчийн хичээл дээрээ дуулсан дуугаа дахин дуулах эсвэл 196 хуудсан дахь сонгогдсон дуунууд дээрээс дуу сонгон хамт дуул.

*Хоолны цаг*

10 минут

Энэ цагт үйл ажиллагаа хийгдэхгүй. Гэхдээ хүүхдүүдэд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бидэнд маш их хайртай. Бид Тэдэнд үргэлж талархалтай байх, одоо бидэнд өгсөн хоол хүнсний төлөө талархах хэрэгтэй гэдгийг сануулж болно. Дараа нь хүүхдүүдийг хоолоо хамтдаа адислахыг урь.

<i>Хичээлийн цаг</i>	10 минут Энэ хичээл нь нярайн ангийнханд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн хайрыг ойлгоход зориулсан хэд хэдэн хэсэгтэй. Жишээ нь, 6-р хичээлээс та дараах хэсгүүдийг ашиглаж болно. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ бидэнд адислалуудыг өгсөн (хуудас 19–23)</li> <li>• Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ хүн бүрт хайртай (хуудас 19)</li> <li>• Нэмэлт үйл ажиллагаанууд 2 (хуудас 21)</li> <li>• Баяжуулах үйл ажиллагаа 1 (хуудас 22)</li> </ul>
<i>Үйл ажиллагааны цаг</i>	15 минут Үйл ажиллагааны цаг нь хүүхдүүдийг өөрсдийн эрч хүчээ зөв гаргах, идэвхтэй байхад тусалдаг. Сайн мэдээний зарчмыг ойлгуулахад үйл ажиллагаа чиглэгдсэн байх ёстой. Жишээ нь: бөмбөг шидэх тоглоом (хуудас XXI), асуулт асуун сайн мэдээний зарчмыг ойлгуулан, сануулж болно.
<i>Хаалт</i>	10 минут Хаалтын цагийг Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ хүүхдүүдэд бүгдэд нь хайртай бөгөөд хүн бүрийг нэрээр нь мэддэг гэдгийг сануулан хэл. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн танд өгсөн олон адислалуудын талаар гэрчлэл болон талархлаа хуваалц. Дараа нь нэг хүүхдийг хаалтын залбирал хийхэд нь тусал.  <b>Хичээл 10: Би модод, ургамал ногоо, цэцэгс байдагт талархдаг</b>
<i>Нээлт</i>	Нярайн ангид хүүхдүүд орж ирэх үед хүүхэд бүрийн нэрийг нь хэлж мэндэл. Тэдэнтэй мэндлэх үедээ, өнөөдрийн хичээл дээр ургамал модод болон цэцэгсийн талаар суралцах болно гэдгээ хэл.
<i>Тоглох цаг</i>	35 минут Энэ цаг дээр хүүхдүүдийг хичээлд бэлтгэн, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бидэнд энэ дэлхий дээр олон сайхан үзэсгэлэнт зүйлсийг бүтээж өгсөн тухай ярь.
<i>Цугларах цаг</i>	10 минут Нээлтийн дуу дуулж, нэг хүүхдийг нээлтийн залбирал хийхэд нь тусал. Хичээл дээр хүүхдүүдэд харуулж, мэдрүүлж, үнэрлэж болох цэцэг эсвэл ургамал авчирч болно. Дараа нь эдгээр сайхан ургамал цэцэгст талархдаг тухайгаа хэл (нэмэлт үйл ажиллагаа 2, 7-р хуудсыг хар).
<i>Хөгжмийн цаг</i>	10 минут “Навчирхаг модны орой дээр” (нэмэлт үйл ажиллагаа 4, 38-р хуудас хар) дууг дуул. Дууны үгсийн үйлдлийг хийж, баяр баясгалантай уур амьсгалыг бий болгосноор хүүхдүүд өөр зүйл хийх боломжийг олгоно. Цаг байвал өнгөрсөн хичээлийн дууг давтан дуул.
<i>Хоолны цаг</i>	10 минут Хэрвээ боломжтой бол сайн мэдээний зарчимтай холбоотой үйл ажиллагааг хийж хоолны цагаа эхэл. Жишээ нь: Энэ цаг дээр талх, жимс идэ-

хээр зохион байгуулж болно. Тэгээд хүүхдүүдэд эдгээр зүйлсийг мод, ургамал болон цэцэгсээс гаргаж авдаг гэдгийг тайлбарла (38-р хуудсан дахь үйл ажиллагаа хар). Дараа нь хүүхдээр зуушаа адислуул.

*Хичээлийн цаг*

10 минут

Сайн мэдээний зарчмыг хүүхдүүдэд ойлгоход нь туслах хэсгүүдийг тухайн хичээлээс сонгон ав. Жишээ нь Хүүхдүүдэд мод, ургамал ба цэцэгс хэрхэн ургадаг талаар ойлгуулахын тул жимсний үрийг гарган үзүүлж болно. Үрээр юу хийдэг үүнээс хэрхэн гоё жимс, ногоо ургадаг талаар хэлж өг (баяжуулах үйл ажиллагаа 4, 37-р хуудас хар). Дараа нь хүүхдүүдэд хар шороо хийсэн цаасан аяганд үр суулгахад тусал. (баяжуулах үйл ажиллагаа 1, 37-р хуудас хар).

*Үйл*

*ажиллагааны цаг*

15 минут

Хичээлийн дараагаар намуухан хөгжим тавьж, хүүхдүүдээр ургамал, модод ба цэцэгсийн зургийг будуулж болно. Үйл ажиллагааг хичээлээс 35–38 хуудаснаас сонгож болно. Зарим хүүхдүүд энэ үед тоглоомоор тоглох сонирхолтой байж болно. Үйл ажиллагааг боломжоороо хий. Гэхдээ хүүхдийг хүчээр оролцуулах гэсний хэрэггүй.

*Хаалт*

10 минут

Хаалтын цаг нь заасан сайн мэдээний зарчмыг нэгтгэн дүгнэж, хүүхдүүдийг хаалтын залбирал хийхэд бэлтгэх үе юм. Мод, ургамал болон цэцэгсийг бидэнд өгсөнд талархаж байгаагаа хүүхдүүдэд сануул. Дараа нь хүүхдээр хаалтын залбирал хийлгэ.

---

## Зорилго

Бид бүгдийг мэдэж, хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд гэдгийг хүүхэд бүр ойлгоход нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Египетээс гарсан нь 2:1–10; Дуулал 82:6; Сургаал ба Гэрээ 138:55–56; ба Мосе 1:1–6-г уншиж суралц. *Сургаалын зарчмууд* (31110), бүлэг 2-ийг үз.
2. Хүүхэд бүрийн хоёр буюу гурван сэтгэл татах зан чанарыг эцэг эхээс нь асуун мэдэж ав.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи болон Агуу Үнэт Сувд.
  - б. Вандуйт уут юм уу жижиг зөөлөн эд.
  - в. Зураг 1-1, Дэлхий (62196); 1-2 ширхэг зураг, Мосе зэгсэн дунд (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 106; 62063).
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

“Би Бурханы Хүүхэд” (Сүмийн дуулал болон Хүүхдийн дуу, 58-р хуудас) дууг хүүхдүүдтэй хамт дуул.

Би Бурханы хүүхэд тул,  
Энэ эх дэлхийд намайг  
Их энэрэнгүй эх эцгийг  
Дэлхийн хамт заяав Тэр.

Надад замаа олоход туслан,  
Хөтлөн удирдаач.  
Түүнтэй амьдрахын тул би  
Юу хийх ёстойг заагаач. . .

Вандуйт уут юм уу зөөлөн эд зүйлээ “гэдэг нэртэй Бурханы хүүхдийг би мэднэ.” гэж хэлээд хүүхэд рүү чулууд. Хүүхдээр өөрийнх нь нэрийг хэлүүлж, эргүүлэн шидэхийг хүс. Хүүхэд бүрийг оролцуулан үүнийг хий.

## Бид Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд

- Тэнгэрлэг Эцэг гэж хэн бэ? (хүүхдүүдийн хариулсан хариулт дээр үндэслэн цааш нь тэдэнд ойлгомжтойгоор тайлбарла.)

Дэлхий 1-1 гэсэн зургийг үзүүл. Бид дэлхийд ирэхээсээ өмнө Тэнгэрлэг Эцэгтэйгээ тэнгэрт амьдарч байсан гэдгийг хэл. Тэгэхэд бид сүнсэн биетэй байсан. Сүнс гэдэг нь бидний дотор байгаа биднийг амьд болгодог зүйл. Бид сүнсэн биетэй байхдаа одооных шиг яс махан биетэй байгаагүй боловч яг л одооныхтойгоо ижилхэн харагддаг байсан.

Тэнгэрлэг Эцэг бидний сүнсний эцэг бөгөөд бид Түүний сүнсэн хүүхдүүд юм. Дэлхийд ирэхээсээ өмнө Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдардаг байснаа бид одоо санадаггүй. Гэхдээ бид энэ талаар судруудаас суралцсан учир Түүний сүнсэн хүүхдүүд мөн гэдгээ мэднэ.

Ариун Библийн Дуулал 82:6-ыг тэдэнд уншиж өгөөд *Хамгийн Дээд Нэгний* гэдэг нь Тэнгэрлэг Эцэг гэдгийг тайлбарлаж өг. Дэлхий дээрх хүн бүр Тэнгэрлэг Эцэгийн Хүүхдүүд гэдгийг онцлон хэл.

Дуу

“Би Бурханы хүүхэд” дууг дахин дуул. *Бурхан* гэдэг нь Тэнгэрлэг Эцэгийн өөр бас нэгэн нэр гэдгийг тайлбарлаж өг.

### **Тэнгэрлэг Эцэг биднийг мэддэг мөн хайрладаг**

Бид Түүний хүүхдүүд тул Тэнгэрлэг Эцэг бидэнд бүгдэд маань маш их хайртай гэдгийг тайлбарла. Тэр бидний нэрийг бас бидний тухай бүхнийг сайн мэддэг. Тэр биднийг юу баярлуулдаг, юу гомдоодгийг сайн мэддэг. Тэр бидэнд юу хамгийн сайн байхыг мэддэг.

Үйл ажиллагаа

Дараах үйлдэлт шүлгийг давтан хэлүүлж, үйлдлийг хийлгэ:

Тэнгэрлэг Эцэг намайг мэднэ

Тэнгэрлэг Эцэг намайг мэддэг (*өөр лүүгээ заа*)

Намайг юу хийх дуртайг мэддэг.

Тэр миний нэрийг мэднэ. Хаана амьдардгийг мэднэ (*хоёр гараа өргөн хурууныхаа үзүүрүүдийг нийлүүлэн дээвэр хий*).

Тэр надад хайртай гэдгийг би бас мэднэ (*хоёр гараа зөрүүлэн хоёр мөрөн дээрээ тавь, тэвэрч буй мэт*).

Тэр намайг юунд баярладгийг мэднэ (*хуруунуудаа инээмсэглэж буй уруулдаа хүргэ*).

Тэр намайг юу гунигтай болгодгийг мэднэ (*урвайсан урууландаа хуруугаа хүргэ*).

Тэр надад туслахыг хүсэж байгааг би мэднэ (*өөр лүүгээ заа*),

Энэ нь намайг баярлуулдаг!

Нэг хүүхдийг ангийн өмнө гарч ирэхийг урь. Хүүхдийн эцэг эхээс мэдсэн зүйлээ ашиглан Тэнгэрлэг Эцэг энэ хүүхдийн сайн чанаруудыг мэднэ гэдгийг хэл. Жишээ нь, “Эмили Тэнгэрлэг Эцэгийн хайртай охин, дүүгээ асрахад нь ээждээ тусалдаг, тэр их хөгжилтэй дандаа инээмсэглэдэг.”

Хүүхэд бүрийг урьж үүнийг хий.

Бид сайн зүйлс хийснээр Тэнгэрлэг Эцэгтэй адил болдог гэдгийг тайлбарла.

### **Бид Тэнгэрлэг Эцэгтэй адил болж чадна**

- Бяцхан нохойг юу гэж нэрлэдэг вэ?
- Гөлөг том болоод юу болох вэ?
- Бяцхан тахиаг юу гэж нэрлэдэг вэ?
- Тэр дэгдээхэй том болоод юу болох вэ?

Яг л эдгээр амьтад шиг бид мөн өсөж том болоод өөрсдийн эх эцэг шигээ болно гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг бидний сүнсний Эцэгийн хувьд бид ч мөн Түүнтэй адил болж болно. Тэнгэрлэг Эцэг биднийг

хайрладаг, сайн ханддаг мөн маш эелдэг, Тэр бидэнд туслахыг хүсдэг. Бид хайрлаж, сайн байж, эелдэг нөхөрсөг байх юм бол Тэнгэрлэг Эцэгтэй адил болж болно. Бид өдөр бүр Түүнтэй адил болохыг хичээх хэрэгтэй гэдгийг тайлбарла.

### **Тэнгэрлэг Эцэгт биднээр хийлгэх гэсэн чухал ажил байгаа**

Түүх

Мосе зэгсэн дунд хэмээх нэртэй 1-2 дугаартай зургийг үзүүл. Эхлэл 2:1–10 -д өгүүлсэн байдаг Фараоны охин Мосег жаахан хүүхэд байхад нь том аюулаас аварсан тухай түүхийг ярь.

Мосе Тэнгэрлэг Эцэгийн чухал туслагч, бошиглогч болон өссөн гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг Мосед тэр Түүний хүүхэд болох тухай (Мосе 1:4, 6 үз) мөн түүнд зориулсан чухал ажил байгааг хэлсэн. Мосе 1:6-гийн эхний өгүүлбэрийг уншиж өг. Мосе энэ ажлаа хийсэн. Тэрээр Израилыг Египетийн боолчлолоос гаргаж, өөр газар авчран тэдэнд Тэнгэрлэг Эцэгийн тушаалуудыг заасан.

Хүүхэд бүрийг нэг нэгээр нь ангийн өмнө гаргаж Мосе 1:6-гийн эхний шүлэг дэх Мосегийн нэрний оронд хүүхдийн өөрийнх нь нэрийг орлуулан уншаад тэднээр давтан хэлүүл: “Мөн чамд зориулсан ажил надад буй, (хүүхдийн нэр) хүү минь (охин минь).”

Дэлхий дээр амьдрах хугацаанд Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан эх эцэг болох, номлогч байх, багш, сүм дээр болон олон нийтэд туслах зэрэг хийх ёстой олон чухал зүйлүүд байдаг.

- Тэнгэрлэг Эцэг чамаас ямар чухал зүйл хийгээсэй гэж хүсэж болох вэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээс том болоод хэн болохыг хүсэж буйг нь асууж, хүүхэд тэвэрч буй аав, ээж; бүрэн цагийн номлогч болж гудамжаар хүмүүстэй ярилцах эсвэл хичээл зааж буй багш зэргийг үггүйгээр хөдөлгөөнөөр дүрслэн үзүүлэхийг хүс.

Гэрчлэл

Тэд бол Тэнгэрлэг Эцэгийн сүнслэг хүүхдүүд бөгөөд Тэрээр тэдэнд хайртай, тэднийг бүгдийг нь мэддэг гэдгийг үргэлж санаж байхыг хэл. Тэдэнд энэ дэлхий дээр хийх ёстой чухал ажлууд байгаа ба тэд Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болж чадна гэдгийг ойлгоход нь тусал. Тэнгэрлэг Эцэг танд хайртай бөгөөд таныг мэддэг гэдгийг ойлгоход тусалсан хувийн туршлагаасаа та хуваалцаж болно.

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Янз бүрийн хүмүүсийн зураг үзүүл, эсвэл хүүхдүүдийн мэддэг хүмүүсийн тухай ярь. Дараа нь тэднээс “Энэ хүн Бурханы хүүхэд мөн үү” хэмээн асуу. Жишээ нь, “Бишоп Бурханы хүүхэд мөн үү” “Цагдаагийн офицер Бурханы хүүхэд мөн үү” “Танай хөрш Бурханы хүүхэд мөн үү?” гэх мэт. Хүүхдүүдэд хүн бүр Бурханы хүүхэд мөн гэдгийг ойлгоход нь тусал.
2. Тэнгэрлэг Эцэг хүүхэд бүрийг мэдэж тэдний төлөө санаа тавьдаг гэдгийг мэдүүлэхийн тулд хүүхдүүдээр дараах өгүүлбэрүүдийг дуусгахыг хүс: “Тэнгэрлэг Эцэг намайг гунигладаг гэдгийг мэднэ” “би аз жаргал, баяр

баясгалантай болдог гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэднэ.” “Миний хийх дуртай зүйлс бол болохыг Тэнгэрлэг Эцэг мэднэ” “Хүүхдийн анги учраас би ирэх дуртай байдгийг Тэнгэрлэг Эцэг мэднэ” гэх мэт.

3. Тэнгэрлэг Эцэг газар ба тэнгэрийн их хаан гэдгийг тайлбарла. Бид Түүний хүүхдүүд учраас бүгдээрээ хунтайж ба гүнж нар. Хүүхэд бүрд титэм хийж өгөөд дээр нь *Би Бурханы хүүхэд* гэж бич. Хүүхдүүдийг титмээ будаж чимэхийг хүс.
4. Хүүхдүүдээр өөрсдөөр нь эсвэл хамтдаа “Эцэг минь амьдыг би мэднэ” (Сүмийн дуулал болон *Хүүхдийн дуу*, 59-р хуудас) дууны эхний мөрийг хэлүүлж эсвэл дуулуул.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдийг өөрсдийнх нь дуртай ямар нэгэн зүйлийн тухай бодохыг хүс (хичээлээс өмнө хүүхдүүдийн эх эцгээс энэ тухай мэдэж авч болно). Хүүхэд бүрээс юунд дуртайг нь асуу. Тэгээд Тэнгэрлэг Эцэг үүнийг чинь мэддэг, жишээлбэл: “Лияа нохойнд дуртай гэдгийг Тэнгэрлэг Эцэг мэддэг байсан”
2. Дараах шүлгийн хөдөлгөөнийг хүүхдүүдээр хийлгэ.  
Хэрэв чи маш их өндөр бол (*гараа өргөн дээш сунга*),  
Сүмд чамд зориулсан газар байна.  
Хэрэв чи маш намхан бол (*доош бол*),  
Сүмд чамд зориулсан газар байна.  
  
Өндөр (*дээш суна*),  
Намхан (*доош бол*),  
Өндөр (*дээш суна*),  
Намхан (*доош бол*)  
Тэнгэрлэг Эцэг бидэнд бүгдэд нь хайртай.
3. Дараах шүлгийн үгийг та өөрөө хэлж байх зуур хүүхдүүдээр хөдөлгөөнийг нь хийлгэ:  
Бяцхан хүү Мосе  
  
Бяцхан хүү Мосе завин ортой байжээ (*нэг гараа аяга хэлбэртэй болгон, нөгөө гарынхаа хуруунуудыг хий*).  
  
Түүний хайртай эгч нь өвсөн дунд нуугдан харж байлаа (*гарынхаа хуруунуудаар завсар гарган нүдээ тагла*).  
  
Нэгэн өдөр гүнж түүнийг олжээ (*доош харан урагш тонгой*) тэгээд түүнийг авч, гартаа тэврэн (*нярай хүүхэд тэвэрч буй бол*);  
  
“Би энэ хүүхдийг авч, бүх аюулаас хол байлгах болно” гэж хэлжээ (*хүүхдийг хоёр гараараа бүүвэйлж байгаа мэт хөдөл*).  
(Eleanor Doan-ий *Fascinating Finger Fun* хэмээх номноос ашиглав.  
© 1951. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

# Тэнгэрлэг Эцэг бие махбодтой

Хичээл

## 2

---

### Зорилго

Тэнгэрлэг Эцэг төгс бие махбодтой бодит хүн, бид Түүний дүр төрхөөр бүтээгдсэн гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт тусал.

---

### Бэлтгэл

1. Залбиралтайгаар Иохан 14:9; Сургаал ба Гэрээ 130:22; Мосе 2:27; ба Жосеф Смитийн түүх 1:14–17-г уншиж суралц. Мөн *Сургаалын зарчмууд* номын (31110) 1-р бүлгийг үз.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи ба Агуу Үнэт Сувд.
  - б. Цаас, өнгийн харандаа хүүхэд бүрд.
  - в. Жижиг толь
  - г. Зураг 1-3, Есүс Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572); зураг 1-4, Анхны үзэгдэл (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 403; 62470).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсэж буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

### Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Цаас ба өнгийн харандаагаа тарааж өг. Хүүхдүүдээс өөрсдийгөө зурахыг хүс. Тэднийг зурж дуусахад өөрөө өөрсдийнхөө зургийг дээш нь өргөхийг хүс. Дараа нь цаасан дээр байгаа нь эсвэл цаасыг барьж байгаа хоёрын аль нь бодит хүүхэд вэ гэдгийг тэднээс асуу. Тэд үүнийг яаж мэдэж байгааг асуу.

Бидэнд бие махбод байгаа учраас бид бодит бөгөөд Тэнгэрлэг Эцэг яг л бидэн шиг бие махбодтой бодит хүн гэдгийг тайлбарла. Бид Тэнгэрлэг Эцэгийн зурагнуудыг харж чадна. Гэхдээ зураг бол бодит хүн биш. Жинхэнэ Тэнгэрлэг Эцэг бие махбодтой амьд юм.

### Есүс Христ Тэнгэрлэг Эцэгтэй адилхан харагддаг

Хэн нэгэн тэднийг яг аав ээжтэйгээ адилхан гэж хэлж байсан эсэхийг асуу. Зураг 1-3 Есүс Христийн зургийг үзүүлээд Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн хүү гэдгийг тайлбарлаж өг. Судруудад Есүс Христ Тэнгэрлэг Эцэгтэй адилхан харагддаг хэмээн бичсэн байдгийг хэл. Ариун Библи харуулж, Иохан 14:9-г хүүхдүүдэд тайлбарлаж өг.

- Есүс Христ хэнтэй адилхан харагддаг вэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босохыг урь. Тэднийг Итгэлийн Тунхагийн 1-ийг цээжлэхийг хүс: “Бурхан, Мөнхийн Эцэг, мөн Түүний Хүү Есүс Христ, мөн Ариун Сүнсэнд бид итгэдэг”



## Бид Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христтэй адилхан харагддаг

Бид Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд тул бас Түүнтэй адилхан дүр төрхтэй. Бид Түүнтэй адилхан бие махбодтой. Мосе 2:27-г хүүхдүүдэд тайлбарлан ярьж өг. Тэнгэрлэг Эцэгтэй адил дүр төрхөөр бүтээгдсэн гэдэг нь бид Түүнтэй адилхан харагддаг гэсэн үг болохыг тайлбарла.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг ээлжлүүлэн толинд харуулж эсвэл өөр хүүхэд рүү харахыг хүс. Хүүхэд бүрийг өөрийн харж буй биеийн эрхтнээс нэрлэхийг хүс. Жишээ нь: гар, хөл, нүд, чих гэх мэт. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нарт мөн энэ бүгд байгаа гэдгийг тайлбарла.

- Чамд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй адилхан зүйл байгаа юу?

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нар адилхан гэдгийг олон бошиглогчид (сүмийн удирдагч нар) харж, Тэдний тухай сударт бичсэн байдгийг тайлбарла.

Түүх

Зураг 1-4 буюу Анхны үзэгдлийг үзүүл. Анхны үзэгдлийн тухай түүхийг Иосеф Смит—Түүх 1:14–17-д бичсэнчлэн ярьж өг.

- Иосеф Смит Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийг юутай адил харагддагийг хэрхэн мэдсэн бэ?
- Тэнгэрлэг Эцэг, Есүс нар ямархуу төрлийн бие махбодтой вэ?

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэгтэй ижил дүрх төрхөөр бүтээгдсэн бие махбодтой байгаадаа талархдаг талаар өөрийн гэрчлэлийг хуваалц. Түүний өгсөн энэ гайхамшигт бие махбодтой тул олон зүйлийг хийж чаддагтаа баяртай байдаг талаар хэл.

---

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдүүд босон зогсож, дараах үгсийг хөдөлгөөний хамт давтан хэлнэ:

Надад гайхамшигтай бие махбод бий

Тэнгэрлэг Эцэгийн надад зориулан төлөвлөсөн  
Гайхамшигтай бие бий (*цээжиндээ гараараа хүр*)  
Тэр надад сонсох чих (*гараараа чихэндээ хүр*)  
Мөн харах нүд өгсөн (*нүд рүүгээ заа*).

Надад алга таших хоёр гар бий (*алгаа таш*),  
Эргэлдэж болох хоёр хөл бий (*дороо эргэлд*).

Хэрэв би хүсвэл хөлнийхөө  
Хуруунд хүрч чадна (*доош тонгойж, хөлнийхөө хуруунд хүр*).

Би өөрийн биеийн тухай бодох үед (*долоовор хуруугаа толгойндоо хүргэ*),  
Хамгийн чухал нь (*чимээгүй доош суу*)  
Түүнтэй адилхан харагдахаар  
Тэнгэрлэг Эцэг намайг төлөвлөсөн

2. Тэнгэрлэг Эцэг өөрийнхтэйгөө адилхан биеийг бидэнд өгсөн гэдгийг хүүхдүүдэд сануул. Энэ гайхамшигт бие махбодиуд маань олон зүйлийг хийж чадна.

3. Хүүхдүүдийг зураг 1-4-г ашиглан Анхны үзэгдлийн тухай түүхийг ээлж ээлжээр ангийнхаа бусад хүүхдүүдэд ярихыг хүс.
4. Марк болон түүний гэр бүлийнх нь үйл ажиллагааны тухай түүхийг ярьж өг:

Маркыг жаахан байхад аав нь нас баржээ. Марк миний аав ямар дүр төрхтэй хүн байсан бол гэж их боддог байжээ. Тэр ээжтэйгээ хамт аавыг нь маш сайн мэддэг байсан хамаатны авга ах эгчийндээ очиж гэр бүлийн цуглаанд оролцохоор явжээ.

Тэднийг ирэхэд Жой ах нь угтан гарч ирэв. Тэр Марк руу хараад, “Би чамайг хаана ч харсан таних юм байна. Чи яг аавтайгаа адилхан нүдтэй юм байна” гэжээ. Харин авга эгч Елизабет нь хараад “Марк чи яг аавтайгаа адилхан хамартай юм байна” гэж хэлэв. Авга эгч Мэри нь харин “Марк чиний инээмсэглэл яг аавын чинь инээмсэглэлийг санагдуулж байна” гэлээ.

Ээжтэйгээ гэр уруугаа буцах замдаа Марк ээждээ, “Өнөөдөр маш гоё өдөр байлаа. Би өнөөдөр аавынхаа талаар олон зүйлийг мэдэж авлаа. Би аавтайгаа их адилхан юм байна гэдгийг мэдлээ. Энэ нь намайг маш их баярлуулж байна. Одоо би толинд харахдаа аавыгаа үргэлж санаж түүнийг хэзээ ч мартажгүй байж чадна.” Маркын ээж эргэн харж, түүний гарыг атган “Чи надад байхад би ч гэсэн түүнийг хэзээ ч мартажгүй” гэж хэллээ.

Марк хэдийгээр аавыгаа хараагүй ч аавтайгаа адилхан гэдгээ мэдсэнтэй адил бид ч бас Тэнгэрлэг Эцэгээ хараагүй ч, Түүнтэй адилхан гэдгээ мэдэж чадна гэдгийг хүүхдүүдэд хэл.

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зураг 1-4 Анхны үзэгдлийг үзүүл. Анхны үзэгдлийн тухай түүхийг хялбарчлан ярьж өг. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нар бодит амьд хүмүүс, Тэд бидний залбирлыг сонсдог гэдгийг тодорхой хэлж өг.
2. Анхны үзэгдлийн зураг 1-4-г ашиглан, бидний бие махбод Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийнхтэй ямар адилхан гэдгийг үзүүл. Зурган дээрх биеийн аль нэг хэсгийг заахад, хүүхдүүдийг тэр заасан биеийн хэсгийг өөр дээрээ заахыг хүс. Жишээ нь, хэрэв та Тэнгэрлэг Эцэгийн гар руу заавал хүүхдүүд бас өөрсдийнхөө гарыг заах гэх мэт.
3. Дараагийн үгсийг та хэлэхэд хүүхдүүд үйлдэл хийнэ:  
Иосеф модон дунд өвдөглөн сууж (*гараа зөрүүлэн, өвдөглөн суу*)  
Онцгой залбирал хэлэв (*хуруугаа уруулдаа хүргэ*).  
Тэр Эцэг, Хүү хоёрыг харав (*гараараа нүдээ саравчлан, дээш хар*)  
Тэнд тэднийг сонсчээ (*гарынхаа алгыг хумин, хоёр чихнийхээ дэргэд барь*).
4. Өөрийнхөө ам руугаа заан, “Энэ бол миний ам” гэж хэл. Тэгээд “Та нар өөрсдийнхөө амыг надад харуулж чадах уу?” гэж асуу. Хүүхдүүдэд өөрсдийнхөө амыг заахад нь тусал. Дараа нь “Тэнгэрлэг Эцэгт ам байдаг уу?” гэж асуу. Энэ мэтээр нүд, хамар, чих, гар ба хөлийг заан давт. Дараа нь биеийн бусад эрхтнүүдийг зааж хүүхдүүдээр нэрийг нь хэлүүл.

# Бидэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө

## Зорилго

Бид энэ дэлхийд ирэхээс өмнө Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүд байж Түүнтэй хамт амьдардаг байсан бөгөөд энэ амьдралын дараа ч Түүнтэй дахин хамт амьдрах болно гэдгийг хүүхэд бүрийг ойлгоход нь тусал.

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Абрахам 3:22–27-г уншиж судал. Мөн *Сургаалын зарчмууд* (31110), бүлэг 2-ыг үз.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Судар.
  - б. Хүүхэлдэй юм уу цаасан дүрс
  - в. Зураг 1-1, Дэлхий (62196); зураг 1-3, Есүс Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572); зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл (62307); зураг 1-6, Гэр бүлийн үдэш (62521); зураг 1-7, Хайраар дүүрэн гэр бүл; зураг 1-8, Ариун Ёслол түгээж байгаа нь (62021); зураг 1-9, Өглөөний залбирал (62310); зураг 1-10, Гэр бүлийн залбирал (62275); зураг 1-11, Баптисм хүртэж буй хүү (62018); зураг 1-12, Ариун Сүнсний бэлэг хүртэж буй охин (62020); зураг 1-13, Иосеф Смит (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 400; 62449).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах зүйлсээ бэлтгэ.

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхэлдэй юм уу цаасан дүрсээ хүүхдийн дэргэдэх сандал дээр тавь. Хүүхдийг босоод дороо эргэж буцаж суухыг хүс.

- Яагаад хүүхэлдэй боссонгүй вэ?
- Чи яагаад босч чадсан бэ?

Хүүхэд болон хүүхэлдэйн хоорондох ялгааны талаар ярилц. Тэд бол амьд юм гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэдний дотор тэднийг амьд болгогч сүнс байдаг учраас тэд харж, сонсож, босч, хөдлөж, бодож мөн ярьж чаддаг.

### Бид Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд

Бид энэ дэлхийд төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүд нь байж хамт амьдарч байсан гэдгийг дахин сануулж хэл. Бид Амьд Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрах маш дуртай мөн аз жаргалтай байсан. Бидэнд одоогийнх шиг ийм махан бие байгаагүй, гэхдээ бидэнд сүнснүүд байсан. Сүнс маань яг бие махбод шиг харагддаг боловч бодит яс мах байхгүй гэдгийг тайлбарла.

- Энэ дэлхийд төрөхөөс өмнө чи хаана амьдардаг байсан бэ?

Дуу

“Би Бурханы Хүүхэд” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 58-р хуудас)  
дууг хүүхдүүдтэй хамт дуул. Хүүхдүүдэд *Бурхан гэдэг нь Тэнгэрлэг  
Эцэгийн бас нэгэн нэр гэдгийг сануулж хэл.*

Би Бурханы хүүхэд тул  
Энэ эх дэлхийд намайг,  
Их энэрэнгүй эх эцэгийг  
Дэлхийн хамт заяав Тэр.

Надад замаа олоход туслан,  
Хөтлөн удирдаач,  
Түүнтэй амьдрахын тул би  
Юу хийх ёстойг заагаач

Үйл ажиллагаа

Хүүхдийг өөрийнхөө дэргэд зогсоо. Түүний нэрийг хэлэн энэ дэлхийд төрөхөөсөө өмнө тэр Тэнгэрлэг Эцэгийн хайртай сүнсэн хүүхэд нь байсан гэдгийг тайлбарлан хэл. Хүүхэд бүртэй энэ маягаар хий.

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай тул бидэнд зориулан төлөвлөгөө зохиосон. Дэлхийг бүтээхээсээ өмнө Тэнгэрлэг Эцэг өөрийн бүх хүүхдүүдээ цуглуулан, төлөвлөгөөгөө тайлбарласан. Бидний аав ээж, ахан дүүс бүгд тэнд хамтдаа байсан.

### **Тэнгэрлэг Эцэг биднийг дэлхий дээр амьдруулахаар илгээсэн**

Зураг 1-1, Дэлхий хэмээх зургийг үзүүл. Энэ дэлхий бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэгийн удирдлаган дор Есүс Христ дэлхийг бүтээсэн. Бид энэ дэлхий дээр төрж, бие махбод хүлээн авахаар ирсэн.

Зураг 1-5 буюу Бяцхан хүүхэдтэй гэр бүл, зургийг үзүүл. Хүүхдүүдээр зургийн талаар яриул. Бид дэлхийд ирэх, суралцах мөн өсөн хөгжинө хэмээн маш баяртай байсан. Бид бяцхан хүүхдүүд болон дэлхийд мэндэлж, биднийг хайрлан өсгөн хүмүүжүүлэх гэр бүлүүдэд ирсэн.

Хүүхдүүдэд бид дэлхийд ирэхдээ булчин яс, арьс цус зэргээс бүрдсэн бие махбодтой болсон гэдгийг хэл. Хүүхдүүдийг өөрсдийн гарыг мэдрэх боломж өг.

- Та нар өөрсдийн гарны ясыг мэдэрч байна уу?
- Та нар өөрсдийн арьсыг харж мэдэрч байна уу?
- Та нар өөрсдийн булчинг мэдэрч байна уу?

Бидний дотор байгаа сүнс бидэнд амийг өгдөг гэдгийг сануул. Гэхдээ бид түүнийг харж бас барьж чадахгүй. Бидний бие махбод маань харин харагдаж бас баригдаж чадна. Бие махбодтой байх нь агуу их адислал.

Үйл ажиллагаа

Дараагийн шүлгийг хүүхдүүдээр давтан хэлүүл. Хэлж буй өөрийн биеийн эрхтэн бүрээ заа.

Би нүдэндээ талархдаг

Би нүдэндээ талархаж байна  
би чих, ам, хамар,  
Мөн гар хуруундаа талархдаг  
Мөн хөл, тавхай хуруунууддаа талархдаг.

(Люси Пиккогийн шүлгийг өөрчлөн найруулав.)

Бид бүхэн энэ дэлхий дээр өсч торнин, олон зүйлийг суралцдаг. Бид зөв зүйлсийг хийхээр сонгохыг сурснаар Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй илүү адилхан болж чадна. Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн бас нэгэн төлөвлөгөө юм.

### **Хэзээ нэгэн өдөр бид Түүн дээр эргэн очихыг Тэнгэрлэг Эцэг маань хүсдэг**

Тэнгэрлэг Эцэгийг хайрлах өөрийн хайраа илэрхийл. Хүүхдүүдэд тэд нэгэн өдөр Тэнгэрлэг Эцэгтэй буцан очиж, Түүнийг харж мөн түүнтэй дахин хамт байж чадна гэдгийг хэл. Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний бас нэгэн хэсэг юм гэдгийг тайлбарла. Энэ дэлхийн амьдрал маань төгсгөл болоход Тэрээр биднийг дахин Түүн дээр буцан очиж хамт амьдрахыг хүсдэг гэдгийг тайлбарла. Тэр мөн биднийг, аав ээж, гэр бүлийнхнийг минь бүгд хамтдаа Түүнтэй дахин хамт байхыг хүсдэг.

Тэнгэрлэг эцэг, Есүс Христтэй дахин хамт амьдрахын тулд бид баптисм хүртэж тушаалуудыг дагах ёстой гэдгийг тайлбарла. Судруудыг хүүхдүүдэд харуул. Судрууд бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн тухай зааж, Тэд биднээр юу хийлгэхийг хүсч буйг хэлж өгдөг болохыг тайлбарла.

“Бэлтгэл” хэсэг дэх зурагнуудыг ашиглан, Тэнгэрлэг Эцэг биднийг энэ дэлхий дээр юу сурч, юу хийхийг хүсдэг тухай ярилц. Тэр биднийг өөрсдийн гэр бүлээ хайрлаж, аминч биш байж, сүмдээ тогтмол явж, ариун ёслолоос хүртэн, өглөөний болон оройн залбирлуудаа хийж, гэр бүлийн залбирал болон гэр бүлийн үдэш хийж, баптисм хүртэн, Ариун Сүнсний өөрсөд дээрээ хүлээн аван батлуулж, Ариун Сүмд гэрлэн, Бошиглогчдын тухай суралцан, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй адил болохыг хүсдэг.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг ба Түүний бидэнд өгсөн төлөвлөгөөнд талархаж байгаагаа хэл. Үргэлж зөвийг сонгон хийснээр тэд нэгэн өдөр Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ дээр эргэн очиж чадна хэмээн тэднийг зоригжуул.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлийн явцад хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. *Би Бурханы хүүхэд хэмээн бичсэн цаасыг хүүхдүүдэд өгч, тэднийг өөрсдийгөө түүн дээр зурахыг хүс. Ангийнхандаа зурсан зургаа үзүүлэхийг хүс. Зургийг үзүүлэх үедээ өөрсдийнхөө талаар ямар нэгэн сайн зүйлс хэлэхийг урь.*

2. Хүүхдүүдээр дараах шүлгийг хэлүүлэн, хөдөлгөөнүүдийг хийлгэ:

Бурханы бүтээл

Бурхан сарыг хийсэн (*гараараа тойрог хий*)

Мөн анивчих оддыг (*гараа атгаж, тэнийлгэ*)

Тэднийг тэнгэрт тавьжээ (*гараа өргө*).

Тэр нарыг (*толгой дээрээ тойрог хий*)

Мөн моддыг (*гараа эгц дээш өргө*)

Мөн цэцэгсийг (*хоёр алгаа аяга шиг болгон нийлүүл*)

Нисч буй жижигхэн шувуудыг бүтээсэн (*гараа долгиолуул*).

(Eleanor Doan –ны *Fascinating Finger Fun* номноос. © 1951. Зөвшөөрлийн дагуу ашиглав.)

3. Өөр өөр цаасан дээр дараах асуултуудыг бич. Хүүхэд бүрээр нэг цаас суглуулан хичээлийг давт. Асуултыг уншиж, хүүхдээр хариултыг хэлүүл. Хэрэгтэй бол дахин давтаж хүүхэд бүрээр хийлгэ.
- Хэн бурханы хүүхэд вэ? (Би; хүн бүр)
  - Дэлхийд төрөхөөсөө өмнө бид хаана амьдарч байсан бэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүстэй хамт тэнгэрт)
  - Тэнгэрлэг Эцэг яагаад Есүсээр бидэнд зориулан дэлхий бүтээхийг хүссэн бэ? (бид бие махбодтой болж, Тэнгэрлэг Эцэг ба Есүстэй дахин хамт амьдрахын тул юу хийх хэрэгтэйгээ суралцахын тул)
  - Тэнгэрлэг Эцэг ба Есүстэй хамт дахин амьдрахын тул бид юу хийх хэрэгтэй вэ? (тушаалуудыг дуулгавартай дагаж, баптисм хүртэж, Ариун Сүмд орох болон бусад. Эдгээр асуултуудад хариулах үедээ хүүхдүүдийг холбогдох зурагнуудыг үзүүлэхийг урь)
  - Энэ дэлхий дээрх амьдралаа бид дуусгаад хэнтэй амьдрах вэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ мөн өөрсдийн гэр бүлүүдтэйгээ)

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

- Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэй нэгэн аавыг нялх хүүхдээ ангид авч ирэхийг урь. Аав нарын тухай болон тэд хүүхдүүддээ ямар их хайртай тухай ярь. Тэднийг хайрладаг хоёр аав байдаг гэдгийг хүүхдүүдэд хэл: энэ дэлхий дээрх тэдний аав болон тэдний Тэнгэрлэг Эцэг. Нялх хүүхдүүд энэ дэлхий дээр төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарч байсан. (Анхааруулга: ангийнхаа хүүхдүүдийн байдалд мэдрэмтгий бай. Учир нь ангийн зарим хүүхдүүд аавгүй байж магад)
- Ангид нэг юм уу хэд хэдэн хос “Аавын гутал” авчир. Энэ том гуталнуудыг хэн өмсдөг талаар ярилц. Хүүхдүүд өөрийн гутал болон хөлөө эдгээр том размерийн гуталтай харьцуулан үзэг. Хүүхэд бүрт “Аавын гутал”-ыг углан алхах боломжийг өг.
- “Би Тэнгэрт амьдардаг байсан” дууны эхний мөрийг дуулах буюу үгийг хэлүүл (*Children’s Songbook*, p. 4)

Үнэн шүү би нилээд хугацааны өмнө тэнгэрт амьдардаг байсан,  
Тэнд амьдарч өөрийн хүмүүсээ хайрладаг байсан. Чи ч бас.  
(© 1987 Janeen Jacobs Brady. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

- Тэнгэрт бид хэнтэй амьдардаг байсан бэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүс болон бүх хүмүүстэй)
- Та үгийг хэлж байх явцад хүүхдүүдээр хөдөлгөөнийг нь хийлгэ. Хүссэнээрээ давтан хий.

*Гар гараасаа барилцан тойрон зогс. Үйл ажиллагааны туршид хөтлөлцсөн хэвээр бай.*

Бид бүгдээрээ Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдардаг байсан (*гараа тойргийн гол руу болгон, бие биесдээ ойрт*).

Тэр биднийг дэлхий дээр амьдруулахаар доош явуулсан (*том тойрог болон тэл*)

Тэр бидэнд хайрлаж суралцах гэр бүлийг өгсөн (*дахин ойрт*).

Бидний гэр бүл биднийг дахин хамтдаа амьдрахад туслах болно (*дахин эргэж том тойрог үүсгэ*).

# Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна

## Зорилго

Тэнгэрлэг Эцэгтээ хандан хэрхэн залбирахыг хүүхэд бүрд зааж, Тэр биднийг сонсдог гэдгийг ойлгоход нь тусал.

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Даниел 6-г уншин суралц. Сургаалын зарчмууд (31110), бүлэг 8.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Зураг 1-9, Өглөөний залбирал (62310); зураг 1-10, Гэр бүлийн залбирал (62275); зураг 1-14, Даниел арслангийн торон дотор (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 117; 62096); зураг 1-15, Хоолоо адислах.
3. Өөрийн хэрэглэх гэж буй баяжуулах үйл ажиллагаандаа шаардлагатай бүх зүйлсээ бэлтгэ.

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Нээлтийн залбирал хийх хүүхдийг урь.

Нээлтийн залбирал хийсэн хүүхдийг гарч ирэхийг урин самбарын өмнө зогсоо. Бид төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарч байсан тухай түрүүчийн хичээл дээр суралцсан гэдгийг хүүхдүүдэд сануул. Тэнгэрлэг Эцэг маань биднийг энэ дэлхийд илгээсэн.

- Дэлхий дээр байхдаа бид яаж Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярих вэ?
- Хэн (нээлтийн залбирал хэлсэн хүүхдийн нэр) залбирал хийж байхдаа хэнтэй ярьсан бэ?

Хүүхдүүдэд бид залбирал хэлж байхдаа Тэнгэрлэг Эцэгтэй ярьдаг гэдгийг ойлгоход тусал.

### Бид Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна

Бид Түүнийг харж чадахгүй ч Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна. Тэр бидний залбирлыг сонсох болно.

Зураг 1-9, Өглөөний залбирал гэсэн зургийг үзүүл.

- Энэ охин юу хийж байна вэ?
- Энэ охин хэнтэй ярьж байна вэ?
- Энэ охин Тэнгэрлэг Эцэгт хандан юу хэлж байна вэ?

Зураг 1-9, Өглөөний залбирал, зураг 1-10, Гэр бүлийн залбирал, мөн зураг 1-15, Хоолоо адислах зэрэг эдгээр зурагнуудыг ашиглан хүүдүүдтэй залбирлын цагуудын тухай ярилц. Бид хэзээ хүссэн цагтаа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч чадна. Ихэвчлэн бид өглөө сэрээд, орой унтахаар

хэвтэхийнхээ өмнө, хоол идэхийнхээ өмнө, гэр бүлээрээ хамтдаа мөн онцгой тусламж хүссэн үедээ залбирдаг тухай тайлбарла. Хүүхдүүдээр эдгээр залбирлуудын тухай ярьж байхдаа зохицох зургийг харуулахыг хүс.

### **Есүс Христ бидэнд Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахыг заасан**

Залбирахдаа хийх ёстой зарим нэгэн зүйлсийн талаар Есүс бидэнд заасан тухай тайлбарлаж өг. Бид залбирахад бэлтгэж Тэнгэрлэг Эцэгийнхээ тухай боддог.

- Залбирахдаа бид гараа яах ёстой вэ?
- Залбирахдаа бид толгой, нүдээ яах ёстой вэ?

Үйл ажиллагаа

Залбирахад бэлтгэхийн тул гараа нугалан урдаа авч, толгойгоо гудайлган нүдээ аних хэрэгтэйг өөрөө үзүүлж, дуурайн хийхийг хүүхдүүдээс хүс. Хэн нэгнийг ангийн өмнө гарган залбиралд бэлтгэх үйлдэл хийлгэн бусад хүүхдүүдээр түүнийг дуурайлган хийлгүүл.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдтэй хамт “Залбирлын дуу” (*Children’s Songbook*, 22-р хуудас) дууг хэд хэдэн удаа дуулах буюу үгийг нь хэл. Дуунд өгүүлэх үйл хөдлөлдүүдийг хий.

Бид залбирахаар толгойгоо бөхийлгөн,  
Гараа нугалан урдаа авч,  
Дараа нь нүдээ аньж залбиран  
Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярьдаг.

- Залбирахад бэлэн болохын тулд бид өөр юу хийдэг вэ?

Гэртээ бид хувийн болон гэр бүлийн залбирлаа хийхдээ гараа нугалан урдаа авч, толгойгоо бөхийлгөн нүдээ анихаас гадна бас өвдөглөн суудаг талаар тайлбарлаж өг.

Дуу

Залбирахдаа бид онцгой зүйлсийг хэлдэг. “Би итгэлтэйгээр залбирдаг” (*Children’s Songbook*, 14-р хуудас) дууны хоёрдугаар бадгийг дуулж эсвэл үгийг хэд хэдэн удаа давтан хэл. Залбирахдаа хэлдэг дөрвөн онцгой зүйлсийг хэлэх үед нэг нэгээр хуруугаа дарж тоолохыг хүс.

Би “Хүндэт Тэнгэрлэг Эцэг минь” гэж эхэлж хэлдэг  
Түүний илгээсэн адислалуудад би талархдаг  
Дараа нь даруухнаар өөрт хэрэгтэй зүйлээ гуйдаг,  
Үүнийг Есүс Христийн нэрээр, Амен.

(© 1987 Janice Karp Perry. Зөвшөөрлийн дагуу ашиглав.)

- Бид залбирлаа яаж эхэлдэг вэ?
- Тэнгэрлэг Эцэгийн юунд бид талархдаг вэ?
- Тэнгэрлэг Эцэгээс бид юу гуйж болох вэ?
- Бид залбирлаа яаж дуусгадаг вэ?

### **Биднийг залбирахад Тэнгэрлэг Эцэг сонсдог**

Түүх

Зураг 1-14, Даниел арслангийн үүрэнд, үзүүл. Даниел 6 дээр гардаг түүхийг ярьж өг. 22-р бүлгийн эхний хэсгийг чанга дуугаар уншиж өг. Даниел арслангийн үүрэнд байхдаа яагаад гэмтээгүй вэ? гэдгийг тайлбарла.



Тэнгэрлэг Эцэгийн тушаал байсан учир Даниел залбирахыг хүссэн гэдгийг тайлбарла. Мөн тэр Тэнгэрлэг Эцэгийн адислалд талархахыг хүссэн.

- Даниел залбирахад хаан юу хийсэн бэ? (Даниел 6:16-г хар)
- Арслангийн үүрэнд Даниелд юу тохиолдсон бэ? (Даниел 6:22-ийг хар)
- Даниелын залбирлыг Тэнгэрлэг Эцэг сонссон гэдгийг яаж мэдэж болох вэ? (Даниел 6:23-г хар)

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг таны залбирлыг сонссон тохиолдлын тухай ярь. Хүүхдүүдийг залбиралтай холбоотой гэрчлэлээсээ хуваалцахыг хүс.

Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирах боломжтой байгаадаа ямар их талархалтай байгаагаа хүүхдүүдэд хэл. Мөн бид залбирахад Тэнгэрлэг Эцэг биднийг сонсдог гэдгийг батал.

Хаалтын залбирал хийх хүүхдийг урьж, залбирахад хэрхэн бэлтгэхээ давтан хий.

- Бид залбирахад бэлтгэхийн тул юу хийх хэрэгтэй вэ? (гараа нугалан, толгойгоо гудайлгаад, нүдээ аних)
- Залбирлын хамгийн эхэнд (хүүхдийн нэрийг орлуул) юу гэж хэлэх ёстой вэ?
- (Хүүхдийн нэрийг орлуул) Тэнгэрлэг Эцэгт юунд талархаж болох вэ?
- (Хүүхдийн нэрийг орлуул) Тэнгэрлэг Эцэгээс юу гуйж болох вэ?
- (Хүүхдийн нэрийг орлуул) залбирлаа хэрхэн дуусгах вэ?

---

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхэд рүү зөөлөн бөмбөг эсвэл вандуйтай уут шид. Хүүхэд бүр бөмбөгөө барих үед түүнээс дараах өгүүлбэрийг нөхөж хэлэхийг хүс. “Би залбирахдаа Тэнгэрлэг Эцэгт . . . -т талархаж байна” гэсэн өгүүлбэрийг хүүхэд “Миний гэр бүл” гэж нөхөж болно. Хүүхэд бүрээс асууж, хэд хэдэн удаа давтаж болно. Мөн хүүхдүүд Тэнгэрлэг Эцэгт залбирахдаа гуйж, хүсч болох зүйлсийг нэрлүүлж болно. Тэдэнд туслах санаа өгөхийн тулд зурагнууд үзүүлж болно.
2. “Талархлын дуу” дууг дуулах буюу үгийг нь хэл (*Children’s Songbook*, p. 20) мөн хөдөлгөөнийг хий:

Тандаа дэлхийг өгсөнд баярлалаа (*дэлхийг дүрсэлж буй мэт гараа дугуйл*);

Бидний иддэг хоол хүнсэнд баярлалаа (*амандаа идэх зүйл хийж байгаа мэт бол*);

Жиргэх шувуудад баярлалаа (*эрхий хуруугаа бусад хуруунуудтайгаа хавсарч шувуун жиргээг дүрсэл*);

Тандаа баярлалаа Бурхан минь бүх зүйлсийн төлөө баярлалаа (*гараа өргөн тэл*)

(Hollis ба Dann -ын *First Year Music* номноос. © 1957 он. D. C. Heath and Company. Зөвшөөрлийн дагуу дахин хэвлэв.)

3. “Би нүдтэйдээ талархаж байна” дуун дээр гарах үгсийн дагуу өөр дээрээ заа:  
 Би нүдтэйдээ талархаж байна,  
 Миний чих, ам, хамар;  
 Мөн гар хуруундаа талархдаг,  
 Мөн хөл, тавхай хуруунууддаа талархдаг.  
 (Lucy Picco-гийн дуунаас авав.)
4. Даниел арслангийн үүрэнд хэмээх түүхийг жүжигчлэн үзүүлэхийг хүүхдүүдээс хүс. Та энгийн хувцаснууд авчирч болно. Хэрэв түүхийг бүрэн эхээр нь үзүүлэх хүсэлгүй байвал хүүхдүүдээр зөвхөн архирах арслангийн дүрийг хийлгэ. Тэгээд архирах арслангийн амыг тэнгэрийн элч таглаж буй мэт дүрслэн амыг нь тагла.
5. “Эцэгтээ талархъя” (*Children’s Songbook*, p.20) дууг дуулуулж эсвэл үгийг нь хэлүүл.
6. Хүүхдүүд залбирахдаа Тэнгэрлэг Эцэгт хандан талархах зүйлсээ зурахыг хүс. Зураг бүр дээр “Би залбирахдаа Тэнгэрлэг Эцэгтээ талархаж чадна” гэж бич.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Бид залбирахдаа бидэнд хайртай биднийг үргэлж сонсдог Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярьдаг гэдгийг сануул. Дараах шүлгийг хүүхдүүдээр хэлүүл:  
 Би өөрийн Тэнгэрлэг Эцэгтээ хайртай;  
 Би залбиралдаа Түүнд талархдаг.  
 Миний Тэнгэрлэг Эцэг надад хайртай;  
 Тэр миний хэлж буй үгсийг сонсдог.
2. Дараах хоёр мөртүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь хүүхдүүдээр хэлүүлж холбогдох хөдөлгөөнүүдийг нь хийхэд тэдэнд тусал:  
 Бид гараа нугалан, толгойгоо бөхийлгөн,  
 Бид нүдээ анилаа, Одоо бид бэлэн боллоо.  
 Бид гараа нугалан, толгойгоо бөхийлгөн,  
 Хэлж буй залбирлыг сонсож байна.
3. Цаасан дээр хүүхэд бүрийн гарын хэлбэрийг зур. Бид залбирал хэлэх үедээ гараа яах ёстойг асуу. Хүүхдүүдээр өөрсдийн гарын хэлбэрийг нь өнгөөр будуул. Өөрсдийнх нь нэрийг зурган дээр нь бич.

# Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү

## Зорилго

Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэдгийг хүүхдүүд ойлгоход нь туслах.

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Матай 3:13–17 ба Лук 1:26–35; 2:1–7, 41–52-г уншиж суралц. *Сургаалын зарчмууд*, 3-р бүлгийг үз.
2. Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр нэг хүүхдийн аавыг ангид урьж, хүүхэд нь бага байхдаа ямар хүүхэд байсан талаар сэтгэгдлээ хуваалцахыг урь. Түүнийг боломжтой бол зураг болон дуртай тоглоомноос нь авчрахыг хүс. Хүүхэддээ ямар хайртайгаа хуваалцахыг хүс.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Зураг 1-16, Христийн мэндэлсний баярын үед хэрэглэдэг “Есүс мэндэлсэн нь” дүрснүүд (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 201; 62495); зураг 1-17, Есүс Хүү Ариун Сүмд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 205; 62500); зураг 1-18, Усаар батлагч Иохан Есүсийг усаар баталсан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 208; 62133).
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ. Багшид анхааруулах нь: Энэ хичээл дээр аавын талаар ярьж байгаа тул, ангид байгаа аавгүй хүүхдүүдийн талаар мэдрэмтгий бай. Бидэнд хайртай Тэнгэрлэг Эцэг бүгдэд маань бий гэдгийг тодруул. Хэрэв ангийн хэн нэгэн хүүхэд хойт эцэгтэй бол тэр ч мөн биднийг халамжлан хайрладаг гэдгийг хэл.

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдээс өнөөдрийн зочин хэн гэдгийг асуу. Зочны хүүхдээс өөрийн зочноо ангийнхандаа танилцуулахыг хүс. Ааваас хүүхдийн бага насны үеийнх нь талаар ярихыг урь. Хүүхэд бүрийг өөрсдийн аав нарынхаа тухай ямар нэгэн зүйл хэлэхийг хүс. Жишээлбэл: Түүний үсний өнгө ч юм уу тэр ямар ажил хийдэг гэдгийг ч юм уу.

### Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү

Хүүхдүүдэд тэдэнд хайртай хоёр аав байдаг гэдгийг хэл: энэ дэлхий дээрх тэдний аав мөн Тэнгэрлэг Эцэг. Бидний дэлхийн эцэг маань бидний бие махбодийн эцэг. Тэнгэрлэг Эцэг бол бидний биеийн доторх сүнсний эцэг юм. Есүс ганцхан аавтай байсан. Учир нь Тэнгэрлэг Эцэг Түүний бие махбод болон сүнснийх нь эцэг. Ийм учраас Есүс Бурханы Хүү юм.

Түүх	<p>Зураг 1-16, Есүс мэндэлсэн нь. зургийг үзүүлж, Есүс төрсөн тухай Лук 1:26–35 ба 2:1–7 дээр бичсэн түүхийг ярьж өг. Тэнгэрийн элч Мариад түүний хүү нь Бурханы Хүү байна гэж хэлснийг тодотго. Зургийг үзүүлж байгаад дараах асуултуудыг асуу:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аль нь Есүсийн ээж вэ?</li> <li>• Түүний нэрийг хэн гэдэг вэ? (Лук1:27-г үз.)</li> <li>• Энэ зурган дээрх эрэгтэй хүн хэн бэ? (Лук 1:27-г үз.)</li> <li>• Есүсийн эцэг нь хэн бэ? (Тэнгэрлэг Эцэг. Иосеф бол Тэнгэрлэг Эцэгээр сонгогдсон Мариа, Есүс нарыг халамжлах ёстой сайн хүн)</li> </ul>
Дуу	<p>“Малын тэвшинд” (<i>Children’s Songbook</i>, р. 42) дууг дуулах буюу үгийг хэл. Дууны үгээр зохих гар хурууны хөдөлгөөнийг хий.</p> <p>Малын тэвшнээс өөр унтах газаргүй, Бяцхан Эзэн Есүс нүдээ аньж хэвтэнэ, Тэнгэр дэх одод түүний дээрээс гийгүүлж Бяцхан Эзэн Есүс өвсөн дээр нойрсоно.</p> <p><b>Есүс Тэнгэрлэг Эцэгт хайртай бөгөөд Түүнд дуулгавартай байдаг</b></p>
Түүх	<p>Зураг 1-17, Есүс Хүү Ариун Сүмд зургийг үзүүлж Лук 2:41–52-д гардаг Есүс Ариун Сүмд ирсэн тухай түүхийг ярьж өг. Тэнгэрлэг Эцэгт хайртай байсан тул Есүс Ариун Сүмд орсон бөгөөд Түүний тухай бусдад заахыг хүссэн гэдгийг тодотго.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Есүс Ариун Сүмд юу хийж байсан бэ? (Лук 2:46-г үз.)</li> </ul>
Үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдийг босгож зогсоогоод дараах үйл ажиллагааг хэд хэдэн удаа давтан хийлгэ:</p> <p>Залуу Есүс ариун сүмд очлоо (<i>дороо алх</i>) Тэр хүчтэй, өндөр болон өсөн бойжихынхоо өмнө (гараа дээш өргө) Өөрийн Эцэгийн ажлыг хийхийн тул (<i>гараа тэл</i>) Тэр бидэнд хайртай учраас л (өөрийгөө тэвэр)</p>
Түүх	<p>Зураг1-18, Баптисм хүртээгч Иохан Есүст баптисм хүртээсэн нь зургийг үзүүлээд Матай 3:13–17-д өгүүлдэг Есүсийн баптисмын тухай түүхийг ярьж өг. Есүс Тэнгэрлэг Эцэгт хайртай байсан учраас баптисм хийлгэж, Түүнд дуулгавартай гэдгээ харуулсан гэдгийг тайлбарла. Мөн Есүс бидэнд сайн үлгэр жишээ үзүүлэхийг хүссэн юм. Матай 17-г чанга дуугаар (<i>Энэ бол Миний хайртай Хүү</i> гэдгээс эхлэн) унш. Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн үгс байсан гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг маань Есүс баптисм хүртсэнд их сэтгэл хангалуун байсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хэн нэгнийг баптисм хийлгэж буйг та нар харсан уу?</li> </ul> <p>Тэнгэрлэг Эцэгт дуулгавартай байж, Түүнд хайртай гэдгээ харуулах нэг арга зам бол тэд найман нас хүрээд баптисм хийлгэх явдал юм гэдгийг тайлбарла.</p>
Гэрчлэл	<p>Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэдэг гэрчлэлээ хуваалц. Есүсийг хайрлах хайр, Түүнд талархах сэтгэгдлээ хуваалц.</p>

---

**Баяжуулах үйл  
ажиллагаа**

Хичээлийн явцад хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаа-нуудаас сонго.

1. Хичээлд хэрэглэх гурван зургийг доош харуулан ширээн дээр эсвэл өвдөг дээрээ тавь. Нэг хүүхдийг урьж, нэг зураг сонгуул. Ангийнханд сонгосон зургаа харуулж, зурган дээрх түүхийг уншиж өг. Үлдсэн хоёр зургийг мөн адил хий.
2. “Есүсийн тухай түүх яриач” дууны эхний бадгийг дуулах буюу үгийг нь унш. (*Children’s Songbook*, p. 57)
3. Хүүхэлдэй, нөмрөг, алчуур зэрэг энгийн юмс ашиглан, Есүсийн төрсөн үйл явдлаар жүжигчилсэн тоглолт хийхийг урь.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зураг 1-16, Есүс мэндэлсэн нь зургийг үзүүлж, зурган дээрх хүүхэд хэн бэ гэдгийг асуу. Есүс мэндэлсэн тухай түүхийг ярьж өг.

Есүс жаахан хүүхэд хэвээр биш гэдгийг тайлбарла. Тэр өсч том болон, Тэнгэрлэг Эцэгийн хамгийн чухал туслагч нь болсон. Зураг 1-3, Есүс бол Христ зургийг үзүүл. Есүс бидэнд хайртай, олон арга замаар бидэнд үргэлж тусалдаг гэдгийг хэл.

2. Хүүхдүүдийг босч зогсоод дараах үгсийг хэлүүл. Эхний бадгийг хэлэхдээ биеэ хумин доош сууж, хоёр дахь бадгийг хэлэхдээ харин тэнийн суниах хөдөлгөөн хий.

Би жаахан байхдаа жаахан, бүр жаахан  
Би жаахан байхдаа намхан, намхан, намхан байв.

Одоо би өсч том болж байна. Том, том бүр том болж байна  
Одоо би өсч том болж байна. Өндөр, өндөр, өндөр! болж байна.

3. Эх эцгээс нь урьдчилан жаахан байсан үеийнх нь зураг юм уу тоглодог байсан тоглоомыг ав. Эдгээрийг ангийнхандаа үзүүл. Зурган дээрх хүүхдийг буюу тоглоомны эзнийг ол. Тэд жаахан байхдаа энэ зурган дээр байгаа шиг харагддаг байсан эсвэл энэ тоглоомоор тоглодог байсан гэдгийг тайлбарла.

# Тэнгэрлэг Эцэг, Есүс надад хайртай

Хичээл  
**6**

---

**Зорилго** Хүүхэд бүрт Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хайртай гэдгийг мэдрэхэд нь тусал.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Марк 10:13–16; Иохан 3:16; мөн 3 Нифай 17:11–12, 21–24-ийг уншиж суралц.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи ба Мормоны Ном.
  - б. Жижиг толь.
  - в. Зураг 1-1, Дэлхий (62196); зураг 1-3, Есүс бол Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572); зураг 1-4, Анхны Үзэгдэл (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 403; 62470); зураг 1-19, Христ ба Хүүхдүүд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 216; 62467); зураг 1-20, Есүс Нифайн хүүхдүүдийг адислаж байгаа нь.
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл  
ажиллагаа**

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхэд бүртэй гар барь. Хүүхэд бүрийг нэрээр нь дуудаж, танд таалагддаг түүний ямар нэгэн сайн зүйлийг түүнд хэл.

Хүүхдээс түүнийг хайрладаг хэн нэгний нэрийг хэлэхийг хүс. Уг хүний хийсэн юу нь тэр хүүхдийг хайрлагдсан гэдгээ мэдрэхэд хүргэсэн гэдгийг асуу.

Бид нарыг бүгдийг нь хайрладаг хоёр хүний тухай энэ хичээл дээр ярих болно гэдгийг хэл. Тэд бидэнд үзэсгэлэнт дэлхий, сайн мэдээ мөн Сүмийг өгсөн.

- Хүн бүрийг хайрладаг энэ хоёр хүн хэн бэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ)

Түүх

Зураг 1-4, Анхны үзэгдлийг үзүүл. Хүүхдүүдийн тусламжтайгаар зураг ямар түүхийн тухай өгүүлж буйг ярь.

- Энэ зураг дээрх хүмүүс хэн болохыг санаж байна уу?
- Тэд юу хийж байна?

**Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бидэнд адислалуудыг өгсөн**

Дэлхийд ирэхийн өмнө бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй хамт амьдарч байсан гэдгийг сануулан хэл. Тэд биднийг энэ дэлхийд ирж, суралцан, өсөх боломжийг төлөвлөсөн. Тэд бид бүгдийг мэддэг бөгөөд хүн бүрийг анхааран халамжилдаг.

Зураг 1-1, Дэлхийг үзүүл

- Бидэнд зориулан юу бүтээхийг Тэнгэрлэг Эцэг маань Есүс Христээс хүссэн бэ?

Тэнгэрлэг Эцэг маань Есүсийг дэлхий болон түүн дээрх бүх зүйлсийг бүтээхийг хүссэн гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христ биднийг амьдрахад хэрэгтэй бүхнийг мөн аз жаргалтай баяр баясгалантай байх бүхнийг төлөвлөсөн гэдгийг ойлгоход нь тусал. Эдгээр бүгд нь Тэд бидэнд ямар их хайртайг харуулдаг.

- Ямар зүйлс бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн хайрыг сануулдаг вэ? (хариултууд нь гэр бүл, найз нөхөд, Сүм, ургамал ба амьтад гэх зэрэг байж болно.)

Дуу

“Миний Тэнгэрлэг Эцэг надад хайртай” (*Children’s Songbook*, р. 228) дууг хөдөлгөөний хамт дуулах буюу үгийг нь хэл. Дараа нь хүүхдийг босч хамтдаа дуулахыг урь.

Шувуун (*хуруугаараа шувуу хий*) дууг сонсох бүрт (*гараа чихэн дээрээ тавь*)  
Эсвэл хөх тэнгэр (*гараа өргөн хуруунуудаа нийлүүл*) өөд харах бүрт (*дээш хар*)

Нүүрэн дээр минь бороо дуслах үед (*хуруугаараа бороон дусал хий*)  
Эсвэл салхи салхилах үед (*хоёр гараа нааш цааш болгон хөдөлгө*),  
Сарнай цэцэгт хүрэх бүрт (*цэцэг үнэртэж буй дүрслэл хий*)  
Эсвэл хөх ягаан моддын дунд алхах үед (*дороо алх*),  
Тэнгэрлэг Эцэгийн надад зориулан бүтээсэн (*гараа өргөн дэлгэ*)  
Энэ үзэсгэлэнт дэлхийд амьдарч байгаадаа талархдаг.

Зураг 1-3, Есүс Христ үзүүл

- Энэ хэн бэ?
- Есүсийн эцэг нь хэн бэ?

Иохан 3:16 (Хүү гэдэг хэсгийг дуустал) эхний хэсгийг унш. Бидэнд өгсөн Тэнгэрлэг Эцэгийн хамгийн агуу адислал бол Есүс Христийг энэ дэлхийд илгээсэн явдал юм гэдгийг тайлбарла.

### **Есүс Хүүхдүүдэд хайртайгаа харуулсан**

Түүх

Зураг 1-19, Христ ба Хүүхдүүд зургийг үзүүл. Есүс хүүхдүүдийг адисалдаг тухай Марк 10:13–16 дахь түүхийг ярьж өг. Хэдийгээр Түүний зарим дагалдагчид хүүхдүүд Түүнд саад болно гэж бодож байсан ч Есүс цаг гарган хүүхдүүдэд хайраа үзүүлж адислаж байлаа.

- Хүүхдүүдийг ирэхэд Есүс яасан бэ? (Марк 10:16-г үз)
- Есүсийн талаар хүүхдүүд ямар сэтгэгдэлтэй байсан гэж та нар бодож байна?

Дуу

“Есүс бяцхан хүүхдүүдэд хайртай байсан” дууг хүүхдүүдтэй хамт дуул (*Children’s Songbook*, р. 59).

Есүс бяцхан хүүхдүүдэд хайртай байсан  
Багачууд ч Түүнд хайртай байсан  
Тэр тэднийг адисалж тусалдаг байсан  
Тэгээд өвөр дээрээ суулгадаг байв

Түүх

Зураг 1-20, Есүс Нифайчуудын хүүхдүүдийг адисалж байгаа нь зургийг үзүүл. Есүс нас барсныхаа дараа Америк дахь хүмүүс дээр ирсэн. Дэлхий дээр Есүсийн амьдарч байсан газраас Америк маш хол байлаа.

3 Нифай 17:11–12, 21–24-д өгүүлдэг Есүс Нифайчуудын хүүхдүүдийг адисалдаг тухай түүхийг ярьж өг. Тэрээр хүүхэд нэг бүрийг адисалсан гэдгийг тайлбарла.

- Хүүхдүүдэд Есүс хайраа хэрхэн харуулж байсан бэ?
- Есүс чамд хайртай гэдгийг чи яаж мэддэг вэ?

Үйл ажиллагаа

Дараах шүлгийн үгийг хүүхдүүдтэй хамт хэд хэдэн удаа давтан хэлж хөдөлгөөнүүдийг нь хий:

Есүс бүх хүүхдүүдэд хайртай

Жижигхэн бяцхан (*гараараа өвдөгнөөс доош заа*),  
Өлгийтэй хүүхдүүд (*өлгийтэй хүүхэд тэвэрч байгаа мэт үзүүл*)  
Том өндөр хүүхдүүдэд ч (*гараараа толгойгоос дээш*).  
Есүс бүх хүүхдүүдэд хайртай (*гараа тэл*).

(From *Finger Fun for Little Folk* by Thea Cannon. © 1949 by the Standard Publishing Company, Cincinnati, Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

### Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бидэнд бүгдэд нь хайртай

Тэнгэрлэг Эцэг болон Есүст хүн бүр ямар чухал вэ гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Тэнгэрлэг Эцэг болон Есүс биднийг нэрээр нь нэг бүрчлэн мэддэг мөн хайрладаг гэдгийг тайлбарла.

Үйл ажиллагаа

Толио өргөн бариад хүүхдүүдийг нэг нэгээрээ гарч ирэхийг урь. Гарч ирсэн хүүхэд бүр өөрийгөө толинд харж, “Энэ бол (хүүхдийн нэр), Тэнгэрлэг Эцэг болон Есүс (хүүхдийн нэр) маш их хайртай” гэж хэлүүл.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ амьд, тэд бидэнд бүгдэд маань хайртай тухай гэрчлэлээ хуваалц. Тэнгэрлэг Эцэг, Есүсийн танд өгсөн олон адислалуудад талархах сэтгэгдлээ хуваалц.

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. “Есүс бидний Хайрт Найз” (*Children’s Songbook*, р. 58) дууг дуулах буюу үгийг хэл. Хүүхэд бүрт “Есүс бидний Хайрт Найз” (хичээлийн төгсгөлд) өгч, зургийг тараан өгч будуул.
2. “Эцэг минь амьдыг би мэднэ” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 59-р хуудас) дууг дуулах буюу үгийг давтан хэл.
3. Тэнгэрлэг Эцэг, Есүс нарын бидэнд өгсөн зүйлсийг харуулсан зураг үзүүл. Үүнд: Ариун Сүм, амьтад, цэцэгс, гэр бүлүүд, хоол хүнс, найз нөхөд, орон гэр, цуглааны байрууд болон судрууд гэх мэт. (Зурагнуудыг цуглааны байрууд дахь номын сангууд, Ариун сургаалын уран зургийн цуглуулга, сүмийн сэтгүүлүүд зэргээс олж болно). Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд хайртай учраас эдгээрийг өгсөн гэдгийг ойлгоход нь тусал.
4. “Заагч” болгон хэрэглэж болох хоосон ундааны сав ч юм уу өөр зүйлийг авчир. Хүүхдүүдийг тойрог болгон шалан дээр суулгаад, хоосон ундааны саваа голд нь байрлуул. Шалан дээр ундааны саваа эргүүл. Сав



эргэсээр хэн нэгэн хүүхэд рүү заан зогсох үед Тэнгэрлэг Эцэг, Есүсийн хайрыг харуулсан ямар зүйл мэддэгийг хэлүүл. Өөрийнх нь ээлж ирэх үед хүүхэд бүр нэг зүйлийг хэлнэ. Өөрийнх нь ээлж таарч хариултаа өгсний дараа тухайн хүүхэд босч шилийг эргүүлснээр өөр хүүхдийн ээлж ирэх болно.

5. Дэлхий дээр амьдрахад бидэнд зайлшгүй хэрэгтэй зүйлсийг хийсэн жижиг хайрцаг юм уу уут бэлтгэ. Түүн дотор хоол хүнсний зүйлс, ус, хувцас зэрэг байж болно. Тэнгэрлэг Эцэг болон Есүс энэ дэлхийг биднийг амьдрахад зориулан бүтээсэн гэдгийг тайлбарла. Энэ хайрцаг эсвэл уутанд бидэнд дэлхий дээр амьдрахад зайлшгүй хэрэгтэй зүйлсийн нэгээхэн хэсэг буйг хэл. Байгаа зүйлээс аль нэгнийх нь тухай товчхон мэдээлэл өгч юуны тухай ярьж буйгаа хүүхдүүдээр таалга. Таасны дараа гаргаж үзүүл. Хүүхдүүдээр саванд байгаа бүх зүйлсийг таатал тоглоомыг үргэлжлүүл.
6. *Тэнгэрлэг Эцэг, Есүс надад хайртай* гэсэн бичигтэй энгэрийн зүүлт хий. Хүүхэд бүрт зүүлгэ. Зүүлтээ гэртээ авч харьж болно. Зүүлтийг хүүхдийн энгэрт зүүх, хүзүүнд нь зүүж өгөх эсвэл цүнхэн дээр нь хатгаж болно. Уг зүүлтийг хичээл эхлэхээс өмнө хүүхэд бүрийн суудал дор нууж болно. Дараа нь тэднээр олуулж болох юм.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Дараах үгсийг давтан хэлүүлж, үйлдлийг хийлгэ:

Хэрэв чи маш их өндөр бол (*гараа өргөн дээш сунга*),  
Сүмд чамд зориулсан газар бий.  
Хэрэв чи маш намхан бол (*доош бол*),  
Сүмд чамд зориулсан газар бий.

Өндөр (*дээш суна*),  
Намхан (*доош бол*),  
Өндөр (*дээш суна*)  
Намхан (*доош бол*)—

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бүгдэд нь хайртай.

2. Дараах үгсийг хэлүүлж, үйлдлийг хийхэд нь хүүхдүүдэд тусал:

Тэнгэрлэг Эцэг намайг мэднэ

Тэнгэрлэг Эцэг намайг мэддэг (*өөр лүүгээ заа*)  
Намайг юу хийх дуртайг мэддэг.


Тэр миний нэрийг мэднэ, хаана амьдардгийг минь мэднэ (*хоёр гараа дээш өргөн хурууны үзүүрүүдийг нийлүүлэн дээвэр хий*).

Тэр надад хайртай гэдгийг би бас мэднэ (*хоёр гараа зөрүүлэн мөрөн дээрээ тавь, тэвэрч байгаа мэт*).

Тэр намайг юунд баярладгийг мэднэ (*хуруунуудаа инээмсэглэсэн урууландаа хүргэ*)

Тэр намайг юу гунигтай болгодгийг ч мэднэ (*урвайсан урууландаа хуруугаа хүргэ*)

Тэр надад туслахыг хүсч байгааг би мэднэ (*өөр лүүгээ заа*),  
Энэ нь намайг баярлуулдаг!



Есүс Бидний Хайрт Найз

---

**Зорилго**

Ариун Сүнс бидэнд тусалдаг гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

---

**Бэлтгэл**

1. Иохан 14:16–17; 2 Нифай 32:5; Моронай 10:4–5; ба Сургаал ба Гэрээ 39:23; 130:22-г залбиралтайгаар уншиж судал. Мөн сургаалын зарчмууд (31110), бүлэг 7-г үз.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи, Сургаал ба Гэрээ
    - б. Уут юм уу танил зүйлсийг хийх сав, хайрцаг
    - в. Зураг 1-3, Есүс бол Христ (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 240; 62572); зураг 1-4, Анхны үзэгдэл (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 403; 62470)
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ
- 

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хэн нэгэн хүүхдийг өөр дээрээ ирэхийг урь. Дуудаж гаргасан хүүхдийнхээ чихэнд Ариун Сүнсний тухай ямар нэгэн зүйл шивнэн хэл. Жишээ нь: “Ариун Сүнс Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд тусалдаг” гэж. Ангид байгаа хүүхэд бүрийг дуудан хий (Ингэхдээ нэг зүйлийг хүүхэд бүрт хэлж болно.) Өнөөдөр хэний тухай ярьж байгааг хүүхдүүд мэдэж байгаа эсэхийг асуу. Тэнгэрлэг Эцэгийн мөн Есүсийн туслагч Ариун Сүнсний тухай ярих болно гэдгийг тайлбарла.

Зураг 1-4, Анхны үзэгдэл зургийг үзүүл. Тэнгэрлэг Эцэг, Есүс нарыг зааж, Тэд бидэнтэй адил бие махбодтой гэдгийг тайлбарла. Ариун Сүнс нь Тэнгэрлэг Эцэг, Есүс нартай олон зүйлээрээ адилхан. Тэр бидэнд хайртай бас бидэнд тусалдаг. Гэвч Түүнд Тэнгэрлэг Эцэг, Есүстэй адил бие махбод байхгүй. Тэр бол сүнсэн биетэй. Тиймээс тэр чимээгүй нам гүмээр бидний оюун ухаанд санаа өгч, бидэнд аз жаргал амар амгаланг мэдрүүлж чаддаг.

**Ариун Сүнс бидэнд амар амгаланг өгч тусалдаг**

- Чамайг гомдсон эсвэл сэтгэлээр унасан үед чинь ээж аав нар нь та нарыг хэрхэн тайвшруулж сэтгэл санааг чинь сайхан болгодог вэ?

Зураг 1-3, Есүс бол Христ зургийг үзүүл. Есүс өөрийн дагалдагчид, Түүний туслахууд Түүнийг нас барсны дараа уйтгарлан гуниглах болно гэдгийг мэдэж байсан тул Тэр Тэнгэрлэг Эцэгээс тэднийг Тайвшруулагчийг илгээхийг хүссэн (Иохан14:16–17-г үз).

Тэр Тайвшруулагч нь Ариун Сүнс бөгөөд Тэр бас биднийг тайвшруулдаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Биднийг уйтгар гунигтай байхад Тэнгэрлэг Эцэг маань бидэнд Ариун Сүнсийг илгээн тайтгаруулдаг гэдгийг тайлбарла.

Түүх

Бидэнд тусламж хэрэгтэй үед Ариун Сүнс биднийг удирдан чиглүүлж анхааруулдаг гэдгийг тайлбарла. Сүмийн арван нэг дэх Ерөнхийлөгч асан Харольд Б. Лийгийн залуу насны нэгэн түүхийг өөрийн үгээр ярьж өг:

“Би найман настай юмуу түүнээс ч бага байсан байх аав маань нэлээд зайтай хөдөө ферм дээр намайг аваачсан юм. Түүнийг ажиллаж байх үед жаахан эрэгтэй хүүхэд бүрийн хийдэг юмсаар өөрийгөө саатуулдаг байлаа. Нэгэн халуун шороотой өдөр би бүр ядартлаа тоглосон байв. Хашааны нөгөө талд байгаа эвдэрч хуучирсан саравч миний анхаарлыг ихэд татлаа. Энэ саравчаар цайз хэрэм хийж тоглож болох юм байна гэсэн бодол толгойнд минь орж ирэв. Тэгээд би хашаа руу очиж нөгөө талд нь гарахаар авирч эхлэв. Гэтэл нэгэн дуу хоолой надад “Харольд битгий тийшээ яв” гэж хэлэхийг би тод сонслоо. Би эргэн тойрныг харж, хэн миний нэрийг дуудан хэлэв хэмээн гайхан харав. Миний аав их хол, талбайн нөгөө талд байлаа. Тэр намайг юу хийж буйг харах боломжгүй байв. Надтай ярих хэн ч эргэн тойронд харагдахгүй байлаа. Дараа нь би миний харж чадахгүй хэн нэгэн надад анхааруулан үүн дээр авирч болохгүй хэмээн хэлснийг ойлгов. Тэнд юу байсныг би хэзээ ч мэдэж чадахгүй. Гэхдээ бидэнд үзэгдэхгүй нэгэн зүйл байдаг гэдгийг багаасаа ойлгож мэдсэн юм.” (Мексик Хот дахь Мексикийн Бүсийн Ерөнхий Чуулган, 1972 он, 48–49-р хуудас).

Заримдаа Ариун Сүнс чангаар шивнэдэг яг л Ерөнхийлөгч Харольд Б.Лийд тохиолдсон шиг гэхдээ ихэвчлэн бидэнд хийж болох эсвэл хийж болохгүй гэсэн чимээгүй мэдрэмжийг өгдөг гэдгийг хэл.

### **Ариун Сүнс бидэнд зөвийг сонгоход тусалдаг**

Ариун Сүнс бидэнд хайртай мөн бидэнд зөвийг сонгоход маань тусалдаг. Хүүхдүүдийг зөвийг сонгон хийж байсан зүйлсийнхээ талаар бодохыг хүс. Жишээ нь: Эцэг эхийнхээ үгэнд дуулгавартай байх, бусдад туслах, өөрсдийн залбирлаа хэлэх зэрэг.

- Зөвийг хийхэд та нарт ямар мэдрэмж төрдөг вэ?
- Та нар буруу зүйл хийхэд ямар мэдрэмж мэдэрдэг вэ?

Ариун Сүнс биднийг зөвийг сонгох үед халуун дулаан сайхан мэдрэмжийг мэдрүүлж харин буруу зүйл хийх үед уйтгар гунигтай мэдрэмж төрүүлдэг гэдгийг тайлбарла.

Хүүхдүүдээр хэн нэгэнд туслаад юмуу зөв сонголт хийснээр сайхан дулаан мэдрэмж мэдэрсэн тухайгаа ярьж хуваалцахыг хүс. Тэднийг Ариун Сүнсний нөлөөг мэдрэхэд нь тусал.

Дуу

Хүүхдүүдтэй хамт “Сонс, сонс” (*Children’s Songbook*, p. 107) дууг дуул.

Намуухан шивнээг сонс!

Сонс! Сонс! Сонголт хийх үедээ сонс.

Тэр чамайг үргэлж чиглүүлэх болно

### **Ариун Сүнс бидэнд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ бодит хүмүүс гэдгийг мэдэхэд тусалдаг**

Ариун Сүнс бидэнд ямар нэгэн зүйлийн бодит үнэн эсэхийг мэдэхэд тусалдаг. Хүүхдүүдэд эд зүйлс хийсэн уутаа харуул. Хүүхдүүдэд доторх зүйлсийг нь харуулахгүйгээр энэ дотор ямар нэгэн зүйл байгаа гэдгийг хэл.

- Энэ уутанд юм байгаа юу?

Хэдийгээр хүүхдүүд доторх зүйлсийг нь хараагүй боловч уутан дотор юм байгаа гэж мэдэж байгаа. Учир нь багш тэнд юм байгаа гэж хэлсэн тул тэд мэдэж байгаа гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг, Есүсийг цөөхөн хүмүүс харсан боловч Ариун Сүнс бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр бодит амьд бөгөөд бидэнд хайртай гэдгийг мэдэхэд тусалдаг. Энэ мэдлэгийг *гэрчлэл* гэж нэрлэдэг гэдгийг тайлбарла. Заримдаа хүмүүс Сүмийн цуглаанууд дээр гэрчлэлээ хуваалцаж, Есүс тэдэнд хайртай гэдгийг мэддэг гэдгээ хэлдэг. Ариун Сүнс эдгээр хүмүүст үнэн гэдгийг мэдэхэд тусалсан.

### **Бид Ариун Сүнсний Бэлгийг хүлээн авч чадна**

Өөрийн усан баталгаа хийлгэсэн, ариун сүнсний бэлэг хүртсэн талаараа ярь. Санваартан ах таны толгой дээр гараа тавин Ариун Сүнсний бэлэг хүртээхэд юу мэдэрсэн талаар ярь.

Чангаар Сургаал ба Гэрээ 39:23-г *Ариун Сүнс* гэдгийг дуустал унш. Хүүхдүүд найман нас хүрэхэд баптисм хийлгэж, ариун сүнсний бэлэг хүртдэг. Тэд Ариун Сүнсний бэлэг хүлээн авна. Ариун Сүнсний бэлэг нь баптисм хийлгэхэд хийсэн гэрээнүүдийн амлалтуудыг сахихад тэдэнд тусалдаг.

Гэрчлэл

Ариун Сүнсэнд талархах сэтгэгдлээ хуваалц. Ариун Сүнс хэрхэн таныг тайвшруулж зөвийг сонгоход тусалдаг талаар хэл.

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлийн явцад хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдүүдэд “Намуухан зөөлөн дуу” (*Children’s Songbook*, р. 106) дууг дуулахад болон үгийг хэлэхэд тусал.
2. Бусдад тусалж, бусадтай хуваалцан сайн үйлс хийж байгаа хүмүүсийн зурагнуудыг үзүүл. Сайн үйлс хийхдээ тэд ямар мэдрэмжтэй болдог талаар асуу. Хүмүүс заримдаа ээждээ тусалдаг боловч ах нартайгаа тоглоомоо булаацалдан, муудалцан зодолдож аав ээжийнхээ үгэнд орохгүй байх зэрэг сайн, муу үйлс хийдэг талаар ярь. Сайн үйлсийн талаар ярихад хүүхдүүд инээмсэглэж, муу үйлсийн талаар ярихад хөмсөг зангидах үйлдэл хийлгэ.
3. Намуухан дуу хоолойгоор “Миний дуу хоолойг сонсож чадах хүн бүхэн хуруугаа хамартаа хүргэ” гэж хэл. Үргэлжлүүлэн хүүхдүүдэд биеийн хэсгүүддээ хүрэхийг бүгд таны намуухан дуу хоолойг сонсон дагатал хэл. Хэдийгээр намуухан дуу хоолойгоор хэлж байсан ч хүүхдүүд түүнийг анхааралтай чагнахад уг дуу хоолойг сонсож, зааврыг дагаж чадаж байна гэдгийг тайлбарла. Ариун Сүнс бидэнтэй намуухан дуу хоолойгоор ярьдаг гэдгийг хэл. Хэрэв бид анхааралтайгаар сонсох юм бол Ариун Сүнс бидэнд чухал зүйлс хэлдэг.
4. Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф тухай түүхийг өөрийн үгээр ярьж өг:

Нэгэн орой Ерөнхийлөгч Вудрафф, эхнэр дөрвөн хүүхдийн хамт аялал хийж яваад найзынхаа гэрт хоноглохоор зогсчээ. Гурван хүүхэд нь байшин дотор унтаж, харин нэг хүүхэд нь гадаа тэргэнд ээж аавынхаа хамт унтжээ.

Ерөнхийлөгч Вудрафф хэлэхдээ: “Би орондоо ороод удаагүй байтал нэгэн дуу хоолой надад: “Бос, түргэн гарч тэргээ хөдөлгөн өөр газар аваач” гэж хэлэв. Энэ дуу хоолой аянга, цахилгаан юм уу газар хөдөлж байгаа чимээ байсангүй. Харин Бурханы Сүнс – Ариун Сүнсний намуухан дуу хоолой байлаа. Би хурдхан босч, тэргээ хөдөлгөж, байшингийн дэргэд авчирлаа. Намайг эргэн орондоо орох үед Ариун Сүнс надад, “Яв. Өөрийн луусыг царс модноос холдуул”. . . гэв. Би тэднийг залуу пеканы модон төгөлд аваачин уяв. Дараа нь би орондоо орлоо. Хагас цаг орчмын дараа хуй салхи салхилж луус байсан царс модыг үндсээр нь таслан, 100 метр хиртэй газар шидэн, замдаа хоёр хашааг нураан эвдэж, зөөврийн байр байсан газарт хаягдав. Би Бурханы Сүнсний илэрхийллийг дуулгавартайгаар дагаж эхнэр хүүхдүүд болон лууснуудынхаа амийг аварсан юм.” (“Leaves from My Journal,” *Millennial Star*, 1881 он, 12 сарын 12, 790–791-р хуудас).

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Энэ хичээлийг заахаас долоо хоногийн өмнө хүүхдийн эх эцгээс хүүхдийн дуртай зүйлийг ангид авчруулахыг хүс. Энэ нь онцгой хөнжил эсвэл тоглоом, онцгой дуу байж болно. Зарим нь авчрах боломжгүй юм уу мартсан байж болох тул урьдчилан бэлтгэсэн зүйлс авчир.

Ангид авчирсан эдгээр зүйлс тэдэнд хэрхэн хайрлагдаж, аюулгүй, найдвартай, хайрлагдсан сайхан сэтгэгдэл төрүүлдэг талаар ярилц. Тэнгэрлэг Эцэг болон Есүсийн нэгэн онцгой туслагч бидэнд аюулгүй, найдвартай хайрлагдсан сайхан мэдрэмжийг мэдрүүлж чадна гэдгийг тайлбарла. Заримдаа бид түүнийг Тайтгаруулагч гэж нэрлэдэг. Учир нь Тэнгэрлэг Эцэг түүнийг биднийг уйтгар гунигтай санаа зовсон үед хамт байлгахгаар илгээсэн. Энэ бол гайхамшигт найз, Ариун Сүнс юм.

2. “Намуухан зөөлөн дуу” (*Children’s Songbook*, р. 106) дууг хамт дуулах буюу үгийг хэлж, үйлдлийг хий:

Сонс, сонс (*алгаа аяга мэт болгон чихэндээ барь*).

Ариун Сүнс шивнэх болно (*долоовор хуруугаа уруулдаа хүргэ*).

Сонс, сонс (*алгаа аяга мэт болгон чихэндээ барь*).

Намуухан дуу хоолойг сонс (*гараа зүрхэн дээрээ тавь*).

# Өдөр болон шөнийг өгсөнд би талархдаг

## Зорилго

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу Есүс Христ өдрийг бүтээснээр бид тоглож мөн ажиллаж, амарч болохын тул шөнийг бүтээсэн гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Эхлэл 1:1, 3–5, 14–18; Хиламан 14:1–13; ба 3 Нифай 1:15–23-г уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи, Мормоны Ном.
  - б. Нар, хайчилбар 1-1; сар, хайчилбар 1-2; одод, хайчилбар 1-3 (адил төстэй хайчилбаруудыг Хүүхдийн хэсгийн үзүүлэн, хайчилбар, 3-р хэсгээс ол).
  - в. Зураг 1-21, Лемен үндэстэн Самуел хэрмэн дээр (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 314; 62370).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Тэнгэрлэг Эцэг төлөвлөн Есүс бүтээсэн нэгэн зүйлийн тухай бод гэж хүүхдүүдэд хэл. Хүүхдүүдээр юун тухай бодож байгаагаа таалга. Нэг нэгээр нь дараах санаануудыг өг:

1. Тэр биднийг дулаацуулдаг
2. Тэр дугуй бас шар өнгөтэй
3. Тэр тэнгэрт байдаг
4. Заримдаа энэ нь үүлний цаагуур, уулсын араар нуугддаг

Хүүхдүүдийг “Нар” гэж таасных нь дараа нарны зурагтай хайчилбарыг гаргаж үзүүл.

- Хэн нарыг хийсэн бэ?

### Бид өдөр ажиллаж бас тоглодог

Түүх

Эхлэл 1:1, 3-5-д өдөр шөнийг бүтээсэн тухай, Эхлэл 1:14–18 дахь нар, сар, оддыг бүтээсэн тухай түүхүүдийг ярьж өг.

- Хэн өдөр, шөнийг бүтээсэн бэ?
- Тэнгэрлэг Эцэг Есүст өдөр бол гэж тэнгэрт юуг тавь гэж хэлсэн бэ?

Нар бидэнд харах гэрлийг өгдөг гэдгийг хэл. Нар мөн бүгдийг дулаацуулж, ургамал ногоог ургахад тусалдаг. Наргүйгээр бид дэлхий дээр амьдарч чадахгүй.

- Нар гардаг үеийг бид юу гэж нэрлэдэг вэ? (Өдөр.)

Өдрийн турш бид олон зүйлийг хийж чадна гэдгийг тайлбарла. Бид ажиллаж, тоглож, мөн бусдад тусалж чадна.

Үйл ажиллагаа

Хүүхдүүд өдөр юу хийдэг талаар ярилц. Жишээ нь, хоол идэх, тоглоом тоглох, шалаа шүүрдэх гэх мэт. Хүүхдүүдийг босон, хийдэг зүйлүүдээ дүрслэн үзүүлэхийг урь. Тэдэнтэй хамтдаа зарим үйлдлийг хийж болно.

- Өдрийн турш та хэн нэгэнд яаж тусалж чадах вэ? (тоглоомоо хураах, аяга тавгаа угаах, дүү нартайгаа тоглох зэрэг)

### **Бид шөнө амардаг**

- Нарыг бид дандаа хардаг уу?

Үдэш бүр нар жарган орой болж, харанхуй болдог гэдгийг тайлбарла. Бид шөнийн цагт нарыг харж чадахгүй.

- Харанхуй байх цаг хугацааг бид юу гэж нэрлэдэг вэ? (Шөнө)
- Шөнийг гэрэлтүүлэхийн тул тэнгэрт юуг тавь гэж Тэнгэрлэг Эцэг Есүст хэлсэн бэ? (сар, одод)

Нарны хайчилбартай хамт сар болон оддын хайчилбараа тавь гэж хүүхдүүдэд хэл.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээр шөнийн цагт хийдэг зарим зүйлсийг хэлэх юм уу үйлдлээр үзүүлэхийг урь. Жишээ нь: Оройн залбирлаа хийх, түүх сонсох, шүдээ угаах мөн унтах зэрэг.

Эмч нар, сувилагчид, гал сөнөөгчид зэрэг зарим хүмүүс шөнийн цагаар ажилладаг боловч ихэнх хүмүүс шөнө унтдаг гэдгийг тайлбарла. Мөн олон амьтад ч шөнийг унтаж өнгөрүүлдэг.

- Яагаад бид унтдаг вэ?

Унтах нь бидний бие махбодид сайн зүйл гэдгийг ойлгоход нь тусал. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ биднийг өөрсдийн биеэ сайн арчлаасай гэж хүсдэг. Хэрэв бид сайн унтаж амрах юм бол илүү эрүүл энх байж, сайхан байх болно. Хэрэв бид сайн унтаж амрахгүй бол ядруу дорой, баяр баясгалангүй байх болно.

Танай орон нутагт жилийн дөрвөн улиралд өдөр шөнийн үргэлжлэх хугацаа өөр өөр байдаг бол түүнийг тайлбарлаж өг. Заримдаа өдөр нь урт, заримдаа шөнө нь урт үргэлжлэх улирал байж болно гэдгийг хэл. Бидний аав ээж нар орондоо орох цаг эсвэл босох цаг болсныг бидэнд хэлж тусалдаг.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босгон зогсоож дараах хуруугаар үзүүлэх тоглоомыг тоглуул: Энэ бяцхан найз

Энэ жижигхэн найз маань орондоо орохоор явж байна (*нэг хуруугаа өргө*). Дэрэн дээрээ толгойгоо тавилаа (*нөгөө гарынхаа алган дээр хуруугаа тавь*). Хөнжилд өөрийгөө ороогоод (*эрхий хуруугаа бусад хуруунуудаараа ороо*), Ингэж тэр шөнөжин унтдаг.



Өглөө болж тэр нүдээ нээлээ.  
Хөнжлөө сөхөн өндийж (*хуруунуудаа нээ*).  
Удалгүй босч хувцсаа өмсөн явахаар бэлдэж (*хуруунууда өргө*)  
Инээмсэглэж, ажиллаж тоглоход бэлэн боллоо.

### **Тэнгэрлэг Эцэг өдөр, шөнийг Есүсийн мэндэлснийг зарлахын тул хэрэглэсэн**

Түүх

Тэнгэрлэг Эцэг өдөр ба шөнийг Есүсийн төрөлтийн талаар хэлэхэд ашигласан гэдгийг хэл. Зураг 1-21, Лемен үндэстэн Самуел хэрмэн дээр зургийг үзүүлж зурган дээрх юу болж байгааг ярьж өг. Бошиглогч Самуел Есүсийг төрөх үед тэнгэрт юу болох тухай Нифайчуудад хэлснийг тайлбарла. Нар жаргасан ч гэсэн тэнгэрт харанхуй болохгүй байх болно гэж тэр хэлсэн. Олон хүн Самуелд итгээгүй хэдий ч энэ бүгд биелсэн гэдгийг тайлбарла. (Хиламан 14:1–13 ба 3 Нифай 1:15–23-ыг үз).

Нифайчууд болон Леменчүүд амьдардаг алс холын Америкт Есүс мэндэлсэн явдал нь чухал зүйл байлаа. Тэнгэрлэг Эцэг Есүс мэндэлсэн шөнийг онцгой болгохын тул өдөр мэт гэгээтэй болгосон.

- Лемен үндэстэн Самуел ямар чухал зүйлийн тухай хүмүүст хэлсэн бэ?
- Есүсийн мэндлэх шөнө Нифайчууд тэнгэрт ямар онцгой зүйлийг харсан бэ?

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг бидэнд туслахын тул Есүс Христээр өдөр болон шөнийг бүтээлгэсэн тухай гэрчлэлээ хуваалц. Тэнгэрлэг Эцэгт өдөр ба шөнө бүтээж өгсөнд талархлаа илэрхийлэхийг дэмжин урамшуул.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго:

1. Цэвэр цагаан цаас, тал хар эсвэл хар хөх цаас хүүхэд бүрт хүрэхээр бэлтгэ. Өдөр шөнийг төлөөлж, цагаан цаасны нэг хагаст хар цаасаа наа. Цаасаар нар, сар хайчлуулан зохих газар нь наалга. Одод хайчилж мөн наа. Хүүхэд бүрийн цаасан дээр *Би өдөр, шөнө байдагт талархаж байна* гэж бич.
2. Хүүхдүүдтэй хамт “Дэлхий маш том” (*Children’s Songbook*, р. 235) дууны хоёрдугаар бадгийг дуул. “Дэлхий маш том” дууны үгний үйлдлийг хий:  
*Дэлхий маш том, өө, дув дугуй (гараараа том дугуй хий),  
Энд Бурханы бүтээлүүд дүүрэн байдаг,  
Шөнийн турш одод гялалзаж (гараа өргөн хуруунуудаа хөдөлгө),  
Өдөр нар дулаацуулж, гэрэлтэй болгодог (гараараа том дугуй хий).  
Дэлхий маш том, өө, дув дугуй.  
Бурхан бид бүгдэд нь хайртай, бидний адислал агуу их (гараа атган өөрийгөө тэвэр).*
3. “Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, р. 253) дууг хүүхдүүдийн өөрсдийнх нь үгийг ашиглан дуул. Бадаг бүрийг дуулахын өмнө хүүхдүүдээс дуунд гарч буй зүйлс өдөр шөнийн хэзээ нь болдгийг асуу. Дуунд гарч буй үгсийн үйлдлийг хий.

4. Өдөр дуусах үед гадаа тоглож байсан ах, дүү хоёрын тухай түүхийг зохион ярилц. Ангийн хүүхдүүдийн мэддэг нэрийг ашиглан танил нөхцөл байдлыг хэрэглэ. Хүүхдүүд өдрийг дуусах үед юу хийдэг талаар ярилц. Нар жаргаж, тэдний ээж нар нь гэртээ орохыг сануулж, хүүхдүүд шаардлагатай гэрийн ажлаа хийж, цэвэрлэгээ угаалгаа хийн, оройн хоолондоо бэлэн болж, аягаа угаахад туслан, орондоо ороход бэлтгэн, оройн түүхээ сонсож, оройн залбирлаа хийх зэрэг жижиг сажиг зүйлсийн талаар ярилц. Ах дүү (эгч дүү) болон бусад хүмүүс, шувууд, шавьж хорхойнууд, амьтад хэрхэн чимээгүй болж, унтдаг тухай ярилц.

Шөнийн турш бидний бие амарч, бид эрүүл чийрэг, хүчтэй байхын тул нүдээ анин унтдаг гэдгийг ойлгоход тусал. Энэ бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг.

Хайчилбар хийж, түүх зохион ярилц. Эсвэл өөрсдөө түүх зохион хүүхдүүдээр жүжигчлэн тоглуул.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хайчилсан нар, сар, оддыг хүүхдүүдэд үзүүл. Дараах асуултуудыг асуу:

- Эдгээр зүйлсийг бид хаана хардаг вэ?
- Бид шөнө нарыг харж чадах уу?
- Өдөр бид оддыг харж чадах уу?

Тэнгэрлэг Эцэг нарыг өдрийн турш гэрэл өгч, биднийг дулаацуулахын тулд харин сар ба оддыг шөнийг гэрэлтүүлэхийн тул Есүсээр бүтээлгэсэн гэдгийг тайлбарла.

2. Та үгийг хэлэх зуур хүүхдүүд хөдөлгөөнийг хийхэд нь тусал:

Бурханы Бүтээл

Бурхан сарыг бүтээсэн (*гараараа тойрог хий*)

Анивчих оддыг (*алгаа атгаж, нээ*)

Тэдгээрийг тэнгэрт тавьсан (*дээш суна*).

Тэр нарыг (*толгой дээрээ хоёр гараараа тойрог хий*)

Мөн моддыг (*гараа эгц өргө*)

Мөн цэцэгсийг (*алгаа аяга хэлбэртэй болго*)

Нисч буй бяцхан шувуудыг бүтээсэн (*гараараа дэв*).

(From *Fascinating Finger Fun* by Eleanor Doan. © 1951. Зөвшөөрлийн дагуу ашиглав.)

# Ус байгаад би талархдаг

## Зорилго

Бидэнд ус өгсөнд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нарт талархаж байгаагаа мэдрэхэд нь туслах.

## Бэлтгэл

1. Эхлэл 1:9–10; Египетээс гарсан нь 17:1–6; ба Матай 3:13–17-г залбиралтайгаар уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Хэрэв боломжтой бол төрөл бүрийн гол, нуур, далай тэнгис харуулсан зурагнуудыг бэлтгэ.
  - в. Зураг 1-8, Ариун ёслол хүртээж байгаа нь (62021); зураг 1-11, Баптисм хүртэж буй хүү (62018); зураг 1-18, Баптисм хүртээгч Иохан Есүст баптисм хүртээсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 208; 62133).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Нэг хүүхдийг ангийн өмнө гарч ирэхийг урь. Түүний чихэнд нь ус хэрэглэдэг үйлдлүүдээс шивнэ. Жишээ нь: Шүд, гараа угаах мөн ногоо услах. Хүүхэд өөрийн сонссон зүйлээ үйлдлээр үзүүлж, бусад хүүхдүүдээр түүнийг нь таалга. (Хүүхдэд яаж үзүүлэх үйлдэл бүрийг та харуулж болно). Хүүхэд бүрээр үйлдэл хийлгэ.

Дээрх үйлдлүүдийг хийхэд ус заавал хэрэглэж буйг тодотго. Тэнгэрлэг Эцэг болон Есүст ус өгсөнд нь бид талархах ёстой гэдгийг хэл.

### Ус нь Бүтээлтийн гол хэсгийн нэг байсан

Эхлэл 1:9–10-г чанга дуугаар уншаад хүүхдүүдэд тайлбарлаж өг.

- Ус яагаад бидэнд чухал вэ?
- Бид усыг яаж авдаг вэ?

Ус нь олон янзын газраас ирдэг гэдгийг ойлгоход нь тусал. Жишээ нь: Нуур, гол, далай тэнгисээс, бороо болон цаснаас гэх мэт. Цас мөс нь хөлдсөн ус гэдгийг хэл. Өөрийн авчирсан олон янзын усны зурагнуудаа үзүүл. Танай орон нутагт ус хаанаас ирдэг талаар ярилц.

Ус нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг байсанд маш их талархалтай байдгаа хэл.

Дуу

“Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, p. 253) дууг дуул. Дууны үгийн дагуу ус ашиглан хийдэг зүйлсийг хэлэхийг урь. Жишээ нь: Хувцсаа угаах, усанд орох, шүдээ угаах. Дууны үгийн дагуу хөдөлгөөн хий.

Хувцсаа угаах нь гоё  
Гоё, гоё, гоё доо!  
Хувцсаа угаах нь гоё  
Гоё, гоё, гоё доо!

(© 1963 by D. C. Heath and Company. Зөвшөөрлийн дагуу дахин хэвлэв.)

### **Олон зүйлд ус заавал хэрэгтэй**

- Яагаад бидэнд ус хэрэгтэй вэ? Үүнийг юунд хэрэглэдэг вэ?

Хүмүүс, амьтад, ургамал, амьд бүхэнд амьдрахад нь ус заавал хэрэгтэй гэдгийг тайлбарла. Хэрэв боломжтой бол хүүхэд бүрт жижиг аягатай ус өгч уулга. Бид усгүйгээр амьдарч чадахгүй талаар ярь.

- Ургамал болон амьтад өөрсдөдөө хэрэгтэй усыг яаж олдог вэ?

Бидэнд хоол хийх, угаалга хийх зэрэгт мөн ус хэрэгтэй болдгийг тайлбарла.

### **Есүс, Мосе болон Израилчуудад элсэн цөлд байхад нь ус өгсөн**

Түүх

Мосе хаднаас ус гаргасан тухай Египетээс гарсан нь 17:1-6 дахь түүхийг ярьж өг. Хүмүүс халуун, хуурай элсэн цөлд байсан гэдгийг тайлбарла. Тэнд ус байсангүй.

- Израилчууд усгүй байсан бол яах байсан бэ?
- Та нар маш их цангаж үзсэн үү? Та нар цангасан үедээ хүйтэн ус уухад ямар санагддаг вэ?

### **Сүмд ус нь чухал зүйлийн нэг**

Түүх

Зураг 1-18, Баптисм хүртээгч Иохан Есүст баптисм хүртээсэн нь зургийг үзүүл. Есүсийн баптисмын тухай Матай 3:13–17 дахь түүхийг ярьж өг.

- Есүс хаана баптисм хийлгэсэн бэ?
- Есүс яаж баптисм хийлгэсэн бэ?

Зураг 1-11, Баптисм хүртэж буй хүү, зургийг үзүүл.

- Бид найман нас хүрээд хаана баптисм хийлгэдэг вэ?
- Та нар хэн нэгнийг баптисм хийлгэж буйг харсан уу?

Баптисмын ажиллагаа үзсэн тухай хүүхдүүдээр чөлөөтэй яриул. Бид баптисм хийлгэхэд ус заавал шаардлагатай гэдгийг тайлбарла.

Зураг 1-8, Ариун Ёслол түгээж буй нь зургийг үзүүл.

- Бид усыг Ариун Ёслол дээр хэрхэн хэрэглэдэг вэ?

Баптисм хийлгэж, Ариун ёслолоос хүртэх боломжийг өгдөг усанд талархаж буйгаа хэл.

Гэрчлэл

Бидэнд усыг өгсөн Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө, хайранд талархалтай байдаг гэрчлэлээ хуваалц. Тэнгэрлэг Эцэг, Есүсийн энэхүү гайхамшигт бэлэгт маш их талархдаг гэдгээ хэл.

---

**Баяжуулах үйл  
ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Доорх дууны үгсийг хүүхдүүдтэй хамт хэлж, үйлдлийг хий:  
Бороон Дуслууд  
Цэцэгс цангаж  
Навчис хатахад (*гараа дэлгэн, дээш сунга*),  
Хөгжилтэй бороон дуслууд  
Тэнгэрээс дусална (*хуруунуудаа хөдөлгөн, гараа доош болго*).  
Бүгдийг усаар норгон (*хуруугаараа хөдөлгөн энд тэнд заа*)  
Өөрсдийн хөгжилтэй тоглоомоо тоглоно  
Нар мандан гарч (*гараа дээш өргөн тойрог хий*)  
Тэдгээрийг хөөн зайлуулна (*гараа ардаа нуу*).
2. Хүүхдүүдээр ус зуруул. Гол, нуур, далай тэнгис, борооны дусал гэх мэт. Хүүхэд бүрийн цаасан дээр *Би ус байгаад талархаж байна* гэж бич.
3. Усан дотор яаж тоглодог талаар ярих юм уу биеэр дүрслэн үзүүлэхийг хүүхдүүдээс хүс. Үүнд: усанд сэлэх, тэшүүрээр гулгах, цасан өвгөн хийх болон шалбааг цацаж тоглох зэрэг.
4. Ус цэвэрлэгээ хийхэд тусалдаг гэдгийг ойлгоход нь тусал. Хувцсаа угаах, гараа угаах зэрэг ус ашигладаг цэвэрлэх үйлдлүүдийг дүрслэн үзүүлэхийг хүс.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Ус хэрэглэдэг янз бүрийн арга замуудын талаар суралцахад нь туслах дараах үйлдлүүдийг хий:
  - а. Хүүхэд бүрт уух жаахан ус өг. Хүүхдүүд ус ууж байх зуур ус нь Тэнгэрлэг Эцэгийн дэлхийд зориулан бүтээсэн нэгэн гол хэсэг гэдгийг сануул. Бид цангасан үедээ ус уудаг.
  - б. Түмпэнд бага зэрэг ус хий. Хүүхэд бүрийг түүнд гараа угаахыг урь. Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд ус өгсөн гэдгийг хэл. Бид юмаа угаахын тул ус хэрэглэдэг гэдгийг тайлбарла.
  - в. Хэрэв боломжтой бол гадагш гарч, хүүхэд бүрээр зүлэг услуул. Эсвэл ангид таримал ургамал авчирч хүүхэд бүрт услах боломжийг өг. Ургамал амьдран ургахын тул ус заавал хэрэгтэй гэдгийг тайлбарла.
2. Хүүхдүүдтэй хамт дараах үйлдлийг хий. Бороо эхлээд зөөлөн орж, дараа нь ширүүснэ.
  - а. Хурууны өндөгнүүдээ нийлүүлэн товш
  - б. Гарын алгаа нийлүүлэн алгаа таш
  - в. Гараараа өвдгөө цохь
  - г. Хөлөө дороо дэвсэл

# Би модод, ургамал ногоо, цэцэгс байдагт талархдаг

Хичээл  
10

---

## Зорилго

Тэнгэрлэг Эцэгтээ бидэнд өгсөн ургамал, цэцэгс модонд талархалтай байхад нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Эхлэл 1:11–13-ыг уншиж судал.
2. Жимс, ногоо болон жижиг даавууны өөдөс эсвэл цаасан уут тавь.
3. Бага хэмжээний жимс, ногоо болон талх бэлтгэ. Хүүхдүүдийн эх эцгээс хэн нэгэн хүүхэд ямар нэгэн хоол хүнсний харшилтай эсэхийг асууж мэд.
4. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Хэрэв боломжтой бол тухайн орон нутагт ургадаг мод, цэцэг, ургамлын зурагнууд, харандаа, халбага, сав зэрэг модоор хийсэн эдлэлийг гэрээсээ авчир.
  - в. Хайчилбар 1-4, цэцэгс (адил төстэй бусад хайчилбаруудыг Хүүхдийн хэсгийн үзүүлэн 3-р хэсгээс олж ав).
  - г. Зураг 1-22, Цэцэг дэлгэрсэн мод, зураг 1-23, Бяцхан дэгдээхэйнүүд үүрэндээ.
5. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Жимс, ногоо хийсэн уутны амыг таглаад дамжуулан хүүхдүүдэд үзүүл. Гэхдээ хүүхэд дотор нь юу байгааг харах ёсгүй. Уутны гадна талаас нь барьж үзээд юу байгааг таалга. Харин бүгд барьж үзэж дуустал хэн ч чангаар хэлэхгүй гэдгийг анхааруул. Хүүхэд бүр тэмтэрч үзсэний дараа уутан дотор юу байгаа гэж бодож байгааг нь хэлүүл. Уутан доторх зүйлсийг нэг нэгээр нь гарган, тэдний харагдах байдал болон хэрэглээний талаар ярилц.

### **Модод, ургамал, цэцэгс нь дэлхийг үзэсгэлэнтэй, амьдрахад сайхан газар болгодог**

Дэлхий дээрх бүх зүйлс Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу бүтээгдсэн гэдгийг хэл. Бүтээлтийн гурав дахь өдөр Есүс модод, ургамал, цэцэгсийг бүтээсэн (Эхлэл 1:11–13-ыг үз). Тэнгэрлэг Эцэг, Есүс дэлхийг модод, ургамал цэцэгсээр дүүрсэн үзэсгэлэнтэй байлгахыг хүссэн гэдгийг тайлбарла.

Авчирсан модод, ургамал цэцэгсийн хайчилбар болон зурагнуудаа гарга. Хүүхдүүдээр модод, ургамал цэцэгсийн тухай яриул.

Түүх Модод, ургамал, цэцэгс нь дэлхийг үзэсгэлэнтэй, амьдрахад сайхан газар болгодог тухай зааж сургасан түүх ярь. Өөрийн амьдардаг газар ургадаг үзэсгэлэнт ургамлын тухай ярилц. Хэрэв танай нутагт байдаг бол зураг 1-22, Цэцэгс дэлгэрсэн мод зургийг хэрэглэж дараах зүйлсийг хий:

Келли нэгэн модны дор тоглох маш дуртай байжээ. Нэгэн өглөө ээж нь Келлиг сэрэхэд нь чи үзээд гайхах нэгэн зүйл байна гэж хэлжээ. Келлигийн дуртай мод нь битүү үзэсгэлэнт цагаан цэцгээр дүүрч тэдгээр нь яг л эрдэнэ шиш мэт харагдаж байлаа. Келли яаж түүний модон дээр эрдэнэ шиш бий болсныг гайхан асуухад, ээж нь гайхамшигт цэцэгсийн учрыг тайлбарлан хэлж өгчээ.

Дуу Хүүхдүүд босч зогсоод “Эрдэнэ шиш үсчинэ” (*Children’s Songbook*, p. 242) дууг гараараа дууны хөдөлгөөнийг хийн дуул. Хаврын улиралд чангаазны мод ургаж, цагаан цэцэгс гардаг нь яг эрдэнэ шиш мэт харагддаг гэдгийг хэл.

Би цонхоороо харахад юу харсан гэж санана?  
Чангаазны модон дээр эрдэнэ шиш дүүрэн байв!  
Хавар надад энэ сайхан гайхамшгийг авчирчээ,  
Цэцэгс миний нүдний өмнө дэлгэрнэ  
Би гараараа атган зугаацаж болно  
Эрдэнэ шиш маш сайхан үнэртэж байна  
Энэ жинхэнэ эрдэнэ шиш биш ч яг л мөн юм шиг  
Чангаазны модон дээр эрдэнэ шиш дэлгэрч байна

Зарим цэцэгс модон дээр ургадаг гэдгийг тайлбарла. Зарим нь бутанд, ороонгон ургамалд (мөлхөө ургамал) зарим нь шууд газар шорооноос ургадаг. Хүүхдүүдээр өөрсдийн харсан цэцэгсийн талаар ярихыг урь.

- Бид өөрсдийн дэлхийг үзэсгэлэнтэй болгохын тул цэцгийг яаж ашигладаг вэ? (бид цэцэрлэгтээ цэцэгс тарьж, цэцгэн багц хийж, цэцгийг үсэндээ хатгаж эсвэл өөрсдийн хувцсандаа хаддаг)
- Яагаад бид цэцэг бэлэглэдэг вэ? (онцгой баярыг тохиолдуулан хүмүүсийг баярлуулахын тулд)

### **Ургамал, модод бидний амьдралд хэрэгтэй**

Түүх Ургамал, модод бидний амьдралд хэрэгтэйг тайлбарла. Зураг 1-22, Цэцэг дэлгэрсэн мод, модны хэрэгцээний талаар түүх ярь. Танай орон нутагт хүмүүс модыг хэрхэн хэрэглэдэг талаар юм уу дараах санааг ашиглан ярь:

Нэгдүгээрт шувууд модон дээр үүрээ засч, тэдний гэр нь болдог. Тэд болгоомжтойгоор өөрсдийн үүрийг засч, ээж шувуу өндгөө үүрэндээ гаргадаг. (Зураг 1-23, Бяцхан шувууд үүрэндээ зургийг үзүүл). Өндөгнөөс дэгдээхэйнүүд гарахад модод тэдний сайн орон гэр нь болдог. Мод тэднийг халуун нар, бороо болон тэдэнд аюул учруулах газрын амьтдаас хамгаалдаг. Мод мөн хүмүүст жимс өгдөг. Хүүхдүүд сүүдэрт нь тоглож, модны бүдүүн мөчирт савлуур хийн тоглодог. Модны үхсэн хэсгийг тасалж, гал түлж, орон гэрээ дулаацуулдаг.

- Яагаад мод бидэнд чухал вэ? (тэд бидэнд хоол тэжээл өгч, сүүдэр гаргаж, тоглох газар болдог)

Гэрээсээ авчирсан болон ангид буй модон эдлэлээ үзүүл. Модыг олон аргаар хэрэглэж ашигладаг талаар хэл.

- Та нар модоор хийдэг өөр юуг мэдэх вэ?

Бид мөн ургамлыг олон янзаар хэрэглэдэг гэдгийг тайлбарла. Ургамал бидэнд өгдөг чухал зүйлийн нэг нь хоол хүнс юм.

- Ямар төрлийн ургамлыг бид иддэг вэ?

Идшэнд хэрэглэдэг ургамлын зураг авчирсан бол одоо үзүүл.

Үйл ажиллагаа

Орон нутагт ургадаг жимс, ногоо, үр тарианы талаар ярь. Үр тариагаар талх, болон гурилан бүтээгдэхүүн хийдэг гэдгийг хэл. Ургамлаас гаргаж авдаг өөрсдийн дуртай хоол хүнсээ хэлэхийг хүүхдүүдээс хүс. Өөрийн авчирсан жимс, ногоо болон талхнаас амсахыг урь. Тэдгээр нь ямар ургамал тарианаас гарсныг хэл.

Тэнгэрлэг Эцэг олон янзын ургамал тариаг биднийг амттай хоол хүнс хэрэглэхэд зориулан Есүсээр бүтээлгэсэн гэдгийг тайлбарла.

- Бид яаж Тэнгэрлэг Эцэгтээ бидний амтат хоол хүнсний төлөө талархаж чадах вэ? (хоол идэхээсээ өмнө адислахаа мартаж болохгүй)

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүсийн бидэнд өгдөг хайрын тухай гэрчлэлээ хуваалц. Өдөр бүр үзэсгэлэнтэй мод, ургамал, цэцгийг харахдаа энэ хайрыг санаж байх хэрэгтэй гэдгийг хэл.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлийн явцад хэрэглэх үйл ажиллагаагаа дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хэсэг үр авчир (цэцгийн үр, вандуй, тариа). Жижиг цаасан аягануудад хар шороо хийж хүүхэд бүр гэртээ авч явахаар өг. Хүүхдүүдэд үр яаж суулгахыг зааж үзүүл. Тэдгээрийг ургахад нь ус, нарны элч хэрэгтэй гэдгийг хэл.
2. Цэцгийн дэлбээ, навч, ургамлын иш зэргийг өнгийн цаасаар хайчилж, хүүхэд бүрээр өөр цаасан дээр цэцгийн хэлбэр гарган наалга. Хүүхдийн хийсэн цаасан дээр *Би үзэсгэлэнт цэцэгст талархаж байна* гэж бич.
3. Дотроо үртэй жимс, ногоо авчир. Хүүхдүүдэд энэ дотор сонирхолтой зүйл байгаа гэж хэл. Жимс эсвэл ногоог огтолж хүүхдүүдэд үрийг нь харуул. Үрийг арчлан суулгаж, усалж, нарны гэрэлд тавих юм бол маш сайхан амттай жимс ногоог ургуулж болно гэдгийг тайлбарла.
4. Хүүхдүүдийг гадаа дагуулан алхаж, олон янзын ургамал ногоо харуул. Хэрэв цаг агаарын байдал тааламжгүй байгаа бол бүгдээрээ ангийнхаа цонхоор гадагш харж ургамал ногооны талаар ярьж болно. Хэрэв зохимжтой бол улирлын өөрчлөлтөөс болж ургамал ногоо бас өөрчлөгддөг талаар ярьж тайлбарла.



---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зураг 1-22, Цэцэгс дэлгэрсэн мод, зургийг үзүүл. Тэнгэрлэг эцэг, Есүс Христ мод ургамал болон цэцэгсийг бүтээсэн гэдгийг хэл (Эхлэл 1:11–13-ыг үз). Мод бидэнд хэрэглэх мод, жимс өгдөг гэдгийг хэл. Ургамал бидэнд жимс, ногоог өгдөг.
2. Хүүхдүүд барьж, үнэрлэж, мэдэрч болох ургамал юм уу ургамлын хэсэг авчир. Жишээ нь, цэцэг, навч гэх мэт. Хүүхэд бүрт барьж, үнэрлэх, мэдрэх боломжийг өг. Тэдгээрийн өнгө, үнэр, үзэсгэлэнт байдлын талаар ярь. Ургамал, мод, цэцэгст талархалтай байдгаа хэл.
3. Үйлдлийг хийж дараах шүлгийг унш. Дараа нь та үгийг хэлж байх зуур хүүхдүүдээр үйлдлүүдийг нь хийлгэ.

Би нүх ухаж байна

Би ухаж байна, ухаж байна (*ухаж байгаа дүр үзүүл*),

Дараа нь би үр суулгаж байна (*үр тарьж байгаа дүр үзүүл*).

Би тармуурдаж байна тармуурдаж байна (*тармуурдаж байгаа мэт бол*),

Тэгээд би хогийн ургамал зулгааж байна (*доош болж, зулгаах хөдөлгөөн хий*).

Нар шарж дулаахан байна (*гараа өргөж тойрог хий*),

Бороо орж (*хуруугаа хөдөлгөн, гараа доош болго*)

Яг миний нүдний өмнө

Миний үр ургаж эхэллээ (*зүүн гарынхаа хуруунуудыг баруун гарынхаа хуруун завсар хий*).

---

**Зорилго**

Бидэнд өгсөн усны амьтад болон загасанд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд талархалтай байхад нь туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Эхлэл 1:20–23; Иона 1–3; Матай 14:15–21; ба Лук 5:1–11-ийг уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Цаасан загас (хичээлийн төгсгөл дэх загварыг хар).
  - в. “Загасчлал” — үзүүртээ уяатай савх, цаасан хавчаар, жаахан наадаг лент (скоч) эсвэл соронз. (дараагийн хичээлүүдэд хэрэглэхээр эдгээрийг хадгал)
  - г. Цаасан загас хадгалах сав.
  - д. Хэрэв боломжтой бол олон төрлийн загасны болон усанд амьдардаг амьтдын зурагнууд авчир.
  - е. Хайчилбар 1-5, загас (төстэй бусад хайчилбарыг, Хүүхдийн хэсгийн үзүүлэн 4 хэсгээс олох боломжтой).
  - ё. Зураг 1-1, Дэлхий (62196); зураг 1-24, Есүс загасчидтай хамт (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 210; 62138); зураг 1-25 Загас, зураг 1-26 Мэлхий, зураг 1-27, Яст мэлхий
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг гол юм уу нууран дээрх гүүрэн дээр зогсож байна гэж төсөөлүүл.

- Ус руу харахад юу харагдаж байна?

Хүүхдээр загас мэт усанд сэлж байгааг дүрслүүл.

**Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг усны амьтад болон загас бүтээхийг хүссэн**

Зураг 1-1, Дэлхий, зургийг үзүүл. Тэнгэрлэг Эцэг Есүсийг бүтээхийг хүссэн зарим зүйлийн талаар өнгөрсөн хичээл дээр ярилцсан гэдгийг хэл. Есүс мөн загасыг бүтээсэн гэдгийг хэл (Эхлэл 1:20–23-ыг үз). Загас нь дэлхийд зориулан өгсөн Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг. Зураг 1-25 Загасыг үзүүл. Загас хаана амьдардаг тухай ярилц.

- Та нар загас харсан уу?

Харсан загаснуудынхаа талаар ярихыг урь.

Хайчилбар 1-5 болон өөрт байгаа бусад зурагнуудаа үзүүл. Алтан загас, туна, цагаан загас, тул загас, халим зэрэг олон төрлийн загаснууд байдаг тухай ярь. Эсвэл ангийн хүүхдүүдийн сайн мэддэг загаснуудын талаар ярь.

- Загаснаас өөр ямар амьтад усанд амьдардаг вэ?

Зураг 1-26, Мэлхий, зураг 1-27, Яст мэлхий үзүүл. Мэлхий болон яст мэлхийний талаар тэд хаана амьдардаг талаар ярь. Мөн бусад усны амьтдын тухай ярь. Зарим усны амьтад нь далайд, зарим нь нууранд, зарим нь голд амьдардаг гэдгийг хэлж тайлбарла.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг усны амьтдыг дүрслэн тэдэн шиг дэвхэрч, сэлж, алхах хөдөлгөөн хийлгэ.

Түүх

Библийг гартаа барьж, загасны талаар бид судар дээрээс уншиж болно гэдгийг хэл. Иона 1–3-т гардаг Ионагийн тухай түүхийг ярьж өг. Ионаг живүүлэхгүйн тулд түүнийг залгиулахаар Есүс Ионад зориулан агуу загасыг бэлтгэсэн гэдгийг тайлбарла. Есүс Ионагаар хийлгэх ажлыг бэлдсэн байв. Түүхийг ярих явцдаа Иона 1:17 юм уу Иона 2:1-г чанга дуугаар унш. (Хэрэв та ангид чангаар уншиж байгаа бол Есүсийг заримдаа “Эзэн” хэмээн нэрлэдгийг хэл)

- Ионаг залгиулахаар том загасыг хэн явуулсан бэ? (Иона1:17.)
- Загас Ионаг залгахад тэр юу хийсэн бэ? (Иона 2:1.)
- Иона загаснаас гараад юу хийсэн бэ? (Иона 3:1–3.)
- Хүмүүс Ионад итгэж, нүглүүдээ наманчилсан уу? (Иона 3:5, 10.)

Зарим загаснууд Ионаг залгисан шиг маш том байдаг, зарим нь маш жижигхэн бүр саванд ч амьдарч чадахаар жижиг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээр дараах хуруун тоглоомыг хийлгэ:

Алтан загас

Миний жижигхэн алтан загасанд хөлний хуруу байхгүй (хөлнийхөө хуруунд хүр).

Тэр чимээгүй сэлж, өөрийн өлсгөлөн хошуугаараа савны хана мөргөдөг (хамраа заа)

Тэр надтай тоглохоор гарч ирж чадахгүй, би ч түүний саванд орж сэлж чадахгүй (сэлж буй дүрслэл үзүүл)

Намайг “Гараад ир, тоглоё,” гэж хэлэхэд

Тэр намайг “Нааш ир” хэмээн хэлэх шиг болдог (*гараараа “наашир” гэж дууд*).

Түүх

Дахин Библи харуулан Лук 5:1–11 дэх Симон Петрийн тухай түүхийг ярь. Тохиромжтой цагт нь Зураг 1-24, Есүс ба Загасчид, үзүүл.

- Яагаад Есүс Симон Петрийн завин дээр гарсан бэ? (Лук 5:3-ыг үз.)
- Симон Петрийг юу хий гэж Есүс хэлсэн бэ? (Лук 5:4-ийг үз.)
- Симон Петр торондоо юу барьсан бэ? (Лук 5:6-г үз.)

## Бидний хэрэгцээнд зориулж Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христ загасыг болон усны амьтдыг бүтээсэн

Тэнгэрлэг дууг дуул. Есүс загасыг бидний хоол хүнсний хэрэгцээнд болон бусад зорилгоор бүтээсэн гэдгийг тайлбарла.

Түүх

Дахин Библийг авч, Матай 14:15–21 дэх түүхийг ярь. Түүхийг ярьж байхдаа Матай 14:16–17-г чанга дуугаар уншиж болно.

- Хүмүүс өлсгөлөн байхад Есүс юу хийсэн бэ? (Матай 14:15–16-г үз.)
- Есүс юугаар хүмүүсийг хооллосон бэ? (Матай 14:19-ийг үз.)

Үйл ажиллагаа

Өөрийн бэлтгэсэн загасчны уургаа харуул. Нэг хүүхдийг урьж, загасчлахыг санал болго. Саванд цаасан загаснуудаа хийгээд хүүхдийг уургаа загастай саван дээр барихад цаасан хавчаарт загас хавчуул, скочдон наа, эсвэл соронзоор соронздон загас “барих” боломжийг хүүхдэд өг. Хүүхэд бүрээр “загас бариул”.

Хүүхдүүдээр загас барьж байсан эсвэл загас идсэн тухай нь яриул.

Гэрчлэл

Усны амьтад болон загас байдагт талархдаг тухай гэрчлэлээ хуваалц.

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Загасчлах үед барьсан цаасан загаснуудыг нь будуул (хүсвэл үйл ажиллагааг давтан хий). *Би загас байдагт талархалтай байдаг* гэж хүүхэд бүрийн загасны ар талд бич.
2. Хүүхдүүдийг хагас дугуй болгон суулга. Хүүхдүүдийн будсан загаснуудыг тэдний урд талд нь шалан дээр тавь. Хамтдаа дараах үгсийг хэл:

Горхинд жижиг загас байна,  
Би чамайг дэгээгүйгээр барьж чадна

Хүүхэд рүү зааж, тухайн хүүхдээр өөрийн загасыг уурга ашиглан юм уу заасныг нь авахуул. Хүүхэд “Би нэг -г барьлаа” гэж загасны өнгийг нь хэлүүл. Хүүхэд барьсан загасаа гэртээ авч явж болно. Хүүхэд бүрийг хийж дуустал үргэлжлүүл.

3. Хүүхдүүдтэй хамт “Эцэгтээ талархъя” (*Children’s Songbook*, p. 20) дууг дуул.
4. Дараах хуруун тоглоомыг тоглохыг урь. Минноу гэдэг нь жижиг загас гэдгийг хэл.

Бяцхан яст мэлхий

Надад жижигхэн яст мэлхий бий  
Тэр хайрцганд амьдардаг (*гараараа аяга хий*).  
Тэр голд сэлдэг (*сэлж буй дүрслэл хий*),  
Мөн чулуу руу авирдаг (*хуруунуудаараа авирах хөдлгөөн хий*).

Тэр минноу руу дайрч (*алгаа таш*).  
Тэр жижиг шавьж руу дайрсан (*алгаа таш*).  
Тэр шумуул руу дайрсан (*алгаа таш*),  
Тэр бас над руу дайрсан (*алгаа таш*)!

Тэр минноуг барьсан (*алгаа таш*);  
Тэр шавьжийг барьсан (*алгаа таш*);  
Тэр шумуулыг барьсан (*алгаа таш*);  
Харин намайг барьж чадаагүй!

(Vachel Lindsay, from *Collected Poems of Vachel Lindsay*. © 1920 by Macmillan Publishing Co., Inc., renewed 1948 by Elizabeth C. Lindsay. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

5. Дараагийн үйл ажиллагааны үгсийг хүүхдээр хэлүүл. Горхи гэдэг нь жижиг гол, булан гэдэг нь нуугдах газар гэдгийг хүүхдүүдэд хэлж өг.

Таван жижиг загас

*Таван хүүхдийг ангийн өмнө гарч ирэхийг урь. Хүүхэд бүр цаасан загасаа барьж гарч ирнэ.*

Таван жижиг загас горхинд сэлж явна

Нэг нь нуугдмал булан руу сэлэв (*нэг хүүхэд өөрийн байрандаа “сэлэн” явж эргэж сууна*).

Жижиг загаснууд, жижиг загаснууд тоглон баярлалдаж байна,  
Жижиг загаснууд, жижиг загаснууд өдөржин сэлж явна

*Дөрвөн загас, дараа нь гурав, дараа нь хоёр загасны тухай дуул. Нэг хүүхэд бадаг бүр дээр “нуугдмал булан” руу сэлэн явах болно. Тэгээд ганц хүүхэд үлдэхэд:*

Нэгэн жижиг загас горхинд сэлэн явж байжээ;

Тэр нуугдмал булан руу сэлэн явлаа.





Жижиг загас, жижиг загас, тоглон баярлаж байна,

Жижиг загас, жижиг загас, өдөржин сэлэн явна.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зураг 1-25, Загас, зураг 1-26, Мэлхий, мөн зураг 1-27, Яст Мэлхий зургийг үзүүл. Өөрийн үгээр усны амьтад болон загас бүтээсэн түүхийг ярьж өг (Эхлэл 1:20–23-ыг). Загас болон бусад усны амьтад талархалтай байдгаа илэрхийл.
  2. Олон амьтад усанд болон усны ойролцоо амьдардаг гэдгийг хэл. Дараах таамаглалуудыг хэлж хүүхдүүдээр ямар амьтны тухай ярьж байгаагаа таалга:
    - а. Миний арьс ногоон, гөлгөр бас гулгамтгай. Би цовхордог. Би нуур, горхи, намгийн дэргэд амьдардаг. Намайг хэн гэдгийг таах уу?  
(Хүүхдүүд “мэлхий” гэж таахад зураг 1-26, Мэлхий үзүүл эсвэл самбар дээр мэлхий зур)
    - б. Би маш удаан. Би нуруун дээрээ хатуу дуулга өмсдөг. Би айсан үедээ толгойгоо, гараа бас хөлөө дуулгынхаа дор хийдэг. Би хэн бэ?  
(Хүүхдүүд “яст мэлхий” хэмээн таахад, зураг 1-27, Яст Мэлхий үзүүл, эсхүл самбар дээр яст мэлхий зур)
- Хүүхдүүдийг хоёр амьтнаа таасны дараа тэднийг мэлхий шиг цовхруул. Мөн дараа нь яст мэлхий мэт удаанаар ойр хавьд нь мөлхүүл.



---

**Зорилго**

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бидэнд амьтад өгсөнд талархалтай байхад нь туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Эхлэл 1:24–25 ба 6:5–8:19-ийг уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Хайчилбар 1-6 мөн 1-19-ийг дуустал, амьтад (ижил төстэй хайчилбар Хүүхдийн хэсгийн үзүүлэн 4 ба 5-р хэсэг).
  - в. Зураг 1-28, Бүтээлт—Амьд бүтээлүүд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 100; 62483); зураг 1-29, Хөвөгч авдар барьсан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 102; 62053); зураг 1-30, Ноа ба амьтадтай хөвөгч авдар (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 103; 62305).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Амьтдын дүрстэй хайчилбаруудыг шалан дээр эсвэл ширээн дээр хүүхдүүдийн өмнө байрлуул. Хүүхдүүдээр дүрс сонгуулж, ямар амьтан болохыг тодруулж, ангийнхандаа үзүүл. Хүүхэд бүрээр хийлгэ.

**Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг амьтад бүтээхийг хүссэн**

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ бидний үзэсгэлэнт дэлхийг бүтээж өдөр ба шөнө, хуурай газар ба далай тэнгис, ургамал модод бүгдийг бүтээсэн гэдгийг сануулан ярь. Библи номыг харуулж, энэ номноос бид Бүтээлтийн тухай уншиж болно гэдгийг хэл. Библи дээр Тэнгэрлэг Эцэг Есүсээр бүх ан амьтдыг бүтээлгэн, дэлхий дээр тавиулсан тухай бичсэн байдгийг тайлбарла.

Зураг 1-28, Бүтээлт—Амьд бүтээлүүд зургийг үзүүл.

- Энэ зурган дээрх зүйлсийг хэн бүтээсэн бэ?
- Энэ зурган дээрх амьтдыг нэрлэнэ үү?

Дэлхий дээрх бүх амьтдыг Есүс бүтээсэн гэдгийг хэл. Зарим амьтад бидний гэртэй ойрхон ферм дээр амьдардаг. Зарим амьтад ой шугуйд, зарим нь ууланд, мөн зарим нь элсэн цөлд амьдардаг. Зарим амьтад нь дэлхийн хамгийн хүйтэн хэсэгт амьдарч байхад зарим нь дэлхийн дулаан газарт амьдардаг.

- Ямар амьтад фермд амьдардаг вэ?
- Ямар амьтад ойд, ууланд мөн элсэн цөлд амьдардаг вэ?
- Чиний хамгийн дуртай амьтан юу вэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босгон өөрийн дуртай амьтнаа биеэр дүрслэн үзүүлэхийг урь.

### **Амьтад бидэнд тусалдаг**

Бидэнд туслахын тул Тэнгэрлэг Эцэг Есүсээс амьтдыг дэлхий дээр тавихыг хүссэн. Зарим амьтдыг бид хоол хүнсэндээ хэрэглэж, заримыг нь өөрсдийн төлөө ажиллуулж, мөн заримыг нь харж сонирхоход болон тоглоход хэрэглэдэг.

- Амьтад бидэнд яаж тусалдаг вэ?
- Ямар амьтдаас бид сүү, өндөг болон мах зэрэг хоол хүнсээ бэлтгэдэг вэ?
- Ямар амьтдаас бид хувцасны материалаа бэлтгэдэг вэ?
- Ямар амьтдыг гэрийн тэжээмэл амьтан болгодог вэ?
- Ямар амьтдыг унаанд хэрэглэдэг вэ?

Төрөл бүрийн амьтдын тухай хүүхдүүдийн өөрсдийнх нь бодлыг яриул.

### **Амьтад үерээс аврагдсан нь**

Эхлэл 6:5–8:19-ийн Ноа болон хөвөгч авдрын тухай түүхийг ярьж өг. Зураг 1-29, Хөвөгч авдар барьсан нь, зураг 1-30, Ноа ба амьтадтай хөвөгч авдар. Түүхийг харуулсан хайчилбар зэргийг ашиглаж болно.

- Есүст дуулгавартай байснаар Ноа болон түүний гэр бүл хэрхэн адислагдсан бэ?
- Амьтад хэрхэн аврагдсан бэ?
- Солонго бидэнд юуг сануулдаг вэ?

Үйл ажиллагаа

Дараах үгсийг хэлэх зуураа хүүхдүүдийг босгож үйлдлүүд хийлгүүл:

Ноа

Ноа асар том авдар хийв (*гараа гадагш тэл*);

Тэр зөвхөн юу хийх ёстойгоо л мэдэж байсан (*долоовор хуруугаа чамархайндаа хүргэ*).

Тэр алхаар балбаж, хөрөөдөж, хэмжилт хийж (*эдгээр үйлдлүүдийг хий*)

Түүнд тушаасны дагуу бүгдийг хийв (*толгойгоо дохь*).

Ноа өөрийн гэр бүлээ дуудаж (*гараараа далла*)

Завинд суухаар алхацгаав (*дороо алх*)—

Мөн хос, хос амьтад (*хоёр хуруугаа гозойлго*)

Завины тавцан дээр гарч ирэв (*хоёр гараараа завиар сэлэх хөдөлгөөн хий*).

Хар үүлс гарч (*толгойгоо гараараа тагла*),

Бороо дусалж эхэллээ (*бороо орж буй мэт хуруугаараа хөдөлгө*)—

Дэлхий усаар бүрхэгдэж (*гар хуруугаараа бүрхэж буй хөдөлгөөн хий*);

Хуурай газар үлдсэнгүй (*толгойгоо тал тал тийшээ эргүүл*).

Дахин нар гарч (*толгой дээрээ гараараа тойрог хий*)

Шарж, дулаацуулах хүртэл.

Олон өдөр шөнө (*хоёр гараа толгойн хажуудаа авчир*),

Авдар аюулгүй хөвөв (*гараараа хөвөх хөдөлгөөн хий*)



Бүх ус татарч (*гараа цээжин дээрээ зөрүүлэн тавь*);  
Хуурай газар харагдаж эхэллээ (*гараа тэлж, гараа сунга*).  
Бурхан үргэлж дэргэд нь байсны төлөө  
Ноагийн гэр бүлийнхэн талархлаа илэрхийллээ (*мэхийж гараа  
цээжиндээ барь*)  
(Бэвэрли Спенсерийн зохиолыг өөрчлөн ашиглав.)

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу үзэсгэлэнтэй дэлхийг бүтээсэнд  
Есүс Христэд талархаж байгаагаа хуваалц. Энэ дэлхий дээр хэрэглэж  
мөн баясаж болох амьтдыг өгсөнд ямар их талархалтай байдгаа илэрхий-  
лэн хэл.

---

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас  
сонго.

1. “Амьтан, Амьтан, Чи хэн бэ?” гэдэг тоглоомыг тогло. Хүүхдүүдийг тойрон  
суухыг урь. Нэг хүүхдийг тойргийн голд зогсоож амьтан болж үзүүлэхийг  
хүс. Бусад хүүхдүүд гараа өргөн, голд зогсож буй хүүхэд ямар амьтан  
болж үзүүлж буйг тааж хэлнэ. Хэн нэгэн хүүхэд зөв таавал, өөрөө голд  
зогсон өөр амьтан дүрслэн үзүүлнэ. Дүрслэн үзүүлэх гэж буй амьтныхаа  
нэрийг эхлээд танд шивнэн хэлэхийг хүүхдүүдээс хүсч болно. Ингэснээр  
тухайн хүүхэд дүрслэх гэж буй амьтныхаа талаар зөв дуу авиа болон,  
үйл хөдлөл, харагдах байдлыг нь зөв үзүүлж буйг ажиглах боломжтой.
2. “Энэ ямар амьтан бэ?” гэдэг тоглоом тоглуул. Нэг амьтны тухай  
төсөөллийг хүүхдүүдэд өгнө. Төсөөлөл нь: тухайн амьтан хаана  
амьдардаг, хэр том, ямар чимээ гаргадаг, ямар өнгөтэй мөн хэрхэн  
хүмүүст тусалдаг гэх мэт. Хүүхдүүдийг гараа өргөн хариултыг өгөхийг  
хүс. Хүссэнээрээ өөр өөр амьтад таалган тогло.
3. Хүүхдүүдтэй хамт “Дэлхий маш том” (*Children’s Songbook*, р. 235) дууны  
үгийг хэл. Дараах үйлдлийг хий:  

Дэлхий маш том өө, дув дугуй (*гараараа том дугуй хий*),  
Энд Бурханы бүтээлүүд байдаг;  
Уулс (*толгой дээрээ уулын орой хий*)  
Толгод (*алгаа доош харуулан урдаа барь*)  
Өндөр модод (*гараа дээш сунга*),  
Том амьтад (*дээш суна*)  
Мөн жижиг амьтад (*доош бол*).  
Дэлхий маш том өө, дув дугуй (*гараараа том дугуй хий*),  
Бурхан бид бүгдэд нь хайртай, бидний адислал агуу их (*гараа атгаж  
өөрийгөө тэвэр*).
4. Хүүхдүүдээр тэдний гэрийн тэжээвэр амьтдынх нь тухай болон тэжээх  
сонирхолтой байгаа амьтдынх нь тухай ярилц. Бид гэрийн амьтадаа яаж  
тэжээж, халамжлах ёстой талаар ярилц.
5. Хүүхдүүдэд цаас болон өнгийн харандаа өг. Тэднээр өөрсдийнх  
нь дуртай амьтныг нь зуруул. Цаасан дээр нь *Би амьтад талархаж  
байна* гэж бич.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зураг 1-28, Бүтээлт—Амьд бүтээлүүд зургийг үзүүл. Өөрийн үгээр амьтад бүтээсэн түүхийг ярьж өг (Эхлэл 1:24–25-ыг үз). Амьтдад талархалтай байдгаа хэл.
2. Хүүхдүүдийн сайн мэддэг хэдэн амьтдыг сонго. Тэгээд хүүхэд бүр нэг амьтан болно. Тухайн амьтан яаж харагдаж байгаа, ямар дуу авиа гаргадаг болон тэдний юунд хэрэгтэй талаар ярилц.
3. “Бүх зүйлс үзэсгэлэнтэй сайхан” (*Children’s Songbook*, р. 231) дууны эхний мөрийг дуулахад нь тусал.

# Би шувууд болон шавьж хорхой байгаад талархдаг

---

## Зорилго

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нарт шувууд, шавьж болон мөлхөгч амьтад өгсний төлөө талархалтай байхад нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Эхлэл 1:20–25 ба Хаадын дээд 16:29–17:6-г уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Хэрэв боломжтой бол өөрийн орон нутагт элбэг байдаг шувууд, шавьж хорхой болон мөлхөгч амьтдын зураг бэлтгэ.
  - в. Хайчилбар 1-20-ээс 1-25, шувууд ба шавьж (ижил төстэй хайчилбаруудыг Хүүхдийн хэсгийн үзүүлэн 4 ба 5-р хэсгээс олж болно).
  - г. Зураг 1-31, Хэрээнүүд Элиаг хооллосон нь; зураг 1-32, Тэнгисийн цахлай шувууны гайхамшиг (Сайн мэдээний уран зургийн цуглуулга 413; 62603).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдэд таамаглах мэдээнүүдийг өгч “Би хэн бэ?” гэсэн асуултанд хариултыг хэлүүл.

1. Надад хошуу бий
2. Надад өд бий.
3. Надад далавч бий.
4. Би агаарт нисдэг.

Хүүхдүүдийг “шувуу” гэж таахад, анги тойрон шувуу болон нисэх мэт хөдөлгөөн хийн яв. Дараа нь суудал руу нь авчирч суулга.

### Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг шувуу бүтээхийг хүссэн

Тэнгэрлэг Эцэг Есүс Христээр шувууг бүтээлгэн энэ дэлхийг улам үзэсгэлэнтэй, амьдрахад сайхан болгохын тул бидний төлөө хийлгэсэн гэдгийг тайлбарла. Библийг хүүхдүүдэд үзүүлж, Библи номон дээр шувуу бүтээсэн тухай бичсэн байдгийг хэл (Эхлэл 1:20–23-ыг үз).

Дэлхий даяар олон янзын шувууд амьдардаг гэдгийг хэл. Өөрийн бэлтгэсэн зурагнууд, хайчилбаруудаа нэг нэгээр нь үзүүл.

- Энэ шувуу мөн үү?
- Чи яаж мэдэж байна? (далавчтай, хошуутай мөн өдтэй)

Хүүхдүүдээр шувууны талаар яриул.

## Шувууд бидэнд тусалж чадна

Түүх

Зураг 1-31, Хэрээнүүд Элиаг хооллосон нь, үзүүл. Хаадын дээд 17:1–6-д байдаг Бошиглогч Элиаг хэрээнүүд хооллосон тухай түүхийг ярьж өг. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нар бүхний дээр, бүр шувуудын дээр хүртэл хүчтэй гэдгийг ойлгоход нь тусал. Элиаг Ахаб хаанаас нуугдаж байх үед нь халамжлахыг Есүс шувуудад хэлсэн.

- Хэрээнүүд Элиад хоол аваачих ёстой гэдгээ яаж мэдэж байсан бэ? (Хаадын дээд 17:4-ийг үз.)
- Хэрээнүүд ямар хоол авчирдаг байсан бэ? (талх, мах; Хаадын дээд 17:6-г үз.)

Үйл ажиллагаа

Нэг хүүхдийг Элиа болгож, бусад хүүхдүүдийг өглөө оройд хоол авчирдаг хэрээ шувуунууд болго.

Түүх

Өөрийн үгээр дараах түүхийг ярьж өг:

Сүмийн анхдагч нар Солт Лейкийн Хөндийд ирээд буудай болон бусад үр тариаг тариалжээ. Тэдэнд талх хийх үр тариа хэрэгтэй байлаа. Тариа өндөр том болон ургав. Тариа хураах цаг болсон тэр үед тэнгэр хар үүлээр бүрхэв. Энэ нь борооны үүл биш харин мянга мянган өлсгөлөн хар хүрэлзгэнүүд байлаа. Хар хүрэлзгэнүүд тариан талбай дээр бууцгааж тариаг идэж эхлэв.

Анхдагч нар өөрсдийн тариаг хамгаалах хамаг л аргаа хэрэглэжээ. Тэд гал шатааж, хүрэлзгэнүүдийг хөөж, бүр тэднийг усаар булхаж ч үзжээ. Гэвч тэднийг зогсоож чадсангүй. Анхдагч нар өвөлдөө хоол хүнсгүй боллоо хэмээн бодож их санаа зовж байв. Тэд өвдөг сөхрөн залбирч Тэнгэрлэг Эцэгээс тусламж хүсчээ.

Удалгүй маш олон цахлайнууд ирж хүрэлзгэнүүдийг идэж эхлэв (Зураг 1-32, Тэнгисийн цахлайн гайхамшиг). Маш түргэн ихэнх хүрэлзгэнүүд алга болжээ. Анхдагч нар цахлайнууд илгээж тэдний тариаг аварсанд Тэнгэрлэг Эцэгтээ талархав. (see William E. Berrett, *The Restored Church* [Солт Лейк Хот: Deseret Book Co., 1961], 283–285-р хуудас).

- Анхдагч нарт цахлайнууд яаж тусалсан бэ?

## Тэнгэрлэг Эцэг Есүс Христийг шавьж ба мөлхөгч амьтдыг бүтээхийг хүссэн

Есүс Христ аалз, могой зэрэг шавьж ба мөлхөгч амьтдыг бүтээсэн гэдгийг хэл. Эдгээр бүтээлүүд нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг юм.

Үйл ажиллагаа

Дараах тааварт гарч буй шавьж, мөлхөгч амьтдыг таахыг урь. Оньсого бүхнийг таахад тухайн амьтны зураг, хайчилбарыг үзүүл.

1. Би шар мөн дүнгэнэдэг  
Миний гэдэс шар үсээр хучигдсан  
Би чамд болон өөртөө бал хийдэг  
Би бол бал цуглуулагч (зөгий, дүнгэнэсэн дуу авиа гарга)

2. Би идшээ барихын тул тор нэхдэг  
Би надад байх ёстой найман хөлтэй  
Ихэвчлэн хүмүүс надад дургүй.  
Би хэн болохыг чи тааж чадах уу? (аалз, гарын хуруунуудаа хөл болгож хөдөлгө)
  3. Би нэгэн удаа авгалдай байсан.  
Би тэнгэрт хөөрөн нисч чадна  
Би үзэсгэлэнтэй далавчтай  
Би бол. (эрвээхэй; хуруунуудаа зөөлөн хөдөлгөж далавч мэт дэв)
- Эдгээр амьтдын талаар чи юу мэдэх вэ?

Шавьжнууд олон шалтгааны учир бүтээгдсэн гэдгийг тайлбарла. Зарим шавьжаар шувуу, амьтад, болон бусад өөр шавьж нар хоол тэжээлээ хийдэг. Зарим нь сайхан дуу авиа гаргаж, гоё сайхан харагддаг. Бал гаргагч зөгийнүүд бидэнд зориулан амтат зөгийн бал хийдэг, тэд мөн жимс, цэцэг болон ногоо ургахад тусалдаг.

Үйл ажиллагаа

Зөгийн зурагтай хайчилбараа үзүүл. Зөгийнүүд зөгийн бал хийхийн тул цэцгийн бал хэрхэн цуглуулдаг, цэцэгнээс цэцэг рүү нисдэг тухай хүүхдүүдэд ойлгуул. Тэгээд хүүхдүүдээр цэцгээс цэцэг рүү нисэн очиж цэцгийн бал цуглуулж буй зөгий мэт үйлдлийг хийлгэ.

- Чи ямар шавьжинд дуртай вэ? Яагаад?

Авчирсан шавьжнуудынхаа зургийг үзүүл. Зарим шавьж нар бидэнд саад болдог гэдгийг тайлбарла. Тэд бидний хоол хүнсийг идэж, биднийг хазаж мөн хатгадаг. Хүүхдүүдэд хүрэлзгэнэ болон цахлайн тухай түүхийг сануул. Хүрэлзгэнүүд анхдагч нарын хоол хүнсийг идэж байсан.

Ихэвчлэн шавьжнууд биднийг шархлуулж, төвөг болдог ч энэ нь тэд зөвхөн өөрсдийгөө хамгаалахын тулд тэгдэг гэдгийг тайлбарла.

Гэрчлэл

Шувуу, шавьж, бусад мөлхөгч амьтад нь дэлхийн бас нэгэн чухал хэсэг юм гэдгийг сануул. Эдгээр бүтээлүүдийн төлөө бас талархалтай байдаг гэдгээ хуваалц.

---

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Эрвээхэй гэдэг тоглоомыг тогло. Хүүхдүүдийг тойрог болгон суулга. Нэг хүүхдийг сонгож эрвээхэй болго. Тэр хүүхэд хүүхдүүдийн толгой дээгүүр цаасан эрвээхэй барьж тойргийн гадна талаар алхана. Хүүхдийг тойрон алхах үед доорх үгсийг хэл:

Гэгээтэй дулаахан зуны өдөр  
Нэгэн бяцхан эрвээхэй  
Хөх тэнгэрт хөөрөн нисч,  
Харин тэр газардахдаа, яг над дээр буулаа!

“Тэр над дээр буулаа” гэж хэлэх үед цаасан эрвээхэйгээ яг хажууд нь зогссон хүүхдийн өвөр дээр тавина. Одоо энэ хүүхэд эрвээхэй болон алхаж дахин үгээ давтан тойрон алхана. Ингэж хүүхэд бүр эрвээхэй болох боломжийг олго.

2. Энгийн үгээр авгалдай хэрхэн эрвээхэй болдгийг тайлбарла. Хүүхдүүдээр авгалдайн үүр хийж байгаа мэт төсөөл. Сандал дээр нь юм уу шалан дээр суулгаад гараараа хөлөө ороон унтаж байгаа мэт болно. Авгалдайнүүд эрвээхэй болохдоо далавчнууд нь гарч, хөдөлж эхэлдэг гэдгийг хэл. Хүүхдүүд гараа хөдөлгөнө. Эрвээхэйнүүд хөдөлж байхдаа ч гэсэн маш чимээгүй байдаг гэдгийг сануул. Өрөө тойрон чимээгүй нис.

3. Хүүхдүүдтэй хамт “Дэлхий маш том” (*Children’s Songbook*, р. 235) дууны үгсийг нь хэл. Дараах “Дэлхий маш том” дууны үйлдлүүдийг хий:

Дэлхий маш том өө, дув дугуй (*гараараа том дугуй хий*),

Энд Бурханы бүтээлүүд байдаг;

Уулс (*толгой дээрээ уулын орой хий*)

Толгод (*алгаа доош харуулан урдаа барь*)

Өндөр модод (*гараа дээш сунга*),

Том амьтад (*дээш суна*)

Мөн жижиг амьтад (*доош бол*).

Шөнийн турш одод гялалзаж (*гараа өргөн хуруунуудаа хөдөлгө*),

Өдөр нар дулаацуулж, гэрэлтэй болгодог (*гараараа том дугуй хий*).

Дэлхий маш том, өө, дув дугуй. Бурхан бид бүгдэд нь хайртай, бидний адислал агуу их (*гараа атган өөрийгөө тэвэр*).

4. “Бүх зүйлс үзэсгэлэнтэй сайхан” (*Children’s Songbook*, р. 231) дууны үгийг хэл. Мөн үйлдлийг хий:

Бүх зүйлс гэгээлэг мөн үзэсгэлэнтэй (*гараараа том дугуйг хий*),

Бүх бүтээлүүд том ба жижигхэн (*гараа том тэлэн, дараа нь нийлүүл*),

Бүх зүйлс мэргэн ба гайхамшигтай (*хуруугаараа толгойгоо заа*),

Энэ бүгдийг Их Эзэн Бурхан хийсэн (*залбирал хийж байгаа мэт гараа зөрүүл*).

Дэлбээгээ нээх цэцэгс бүр (*нударга хийж дараа нь дэлгэ*),

Жиргэх шувууд бүр (*эрхий хуруугаа бусад хуруунуудтайгаа нийлүүлж шувуу мэт жиргэ*),

Тэр тэдгээрийн тодрох өнгийг хийсэн (*гараараа солонго хий*);

Тэр тэдний бяцхан далавчийг хийсэн (*далавч мэт гараа дэв*).

5. Жижиг савтай зөгийн бал авчирч хүүхдүүдэд үнэртүүлэн амтлуул. (хүүхдүүдийн эх эцгээс хэн нэгэн зөгийн балны харшилтай эсэхийг тодруул.)

6. Хүүхдүүдээр дараах хуруугаар тоглох тоглоом тоглуул:

Бяцхан хоёр дууч шувуу

Бяцхан хоёр дууч шувуу хашаан дээр суулаа (*хуруугаа мөрөн дээрээ тавь*),

Нэгийг Петр гэдэг (*зүүн хуруугаа өргө*)

Нөгөөдөхийг нь Паул гэнэ (*баруун хуруугаа өргө*).

Нис, Петр (*зүүн хуруугаа нуруун дээрээ тавь*);

Нис дээ, Паул (*баруун хуруугаа нуруун дээрээ тавь*).

Буцаад ир Петр (*зүүн хуруугаа мөрөн дээрээ дахин тавь*);

Буцаад ир, Паул (*баруун хуруугаа мөрөн дээрээ дахин тавь*).

Зөгийн үүр

Энд зөгийн үүр байна (*зүүн гараа аяга хэлбэртэй болгон доош харуул*).

Зөгийнүүд нь хаана байна?

Хэнд ч харагдахгүй газар нуугдаа юу (*баруун гарын хуруунуудаа аяга хэлбэртэй болгосон зүүн гаран дороо нуу*).

Үүрнээс тэд удахгүй нисэн гарч ирнэ (*баруун гарынхаа хуруунуудыг нэг нэгээр нь гаргаж, гозойлгон тоолно*).

Нэг, хоёр, гурав, дөрөв, тав! БЗЗЗ!

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зурагнууд, хайчилбар, болон шувууд зурсан зургаа үзүүл. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ шувуудыг бүтээсэн гэдгийг хэлье (Эхлэл 1:20–23-ыг үз). Шувуудад талархалтай байдгаа хуваалц.

2. Шувууд хоолоо олж идэх зориулалттай онцгой хошуутай байдаг гэдгийг тайлбарла. Гараа амныхаа урд авчран шувууны хошуу мэт хэлбэр гарган хоолоо идэж байгаа мэт дүрсэл. Мөн нисэхэд зориулж далавчтай байдаг гэдгийг хэл. Хүүхдүүдийг шувуу мэт гараараа даллан нисэхийг урь.

3. “Модон дээрх шувууд” (*Children’s Songbook*, р. 241) дууны үгийг хэл. Үйлдлийг мөн хий:

Модны мөчрүүд дундаас (*толгой дээрээ гараа барь*).

Бид жижигхэн үүрийг олох болно (*хоёр гараа нийлүүлэн аяга мэт болго*)

Дотор нь байгаа өндгийг тоолъё,

Энд нэг, хоёр, гурав (*тоолох бүрт нэг хуруугаа гозойлго*).

Ээж шувуу нь үүрэндээ сууна (*зүүн гараа аяга мэт болгож, баруун гараа дээр нь тавь*)

Бүх гурван өндгөө дарна (*гурван хуруугаа гозойлго*).

Аав шувуу эргэлдэн тойрон нисч (*гараараа нисч буй шувуу бол*)

Өөрийн гэр бүлээ хамгаална.

4. Хүүхдүүдээр хуруун тоглоомыг хийлгэ:

Жижигхэн аалз

Жижигхэн бяцхан аалз усны хоолой дамжин дээшилнэ (*хоёр хуруугаа ашиглан, нөгөө гар дээрээ “авирах” хөдөлгөөн хий*).

Бороо орж аалзыг доош унагав (*гараа толгой дээрээ өргөн, доош аажмаар буулгахдаа хуруунуудаа хөдөлгө*).

Бороо орж нарыг хаав (*толгой дээрээ гараараа тойрог хий*).

Дараа нь бяцхан жаахан аалз дахин усны хоолой дамжин авирлаа (*эхний мөрнөөс дахин бүх хөдөлгөөнийг хий*).

# Адам Ева хоёр Тэнгэрлэг Эцэгийн дүр төрхөөр бүтээгдсэн

Хичээл

# 14

---

<b>Зорилго</b>	Хүүхдүүдэд Адам Ева нар Тэнгэрлэг эцэгийн дүр төрхөөр бүтээгдсэн гэдгийг ойлгоход нь туслах
<b>Бэлтгэл</b>	<ol style="list-style-type: none"><li>Залбиралтайгаар Эхлэл 1; 2:15–25; ба 3-г уншиж судал. <i>Сургаалын зарчмууд</i> (31110), бүлэг 5 ба 6.</li><li>Шаардлагатай зүйлс:<ol style="list-style-type: none"><li>Ариун Библи</li><li>Хайчилбар 1-1 -ээс 1-25 (ижил төстэй хайчилбаруудыг Хүүхдийн хэсгийн үзүүлэн 3, 4, ба 5).</li><li>Зураг 1-33, Адам, Ева хоёр (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 101; 62461); зураг 1-34, Адам ба Ева, Өөрсдийн хүүхдүүдийг сургасан нь</li></ol></li><li>Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.</li></ol>
<b>Суралцах үйл ажиллагаа</b>	Хүүхдээр нээлтийн залбирал хийлгэ
Анхаарал татах үйл ажиллагаа	Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүр бос гэж хэл. Бид бүгдээрээ Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд тул бүгд босох ёстой гэдгийг сануул.
Дуу	“Би Бурханы хүүхэд” (Сүмийн Дуулал ба Хүүхдийн Дуу, 58-р хуудас) дууг бүх хүүхдүүдтэй хамт дуул. Дуун дээр Тэнгэрлэг Эцэг бидэнд дэлхийн орон гэрийг өгсөн гэдгийг хэл.  Би Бурханы хүүхэд тул Энэ дэлхийд намайг Их энэрэнгүй эх эцгийг Дэлхийн хамт заяав Тэр  Надад замаа олоход туслан Хөтлөн удирдаач Түүнтэй амьдрахын тул би Юу хийх ёстойг заагаач
Үйл ажиллагаа	<b>Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу дэлхий бүтээгдсэн</b> Хайчилбаруудыг доош харуулан ширээн дээр эсвэл өвдөг дээрээ тавь. <ul style="list-style-type: none"><li>Дэлхий дээр Есүсийн бүтээсэн зүйлсээс нэрлэнэ үү?</li></ul> Хүүхдийн нэрлэсэн бүтээл бүрийн хайчилбарыг харуул. <ul style="list-style-type: none"><li>Чи ямар бүтээлд нь илүү талархдаг вэ?</li></ul>



Хүүхдүүдийг дэлхий дээрх бүтээл бүхэн бидэнд зориулагдан бүтээгдсэн гэдгийг ойлгоход тусал. Энэ дэлхий дээрх юм бүхнийг Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн гэдгийг хэл.

Дуу

“Би Бурханы хүүхэд” дууг дахин дуул.

### **Адам Ева нар Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг байсан**

Хүүхдүүдэд хайчилбаруудыг үзүүл.

- Дэлхий дээр өөр юу хэрэгтэй вэ?

Зураг 1-33, Адам Ева хоёр, зургийг үзүүл. Дэлхий дээр бүх зүйлийг бүтээсний дараа Адам Ева хоёрыг бүтээсэн гэдгийг тайлбарла. Эхлэл 1:26–28-д гардаг хүнийг бүтээсэн тухай түүхийг ярьж өг. Адам Ева нар дэлхий дээрх анхны хүмүүс гэдгийг тайлбарла. Тэд Тэнгэрлэг Эцэгтэй адил дүр төрх, бие махбодтой байсан.

- Дэлхий дээрх анхны эрэгтэй хүн хэн бэ?
- Анхны эмэгтэйг хэн гэдэг вэ?
- Адам Ева нар ямар бие махбодтой байсан бэ?

Хүүхдүүдийг өөрсдийн гар хөлөө барьж мэдрэхийг хүс. Тэгээд бид Адам Ева нартай адилхан бие махбодтой гэдгийг сануул.

Түүх

Зураг 1-33, Адам Ева хоёр, дахин үзүүлж, өөрийн үгээр Адам Ева хоёрын тухай түүхийг дараах зүйлсийг тодруулан ярь (Эхлэл 2:15–25; 3-ыг үз):

1. Бие махбодийг хүлээн авсны дараа Адам Ева нар Едений Цэцэрлэг хэмээн нэрлэгдэх үзэсгэлэнтэй газар амьдарч байлаа.
2. Тэнгэрлэг Эцэг Адам Ева нарыг эхнэр нөхөр болгон мөнхийн холболтоор холбосон.
3. Едений Цэцэрлэгт жимс, ногоо амархан өөрсдөө ургадаг мөн амьтад аюулгүй дуулгавартай байлаа.
4. Адам Ева нар муу сайны ялгааг мэддэггүй байв.
5. Адам Ева нар хүүхэдтэй болох боломжгүй байв.
6. Адам Ева нар бүх модны жимс идэж болох боловч ганцхан модны жимсийг идэхийг хориглосон байв.
7. Адам Ева нар тэр модны жимснээс идэв.
8. Адам Ева нар Едений Цэцэрлэгийг орхин явах хэрэгтэй боллоо.
9. Бүх дэлхий өөрчлөгдсөн: Адам Ева нар хоол хүнсээ олж идэхийн тул хөдөлмөрлөх хэрэгтэй болсон. Зэрлэг хогийн ургамлууд ургаж, амьтад зэрлэгшсэн.
10. Адам Ева нар үр хүүхэд төрүүлж эхлэв.

Зураг 1-34, Адам Ева нар Хүүхдүүдээ сургаж байгаа нь зургийг үзүүл. Адам Ева нар олон хүүхэдтэй болох адислал хүртсэн. Тэд дэлхий дээрх анхны эх эцэг байсан бөгөөд хүүхдэдээ Тэнгэрлэг Эцэг, Есүсийн тухай заасан. Тэдний гэр бүлүүд өсөн үржиж дэлхий даяар тархсан.

- Адам Ева нар Едений Цэцэрлэгийг орхин явсны дараа юу хийсэн бэ?

Адам Ева болон тэдний хүүхдүүд дэлхий дээрх ан амьтад, ургамал ногоог хэрэглэж, тэд бүгдэд талархан баярлаж байв.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээр хуруун тоглоом тоглуул:

Адам ба Ева

Дэлхий дөнгөж шинэ байхад

Адам Ева дэлхий дээр амьдарч байв (*гараа аяга мэт болгон дэлхийг хий*)

Тэдний хоол хүнс нь бэлэн ургаж (*юм идэж байгаа мэт гараа амандаа хүргэ*).

Бас олон амьтад тэдэнд байв (*нэг гараараа нөгөө гараа ил*)

Адам Ева хоёр эцэг эх болж (*хоёр хуруугаа нийлүүл*)

Тэд бас хүүхэдтэй болов (*дахин хоёр хуруу нэмж гарга*).

Хичнээн олон хүүхэд төрснийг (*арван хуруугаа гозойлгон хөдөлгө*).

Дэлхий хичнээн том болсноос хар (*хоёр гараараа том тойрог хийгээд дараа нь хажуу тийш нь дэл*)!

Адам Ева хоёр дэлхийн анхны эцэг эх байсан тул бид тэдний гэр бүлийн нэг хэсэг болно гэдгийг ойлгоход нь тусал.

### **Тэнгэрлэг Эцэг, Есүс нар Дэлхийг сайхан болсон гэж хэлсэн**

Эхлэл 1:31-ийн эхний өгүүлбэрийг чангаар унш. Таныг даган чангаар хэлэхийг хүүхдүүдээс хүс. Тэнгэрлэг Эцэг, Есүс өөрсдийн бүтээсэн бүтээлүүддээ сэтгэл хангалуун байсан. Ялангуяа тэд биднийг маш сайн боллоо гэж маш их талархаж байдаг.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг болон Есүсийн биднийг хайрладаг хайрын талаар гэрчлэлээ хуваалц. Дэлхий болон түүн дээрх бүх зүйлс нь бидэнд зориулагдсан. Бид цэцэгс, одод болон бусад бүтээлүүдийг харах бүрт Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн хайрыг мэдэрдэг. Тэдний хайр хийгээд дэлхийг өгсөнд нь талархлаа хуваалц.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хичээл 8-13-аас “Бурханы бүтээл” эсвэл “Ноа” зэрэг хэд хэдэн үйл ажиллагааг сонгон ав.
2. Хуруугаараа бүтээлтийн өдрүүдийг тоолон, хэд дэх өдөр нь юу бүтээснийг ярь.
3. Хүүхдүүдтэй хамт “Тэнгэрлэг Эцэг надад хайртай” (*Children’s Songbook*, р. 228) дууг дуулах буюу үгийг хэл.
4. Хүүхдүүдээр Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний хэсэг болсон цэцэгс, модод эсвэл нар зэргийг зуруулах буюу өнгөөр ялган будуул. Хүүхдийн зурсан зурагны дээд талд *Би дэлхийд талархаж байна* гэж бич.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. “Дэлхий маш том” (*Children’s Songbook*, р. 235) дууны үгийг хэл.  
Хүүхдүүдээр үйлдлийг хийлгэ:

Дэлхий маш том өө, дув дугуй (*гараараа том дугуй хий*),

Энд Бурханы Бүтээлүүд байдаг;

Уулс (*толгой дээрээ уулын орой хий*)

Толгод (*алгаа доош харуулан урдаа барь*)

Өндөр модод (*гараа дээш сунга*),

Том амьтад (*дээш суна*)

Мөн жижиг амьтад (*доош бол*).

Дэлхий маш том өө, дув дугуй (*гараараа том дугуй хий*),

Бурхан бид бүгдэд нь хайртай, бидний адислал агуу их

(*гараа атгаж өөрийгөө тэвэр*).

2. Таныг дараах үгийг хэлж байхад хүүхдүүд хуруугаараа үйлдлүүдийг хийх:

Бурханы бүтээл

Бурхан сарыг хийсэн (*гараараа тойрог хий*)

Анивчих оддыг (*алгаа атгаж, нээ*)

Тэдгээрийг тэнгэрт тавьсан (*дээш суна*).

Тэр нарыг (*толгой дээрээ хоёр гараараа тойрог хий*)

Мөн моддыг (*гараа эгц өргө*)

Мөн цэцэгсийг (*алгаа аяга хэлбэртэй болго*)

Нисч буй бяцхан шувуудыг хийсэн (*гараараа дэв*).

(From *Fascinating Finger Fun* by Eleanor Doan. © 1951. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

# Хүндэтгэлийн өдөр бол бишрэн шүтэх өдөр

Хичээл  
**15**

---

## Зорилго

Хүүхэд бүрт Хүндэтгэлийн өдөр нь хүндэтгэл бишрэлийн өдөр гэдгийг ойлгоход нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Эхлэл 2:1–3 ба Египетээс гарсан нь 16:11–31-ийг уншиж судал. Мөн *Сургаалын Зарчмууд* (31110), бүлэг 24.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи.
  - б. Зураг 1-6, Гэр бүлийн үдэш (62521); зураг 1-7, Хайртай гэр бүл; зураг 1-8, Ариун Ёслол түгээж байгаа нь (62021); зураг 1-9, Өглөөний залбирал (62310); зураг 1-10, Гэр бүлийн залбирал (62275); зураг 1-35, Манна цуглуулсан нь; зураг 1-36, Судрын түүх уншиж буй эх эцэг ба хүүхдүүд.
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдээр бүтээлтийн өдөр бүрийг дүрслэн үзүүлэхийг урь. Та тэдэнд юу болсныг хэлж өг (Эхлэл 1-ийг үз):

Нэг дэх өдөр. Унтаж байгаад сэргэж буй мэт бол энэ нь өдөр шөнө гэсэн үг.

Хоёр дахь өдөр. Бос, эргэн тойрноо хар, гараа өргөнөөр тэлж тэнгэр хий.

Гурав дахь өдөр. Цэцэг зулгаан үнэрлэж байгаа мэт үйлдэл хий.

Дөрөв дэх өдөр. Гараараа том, жижиг дугуйнуудыг хийж, нар, сарыг дүрсэлж, мөн хуруугаа хөдөлгөнгөө гараа хөдөлгөж оддыг дүрсэл.

Тав дахь өдөр. Өрөөн дотроо нисч буй шувуу эсвэл далайд шумбан буй загас бол.

Зургаа дахь өдөр. Амьтан бол. Өрөөн дотроо нааш цааш ямар нэгэн амьтан болон алх. Дараа нь босч эгнээгээр зогсон, “Миний нэр (хүүхэд өөрийн нэрээ хэл). Би бол Бурханы хүүхэд” гэж хэл.

Хүүхдүүдийг чимээгүй буцан суухыг урь.

Хүүхдүүдэд долоо дахь өдөр Тэнгэрлэг эцэг, Есүс амарсан гэдгийг хэл. Энэ өдрийг Хүндэтгэлийн өдөр гэдэг.

Хүүхдүүдээр *Хүндэтгэлийн өдөр* хэмээн хэд хэдэн удаа давтан хэлүүл.

## Хүндэтгэлийн өдөр нь Ариун өдөр

Эхлэл 2:1–2 ба шүлэг 3-ийн өдөр гэдэг үг хүртэл унш. Тэнгэрлэг Эцэг ба Есүс дэлхийг болон түүн дээрх бүгдийг бүтээж дуусан, долоо дахь өдрийг адисалсан гэдгийг тайлбарла. Долоо хоногийн бусад өдрөөс онцгой, Ариун өдөр байхаар бүтээгдсэн. Хүндэтгэлийн өдөр нь бид ажлаасаа амарч, Тэнгэрлэг Эцэг, Есүс нарыг шүтэн бишрэх өдөр юм.

- Долоо хоногийн хэд дэх өдөр Хүндэтгэлийн өдөр вэ?
- Тэнгэрлэг Эцэг болон Есүс Хүндэтгэлийн өдөр юу хийсэн бэ? (Эхлэл 2:2-ыг үз.)

Үйл ажиллагаа

Хүүхдүүд долоон хуруугаа гозойлгоно. Тэдэнтэй хамт хуруугаа нэг нэгээр нь хөдөлгөн долоо хүртэл тоол. Зургаан өдөрт (зургаан хуруугаа хөдөлгө), бид ажлаа хийнэ. Долоо дахь өдөр нь (долоо дахь хуруугаа хөдөлгө), Хүндэтгэлийн өдөр учир бид амрах болно.

Түүх

Зураг 1-35, Манна цуглуулсан нь зургийг үзүүлж Израилчууд болон маннагийн тухай Египетээс гарсан нь 16:11–31 дахь түүхийг ярьж өг.

Хүүхдүүдэд маннагийн гайхамшгийн тухай ойлгоход нь тусал. Израилчууд өдөр бүр яг өдрийнхөө хэрэгцээндээ хангалттай маннаг цуглуулж, харин зургаа дахь өдрөө хоёр өдрийн хэрэгцээгээ цуглуулдаг байсан гэдгийг тайлбарла. Хэрэв Израилчууд ганц зургаа дахь өдөр биш бусад өдрүүдэд бас хэрэгцээнээсээ илүүг цуглуулбал энэ нь муудаж өмхийрдэг байлаа. Хүндэтгэлийн өдөр болох долоо дахь өдөр цуглуулах манна байдаггүй байв. Энэ өдөр Израилчууд зургаа дахь өдрөө цуглуулсан илүү маннагаа иддэг байв.

- Израилчууд яаж хүнсээ бэлтгэж байсан бэ?
- Яагаад тэд Хүндэтгэлийн өдөр манна цуглуулдаггүй байсан бэ?

Египетээс гарсан нь 16:26-г чангаар унш. Израилчууд Хүндэтгэлийн өдөр ажиллах ёсгүй гэдгийг тэдэнд заасан байсан гэдгийг тайлбарла. Хүндэтгэлийн өдөр Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг өөрсдийн ажлын тухай бодохын оронд, Тэдний тухай бодохыг хүсдэг. Хүндэтгэлийн өдөр нь Тэнгэрлэг Эцэг, Есүсийн хувьд маш ариун өдөр юм.

Хүндэтгэлийн өдөр ажиллаж, үргэлж хийж заншсан зүйлээ хийдэг өдөр биш харин Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг хүндэтгэн бишрэх өдөр. *Бишрэн хүндэтгэх* гэдэг нь Тэнгэрлэг Эцэг ба Христийн тухай бодож, тэдэнд хайртайгаа харуулсан зүйлсийг хийх ёстой гэсэн үг.

## Хүндэтгэлийн өдөр нь бишрэн шүтэх өдөр

Хүүхдүүдэд Хүндэтгэлийн өдөр нь Тэнгэрлэг Эцэг ба Есүсийг олон янзын аргаар хүндэтгэн шүтэх боломжтой тул баяр баясгалангийн өдөр юм гэдгийг ойлгоход нь тусал.

- Тэнгэрлэг Эцэг, Есүст хайраа үзүүлэх ямар зүйл чи өнөөдөр хийсэн бэ?

Тэнгэрлэг Эцэг, Есүсийг хүндэтгэн бишрэх болон хайраа харуулах нэг чухал арга бол сүм дээрээ ирж ариун ёслолоосоо хүртэх явдал юм.

Зураг 1-8, Ариун Ёслол хүртээж байгаа нь, зургийг үзүүл. Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг дуулж, сонсож, дуулгавартай байж, багш нарыгаа сонсон сайн томоотой байж, Тэнгэрлэг Эцэгийн болон Есүсийн хайрыг улам ихээр мэдэх боломжтой байхад маш их баяртай байдаг.

Үйл ажиллагаа

Дараах хуруун тоглоомыг хүүхдүүдээр тоглуул:

Өнөөдөр би сүмдээ ирсэндээ баяртай байна

Би өнөөдөр сүмдээ ирсэндээ баяртай байна (*эрхий ба долоовор хуруунуудаа нийлүүлэн цагираг хийгээд үлдсэн хуруунуудынхаа үзүүрийг нийлүүлэн сүмийн орой хий*).

Би сонсож сурдаг (*чихэн дээрээ гараа дэлгэн барь*)

Бас залбирч (*гараа нугалан толгойгоо бөхийлгө*).

Би өндөр дээд Есүсээс суралцдаг (*дээш заа*);

Би Есүс болон Түүний хайрын тухай боддог (*өөрийгөө тэвэр*).

Сүмдээ ирэхдээ бид цэвэр цэмцгэр байж, Тэнгэрлэг Эцэг, Есүс нартаа өөрсдийн хайраа харуулж болно. Бид нүүр гараа угааж, үсээ самнан, хамгийн сайхан цэвэр хувцсаа өмсөн сүмдээ ирэх ёстой.

Үйл ажиллагаа

Хүүхдээр сүмдээ ирэхээр бэлтгэж байгаа тухай хөдөлгөөнт дүрслэлийг хийлгэ.

- Тэнгэрлэг Эцэг ба Есүсийг бишрэн шүтэх ямар зүйлсийг бид сүм дээр хийдэг вэ?
- Тэнгэрлэг Эцэг ба Есүсийг бишрэн шүтэх ямар зүйлсийг бид гэртээ хийж чадах вэ?

Хүндэтгэлийн өдөр бид мөнгө зарцуулах худалдаа наймаа хийж дэлгүүр явдаггүй. Мөн биеийн тамир хийж, зурагт үзэх болон бусад зугаа цэнгэлийн зүйлс хийдэггүй. Хүндэтгэлийн өдөр бид цэцэрлэг талбай дээрээ ажилладаггүй, загасчлах болон ан гөрөө хийдэггүй.

Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалах олон зүйлсийг гэртээ бид хийж чадна. Ярилцлагын үеэр “Бэлтгэл” хэсгээс бэлтгэсэн зурагнуудаа тохиромжтой үед нь үзүүл. Бид гэр бүлийнхэнтэйгээ намуухан тоглоом тоглож, судруудаас түүх уншуулж, гэр бүлийн зургийн цомог хийж, ахан дүүс хамаатан садан болон өвчтэй найз нөхдийнхөөрөө айлчилж, өөрсдийн талархаж байдаг зүйлсийнхээ тухай зураг зурж, гэр бүлийнхэнтэйгээ салхинд явган алхаж, залбирал хэлж, дуу дуулан, зохистой сайхан хөгжим сонсож болно.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээр Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалахын тулд хийдэг зүйлсээ хөдөлгөөнт дүрсээр хийн үзүүлэхийг хүс.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг сүмдээ ирж, дуугаа дуулан, залбирлаа хэлж, багш нарыгаа дуулгавартай сонсоход маш их баяртай байдаг гэдгийг хэл. Тэд мөн Хүндэтгэлийн өдөр биднийг гэртээ зөв зохистой байхад баярладаг. Хүндэтгэлийн өдөр хийх дуртай бишрэлтэй зүйлсийнхээ талаар мөн энэ өдөр ямар их баяртай байдаг тухайгаа ярилц. Хүүхдүүдийг энэ хичээлээс сурсан зүйлсийнхээ талаар гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахыг уриалан зоригжуул.

---

**Баяжуулах үйл  
ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Ангийн хүүхэд тус бүрт нэг бадгийг зохиож, дараах үйл ажиллагааг хий. Хүүхдүүдийг хамтдаа хөдөлгөөнийг нь хийхийг урь.

Өнөөдөр Ням гараг учир

*Нэг хүүхдийг зааж, хүүхдийн нэрийг хэлэн дараах мөртүүдийг хэлэнгээ үйлдлийг хий:*

(Хүүхдийн нэр) өнөөдөр судраас сонссон (*гараа атган чихэн дээрээ барь*).  
(Хүүхдийн нэр) өнөөдөр Ням гараг учир тэр судраас суралцаж сонссон.

*Дараах санаануудыг ашиглан хүүхэд бүртэй үүнийг давтан хий:*

(Хүүхдийн нэр) Хүүхдийн хэсгийн ангидаа залбирал хийсэн (*гараа нугалан, толгойгоо бөхийлгөж, нүдээ ань*).

(Хүүхдийн нэр) өнөөдөр зураг зурсан (*гараараа зурах хөдөлгөөн хий*).

(Хүүхдийн нэр) өнөөдөр ганцаардсан нэгнийд зочилсон (*хүүхдэдтэй гар барин таларх*).

(Хүүхдийн нэр) өнөөдөр гэр бүлийн түүх суралцсан (*хуудас эргүүлэн зураг үзэж буй хөдөлгөөн хий*).

(Хүүхдийн нэр) өнөөдөр эмээ, өвөөдөө захидал бичсэн (*юм бичиж буй бол*).

(Хүүхдийн нэр) өнөөдөр түүх сонссон (*гараа атган чихэн дээрээ тавь*).

2. Өөрийн үгээр дараах түүхийг ярь:

Анхдагч нар Солт Лейкийн хөндийд амьдрахаар олон мянган бээр газрыг туулан аялсан. Тэд Хүндэтгэлийн өдрөөс хэдхэн хоногийн өмнө хүрэх газраа ирэв. Тэд амьдрах байшингаа барьж, тариагаа тарих хэрэгтэй байсан ч Хүндэтгэлийн өдөр ажиллахгүй байхаар шийдсэн. Тэд маш их ажиллаж, түргэн газраа хагалан, тариагаа тарихад бэлэн болгов. Газрын хөрс маш хатуу байсан учир тэд хөрсийг хангалттай чийглэн, анжсаар ажиллах боломжтой болгосон. Хагас сайн өдрийн орой гэхэд тэд маш том талбайд ногоо тариалж дууссан байлаа. Ням гарагийн өглөө тэд өөрсдийн Хүндэтгэлийн цуглаандаа явж, Тэнгэрлэг Эцэгтээ шинэ газарт авчран, амьдрах боломжийг өгсөнд нь талархлаа илэрхийлэв.

3. Хүүхдүүдээр Хүндэтгэлийн өдрийн үйл ажиллагаанд оролцож буй өөр өөрсдийгөө зурахыг хүс. Зурсан зургуудынхаа тухай нэрлэн ярилцуул. Хүүхдүүдийн нэр болон хийж буй зүйлийг нь зураг дээр бич. Жишээ нь: *Давид Хүндэтгэлийн өдөр хүүхдийн дуу дуулж байна.*

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Та доорх үйл хөдлөлт шүлгийг хэлж хүүхдүүд үйлдлийг нь хийнэ:

Бүтээлт

Есүс нар мандаг (*гараараа том тойрог толгой дээрээ хий*),

Бороо орог (*хуруунуудаа хөдөлгөн гараа доош хөдөлгө*),

Цэцэгс ургаг хэмээн хэлэв (*гар алгаа дээш харуулан аяга мэт болго*).

Мөн Есүс шувууд жиргэг (*шувууны хошуу мэт гарын хуруугаа хөдөлгө*),  
Хэмээн хэлэхэд бүгд түүний хэлснээр болов (*гараа урдаа зөрүүлэн нугал*).  
(Johnie B. Wood, in *Sing, Look, Do, Action Songs for Children*, ed. Dorothy M.  
Peterson [Cincinnati: Standard Publishing Co., 1965].)

Дэлхийн бүтээлт дууссаны дараа Тэнгэрлэг Эцэг, Есүс нар амарсан  
болохыг тайлбарла. Хүндэтгэлийн өдөр бид амардаг. Энэ өдөр бид  
амрахдаа Тэнгэрлэг Эцэг, Есүсийг санан дурсдаг.

2. Өөрсдийн ажлаа хагас сайн өдөр хийж дуусгавал Ням гарагт бид  
Тэнгэрлэг Эцэг, Есүсийг санахад хялбар болно.



---

**Зорилго**

Хүүхэд бүрийг өөрийн бие махбодийг хайрлан хүндэтгэхэд туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Даниел ба Сургаал ба Гэрээ 89-ийг уншиж судал. *Сургаалын зарчмууд* (31110), бүлэг 29-ийг үз.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи, Сургаал ба Гэрээ
    - б. Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл (62307); зураг 1-37, Даниел, Хааны мах болон дарснаас татгалзсан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 114; 62094); зураг1-38, Бөмбөгөөр тоглож буй хүүхэд.
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.  
Багшид анхааруулах нь: Тухайн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал тэдэнд мэдрэмтгий бай. Тэдний бие махбодийн хийж чаддаггүй зүйлсэд бус харин хийж чадах зүйлсэд анхаарал хандуул.
- 

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг босгож зогсоо. Тэднээр “Толгой, мөр, өвдөг хөл” (*Children’s Songbook*, р. 275) дууг дуулуулах эсвэл үгийг хэлүүлэн, хөдөлгөөнийг хийлгэ. Дуугаа үйлдлээ хийн тухайн эрхтнээ заахаар хангалттай удаан дуул. Эсвэл биеийн эрхтэнээ хөдөлгө. Жишээ нь: Толгойгоо дохь, мөрөө хавч, өвдгөө нугал, өлмий дээрээ зогс.

Толгой, мөр, өвдөг, хөл, өвдөг, хөл, өвдөг, хөл  
Толгой, мөр, өвдөг хөл, нүд, чих, ам, хамар

Хүүхдүүдэд энэ дууг дуулахад бид өөрсдийн биеийн эрхтэнүүдээ нэрлэн дууллаа гэдгийг тайлбарла.

**Тэнгэрлэг Эцэг хүн бүр бие махбодтой байхаар төлөвлөсөн**

Бид дэлхийд ирэхээсээ өмнө Тэнгэрлэг Эцэг, Есүс Христтэй хамт амьдардаг байхад махан бие бидэнд байгаагүй гэдгийг сануул. Бид сүнснүүд байсан. Бид махан биетэй болохын тул дэлхийд ирсэн. Тэнгэрлэг Эцэг бидэнд зориулан дэлхийг бүтээж, бид төрж, биднийг өсгөн хүмүүжүүлэх эх эцгийг хамт байлгахаар төлөвлөсөн.

Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл зургийг үзүүл.

- Энэ зурган дээр хэн хэн байна?
- Биднийг дэлхийд төрж, гэр бүлтэй байх төлөвлөгөөг хэн хийсэн бэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босгон зогсоож, таныг даган дээрээс доош өөрсдийн толгойноос (*толгойндоо хүр*) хөлийн хуруу (*хөлийн хуруундаа хүр*) хүртэл тайлбарлан хэлэхэд даган хийхийг урь. Бидний нүүр (*инээмсэглэ*) бидний хуруунууд (*хуруунуудаа хөдөлгө*) нь бидний биеийн нэгэн хэсэг. Хүүхдүүдийг дороо нэг эргээд буцаан суудалд нь суулга.

Бидний бие маш олон зүйлийг хийж чадна гэдгийг тайлбарла. Бидний эрхтэн бүр өөрсдийн онцгой үүргүүдтэй.

- Чи нүдээрээ юу хийж чадах вэ?
- Чиний чих юу хийж чадах вэ?
- Чи амаараа юу хийж чадах вэ?
- Чи гараараа юу хийж чадах вэ?
- Чи шүдээрээ юу хийж чадах вэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босгож дараах хөдөлгөөнүүдийн хийлгэ:

Надад гайхамшигтай бие махбод бий

Тэнгэрлэг Эцэгийн надад зориулан төлөвлөсөн  
Гайхамшигтай бие бий (*цээжиндээ гараараа хүр*)  
Тэр надад сонсох чих (*гараараа чихэндээ хүр*)  
Мөн харах нүд өгсөн (*нүд рүүгээ заа*).

Надад алга таших хоёр гар бий (*алгаа таш*),  
Эргэлдэж болох хоёр хөл бий (*дороо эргэлд*).  
Хэрэв би хүсвэл хөлнийхөө  
Хуруунд хүрч чадна (*доош тонгойж, хөлнийхөө хуруунд хүр*).

Би өөрийн биеийн тухай бодох үед (*долоовор хуруугаа толгойндоо хүргэ*),  
Хамгийн чухал нь (*чимээгүй доош суу*)  
Түүнтэй адилхан харагдахаар  
Тэнгэрлэг Эцэг намайг төлөвлөсөн

### **Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ биднийг өөрсдийн биеэ арчлан хайрлахыг хүсдэг**

Бидний бие махбод маш чухал учир Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нар бидэнд түүнийг арчлан эрүүл чийрэг, хүчтэй байлгах заавруудыг өгсөн. Энэ зааврыг Мэргэн Ухааны Үг хэмээн нэрлэдэг. Сургаал ба Гэрээ судар (эсвэл судруудын эмхэтгэл номон дээр Сургаал ба Гэрээ эхэлдэг хэсгийг) харуул. Мэргэн Ухааны Үг энэ судар номон дээр бичигдсэн гэдгийг тайлбарла.

Мэргэн Ухааны Үг-д заасан бидний биеийг эрүүл чийрэг, хүчтэй байлгах жимс, ногоо, үр тариа зэрэг хүнсний зүйлүүдийн тухай ярилц. Мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс нарын биднийг бүү хэрэглэ гэсэн тамхи, архи, кофе зэрэг зүйлсийн талаар ярилц. Хүүхдүүдэд Мэргэн Ухааны Үгийн хуулийг дуулгавартайгаар сахин, зөв сайн хоол хүнс хэрэглэж байвал Тэнгэрлэг Эцэг болон Есүс баярлаж мөн биднийг улам ихээр адислах болно гэдгийг ойлгоход нь тусал.

Даниел 1 дээр гардаг Даниел Тэнгэрлэг Эцэгийн хүссэн хоол хүнсийг идэж байсан түүхийг ярь. Зураг 1-37, Даниел, Хааны мах болон дарснаас татгалзсан нь, зургийг тохиромжтой үед нь үзүүл.

- Хаан Даниелийг түүнд сайн биш хоол хүнсийг идэхийг хүсэхэд тэр яасан бэ? (Даниел 1:8, 12–13-ыг үз.)
- Юу идэж болохыг заасан Тэнгэрлэг Эцэгийн үгийг дагаснаар Даниел ба түүний нөхөд хэрхэн адислагдсан бэ? (Даниел 1:15, 17, 20-ийг үз.)
- Чи ямар эрүүл хүнс хэрэглэдэг вэ?
- Яагаад чи эрүүл хүнс хэрэглэдэг вэ?
- Өөрт сайн хоол хүнс хэрэглэхэд чи ямар мэдрэмж авдаг вэ?

Бид өөрсдийн биеэ эрүүл чийрэг, хүчтэй байлгахын тул бусад зүйлсийг бас хийх хэрэгтэй гэдгийг тайлбарла.

Зураг 1-38, Бөмбөгөөр тоглож буй хүүхэд зургийг үзүүл

- Энэ хүүхдүүд юу хийж байна?
- Бид дасгал хийх нь биед ямар хэрэгтэй вэ?
- Бид өөр ямар дасгалууд хийж болох вэ?

Хоёр гараа алгаар нь нийлүүлэн нүүрнийхээ хажууд барьж унтаж байгаа мэт нүдээ ань.

- Би юу хийж байна вэ?
- Бид хангалттай нойроо авч, унтах нь яагаад чухал вэ?

Гараа угааж байгаа мэт бол.

- Би юу хийж байна вэ?
- Бид хэзээ гараа угаах хэрэгтэй вэ?
- Хэзээ бид усанд орох ёстой вэ?
- Бид хэзээ шүдээ угаах ёстой вэ?
- Бид яагаад цэвэр цэмцгэр байх ёстой вэ?

Цаг агаарт тохирсон зөв хувцаслах, аюулгүй сайн тустай зүйлсийг хийх, цэвэр агаарт алхах зэрэг эрүүл мэндэд тустай бусад зүйлсийн тухай ярилц.

### **Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ өөрсдийн биеийг арчлан хамгаалж байхыг биднээс хүсдэг**

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ биднийг өөрсдийн биеэ элдэв аюул осол, бэртлээс хамгаалж байхыг хүсдэг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдээс тэдэнд тулгарч болох элдэв аюул ослын талаар өөрийн болон дараах асуултуудыг асуун ярилц:

- Хэрэв шүдэнзээр тогловол юу болж болзошгүй вэ?
- Хэрэв машин зам дээр юм уу ойролцоо нь тогловол юу болж болзошгүй вэ?

- Хэрэв хутга хайч зэрэг хурц зүйлээс болгоомжтой байхгүй бол яах вэ?
- Машинаар явахдаа бид яагаад хамгаалалтын бүс хэрэглэдэг вэ?

Бид өөрсдийн биеийг хамгаалах ёстой гэдгийг хэл. Биднийг гэмтээх аюултай, бие махбодид маань аюултай зүйлсийг хийж болохгүй. Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг найдвартай хамгаалалттай, аз жаргалтай байхыг хүсдэг гэдгийг тайлбарла. Тэд мөн биднийг биеэ арчлан хамгаалснаар эрүүл байгаасай хэмээн хүсдэг.

Гэрчлэл

Өөрийн бие махбодийн тухай түүнд талархалтай байдаг талаар гэрчлэлээ хуваалц. Мөн хүүхдүүд өөрсдийн биеийг арчлан эрүүл чийрэг хүчтэй байгаад талархалтай байгаагаа хэл.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. “Намайг дагаад хий” (*Children’s Songbook*, р. 276) дууны хөдөлгөөнийг хийж дуул эсвэл үгийг нь хэл. Дууны үгийг 36-р хичээлээс харж болно. Олон янзын зүйлсийг хийж болох ийм бие байгаад талархаж байгаагаа хүүхдүүдэд хэл.
2. Төрөл бүрийн хоол хүнс болон уух ундааны зурагнууд авчир. Хүүхдүүдээр аль бидний биенд сайн, муу болохыг хэлүүл. Зарим зүйлс сайн боловч хэтэрхий ихээр хэрэглэвэл муу болохыг тайлбарлан хэл. Жишээ нь: чихэр хэдий амттай ч ихээр идвэл биднийг өвчтэй болгодог. Хүүхдүүдэд сайн зүйлстэй зурагнуудыг дэлгэн үзүүл.
3. Уутанд юм уу хайрцаганд бидний биеэ арчлан тордоход хэрэглэдэг зарим зүйлсийг хий. Үүнд: Бид ариун цэврийг сахихад хэрэгтэй саван, бие угаагч, жижиг алчуур, шүдний сойз, эрүүл хүнсний зүйлс, жижиг хөнжил болон дасгал хөдөлгөөн хийх бөмбөг зэрэг зүйлс байж болно. Хүүхдүүдэд эхлээд тухайн зүйлийн тухай таамаглалуудыг хэлж, дараа нь таалга. Тэгээд хүүхдийг таасан үед уут буюу хайрцагнаасаа гарган харуул. Уутан дахь бүх зүйлсийг дуустал хий.
4. Хүүхдүүдийг босгон, өөрсдийн биеийг цэвэрлэж байгаа хөдөлгөөнт дүрслэлийг үзүүлэхийг хүс. Гараа угаах, шүдээ угаах, үсээ самнах зэрэг үйлдэл хийж байгаа мэт бол. Дараа нь тэднээр хамгийн дуртай усанд сэлэх, алхах, дэвхрэх, гулгах, бөмбөг шидэх зэрэг дасгал хөдөлгөөнийг үзүүлэхийг хүс.
5. Зарим хүмүүсийн бие махбод хөгжлийн ямар нэгэн бэрхшээлтэй байдаг тухай ярь. Бид тэдгээр хүмүүсийг шоолж дооглон, ад үздэггүй. Бид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн тусалж чадах болон тэдэнд хэрхэн хандах талаар ярилц (тэдэнтэй ярилцаж, найз нь байж, бусадтай адил харьцаж, хэрэв тусламж хэрэгтэй бол тусламж үзүүл).
6. Хүүхдүүдээр өөрсдийг нь зуруул. *Би өөрийн биед талархаж байна* гэж бич.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл, зургийг үзүүл. Хүүхдүүдээр зургийн талаар яриул.

- Чи жаахан нярай байсан уу?
- Нярай хүүхдүүд явж, ярьж чадах уу?

Бид бүгдээрээ нярай хүүхэд байсан гэдгийг хэл. Гэхдээ одоо бүгд өсч том болсон тул тэдний бие махбод олон зүйлийг хийж чадна. Өсөн том болох тусам улам л олон зүйлийг хийж чаддаг болно.

Зураг 1-16, Есүс Христ мэндэлсэн нь, Есүс мөн нярай жаахан хүүхэд байсан гэдгийг сануул.

2. Өөрийн ам руугаа заагаад: “Энэ миний ам” гэж хэл. Дараа нь “Чи өөрийн амаа харуулж чадах уу?” гэж асуу. Тэгээд хүүхдүүдэд өөрсдийн амаа заахад нь тусал. Үүнтэй адил нүд, хамар, чих, гар болон хөлөө заа. Дараа нь биеийнхээ хэсэг бүрийг нэрлэлгүйгээр зааж хүүхдүүдээр хэлүүл. Хэрэв хүүхдүүд бүгдийг зөв таавал хүүхдүүдийн сайн нэрлэж мэдэхгүй биеийн эрхтэнийг зааж болно. Жишээ нь: өвдөг, тохой, бугуй, шагай зэрэг.

3. Өөрийн хэсгийн нэгэн бяцхан хүүхдийн тухай энгийн түүх зохион ярилц. Тэр хүүхэд өглөө сэрж, хувцсаа өмсөж, өглөөний ундаа уух зэрэг өдрийн турш хийх зүйлсийг ярилц. Түүхийг ярьж байхдаа хэлж буй үйлдэл бүрийг хүүхэд биеийн аль хэсгээрээ хийж буйг хүүхдүүдээс асуу.

4. Хүүхдүүдийг босч зогсоод дараах үгсийг “Нэгэн цасан хүн байжээ” (*Children’s Songbook*, р. 249) дууны аянд дуул. Эхний бадгийг дуулахдаа биеэ хумин атийж, хоёр дахь бадгийг дуулахдаа тэнийн суниах хөдөлгөөн хий.

Би нэгэнтээ бяцхан жаахан хүүхэд байсан,  
Би бяцхан хүүхэд байхдаа маш жижигхэн байсан.

Одоо би өсч том бүр том болж байна,  
Одоо би өсч том болон өндөр болж байна!

# Надад гар байгаад би талархдаг

Хичээл  
17

---

## Зорилго

Өөрсдийн гар, түүний хийж чадах зүйлд талархаж сурахад нь хүүхдүүдэд туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Матай 19:13–15 ба Сургаал ба Гэрээ 20:70; 35:6; 42:43–44-ийг уншиж судал.
2. Дотор нь төрөл бүрийн даавууны өөдөс, янз бүрийн хэлбэр дүрстэй чулуу, навч, халбага, сам болон харандаа хийсэн уут юм уу хайрцаг бэлтгэ. Хүүхэд бүрт оногдохоор тоотой байвал зүгээр.
3. Хэрэв боломжтой бол хүүхэд бүрт дохионы хэлний заавартай хуудаснууд тарааж өг (хичээлийн төгсгөлд хавсаргасан)
4. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Товч юм уу задгай мөнгө буюу ямар нэгэн жижиг зүйл.
  - в. Зураг 1-8, Ариун Ёслол түгээж байгаа нь (62021); Зураг 1-11, Усаар батлуулж буй жаал хүү (62018); зураг 1-12, Ариун Сүнсний бэлэг хүлээн авч буй охин (62020); зураг 1-39, Хүүхдийн адислал; зураг 1-40, Өвчтөнийг эдгээсэн нь (62342).
5. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

Багшид анхааруулах нь: Тухайн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал тэдэнд мэдрэмтгий бай. Тэдний бие хийж чаддаггүй зүйлсэд бус харин хийж чадах зүйлсэд анхаарал хандуул.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүд харалгүйгээр уутанд гараа хийн доторх зүйлийг тэмтрэн мэдрэхийг урь. Хүүхдээс гарт баригдсан зүйлийг барьснаар юу мэдрэгдэж байгааг (зөөлөн, хатуу, гөлгөр, барзгар), тэгээд юу болохыг таахыг хүс. Дараа нь хүүхдийг уутнаас гарган ангийнхандаа үзүүлэхийг хүс. Хүүхдүүдээр бариулж үзүүл. Хүүхэд бүрээр үүнийг хийлгэ.

- Уутан дахь зүйлийг авахын тул чи юугаа хэрэглэсэн бэ?
- Баригдсан зүйлийг мэдрэхийн тул чи юу хэрэглэсэн бэ?

Бидний гар бол бидэнд өгөгдсөн агуу адислал гэдгийг тайлбарла. Бид гараа маш олон зүйлд ашигладаг.

### Бид гараараа олон зүйлийг хийж чадна

Хүүхдүүдээр өөрсдийнх нь гарыг бариулж гараа харахыг хүс. Хүүхдүүдтэй тэд гараараа юу хийж чадах талаар ярилц. Тэд эрхий хуруу болон бусад

хуруунуудаараа ямар нэгэн зүйлийг барьж авч чадна. Тэд алган дээрээ ямар нэгэн зүйл тогтоон барьж чадна. Гараараа даллаж чадна. Гараа бүх чиглэлд эргүүлж чадна.

Үйл ажиллагаа

Өөрийн эрхий хуруугаа оролцуулалгүйгээр товч юм уу задгай мөнгө зэрэг жижиг зүйлийг түүж авахыг хичээ. Хүүхдэд бидний биеийн жижиг хэсэг ч маш чухал болохыг хэл.

Үйл ажиллагаа

- Сүмд ирэхээр бэлтгэхэд чиний гар хир тусалдаг вэ?

Хүүхдүүдийг өглөө босоод хийдэг зүйлүүдээ хөдөлгөөнөөр дүрслэн үзүүлэхийг урь. Жишээ нь: Гар нүүрээ угаах, хувцсаа өмсөх, үсээ самнах, юм идэх, шүдээ угаах.

- Гар тоглоход яаж тусалдаг вэ?

Хүүхдүүдээр бөмбөг шидэхэд, хүүхэлдэйгээ хооллоход, элсээр байшин барихад эсвэл бөмбөр тоглоход гараа хэрхэн хэрэглэдэг талаар хөдөлгөөнт дүрслэл хийн үзүүлэхийг хүс.

- Ажил хийхэд гар яаж тусалдаг вэ?

Хүүхдүүдээр тоглоомоо хураах, ширээгээ засах, ороо хураах, гэрийн амьтнаа хооллоход гар яаж тусалдгийг дүрслэн үзүүлэхийг хүс.

- Сүм дээр ирэхэд гар яаж тусалдаг вэ?

Хүүхдүүдээр сүм дээр хийдэг гар барих, зураг үзүүлэх, асуултанд хариулахаар гараа өргөх эсвэл ариун ёслолоос хүртэх зэрэг зүйлсийг дүрслэн үзүүлэхийг хүс.

Бидний гар бидэнд өгөгдсөн агуу том адислал бөгөөд Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг гараа өөрсдөдөө болон бусдад туслахад ашиглаасай хэмээн хүсч байдаг гэдгийг ойлгоход нь тусал. Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг гараараа бусдад энэрэнгүй биш бусдыг цохих, чимхэх, маажих зэрэг муухай зүйл хийхийг хүсдэггүй. Тэд биднийг гараа сайн зүйл хийхэд зориулахыг хүсдэг.

### **Бусад хүмүүс өөрсдийн гараа бидэнд туслахын тул хэрэглэдэг**

- Та нарын аав ээж болон гэр бүлийн бусад гишүүд та нарт туслахын тулд гараа хэрхэн хэрэглэдэг вэ?

Бидний гэр бүлийнхэн бидний хоолыг бэлтгэдэг. Бидний хувцас угаадаг. Бидний гутлын үдээсийг үдэж өгдөг. Бидэнтэй хамт тоглодог. Мөн бусад олон зүйлийг бидний төлөө хийдэг.

Санваарын эрх мэдэлтэй ах нар өөрсдийн гарыг бидний толгой дээр тавьж адислал өгдөг гэдгийг тайлбарла. “Бэлтгэл” хэсгээс авсан зурагнуудыг нэг нэгээр нь хүүхдүүдийг юуны адислал хийж буйг хэлүүлэн, олон төрлийн адислалуудыг бид санваарын эрх мэдэлтэн ах нараасаа авч чадна гэдгийг хэл. Тэд биднийг бяцхан хүүхэд байхад хүүхдийн адислал өгдөг. Найман нас хүрэхэд баптисм хүртэж чадна. Баптисм хүртсэний дараа бид ариун сүнсний бэлгийн адислал хүртдэг. Бид санваартан ах нарын адислан түгээдэг талх усыг долоо хоног болгон болдог ариун ёслолоосоо хүртэж чадна. Биднийг өвчтэй байхад эрүүл мэндийн адислал мөн өгдөг.

Түүх	<p>Ариун Библиэ нээн, Матай 19:13–15 дахь Есүс хүүхдүүдийг адисалдаг түүхийг ярьж өг.13-р шүлгийн эхний хэсгийг чанга дуугаар “залбируулах” гэдэг үгийг дуустал унш. Есүс хэрхэн өөрийн гарыг ашиглан хүүхдүүдийг адисалсан тухай ярь.</p> <p>Есүс гараа ашиглан өвчтэйг адислах, сохрыг хараа оруулах, нас барсныг амилуулах зэрэг өөр олон замаар бусад олон хүмүүст тусалсан гэдгийг тайлбарла.</p> <p><b>Бидний гар ярьж чадна</b></p> <p>Гараараа далла эсвэл дохь. Гараараа юу гэж хэлж буйг хүүхдүүдээс асуу.</p> <p>Зарим хэлгүй дүлий хүмүүс сонсож ярьж чадахгүй учраас өөрсдийн гараараа дохио хийж үгсийг хэлдэг гэдгийг тайлбарла. Тэд гараараа ярьдаг. Үүнийг дохионы хэл гэж нэрлэдэг.</p>
Үйл ажиллагаа	Хичээлийн төгсгөлд тарааж өгсөн дохионы хэлний заавартай хуудсыг ашиглан “аав”, “ээж”, “Би чамд хайртай” гэдгийг Америкийн дохионы хэлээр хэрхэн хэлдгийг зааж өг. Хэрэв боломжтой бол хуудсыг хүүхдүүдэд гэрт нь өгч явуулан, гэрийнхэнтэйгээ хуваалцах боломжийг өг.
Гэрчлэл	Гараа харуулж байгаад ямар талархалтай байдаг гэрчлэлээ хуваалц. Өөртөө болон бусдад туслахад зориулан гар өгсөнд нь Тэнгэрлэг Эцэгт талархалтай байхыг хүүхдүүдэд уриал.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Цаасан дээр хүүхэд бүрээр өөрсдийнх нь гарын хэвийг зуруул. *Би өөрийн гартаа талархалтай байна* гэж тэдний цаасан дээр бич. Хүүхэд бүрээр зургийг нь будуулж, гэрт нь өгч явуул.
2. Хэрэв газар байрлал, цаг агаар нь тохиромжтой бол хүүхдүүдийг гадаа авч гаран тоосго, шохой, модны холтос, өвс зэрэг төрөл бүрийн юмсыг барьж үзэх боломжийг өг.
3. Дараагийн үйл ажиллагаагаар хүүхдүүдээр хуруунууд ба эрхий хурууг нь тоолуул:

Хуруугаа тоолцгооё

*Нэг гараа урдаа өргөн, нөгөө гарынхаа хуруугаар заан чигчий хуруунаасаа эхлэн тоол.*

Нэг хуруу, хоёр хуруу, гурван хуруу, дөрөв.

Одоо эрхий хуруу нэг тоо нэмлээ

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөснөөр

Нэг гарт маань таван хуруу байна

*Одоо нөгөө гараа урдаа өргөн, чигчийгээсээ эхлэн хуруугаа тоол:*

Нэг хуруу, хоёр хуруу, гурван хуруу, дөрөв.

Одоо эрхий хуруу нэг тоо нэмлээ

Энэ гарт бас таван хуруу байна

Би тэдэнд юу хийх хэрэгтэйг зааж чадна



*Хоёр гараа урдаа өргөн, тоолсон хуруугаа нугал*

Бүгдээрээ нийлээд арав — дахиад нэг тоольё  
Нэг, хоёр, гурав, дөрөв  
Тав, зургаа, долоо, найм, ес, арав — бүгд арав.  
(*Нэгэн зэрэг хуруунуудаа дэлгэ*)  
Тэд шулуун, урт байж чадна

4. “Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, p. 253) дууг хэд хэдэн удаа давтан дуул. Бадаг бүр дээр хүүхдүүдээр гар нь юу хийж чаддагийг хэлүүл. Жишээ нь: бөмбөг ойлгох, цэцэг түүх, хүүхэлдэй өлгийдөх, баяртай гэж дохих.

5. Хүүхдүүдээр дараах үгсийг хэлүүлэн, үйлдлийг нь хийлгэ:

Би өндөр сунаж байна

Би дээшээ өндөрт

Бас доош нам сууна

Одоо хоёр гараа сэгсэр.

Би хуруунуудаа дэлгэж

Одоо би атгаж байна

Би гараа урдаа

Одоо ардаа хүргэж

Ингэж би алгаа ташдаг.

Одоо суугаад, өвдгөн дээрээ гараа амраая

Ингээд тэд томоотой байг.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Дараах үйл хөдлөлт шүлгийн үгийг та хэлэхэд тэд үйлдлийг нь хийг:

Би өөрийн гартаа дуртай

Би өөрийн гартаа дуртай; тэд миний найзууд (*гараа урдаа барин, хар*).

Өдрийн турш тэд завгүй тусалдаг (*гар юу хийдгийг дүрсэл*).

Тэд чимээгүй нугарч (*гараа нугал*) эсхүл чанга алга ташдаг (*алгаа таш*)!

Тэд зөвийг хийхэд, надад бахархах сэтгэл төрдөг!

2. Хүүхдүүдийг тойрог болгон суулга. Нэгэн нөхцөл байдлыг тэдэнд хэл. Тэгээд энэ нөхцөлд тэд гараараа юу хийдгийг дүрслэн үзүүлэхийг хүс.

Жишээнүүд:

Хоол идэхийн өмнө чиний гар юу хийх ёстойг үзүүлнэ үү.

Түүх сонсож байх үед чиний гар юу хийх ёстойг үзүүлнэ үү.

Тоглоомнуудаа хураагаарай гэж хэлэхэд чиний гар юу хийх ёстойг үзүүлнэ үү.

Залбирал хэлэх үед чиний гар яах ёстойг үзүүлнэ үү.

Бид дандаа гартаа тэдний юу хийх хэрэгтэйг хийхэд нь туслах ёстой гэдгийг тайлбарла.

3. Дараах үгсийг хүүхдүүдээр давтуулж хэлүүлээд үйлдлийг нь хүүхдүүдтэй хамт хий:

Алгаа таш

Алгаа таш, алгаа таш

Яг над шиг таш

Мөрөндөө хүр, мөрөндөө хүр

Яг л над шиг хүр

Өвдгөө цохь, өвдгөө цохь

Яг л над шиг цохь

Толгойгоо сэгсэр, толгойгоо сэгсэр

Яг над шиг сэгсэр

Алгаа таш, алгаа таш

Одоо тэднийг тайван байлга



БИ




ААВ



ЧАМД



ХАЙРТАЙ



ЭЭЖ

Бидний гар ярьж чадна

# Надад чих байдагт би талархдаг

Хичээл  
**18**

---

## Зорилго

Хүүхдүүдэд тэдний чих юу чаддагт талархах ухамсрыг суулгахад туслах

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Марк 7:32–35 ба Иосеф Смит—Түүх 1:17-г уншиж судал.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи ба Агуу Үнэт Сувд
    - б. Зураг 1-4, Анхны үзэгдэл (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 403; 62470); зураг 1-41, Сонсох аппараттай хүүхэд; Амьд бошиглогчийн зураг.
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.
- Багшид анхааруулах нь: Тухайн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал тэдэнд мэдрэмтгий бай. Тэдний бие хийж чаддаггүй зүйлсэд бус харин хийж чадах зүйлсэд анхаарал хандуул.
- 

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Дараах үгсийг шивнэн хэл:

Хүүхэд бүртэй мэндэл. Хүүхдүүдийг удирдаж суулгах, гараа өргөх, доош болгох, хоёр хуруугаа гозойлгох хөдөлгөөнүүдийг хий.

Өөрийнхөө намуухан дууны өнгөөр шивнэн хэлэх үед тэд түүнийг юу хэлэх гэж байгааг яаж мэдсэн бэ гэдгийг асуу.

- Чиний ямар эрхтэн миний хэлсэн үгийг сонсож ойлгоход тусалсан бэ?

### Чих нь бидэнд өгсөн адислал юм

Дуу

Хүүхдүүдтэй хамт “Эцэгтээ талархъя” (*Children’s Songbook*, р. 20) дууны 1 ба 2-р бадгийг дуул.

Бүх зүйлсийг бидэнд өгсөн Эцэгтээ талархлаа илэрхийлье  
Нүд, чих, гар ба хөл  
Өмсөх хувцас, идэх хоол.

- Тэнгэрлэг Эцэг бидэнд юу өгсөн тухай энэ дуунд гарч байна?
- Эдгээрийн аль нь биднийг юм сонсоход тусалдаг вэ? (бидний чих)

Хүүхдүүдийг чихээ барьж үзэн мэдрэхийг хүс. Тэдний толгойн хэсэгт ил харагдаж байгаа чихний гадаргуу нь сонсох хэсэг биш гэдгийг тайлбарла. Энэ хэсэг нь дуу чимээг дотогш ороход тусалж, чихний хэнгэрэг буюу сонсголын эрхтэнд тусалдаг.

- Бид яаж чихээ арчлах вэ?

Бид чихээ хэт чанга дуу авианаас, мөн гэмтээж болох зүйлээс хамгаалж арчлах хэрэгтэй гэдгийг тайлбарла.

Ямар нэгэн шалтгаанаар зарим хүмүүсийн чихний сонсгол муу байдаг. Тиймээс тэд ихэнх хүмүүсийн сонсож чадах зүйлийг сонсдоггүй. Хэрэв хүүхдүүдийн мэддэг хэн нэгэн сонсголын аппараттай бол түүний талаар тайлбарла. Зураг 1-41, Сонсголын аппараттай хүүхдэд зургийг тайлбарлах явцдаа үзүүл. Сонсгол муутай хүмүүс ихэвчлэн ярьж чаддаггүй гэдгийг ойлгоход нь тусал. Учир нь хүмүүс сонсдог зүйлээ дагаж, ярьж сурдаг.

Үйл ажиллагаа

Англи дохионы хэлээр “Би чамд хайртай” (хичээл 17) гэж хий.

- Энэ юу гэж байгааг санаж байна уу?

Хүүхдүүдээр дохиог хийлгэ.

Түрүүчийн хичээл дээр бидний гар, дохионы хэлээр ярихад тусалдаг тухай ярьсныг сануул. Сонсгол муутай хүмүүс дохионы хэл, бичиг, уруул унших зэрэг өөр арга замаар харьцдаг гэдгийг хэл.

Түүх

Марк 7:32–35 дээр байдаг Есүс ба дүлий хүний тухай түүхийг холбон ярь.

- Хэлгүй дүлий хүн сонсож эхлэхэд түүнд ямар мэдрэмж төрсөн гэж бодож байна?

Сонсоно гэдэг бас нэгэн том адислал гэдгийг тодруул.

### **Бид чихээрээ олон дуу чимээг сонсож чадна**

Үйл ажиллагаа

Одоо чихээ ашиглаж үйл ажиллагаа хийнэ гэдгийг хэл.

Хүүхэд бүрийг нэг нэгээр ээлжлэн ангийн өмнө гарга. Нэг мэддэг амьтны эсвэл ямар нэгэн дуу чимээ гаргадаг эд зүйлсийн нэрийг чихэнд нь шивнэн хэлнэ. Хүүхэд тухайн дуу авиаг гаргана. Бусад хүүхдүүд юу тийм дуу авиа гаргадаг болохыг таана (үхэр мөөрөх, нохой хуцах, утас хангинах, эсвэл машин дуут дохиогоо дуугаргах).

Чихээрээ бүхнийг сонсдог тул гэмтэхээс сэргийлж, чихэнд халтай дуу чимээний талаар хүүхдүүдтэй ярилц.

- Чиний сонсох дуртай ямар дуу чимээ байдаг вэ?

### **Бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн сургаалыг сонсож чадна**

Хүүхдүүдийг чимээгүй сууж сонсохыг хүс.

- Чи юу сонсож байна?

Тэдний сонсож байгаа хаалга онгойж хаагдах, хонгилд ярилцах хүмүүсийн чимээ, даралтат хөгжмийн эгшиг эсвэл салхи зэрэг олон дуу чимээний талаар ярилц.

- Сүм дээр бид өөр ямар юм сонсдог вэ?

Бид өөрсдийн багш нар, эцэг эх, Сүмийн болон Хүүхдийн хэсгийн удирдагчид, бишоп зэргийн үгийг хэрхэн сонсдог талаар тайлбарла.

- Эдгээр хүмүүсийг сонсох нь яагаад чухал вэ?

Эдгээр хүмүүс бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг юу хийгээсэй хэмээн хүсч буйг зааж хэлж өгдөг гэдгийг тайлбарла.

Түүх

Зураг 1-4, Анхны Үзэгдэл, энэ зургийн түүхийн талаар юу мэдэж байгаагаа хэлэхийг хүүхдүүдээс хүс. Судраа нээж, Агуу Үнэт Сувдыг гарган Тэнгэрлэг Эцэг Иосеф Смитэд “Энэ бол Миний Хайрт Хүү. Түүний үгийг сонс!” хэмээн хэлсэн үгийг Иосеф Смит-Түүх 1:17 дээрээс чанга дуугаар унш.

Тэнгэрлэг Эцэг биднийг Түүний хэлсэн болон Есүсийн хэлж буй үгсийг сонсоосой хэмээн хүсдэг гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг ба Есүс хүн бүртэй шууд ярихгүй байж болох ч бид өөрсдийн эх эцэг, багш нар, Сүмийн удирдагч нараа сонсож чадна. Тэд бидэнд Тэнгэрлэг Эцэг ба Есүс биднийг юу мэдээсэй гэж хүсч байгааг хэлж өгч чадна. Ариун Сүнс мөн бидэнд Тэнгэрлэг Эцэг болон Есүс биднийг юу хийхийг хүсч байгааг мэдүүлж тусалж чадна.

Амьд Бошиглогчийн зураг үзүүл.

- Энэ хэн бэ?

Тэнгэрлэг Эцэг, Есүс нар бидэнтэй Сүмийн удирдагчдаар дамжуулан ялангуяа Амьд Бошиглогч, бидний бишоп нараар дамжуулан ярьдаг. Эдгээр удирдагчид бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр биднийг юу хийгээсэй гэж хүсч буйг хэлж өгдөг. Тэднийг бид анхааралтай сонсох ёстой.

Гэрчлэл

Сонсох бэлэг өгсөн чихэндээ талархалтай байдгаа хуваалц.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. Хүүхдийг нүдээ аниад гараараа таглахыг хүс. Нэг хүүхдийн толгойнд хүр. Тэр хүүхэд “Би чихэндээ талархаж байна” гэж хэлнэ. Бусад хүүхдүүдээр хэн хэлснийг нь таалгуул. Хүүхэд бүрээр хийлгэ.
2. Дараах үйлдэлт шүлгийг хүүхдүүдтэй хамт хий:
 

Надад гайхамшигтай бие махбод бий

Тэнгэрлэг Эцэгийн надад зориулан төлөвлөсөн  
Гайхамшигтай бие бий (*цээжиндээ гараараа хүр*)  
Тэр надад сонсох чих (*гараараа чихэндээ хүр*)  
Мөн харах нүд өгсөн (*нүд рүүгээ заа*).

Надад алга таших хоёр гар бий (*алгаа таш*),  
Эргэлдэж болох хоёр хөл бий (*дороо эргэлд*).  
Хэрэв би хүсвэл хөлнийхөө  
Хуруунд хүрч чадна (*доош тонгойж, хөлнийхөө хуруунд хүр*).

Би өөрийн биеийн тухай бодох үед (*долоовор хуруугаа толгойндоо хүргэ*),  
Хамгийн чухал нь (*чимээгүй доош суу*)  
Түүнтэй адилхан харагдахаар  
Тэнгэрлэг Эцэг намайг төлөвлөсөн
3. Хүүхдүүдийг нэг зүг рүү харуулан суулгаж өөрөө ард нь суу. Гараараа юм уу чимээ гаргах бусад зүйлсээр чимээ гарга. Тэгээд яаж дуу чимээ гаргаж байгаагаа хүүхдүүдээр таалга. Та алга таших, хуруугаа таш, эсхүл хонх дуугарга. Хүүхдүүдээр өөрсдөөр нь чимээ гаргуул.

4. Амьдардаг орчин тойрныхоо нохой хуцах, шувуу жиргэх эсвэл инээх гэх зэрэг чимээ гарган, хүүхдүүдээр таалган тогло.
5. Дохионы хэлээр энгийн дуу юм уу хэллэгийг хүүхдүүдэд заа. Дохионы хэлээр сайн ярьдаг хэн нэгнийг та мэддэг бол ангидаа урьж, “Би Бурханы Хүүхэд” дууг дохионы хэлээр үзүүлэхийг хүс. Харин ангийн хүүхдүүд дууг дуулна.
6. Хүүхдүүдтэй хамт тойрог болон суу. Хажуугийн хүүхдэдээ богино өгүүлбэр шивнэн хэл. Энэ хүүхэд дараагийн хүүхдэд гэх мэт тойрог тойруулан үгийг шивнэн дамжуул. Сүүлийн хүүхэд чангаар өгүүлбэрийг хэлнэ. Эхний хэлсэн өгүүлбэр ямар өгүүлбэр байсныг хэл. Дамжуулах явцад хэрхэн өөрчлөгдсөн байна?  
  
Үйл ажиллагааны дараа тухайн өгүүлбэрийг сонсохын тулд юуг хэрэглэснийг хүүхдүүдээс асуу. (Чих) Тэнгэрлэг Эцэг чих өгсөнд талархах ёстойг сануул.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хэрэв боломжтой бол хүүхдүүдийг гадаа дагуулан гар. Тэднийг эргэн тойрноо анхааралтай сонсохыг хүс. Тэд юу сонсож байна? Ангидаа эргэж ороод, тэдний сонссон дуу чимээнүүдийн талаар ярилц.
2. Хүүхдүүдийг босгон, дараах үгсийг хэлүүлж үйлдлүүдийг хийлгэ:  
  
Нүдэндээ хүр  
  
Нүдэндээ хүр  
Хамартаа хүр  
Чихэндээ хүр  
Хөлийн хуруундаа хүр  
  
Гараа сунга  
Аль болох өндөр  
Бүр өндөр  
Тэнгэрт хүртэл сунга  
  
Үсэн дээрээ  
Гараа тавь  
Сандал дээрээ  
Доош чимээгүй суу

# Надад нүд байдагт би талархдаг

Хичээл  
**19**

---

**Зорилго** Хүүхдүүдэд нүд болон түүний хийдэг чадварт талархалтай байхад нь туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Иохан 9:1–7 ба 3 Нифай 11:1–17-г уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи ба Мормоны ном
  - б. Том нүхтэй дамар, гутлын үдээс юм уу хэсэг утас (том ангитай бол тус бүрээс нь нэгээс илүүг авчрах)
  - в. Ороолт эсхүл нүд боох зөөлөн эдлэл
  - г. Зураг 1-43, Есүс хараагүй хүнийг эдгээсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 213; 62145); зураг1-44, Есүс Америк тивд сургаалыг заасан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 316; 62380).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

Багшид анхааруулах нь: Тухайн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал тэдэнд мэдрэмтгий бай. Тэдний бие махбодийн хийж чаддаггүй зүйлсэд бус харин хийж чадах зүйлсэд анхаарал хандуул.

---

## **Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдэд харж байгаад үдээс юмуу утсаа дамар уруу шургуулах нь амар болохыг үзүүл. Дараа нь нүдээ таглаад үдээсийг дамар уруу шургуулахыг хичээ. Хүүхэд бүрээр үүнийг хийлгэ.

### **Бидэнд нүд өгсөн нь том адислал**

Бид уншиж, суралцаж, ажиллаж, тоглож мөн үзэсгэлэнтэй ертөнцийг харахын тулд нүд заяасан гэдгийг тайлбарла.

Хэрэв тэд харж чаддаггүй байсан бол тэдний амьдрал ямар өөр байх байсан талаар ярилц.

- Чи яаж хоолоо идэх вэ?
- Ямар хувцас өмсөхөө яаж мэдэх вэ?
- Гэртээ хүрэх замаа яаж мэдэх вэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдтэй хамт “Хоёр жижигхэн нүд” (*Children’s Songbook*, p. 268) дууг дуул.



Хоёр жижиг нүд цавчилж байна, цавчилж байна, цавчилж байна  
 Хоёр жижиг нүд харж байна;  
 Толгой ба мөр, өвдөг ба хөлийн хуруу  
 Намайг бүрэлдүүлэх бусад олон зүйлс  
 Тра ля ля ля ля  
 Хардаг хоёр нүд  
 Цавчлах хоёр жижиг нүд  
 Намайг бүрдүүлэх бусад олон зүйлс  
 (From *Merrily We Sing*, © 1948, 1975 by Pioneer Press, Inc. [a division of  
 Jackman Music]. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

Үйл ажиллагаа Хүүхдүүдийг цонхоор харахыг урь (эсвэл сайхан зураг) Тэднийг анх удаа нүдээ нээж байгаа мэт дүр эсгэхийг хүс. Юу харсан тухай нь яриул. Өнгө болон хэлбэр дүрснүүдийнх тухай ярилц. Харах гэдэг ямар гайхамшигтай адислал болохыг ухаарахад нь тусал.

- Чиний харах дуртай зүйлс

Зарим хүмүүсийн нүд сайн харж чаддаггүй. Тэд сайн харахын тул нүдний шил юм уу контакт линз зүүх хэрэгтэй болдог. Харин зарим хүмүүс хараагүй тул юу ч харж чаддаггүй.

Үйл ажиллагаа Хараагүй хүмүүс хэрхэн таяг эсвэл хөтлөгч нохойны тусламжтай явахыг суралцдаг тухай ярилц. Нэг хүүхдийн нүдийг боогоод, та өөрөө хөтлөгч нохой нь бол. Хүүхдэд гараа бариулахад, хүүхэд яг л хөтлөгч нохойн бариул мэт барина. Хүүхдийг өрөөгөөр тойруулан явуул. Хүүхэд бүрийг хараагүй хүн эсвэл хөтлөгч нохой шиг дүр эсгүүл.

Түүх Зураг 1-43, Есүс хараагүй хүнийг эдгээсэн нь зургийг үзүүлэн Иохан 9:1–7 дээр гардаг Есүс хараагүй хүнийг эдгээсэн тухай түүхийг ярьж өг.

- Есүс шавраар юу хийсэн бэ? (Иохан 9:6-г үз.)
- Хараагүй эр шаврыг цөөрөмд угаахад юу тохиолдсон бэ? (Иохан 9:7-г үз.)
- Хараагүй эр харж чаддаг болоод юу мэдэрсэн гэж бодож байна?

### **Надад нүд өгсөнд нь Тэнгэрлэг Эцэгт би талархдаг**

Үйл ажиллагаа Хүүхдүүдийг босч зогсоод таныг даган шүлгийг хэлж, шүлэгт дурдагдах биеийн хэсгүүдийг өөр дээрээ заана:

Би нүдэндээ талархаж байна

Би нүдэндээ талархаж байна,

Миний чих, ам, хамар;

Мөн гар хуруундаа талархдаг,

Мөн хөл, тавхай хуруунууддаа талархдаг.

(Adapted from a verse by Lucy Picco.)

Түүх Есүс Америк тивд сургаалыг заасан нь буюу зураг 1-44-ийг хүүхдүүдэд тойруулан үзүүлж зурагнаас харж байгаа зүйлээсээ хүүхэд бүр нэгийг хэлэхийг хүс. Есүс Америк тивд очсон тухай 3 Нифай 11:1–7 дээр гардаг түүхийг ярьж өг.

- Хүмүүс хэнийг харсан бэ?

- Есүсийг хараад хүмүүст юу мэдрэгдсэн бэ? (3 Нифай 11:16–17-г үз.)
- Есүсийн нөмрөг ямар өнгөтэй байсан бэ? (3 Нифай 11:8-ыг үз.)

Нифайчуудын адил бид Есүсийг бодитойгоор харж чадахгүй байж болно. Гэхдээ бид үзэсгэлэнтэй байгаль дэлхийг харах бүрт Түүний бидний төлөө хайрыг нь санаж чадна гэдгийг тайлбарла.

Гэрчлэл

Хүүхдүүдтэй нүдэндээ талархалтай байдаг тухай өөрийн гэрчлэлээ хуваалц. Өдөр бүр Тэнгэрлэг Эцэгийн болон Есүсийн хайрыг мэдрэх гайхамшигт зүйлсийг харж чаддагтаа маш их талархалтай байдаг талаараа хэл. Тэнгэрлэг Эцэгтээ нүд өгсөнд талархах ёстойг сануул.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд дараах үйл ажиллагаануудаас сонгож ашигла.

1. Хүүхдүүдийг анхааралтайгаар бие биенийхээ нүд, сормуус, хөмсөг, зовхийг харахыг урь. Бидний хөмсөг, сормуус, зовхи зэрэг нь шороо, тоос болон нулимс нүдэнд орохоос хамгаалдаг гэдгийг тайлбарла.

Хичээл эхлэхээс өмнө, зүү шөвөг зэрэг хурц зүйл ашиглан цаасан дээр дугуй, дөрвөлжин дүрсний хүрээг нүхэлж хэлбэр гарга. Ангид нэг хүүхдийн нүдийг боон харах боломжгүй болгоод цаасан дээрх нүхнүүдийг тэмтрүүлэн ямар хэлбэртэй нүхнүүд болохыг таалга. Энэ нь хараагүй хүмүүс уншихад зориулсан брайл бичиг гэдгийг тайлбарла.

3. Цаасан уут ашиглан хүүхэд бүрт нээгдэж, хаагддаг “нүд” хийлгэ. (хичээлийн төгсгөлд байгаа зураг, буюу хавсаргасан үзүүлэнг хар). Цаасан уут бүр дээр *Би өөрийн нүдэндээ талархаж байна* гэж бич. Цаасан уутан дээрээ үс зурж, нүдийг нь өнгөөр ялган будуул. Цаасан “нүд”-ээ ашиглан нойрноос сэрэх ба унтах, залбирал хэлэх, айх зэрэг үед бидний нүд яадгийг цаасан уутан нүдээ ашиглан дүрслэн үзүүл.
4. Хэрэв боломжтой бол хүүхдүүдтэй хамт гадаа гарч алх. Тэднийг гар гараасаа хөтлөлцөн, харж байгаа зүйлдээ анхаарлаа төвлөрүүлэн маш чимээгүй алхахыг хүс. Ангид эргэж ирээд харсан зүйлийнхээ тухай ээлжлэн ярихыг урь.

## Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа

1. Хүүхдүүдтэй хамт “Эрдэнэ шиш цовхчино” (*Children’s Songbook*, 242-р хуудас) дууг дуул. Чангаанзны модны цэцэг эрдэнэ шиштэй адил харагддаг гэдгийг тайлбарла.

- Хэрэв цонхоор харах юм бол дуун дээр гарч байгаатай адил чангаанзны модон дээр эрдэнэ шиш цовхчиж байна уу? Цонхоор юу харагдаж байна вэ?

Хүүхдүүдийг цонхоор харуул эсвэл хэсэг зуур гадагш авч гар. Дараа нь ангидаа эргэн орж тэдний юу харсан тухай ярилц.

- Эдгээр зүйлийг харахын тул чи юугаа хэрэглэсэн бэ? (Нүд)

Бид Тэнгэрлэг Эцэгтээ нүд өгсөнд талархах ёстой гэдгийг хэл.


2. Хүүхдүүдийг босч “Нүдэндээ хүр,” шүлгийн үйлдлийг хэлж уншихыг урь:

Нүдэндээ хүр  
Хамартаа хүр  
Чихэндээ хүр  
Хөлийн хуруундаа хүр

Гараа сунга  
Аль болох өндөр  
Бүр өндөр  
Тэнгэрт хүртэл сунга

Үсэн дээрээ  
Гараа тавь  
Сандал дээрээ  
Доош чимээгүй суу

Хүүхдүүдэд жижиг зүйл үзүүл. Үүнийг ангид нэг газар тавина. Тэд нүдээ ашиглан олох ёстой гэж хэл. Хүүхдүүдийг нүдээ анихыг хүсч, жижиг зүйлээ харагдах боломжтой боловч хэтэрхий ил тод бус газар тавь. Одоо хүүхдүүд нүдээ нээж, хөдөлгөөн хийлгүй, чимээ гаргалгүй олохыг хүс. Жижиг зүйлийг олсон хүүхэд гараа урдаа зөрүүлэн томоотой байж, бусдыг нүдээ ашиглан юмаа олоход нь саад болохгүй байхыг сануул. Хүссэн тоогоороо үүнийг давтан хий.



# Би үнэрлэж, амталж чаддагтаа талархдаг

Хичээл  
20

---

## Зорилго

Хүүхдүүдэд үнэрлэх, амтлах мэдрэмжиндээ талархалтай байхад нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Египетээс гарсан нь16:11–15, 31 ба Сургаал ба Гэрээ 59:18–19-ийг уншиж судал.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи ба С ба Г
    - б. Хүүхэд бүрт сайхан үнэртэй хүнсний дээжис бэлтгэ (жимс, талх, жигнэмэг, эрдэнэ шиш). Дээжсээ уутанд хий. Хүүхдүүдийн эх эцгээс тэдний хүүхэд эдгээрийн аль нэгнээс харшилтай эсэхийг лавлаж мэд.
    - в. Ямар нэгэн исгэлэн (лимоны жүүс), давслаг (давс), ба чихэрлэг (элсэн чихэр) зүйлс хүүхдүүдэд амтлуул. Хүүхдүүдийн эх эцгээс тэдний хүүхэд эдгээрийн аль нэгнээс харшилтай эсэхийг тодруул.
    - г. Зураг1-35, Манна цуглуулсан нь
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.  
Багшид анхааруулах нь: Тухайн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал тэдэнд мэдрэмтгий бай. Тэдний бие махбодийн хийж чаддаггүй зүйлсэд бус харин хийж чадах зүйлсэд анхаарал хандуул.
- 

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг нүдээ анихыг хүс. Уутан дахь хүнсний дээжээс нэгийг үнэртэн юу болохыг таахыг хүс. Нүдээ аниастай хэвээр хүүхдийг авсан зүйлээ идэхийг өг. Хүүхдийг нүдээ нээхийг хүсч, тэд юу идсэнийг нь харуулах буюу хэл.

- Энэ ямар үнэртэй байсан бэ?
- Энэ ямар амттай байсан бэ?

Бид хэдий харахгүй байсан ч идэж байгаа зүйлээ амталж таашаал авч чадна гэдгийг хүүхдүүдэд хэл. Үүнийг бид Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн үнэрлэх, амтлах мэдрэмжийн тусламжтайгаар хийж чадна.

### Бид бүгдэд хамар байдаг тул үнэрлэж чадна

- Бид яаж юмыг үнэрлэдэг вэ?

Хоол хийхэд гарах үнэр, бороо орсны дараах цэвэр агаар, цэцэгс зэрэг долоо хоногийн туршид үнэртсэн зүйлсийнх нь талаар хүүхдүүдтэй ярилц. Бид Тэнгэрлэг Эцэгтээ үнэрлэх, амтлах мэдрэмжийнхээ төлөө талархах ёстой гэдгийг хэл.

- Та нар ямар зүйл үнэрлэх дуртай вэ?

Үйл ажиллагаа	<p>Дараах үйл ажиллагааг хийхэд нь хүүхдүүдэд тусал:</p> <p>Надад хамар бий</p> <p>Надад хамар бий (<i>хамраа заа</i>).</p> <p>Энэ нь миний нүүрний (<i>гараа хацар дээрээ тавь</i>),</p> <p>Яг голд нь байдаг</p> <p>Хамгийн гоё газар (<i>хуруугаараа хамраа тойруулан тойрог хөдөлгөөн хий</i>).</p> <p>Миний хамар шиншилж чадна (<i>үнэрлэ</i>);</p> <p>Миний хамар үнэрлэж чадна (<i>гүнзгий амьсгаа аваад гарга</i>).</p> <p>Миний хамар сайн ажилладагт нь</p> <p>Тэнгэрлэг Эцэгтээ би талархаж байна (<i>гараа зөрүүл</i>)</p> <p><b>Бидэнд амталж чадах хэл бий</b></p> <p>Тэнгэрлэг Эцэг биднийг амталж чадах хэлээр адисласан гэдгийг тайлбарла. Хэрэв тэд хүсч байвал хүүхдүүдээр исгэлэн, шорвог, чихэрлэг зүйлс амтлуул.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аль нь исгэлэн бэ?</li> <li>• Аль нь давслаг вэ?</li> <li>• Аль нь чихэрлэг вэ?</li> <li>• Чиний амтлах хамгийн дуртай зүйл юу вэ?</li> </ul> <p>Сургаал ба Гэрээ үзүүл (гурамсан судрын Сургаал ба Гэрээний нүүр хуудсыг). Энэхүү сударт бидэнд хэрэглэхэд болон таашаал авахад зориулан үнэрлэх ба амтлахад сайхан зүйлсийг өгсөн гэдгийг хэлсэн байдгийг тайлбарла (С ба Г 59:18–19-ийг үз).</p>
Түүх	<p>Зураг 1-35, Манна цуглуулсан нь, зургийг үзүүл. Египетээс гарсан нь 16:11–15, 31-д гардаг маннагийн тухай түүхийг ярьж өг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Манна ямар амттай байсан бэ? (Египетээс гарсан нь 16:31-ийг үз.)</li> <li>• Та нар зөгийн бал амталж үзсэн үү?</li> <li>• Ямар амттай байсан бэ?</li> </ul> <p>Мөн амталж болохгүй аюултай олон зүйлс байдгийг тайлбарла. Жишээ нь: зарим жимс, цэвэрлэгээний бодисууд, мэдэхгүй шилтэй лаазтай зүйлс, эх эцгийн зөвшөөрөлгүйгээр ямар ч эм амталж болохгүй. Эдгээр зүйлс бидний эд эрхтэнийг маш их гэмтээж, өвтгөж болно. Өөрсдийн олсон таньж мэдэхгүй зүйлээ заавал томчууд болон эх эцгээсээ асууж байж амтлах юмуу идэх хэрэгтэй гэдгийг анхааруул.</p>
Гэрчлэл	<p>Юмыг үнэрлэх хамар, амтлах хэл өгсөнд талархалтай байдаг тухай гэрчлэлээ хуваалц. Тэнгэрлэг Эцэгтээ үнэрлэх, амтлах мэдрэмж өгсөнд талархах ёстой гэдгийг хүүхдүүдэд сануулан хэл.</p>

---

**Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. Хурц онцгой сайхан үнэртэй саван, цэцэг, лимон, мөн зарим үнэргүй цаас, тоглоом зэрэг зүйлсийг авчир. Хүүхдүүдээр үнэртэй зүйлсийг

сонгуулан, нэг нэгээр нь хүүхдүүдийн нүдийг аниулж үнэртүүлэн юу болохыг таалга. Хүүхэд бүрээр хийлгэ.

2. Хүүхдүүдийг толинд хэлээ харахыг урь. Бидний хэлний дээр амтлах олон эд эсүүд чихэрлэг, давслаг, исгэлэн зэргийг ялган таньдаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд ус амтлуул. Мөн бидний хэл чийглэг юм уу хүйтэн зүйлийг мэдэрч чаддаг гэдгийг тайлбарлан хэл.
3. Хүүхэд бүрээр өөрсдийнх нь дуртай идэх юмыг зуруул. Өөрийн зурсан зургаа үзүүлж ямар идэх юманд дуртай болохыг нь хэлүүл.
4. Гаднаасаа ижил төстэй харагддаг ч өөр амттай давс ба сахар, гурил ба крахмал (төмсний гурил) зэрэг зүйлсээс бага хэсгийг авчир. Хүүхдүүдээр бага зэрэг амтлуул. Дараа нь ямар амттай байгааг асуу. Яаж зарим зүйлс ижил харагддаг мөртлөө өөр өөр амттай байдаг талаар ярилц. (Таны авчирсан аль нэг зүйлсээс хүүхэд нь харшилтай эсэх талаар эх эцгээс нь тодруул)
5. “Талархлын дуу” (*Children’s Songbook*, p. 20) дууг дуул.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Цаасан дээр юм уу самбар дээр зууван дүрс зур. Энэ нь хүний нүүр гэж хэл.
  - Юу байхгүй байна?

Хүүхдүүд нүд, чих, хамар ам гэж хэлэхэд тэдгээрийг нэмж зур. Дараа нь эдгээр эрхтэнүүд юу хийдэг ямар хэрэгтэй болохыг ярь. Тэнгэрлэг Эцэгтээ өөрийн биеийн төлөө ямар их талархалтай байдгаа илэрхийл.
2. Амаа заан “Энэ бол миний ам” гэж хэл. Дараа нь “Та нар өөрсдийнхөө амыг зааж чадах уу?” гэж асуугаад хүүхдүүдэд ам руугаа заахад нь тусал. Үүнийг нүд, хамар, чих, гар болон хөл дээр давтан хий. Дараа нь нэрийг нь хэлэлгүй зааж, хүүхдүүдээр нэрлүүл. Хэрэв хүүхдүүд бүх хэсгийг зөв зааж нэрлэвэл, тэдний бага мэдэх тохой, өвдөг, бугуй, шилбэ шагай зэргийн нэрийг асуу.
3. Хүүхдүүдийг босч зогсоод дараах үгсийг хэлэн үйлдлийг хийхийг хүс:
 

Нүдэндээ хүр  
Нүдэндээ хүр  
Хамартаа хүр  
Чихэндээ хүр  
Хөлийн хуруундаа хүр

Гараа сунга  
Аль болох өндөр  
Бүр өндөр  
Тэнгэрт хүртэл сунга

Үсэн дээрээ  
Гараа тавь  
Сандал дээрээ  
Доош чимээгүй суу

---

**Зорилго**

Хүүхдүүдэд өөрсдийн мэдрэмжүүдийг таньж, баяр бахдалтай байхад суралцахад нь туслах

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Лук 15:11–32-ыг уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи.
  - б. Инээсэн/Ширүүн ууртай нүүрний дүрс (хичээлийн төгсгөлд заасан загварыг үз).
  - в. Шохой ба арилгагч
  - г. Зураг 1-45, Сав суулга угааж байгаа нь; зураг 1-46, Ээждээ цэцэг өгч байгаа хүүхдүүд; зураг 1-47, Маргалдаж байгаа хүүхдүүд; зураг 1-48, Шоогоор тоглож байгаа хүүхдүүд; зураг 1-49, Үрэлгэн хүү (Сургаалын Зурагнууд 220; 62155).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдээр нээлтийн залбирал хийлгэ.

Инээсэн/Уурласан нүүрний дүрсээ үзүүл. “Инээмсэглэл” (*Children’s Songbook*, р. 267) дууг хүүхдүүдтэй хамт хэд хэдэн удаа дуул. Хэдэн хүүхдээр инээсэн болон уурласан царайг яг тохиромжтой үед нь гаргахыг хүс.

Хэрэв чи зангирсан хөмсөгтэй учирвал  
Түүнийг бүү уурласан хэвээр нь байлга  
Хурдхан түүнийг эргүүлэн өөрчил  
Инээмсэглэл уурыг холдуулна

Хэн ч ууртай царайнд дургүй  
Түүнийг инээмсэглэлээр соль  
Үргэлж инээмсэглэн явж  
Ертөнцийг илүү сайхан болгоё

**Бидний мэдрэмжүүд нүүр царай ба үйлдлээр маань илэрдэг**


- Нүүрэндээ инээмсэглэлтэй байхад чамд ямар санагддаг вэ?
- Хөмсөг зангидсан царайтай байхад чамд ямар байдаг вэ?

Бидний царайг хараад сэтгэл санаа маань ямар байгааг хүмүүс хэлж чаддаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг өөрсдийн аз жаргалтай царайг харуулахыг хүс.

Үйл ажиллагаа

Самбар дээр дөрвөн том дугуй зур. Өөр өөр сэтгэлийн хөдөлгөөнүүдийг илэрхийлсэн царай зур: аз жаргалтай, уйтгартай, ууртай ба айсан (үзүүлэн үз). Бүх царайгаа зурж дуусаад хүүхдүүдээс ямар мэдрэмжүүд зурагдсан

байгааг асуу. Дараа нь тэднийг аз жаргалтай, уйтгартай, ууртай, айсан царай дүрслэхийг хүс.



- Юу чамайг аз жаргалтай болгодог вэ?
- Юу чамайг уйтгартай болгодог вэ?
- Юу чамайг уурлуулдаг вэ?
- Юу чамайг айлгадаг вэ?

Ямар үед та аз жаргалтай, уйтгартай, уурладаг эсвэл айдаг талаараа хуваалцан ярь.

### **Бид өөрсдийн мэдрэмжийг удирдан захирахад суралцаж чадна**

Бид өөрсдийн олон янзын мэдрэмжүүдээ ил гаргах нь сайн. Гэхдээ бид тэднийг ялангуяа уураа зөв замаар гаргах хэрэгтэй.

Зураг 1-47, Маргалдаж буй хүүхдүүд, үзүүл.

- Эдгээр хүүхдүүд ямар мэдрэмжтэй байна гэж та нар бодож байна?
- Тэд бие биендээ юу гэж хэлж байгаа гэж бодож байна?
- Уурласан үедээ бид юу хийх ёстой вэ?

Мөн бид уурласан үедээ хэн нэгнийг цохих, хашгичих эсвэл өвтгөх зүйл хийж болох тул бид өөрсдийн мэдрэмжээ зөөлөн тайван нөхөрсөг гаргахад суралцаж чадна. Бид цохих юмуу хашгичихад улам л ууртай болдог, гэхдээ нөхөрсөг байснаар бид илүү сайхан мэдрэмж авахад өөрсдөдөө тусалж чадна.

### **Үйл ажиллагаа**

Хүүхэд бүрээр зурган дээрх хүүхдүүдийн оронд байна гэж дүрслүүл. Зурган дээрх хүүхдүүд хашгиралдан хэрэлдэж цохилдохын оронд хэлж болох үгсийг бодуул. Жишээ нь: “Одоо би хийж болох уу?” “Ээлжлээд хийцгээе,” “Чи намайг муухай үгээр дуудах нь намайг их гунигтай болгодог” эсвэл “Чамайг ингэхэд би дургүй” гэх мэт.

Зураг 1-48, Шоогоор тоглож буй хүүхдүүд, үзүүл. Эдгээр хүүхдүүд хамтдаа маш эвсэг тоглож, аз жаргалтай царайтай байна, учир нь тэд хоорондоо нөхөрсөг дотно харьцаж, хуваалцаж байна гэдгийг хэл.

- Чамайг уйтгартай, ууртай, айсан байхад хэн тусалж сайхан болгож чадах вэ?

Аав, ээж болон ойр дотны хайртай хүмүүстэйгээ ярилцсанаар бид яагаад ийм мэдрэмжтэй байгааг ойлгоход нь тэдэнд тусалж чадна гэдгийг тайлбарла. Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирвал Ариун Сүнс бидэнд



тусална. Ариун Сүнс бидэнд юу хэрэгтэйг заах тул бид дахин аз жаргалтай байж чадна.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босгож зогсоогоод, дараах үйл ажиллагааг хэд хэдэн удаа хий:

Миний мэдрэмжүүд

Заримдаа намайг маш уйтгартай байхад (*уйтгартай дүр хий*),  
Миний ээж намайг тэвэрдэг. Тэгээд би баярладаг (*өөрийгөө тэвэр, аз жаргалтай дүр гарга*).

Заримдаа намайг ууртай байхад (*ууртай дүр үзүүл*),  
Би холдон явж Аавтайгаа ярьдаг (*дороо явж, ярьж буй мэт толгойгоо дохь*).

Ямар нэгэн юм намайг айлгавал (*айсан дүр хий*),  
Тайвшруулах залбирал би хэлдэг (*гараа нугал*).

Дараа нь би тоглохоор гарахдаа,  
Өдөржин би аз жаргалтай байх болно (*аз жаргалтай царай гарга*).

### **Туслах нь намайг аз жаргалтай болгодог**

Зураг 1-46, Хүүхдүүд ээждээ цэцэг өгч байгаа нь зургийг үзүүл..

- Энэ зурган дээрх хүмүүс ямар мэдрэмжтэй байна гэж бодож байна?
- Яагаад тэд тийм мэдрэмжтэй байна вэ?
- Хэн нэгэнд ямар нэгэн зүйл өгөхөд чамд ямар мэдрэмж төрдөг вэ?

Зураг 1-45, Сав суулгаа угааж байгаа нь, үзүүл.

- Энэ охин юу хийж байна?
- Энэ зурган дээрх охин ямар мэдрэмжтэй байна гэж чи бодож байна? Яагаад?
- Хэн нэгэнд туслахад чамд ямар мэдрэмж төрдөг вэ?

Үйл ажиллагаа

Дараах үйл ажиллагааг хүүхдүүдээр хийлгэ:

Бусдад туслах нь намайг аз жаргалтай болгодог

Би ээждээ туслах дуртай (*хормогч зүүж байгаа дүрслэл хий*);

Түүнд хийх зүйл их байна

Би түүнд сав суулга хатаахад нь тусална (*сав суулга хатааж байгааг дүрсэл*)

Бас бяцхан хүүхэд хооллоно (*хүүхэд угжиж буй дүр гарга*).

Би аавдаа туслах дуртай (*ажлын бээлий өмсөж байгаа дүр үзүүл*);

Түүнд хийх зүйл маш их байна (*бут янзалж, хогийн ургамал зулгааж дүр хий*).

Цэцэрлэгт хийх ажлыг нь дуустал

Би түүнд тусална (*ногоо усалж буй дүр хий*)

Туслах нь намайг аз жаргалтай болгодог (*инээмсэглэсэн нүүр заа*).

Энэ нь надад сайхан мэдрэмж өгдөг (*гараа солбин мөрөн дээрээ тавьж, өөрийгөө тэвэр*).

Би бусдад тусалж байхдаа (*гараа тэл*),

Би хийх ёстой зүйлээ л хийдэг (*толгойгоо дохин, гараа нугал*)!

## Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг аз жаргалтай байхыг хүсдэг

Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг аз жаргалтай байхыг хүсдэг гэдгийг тайлбарла. Тэдний хийгээсэй гэж хүссэн зүйлийг бид хийхэд аз жаргалтай болдог гэдгийг Тэд мэддэг.

Түүх

Зураг 1-49, Үрэлгэн хүү, үзүүл. Лук 15:11–32 дээрх түүхийг ярьж өг. Эцэг болон хүү нь өөр өөр мэдрэмжтэй байсан гэдгийг хэл. Тэдний мэдрэмжийг самбар дээрх мэдрэмжүүдээс аль нь болохыг нэг хүүхдээр заалга. Жишээ нь: Хүү гэрээсээ хол явах дуртай байсан. Түүнийг явахад аав нь *гунигтай* байсан. Хэсэг хугацааны дараа хүүгийн найзууд түүнийг орхисон. Тэр *гунигтай* болсон. Удалгүй тэр огт мөнгөгүй болсон. Тэр *айсан*, учир нь тэр өлсөж, хэн ч түүнд хоол өгөөгүй . . . гэх мэт.

- Хүү гэртээ ирээд ямар мэдрэмжтэй байсан гэж бодож байна?
- Хүүгээ эргэж ирэхэд аав нь яагаад баярлаж байсан бэ? (Лук 15:24-ийг үз.)
- Яагаад ах нь дүүгээ эргэн ирэхэд ууртай байсан бэ? (Лук 15:28–30-ыг үз.) Тэр ахин аз жаргалтай байхын тул яах ёстой вэ?

Гэрчлэл

Хүүхдүүдэд хүн бүхэн л заримдаа аз жаргалтай, уйтгартай, ууртай, айдастай байдаг гэдгийг ойлгуул. Эдгээр мэдрэмжүүдийг бид зөв замаар гаргаж сурах хэрэгтэй. Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг аз жаргалтай байхыг хүсдэг гэдгийг сануул. Хүүхдүүдэд Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг хийгээсэй гэсэн зүйлийг хийхэд бид яаж аз жаргалтай байдаг талаар хэл.

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго


1. Хүүхдүүдийг тойрог болгон зогсоо. Тэднийг уруулаа инэмсэглэлгүй зүгээр шулуун болгохыг хүс. Хүүхдүүд рүү тойруулан харж инээгээд: “Би чамд (хүүхдийн нэр) инээмсэглэл өгч байна” гэж хэл. Тэр хүүхэд нь одоо инээмсэглэж үгийг давтан, дараагийн хүүхдийн нэрийг хэлнэ. Тойрог дахь хүүхэд бүр хийтэл үргэлжлүүл.
 

Бид бусад руу харан инээмсэглэхэд тэд ихэнхдээ эргүүлэн заавал инээмсэглэдэг гэдгийг хүүхдүүдэд сануул. Инээмсэглэж байхдаа уйтгартай, ууртай болон айдастай байх нь хэцүү.
2. Хүүхдүүдийг аз жаргалтай болгодог зүйлийнхээ тухай бодохыг хүс. Хүүхэд рүү вандуйтай уут юм уу зөөлөн эд шидэн: “(хүүхдийн нэр) \_\_\_\_\_ -д аз жаргалтай болдог”. Хүүхэд хариултыг хэлж эргүүлэн вандуйтай уут юм уу зөөлөн эдийг чам руу шиднэ. Хүүхэд бүртэй үүнийг хий.
3. Гэрийн ажилд туслан ээжийгээ баярлуулдаг хүүхдийн тухай түүх ярьж өг. Ээж нь хүүхдүүдийнх нь хэн нь үүнийг хийснийг мэдээгүй тул гэр бүлийнхнээсээ хэн тусалсныг асуудаг. Тэр сайн үйлс хийсэн хүүхэд рүү ойртон очоод л хүүхдийн нүүр дүүрэн инээмсэглэлээр хэн түүнд тусалсныг мэддэг. Хүүхэд сайн үйлс хийсэндээ баяртай байсан тул аз жаргалтай байлаа.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Дараах үгсийг хэлэнгээ хүүхдүүдийг удирдан үйлдлийг хий. Хүүхдүүд хүсч байвал давтан хий.  
Аз жаргалтай өдрүүдийг бий болго  
Сайхан бүгдийг харах хоёр нүд (*нүдээ заа*),  
Өдрийн турш инээмсэглэх хоёр уруул (*нүүр дүүрэн инээ*).  
Бусдын хэлэхийг сонсох хоёр чих (*гараа аяга болгон чихэндээ барь*),  
Тоглоомоо хураах хоёр гар (*тоглоомоо цуглуулж, хурааж байгаа дүрслэл хий*).  
Өдөр бүр нөхөрсөг үгс хэлэх хэл (*ам руугаа заа*),  
Ажиллаж тоглох хайраар дүүрэн зүрх (*зүрхэн дээрээ гараа тавь*).  
Баяртайгаар гүйх хоёр хөл (*хоёр хөлөө заа*)—  
Өдрөө бүгдээрээ жаргалтай болгоё.
2. “Хэрвээ сайхан амьдарч байвал” (*Children’s Songbook*, р. 266) дууг дуул.  
Дууны үгийн үйлдлийг хий. Дууны номын буланд өгсөн нэмэлт үгсийг нэмэн давтан дуул.
3. Хүүхдээр жаргалтай, уйтгартай, уурласан мөн ядарсан царай хийлгэ.  
Уйлж гомдоллохын оронд тэд юу мэдэрч байгаагаа үгээр хэлж ойлголцож болно гэдгийг тайлбарла. Бид мэдрэмжээ бусадтай хуваалцах үед тайвшрал ирдэг.



---

**Зорилго**

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн хувьд бид олон зүйлийг хийж чадна гэдгийг ойлгоход нь тусал.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар 1 Самуел 17-г уншиж судал.
2. Хүүхдүүдийн эх эцэгтэй уулзаж хүүхдийн хамгийн сайн хийж чаддаг юм уу суралцаж байгаа ямар нэгэн зүйлийг нь мэдэж ав.
3. Цаасан дээр алгаа таш, гурав хүртэл тоол, өрөөг тойрон алх, үсэр, дугуй зур (самбар дээр юм уу цаасан дээр), хөл дээрээ зогс, гараа нугал эсвэл цэнхэр өнгө заа зэрэг энгийн заавруудыг бичсэн хуудсуудыг бэлтгэ. Ангид байгаа хүүхдийн тоогоор болон бага зэрэг нөөцтэй бэлд. Ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хийж чадах зүйлийг оруулахаа бүү март.
4. Хүүхдүүдийн нэрсийг тусдаа жижиг цаасан дээр бич.
5. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Жижиг загасны уурга (дурын, хичээл 11-ийг үз).
  - в. Нэр бичсэн хуудаснуудыг хадгалах сав (дурын).
  - г. Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл (62307); зураг 1-10, Гэр бүлийн залбирал (62275); зураг 1-38, Бөмбөгөөр тоглож буй хүүхдүүд; зураг 1-50, Би хувцсаа өмсөж чадна; зураг 1-51, Хамтдаа ажиллаж буй гэр бүл (62313); гэр бүл 1-52, Давид Голиатыг алсан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулга 112; 62073).
6. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

Багшид анхааруулах нь: Тухайн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал тэдэнд мэдрэмтгий бай. Тэдний бие махбодийн хийж чаддаггүй зүйлсэд бус харин хийж чадах зүйлсэд анхаарал хандуул.

---

**Суралцах үйл  
ажиллагаа**

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийн нэр бичсэн цааснуудаа нугалан савандаа хийх юм уу шалан дээр тавь. Хүүхдүүдээр загасны уургаа ашиглаад юм уу гараараа аль нэг цаасыг авахуул. Сонгосон цаасан дээрх нэрийг уншина. Тухайн хүүхдийг өөрийн хажуудаа ирж зогсооно. Ангийнханд тухайн хүүхдийн сайн хийдэг зүйл юм уу сурч байгаа зүйлийг хэл. Хүүхэд бүрээр хийлгэ. Хүүхдүүдэд тэдний сайн хийдэг эсвэл сурч байгаа зүйлийнх нь төлөө талархал илэрхийл.

## **Бидний бие олон зүйлийг хийж чадна**

Дуу

“Би Бурханы хүүхэд” (Сүмийн Дуулал болон Хүүхдийн Дуу, 58-р хуудас) хүүхдүүдтэй хамт дуул.

Би Бурханы Хүүхэд тул,  
Энэ эх дэлхийд намайг,  
Их энэрэнгүй эх эцгийг  
Дэлхийн хамт заяав Тэр.

Надад замаа олоход туслан  
Хөтлөн удирдаач.  
Түүнтэй амьдрахын тул би  
Юу хийх ёстойг заагаач.

- Бидний сүнсний эцэг хэн бэ?
- Хэн бидэнд бие махбод олгохоор дэлхий рүү явуулсан бэ?

Тэнгэрлэг Эцэг биднийг бие махбод олж аваг хэмээн дэлхий рүү илгээсэн гэдгийг ярилц. Тэр биднийг өөрсдийн бие махбодийг ашиглан олон зүйл хийж сурахыг хүсдэг ба бие махбодио зөв зохистой зүйл хийхэд хэрэглэн, Түүнтэй адил болоосой гэж хүсдэг гэдгийг тайлбарла.

- Гараараа бид юу хийж чадах вэ? хөлөөрөө? амаараа? нүдээрээ?

Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл.

- Энэ нялх хүүхэд юу хийж чадна гэж бодож байна?

Дараах асуултуудыг асуу эсхүл нялхаасаа одоог хүртэл хийж сурсан зүйлсийг нь хэлүүлэх ижил төрлийн асуултууд асуу.

- Нялх хүүхэд явж чадах уу?
- Нялх хүүхэд ярьж чадах уу?
- Нялх хүүхэд өөрөө хоолоо идэж чадах уу?
- Нялх хүүхэд өөрөө хувцсаа өмсөж чадах уу?
- Нялх хүүхэд агаарт эргэж чадах уу?
- Нялх хүүхэд дуу дуулж чадах уу?
- Нялх хүүхэд гурван дугуйт унаж чадах уу?

Тэд өсч том болох тусам улам олон зүйлийг сурах болно гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Нэг нэгээр нь зураг 1-10, 1-38, 1-50, ба 1-51 зурагнуудыг үзүүл. Нэг хүүхдээр зургийг бариулж, бусад хүүхдүүд зурган дээр юу болж буйг тайлбарлана. Хүүхэд зургийг тайлбарлаж дууссаны дараа тэдэнд бидний бие махбодийн хийж чаддаг зүйлсийг таньж мэдсэнийг нь магтан сайшаа.

Үйл ажиллагаа

Хүүхэд бүрээр заавар бичсэн хуудаснаас сонгон авахуул. Зааврыг чангаар уншиж зааварт юу гэж заасныг хийлгэ. Хүүхэд бүрээр хийлгэ.

- Одоо чи юу хийхийг сурч байна?
- Том болоод юу хийж сурахыг хүсч байна?

Олон зүйлийг хийж чадах бие өгсөн Тэнгэрлэг Эцэгтээ талархалтай байгаагаа хүүхдүүдэд хэл.

### **Тэнгэрлэг Эцэг биднийг олон зүйл хийж сурахад тусалж чадна**

Бид заримдаа нилээд хэцүү зүйлийг хүртэл хийх хэрэгтэй болдог гэдгийг хүүхдүүдэд хэл. Ямар хэцүү зүйлийг хийх гэж чи их хичээсэн бэ?

- Эдгээр зүйлсийг хийж чаддаг болоход хэн тусалж чадах вэ? (эх эцэг, ах эгч, багш нар)
- Хэцүү зүйлийг хийхэд туслахыг бид хэнээс залбиран гуйж чадах вэ? (Тэнгэрлэг Эцэг)

Бидэнд мөн Есүс Христ хэцүү зүйлийг хийхэд тусална гэдгийг тайлбарла.

Түүх

Зураг 1-52, Давид Голиатыг алсан нь, үзүүл. Давид Голиат нарын тухай 1 Самуел 17-д гардаг түүхийг ярьж өг. Есүс Давидад хэцүү зүйлийг хийхэд нь тусалсан гэдгийг тайлбарла.

- Хэн Израилын армийг сүрдүүлж байсан бэ? (1 Самуел 17:4–8-ыг үз.)
- Давид хэнийг өөртөө тусална гэдэгт найдвартай байсан бэ? (1 Самуел 17:37-г үз.)

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэгт өөрийн олон зүйлүүдийг хийж чадах биеийн төлөө талархалтай байдгаа хуваалц. Тэнгэрлэг Эцэгээс тэднийг сайн зүйлийг хийхэд туслахыг гуйхад нь хүүхдүүдийг зоригжуул.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. Хүүхдүүдтэй хамт “Намайг дагаад хий” (*Children’s Songbook*, р. 276 Дууны үгийг 36-р хичээлээс үз.) дууг дуул. Эсвэл “Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, р. 253) дууг дуулж, мөн зохих хөдөлгөөнийг хий. Нэмэлт бадгуудад үйл хөдлөл санал болгохыг хүүхдүүдээс хүс.
2. Цаас, өнгийн харандаа өгч хүүхэд бүрээр өөрсдийн хийж чадах нэг юм уу хоёр зүйлийг зурахыг хүс. *Би олон зүйлийг хийж чадна* гэж хүүхэд бүрийн цаасан дээр бич.
3. Гэрийнхээ хэн нэгэнд ширээ засах, хогоо шүүрдэх, гэрийн амьтнаа хооллох зэрэг тусалж чадах зүйлээсээ сонгоход нь хүүхдүүдэд тусал. Хичээлийн дараа гэртээ очоод юу хийх ёстойгоо мартаггүйн тулд аав ээждээ энэ өдөр ангид юу хийхээр сонгосноо хэлэхийг хүс.
4. 16-20-р хичээлийн үйл ажиллагаанаас тохиромжтойг сонгон давт.

---

### **Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдийг босгон, “Нэгэн цасан өвгөн байжээ” (*Children’s Songbook*, р. 249) дууг хамтдаа дуул. Хүүхдүүдийг босгон дууны эхний бадаг дээр доош болж, хоёр дахь бадаг дээр дээш сунах үйлдлийг хийлгэ.

Би жаахан байхдаа жаахан, бүр жаахан  
Би жаахан байхдаа намхан, намхан, намхан байв.

Одоо би өсч том болж байна, том, том, бүр том болж байна  
Одоо би өсч том болж байна, өндөр, өндөр, өндөр! болж байна.

Хүүхдүүдээр бага байснаасаа хойш өдийг хүртэл хийж сурсан  
зүйлсийнх нь тухай яриул.

2. Цовхрох, алга таших, үсрэх хөдөлгөөнийг хийж, хүүхдүүдээр юу хийж байгаагаа хэлүүл. Дараа нь хүүхдүүдийг дээрх үйлдлүүдийг хийхийг хүс. Хүүхэд бүрт үйлдэл хийх боломжийг өг. Бусад нь үйлдлийг нэрлээд мөн дуурайж хийнэ.



---

**Зорилго**

Тэнгэрлэг Эцэг бидэнд хэрэгтэй, биднийг хайрладаг гэр бүлүүдийг өгсөн гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Лук 1:26–35-ыг уншиж судал.
2. Ангийн хүүхдүүдийн гэр бүлийнхэнтэй ойр байж тэдний гэр бүлд тохиолдож буй ямар нэгэн эерэг зүйлийг мэдэж аван, дурьдахад бэлэн бай. Жишээ нь: шинэ хүүхэд төрсөн, ах эгч номлолд явсан эсвэл гэр бүлээрээ аялал хийсэн зэрэг.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Шохой ба арилгагч
  - в. Зураг1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл (62307); зураг 1-7, Хайртай гэр бүл; зураг1-16, Есүсийн төрөлт (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 201; 62495); зураг 1-23, Бяцхан дэгдээхэй үүрэндээ; зураг 1-51, Гэр бүл хамтдаа ажиллаж байгаа нь (62313); зураг 1-53, Гэр бүлийн баяр хөөр (62384).
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ. Багшид анхааруулах нь: Ангийн хүүхдүүдийн гэр бүлийн байдалд мэд-рэмтгий бай. Хүүхдүүдэд гэр бүл гэдэг нь хэдэн хүн байх нь чухал биш, харин гэр бүлийн гишүүд бие биеэ хайрлаж хүндэтгэн халамжлан дэмж-дэг байх нь чухал гэдгийг ойлгоход нь тусал.

---

**Суралцах үйл  
ажиллагаа**

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Зураг 1-23, Үүрэндээ байгаа шувуухай, зургийг үзүүл. Хүүхдүүдтэй зургийн талаар ярилцаж, шувуу ба үүрийг ялган ойлгуул.

- Бяцхан шувуухайд хэн үүр засаж өгсөн бэ?
- Яагаад бяцхан шувуухайд түүнийг арчлан халамжлах аав ээж хэрэгтэй вэ? (тэднийг хооллож тэжээж, дулаан байлгахын тулд, мөн аюулаас тэднийг хамгаалахын тулд.)
- Бяцхан шувуухайг том болоход хэн нисэхийг заах вэ?

Бяцхан шувуухайнуудад тэднийг халамжлан хамгаалах гэр бүл байдаг гэдгийг хүүхдүүдэд тайлбарла.

**Би гэр бүлийн гишүүн**

- Чамд гэр бүл бий юу?
- Яагаад чамайг халамжлан хамгаалах гэр бүл хэрэгтэй вэ?

Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл, зургийг үзүүл. Тэнгэрлэг Эцэг хэрхэн биднийг дэлхийд ирж гэр бүлийн нэгэн гишүүн байхаар төлөвлөсөн тухай ярилц. Бяцхан дөнгөж төрсөн хүүхэд өөрөө өөрийгөө арчилж чадахгүй гэдгийг тайлбарла. Бяцхан хүүхэд өөрөө хоолоо идэж, хувцсаа өмсөж чадахгүй. Иймээс түүнийг арчлан хамгаалах гэр бүл хэрэгтэй.

- Чамайг төрөхөд хэн арчилж хамгаалж байсан бэ?
- Чамайг нялх байхад танай гэр бүлийнхэн чиний төлөө юу хийж байсан бэ?
- Одоо танай гэр бүлийнхэн чиний төлөө юу хийж байгаа вэ?
- Хэн биднийг гэр бүлтэй байлгахаар төлөвлөсөн бэ?

Хүүхдүүдэд тэднийг төрөхөд гэр бүлийнхэн нь ямар их баяртай байсныг ойлгоход нь тусал. Тэдний эх эцэг болон бусад гэр бүлийн гишүүд тэдэнд ямар их хайртай, мөн тэднийг жаргалтай байхыг хүсдэг гэдгийг тодруулан хэл.

Дуу

“Би Бурханы Хүүхэд” (Сүмийн Дуулал болон Хүүхдийн Дуу, 58-р хуудас) дууг дуул.

Би Бурханы Хүүхэд тул  
Энэ эх дэлхийд намайг  
Их энэрэнгүй эх эцгийг  
Дэлхийн хамт заяав Тэр.

Надад замаа олоход туслан  
Хөтлөн удирдаач  
Түүнтэй амьдрахын тул би  
Юу хийх ёстойг заагаач.

Зураг 1-16, Есүсийн төрөлт, зургийг үзүүл. Есүс дэлхийд ирэхдээ гэр бүлд төрсөн гэдгийг тайлбарла. (Лук 1:26–35-ыг үз).

- Энэ зурган дээр хэн хэн байна вэ?
- Есүсийн ээж хэн бэ?
- Есүсийн аав нь хэн бэ? (Тэнгэрлэг Эцэг Есүсийн аав гэдгийг хүүхдүүдэд сануул; Иосеф нь Мариа ба Есүсийг халамжлахаар Тэнгэрлэг Эцэгээр сонгогдсон сайн хүн байсан)
- Мариа Иосеф нар Есүсийн талаар ямар мэдрэмжтэй байсан бэ?
- Нялх Есүсийг Мариа Иосеф нар хэрхэн асран өсгөсөн гэж бодож байна?
- Есүсийг хайрлан, халамжлан хүмүүжүүлэх гэр бүлийг хэн өгсөн бэ?

### **Тэнгэрлэг Эцэг, Есүс гэр бүл бүрт хайртай**

Зураг 1-7, Хайртай гэр бүл, зургийг үзүүл. Зарим гэр бүлд аав ээж байдаг. Зарим гэр бүлүүд ганцхан ээж юм уу эсвэл ганцхан аав байдаг. Зарим гэр бүлүүдэд хүүхдүүдийг асран хүмүүжүүлэх хэн нэгэн буюу эмээ өвөө байдаг. Зарим гэр бүлүүд олон хүүхэдтэй, харин зарим нь ганцхан хүүхэдтэй эсвэл бүр хүүхэдгүй байдаг. Гэр бүл бүхэн өөр боловч Тэнгэрлэг Эцэг, Есүс нар бүх гэр бүлүүдэд хайртай гэдгийг ойлгоход хүүхдүүдэд тусал.

Үйл ажиллагаа Хүүхэд бүрийг өөрийн гэр бүлийнхээ талаар ярихыг урь. Тэднээс самбар дээр өөрсдийн гэр бүлийн гишүүдийг дүрсэлсэн (толгойг дугуй дүрсээр, бусад хэсгийг шулуун зураасаар дүрсэл) зургийг нэг нэгээрээ гарч ирэн зурахыг хүс. Гэр бүлийнхээ гишүүдийн нэрийг чангаар хэлж, хэдэн хүнтэйг нь тоолуул. Хүүхэд бүрийг гэр бүлээ танилцуулж дуусахад, тэдний гэр бүлийн талаар мэдсэн зүйлээ хуваалцан ярь.

**Тэнгэрлэг Эцэг ба Есүс гэр бүлийн гишүүд хайраа бие биедээ харуулахыг хүсдэг**

Дуу “Аз жаргалтай гэр бүл” (*Children’s Songbook*, p. 198) дууг дуулах юмуу үгийг нь хэл.

Би ээждээ хайртай, тэр ч надад хайртай  
Бид аавдаа хайртай, үнэхээрийн маш их хайртай  
Тэр бидэнд хайртай, үүнийг нь ч харж болно  
Бид аз жаргалтай гэр бүл.

(From *Merrily We Sing*, © 1948, 1975 by Pioneer Music Press, Inc. [a division of Jackman Music]. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

- Танай гэр бүлийнхэн чамд хайртай гэдгийг чи яаж мэддэг вэ?
- Гэр бүлийнхэндээ хайртай гэдгээ чи яаж харуулдаг вэ?

Зураг 1-53, Гэр бүлийн баяр хөөр зургийг үзүүл.

- Энэ аз жаргалтай гэр бүл үү? Чи яаж мэдсэн бэ?
- Чи гэр бүлийнхэнтэйгээ юу хийх дуртай вэ?
- Бие биетэйгээ нөхөрсөг байхад чамд ямар байдаг вэ?

Зураг 1-51, Гэр бүлийнхэн хамтдаа ажиллаж байгаа нь, зургийг үзүүл.

- Энэ гэр бүл юу хийж байна вэ?
- Чи гэр бүлийнхэндээ яаж тусалдаг вэ?
- Гэр бүлийнхэндээ туслахад чамд ямар байдаг вэ?

Үйл ажиллагаа Гэртээ гэр бүлийнхэндээ туслах, тоглоомоо хураах, бага дүүтэйгээ тоглох, аяга тавгаа угаахад туслах зэрэг янз бүрийн арга замын талаар бодохыг хүс. Өөрсдийн санаануудаа үйлдлээр үзүүлэхийг хүс. Ирэх долоо хоногт гэр бүлийнхэндээ туслахыг уриал.

Гэрчлэл Гэр бүлийн гишүүн байхын адислалд Тэнгэрлэг Эцэгт талархалтай байдаг талаараа гэрчлэлээ хуваалц.

---

**Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. “Аз жаргалтай гэр бүл” дууг дахин дуул. Дөрвөн хүүхдийг дуунд гарч буй гэр бүлийнхэн болгохоор сонго. Гэр бүлийн аль гишүүнийг төлөөлж байгаагаа харуулах зургийг бариул. Дөрвөн хүүхдийн ар талаар зогсож

дуунд хэний тухай хэлж байна тэр гишүүнийг төлөөлж буй хүүхэд рүү заа. Дөрөв дөрвөөр хүүхдүүдийг ээлжлүүлэн сольж дууг давтан дуул. Хүүхэд бүрийг оролцтол үргэлжлүүл.

2. Мозая 4:14–15-д гардаг Хаан Бенжамины гэр бүлийнхэндээ хэлсэн зааврын талаар хэл, 15-р шүлгийн сүүлийн хэсгийг чанга дуугаар унш. Хүүхдүүдээр гэр бүлийн гишүүд бие биеэ хайрлаж, бусдад үйлчлэх арга замуудыг хэлүүл.

3. Хүүхдүүдээр дараах хуруун тоглоом тоглуул:

Миний гэр бүл

Энэ миний хөөрхөн ээж (*долоовор хуруугаа заа*);

Энэ өндөр миний аав (*дунд хуруугаа заа*).

Энэ миний эгч (*ядам хуруугаа заа*)

Энэ бүгд биш.

Энэ миний бяцхан дүү (*чигчий хуруугаа заа*),

Үнэхээр жижигхэн, бүр жижиг

Энэ өөр хүн чинь хэн бэ (*эрхий хуруугаа заа*)?

Мэдээж энэ чинь би.

Нэг, хоёр, гурав, дөрөв, тав, чи харж байна (*тоолох зуураа бүх хуруундаа хүр*),

Маш сайхан гэр бүл!

Хүүхдүүдийг өөрийн гэр бүлийн гишүүдийн тоогоор хуруугаа гарган харуулахыг хүс (Хэрэв хүүхдийн гэр бүл арваас дээш хүнтэй бол өөр хүүхдээр туслуул). Хүүхэд бүр сүүлийн хоёр мөрийг хэлэх буюу гэр бүлийнхээ гишүүдийн тоог тоолоод “Маш сайхан гэр бүл” гэж хэлнэ.

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Зураг 1-23, Бяцхан шувуу үүрэндээ, зургийг үзүүл. Та дуулах юмуу үгийг нь хэлж байх явцдаа хүүхдүүдэд “Модон дээрх шувууд” (*Children’s Songbook*, р. 241) дууны үйлдлийг хийхэд тусал:

Модны мөчрүүд дундаас (*толгой дээрээ гараа барь*).

Бид жижигхэн үүрийг олох болно (*хоёр гараа нийлүүлэн аяга мэт болго*)

Дотор нь байгаа өндгийг тоолъё,

Энд нэг, хоёр, гурав (*тоолох бүрт нэг хуруугаа гозойлго*).

Ээж шувуу нь үүрэндээ сууна (*зүүн гараа аяга мэт болгож, баруун гараа дээр нь тавь*)

Бүх гурван өндгөө дарна (*гурван хуруугаа гозойлго*).

Аав шувуу эргэлдэн тойрон нисч (*гараараа нисч буй шувуу бол*)

Өөрийн гэр бүлээ хамгаална.

2. “Энд бид хамтдаа” (*Children’s Songbook*, р. 261) дууны үгийг хэл.

Энд бид хамтдаа, хамтдаа, хамтдаа

Өө, энд бид гэр бүлдээ хамтдаа

Тэр аав, ээж, эгч, ах;

Өө, энд хамтдаа энэ цэлмэг нартай өдөр.

3. Та үгийг хэлэхэд, хүүхдүүдийг үйлдлийг хийж, даган хэлэхэд тусал:

Миний гэр бүл

Модон дээрх шувууд шиг (*гараа далавч мэт болго*),

Би бас өөрийн гэр бүлтэй (*өөр лүүгээ заа*).

Тэд надад хоол өгдөг (*юм идэж буй бол*)

Надад тоглохыг заадаг (*үсэр*),

Тэгээд би өдөржин аюулгүй аз жаргалтай байж чадна (*томоор инээ*).

4. Тохирох ая хийн дараах үгсийг дүүсдээ үгсийг хэл:

Ээж надад хайртай. ээж надад хайртай

Аав бас, аав бас

Гэр бүлийнхэн, гэр бүлийнхэн чинь

Үнэнээсээ хайртай, үнэнээсээ та нарт хайртай

---

**Зорилго**

Хүүхэд бүрийг ах эгч нартаа хайраа үзүүлэхэд нь тусал.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Египетээс гарсан нь 1:22–2:10-ыг уншиж судал.
2. Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр нэг ээжийг ангид нярай хүүхэдтэйгээ ирэхийг урь. Тэр болон түүний гэр бүлийнхэн хүүхдийг аюулгүй байлгахад анхааран хийдэг зүйлсээ оролцуулан, хэрхэн халамжлан өсгөдөг талаараа ярихыг хүс. Түүнийг хүүхдээ хайрлах хайрынхаа талаар мөн ярихыг хүс. Хэрэв нярай хүүхэдтэй ээж байхгүй бол нэг ээжийг хүүхэд нь нярай байсан үеийнх нь зургийг авчран ярихыг хүсч болно.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Нялх хүүхэлдэй
  - в. Зураг 1-2, Мосе Зэгсэн дунд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 106; 62063); зураг 1-13, Иосеф Смит (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 400; 62449)
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

Багшид анхааруулах нь: Энэ хичээлийг заах үед ах, эгчгүй хүүхдүүдэд мэдрэмтгий бай.

---

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Нярай хүүхэдтэй ээжийг ангийнхандаа танилцуулан өөрийн хүүхдийн талаар ангийн хүүхдүүдэд ярьж өгөхийг хүс. Хүүхдүүд түүний хүүхдийн талаар асуулт асуу. Шинэ хүүхэд төрөхөд гэр бүлийнхэн нь ямар их баяртай, догдолж байсныг яриул.

**Бид өөрсдийн ах эгч, дүүсээ хайрлаж чадна**

- Та нарт жаахан дүү байгаа юу?

Бага дүүтэй хүүхдээр дүүгийнхээ талаар болон гэр бүлийнхэн нь дүүг нь төрөхөөс өмнө хэрхэн бэлтгэл хийж байсан талаар ярихыг хүс.

- Та нарт ах эгч бий юу?

Хүүхдээр тэдний ах эгчийнх нь талаар яриул. Өмнөх хичээл дээр бидний гэр бүлүүд өөр өөрийн өвөрмөц амьдралтай болох талаар ярьсан гэдгийг сануул. Зарим хүмүүс олон ах эгчтэй байхад зарим нь цөөхөн эсвэл бүр байхгүй. Хэдэн ах эгчтэй байх нь хамаагүй бид хайрлаж, элэгсэг дотно байх ёстой.

Түүх

Зураг 1-13, Иосеф Смит, зургийг үзүүл. Сүмийн анхны Ерөнхийлөгч, Бошиглогч Иосеф Смит, Хайрум гэдэг ахтай байсан. Тэр ахдаа маш их хайртай байлаа. Хайрум, Иосеф нар сайн найзууд байсан бөгөөд амьдралынхаа туршид бие биедээ тусалдаг байсан. Хайрум хэрхэн Иосефт тусалж байсан түүхийг өөрийн үгээр ярьж өг:

Иосеф Смит бага байхдаа хөлөндөө маш их хүнд өвчтэй болж, хэцүүхэн байлаа. Түүний ээж өдөр шөнөгүй хүүгээ халамжлан асарсаар өөрөө ядарч өвдсөн тул амрах хэрэгтэй болсон. Том ах Хайрум нь ээжийнхээ оронд Иосефийг асрахыг хүссэн. Хайрумын эх эцэг түүнд итгэж болно гэдгийг мэдэж байсан тул түүнийг Иосефыг асрахыг зөвшөөрчээ. Хайрум өвчинд шаналж буй дүүгийнхээ дэргэд олон хоног байжээ. Маш хүнд өвдөлтийг нь бага ч болов багасгах ганц арга нь Иосефын хөлийг барьж өгөх л байсан тул Хайрум дүүгийнхээ хөлийг барьж өгдөг байв (Lucy Mack Smith, *Joseph Smith History*, редактор Preston Nibley [Salt Lake City: Bookcraft, 1954], 55-р хуудас).

- Хайрум өөрийн дүү Иосефт хайртай байсан гэдгийг та нар яаж мэдэж байна?

Ах эгчдээ өөрийн хайраа үзүүлэх нэг арга бол тэдэнд туслах юм гэдгийг тайлбарла.

#### **Бид өөрсдийн ах эгчдээ тусалж чадна**

- Өөрийн ах эгчдээ яаж тусалж чадах вэ?
- Танай ах эгч чамд яаж тусалдаг вэ?

Үйл ажиллагаа

Өөрсдийн ах эгчтэйгээ хэрхэн харьцах талаар үйл хөдлөлөөр харуул. Хүүхэд ах эгч, дүүсдээ тусалж байгаа үйлдэл хийж байвал эрхий хуруугаа гозойлго, харин туслахгүй бол эрхий хуруугаа доош харуул. Дараах санаануудаас хэрэглэ:

- Өөрийн шинэ тоглоомоо эгчтэйгээ хуваалцах.
- Ахынхаа бөмбөгийг түүний зөвшөөрөлгүйгээр авах.
- Дүүдээ тоглоомоо хураахад нь туслах.
- Ахаасаа түүний бөмбөгөөр тоглож болохыг асуух.
- Дүүтэйгээ хамт тоглохоос татгалзах.
- Ахыгаа гунигтай байхад нь элэгсэг дотно байх.
- Эгчийгээ ганцаардаж байх үед нь хамт тоглох.

#### **Бид нялх дүү нартаа тусалж чадна**

Магадгүй дүүтэй болох нь хэцүү байдаг. Учир нь гэр бүлийнхэн нь түүнд илүү анхаарал халамж тавьдаг. Хэдий эх эцэг нь дүүд нь илүү цаг зарж байгаа боловч тэд хүүхдүүддээ бүгдэд нь хайртай хэвээр байгаа гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Нярай хүүхдэд илүү их анхаарал халамж хэрэгтэй гэдгийг сануул. Том хүүхдийн хувьд (энэ ангид байгаа хүүхдүүд) олон зүйлийг өөрсдөдөө болон дүүдээ зориулан хийж чадна.

- Яаж аав ээждээ дүүгээ асрахад нь тусалж чадах вэ?

Үйл ажиллагаа	<p>Хүүхэлдэйг тэврэн хүүхэд яаж тэврэхийг үзүүл. Хялбархан бүүвэйн дуу заах юмуу “Би Бурханы Хүүхэд” (<i>Сүмийн Дуулал болон Хүүхдийн Дуу</i>, 58-р хуудас) дууг дуулах зуур хүүхдүүд хүүхэлдэйг ээлжлэн тэвэрч болно.</p> <p>Би Бурханы Хүүхэд тул, Энэ эх дэлхийд намайг Их энэрэнгүй эх эцгийг Дэлхийн хамт заяав Тэр</p> <p>Надад замаа олоход туслан Хөтлөн удирдаач. Түүнтэй амьдрахын тул би Юу хийх ёстойг заагаач.</p>
Түүх	<p>Мосе түүнийг хайрладаг эгчтэй байсан ба түүнийг нялх байхад нь түүнд тусалсан гэдгийг тайлбарлан ярь. Зураг 1-2, Мосе Зэгсэн дунд, зургийг ашиглан Египетээс гарсан нь 1:22–2:10 дээр гардаг Мосегийн бага насны тухай түүхийг ярьж өг. Мириам дүүгийнхээ араас хэрхэн харж байсныг тодруул.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бяцхан Мосед Мириам яаж тусалсан бэ?</li> </ul>
Гэрчлэл	<p>Ах эгч дүүс бие биесээ хайрлахын чухлын талаар гэрчлэлээ хуваалц. Хэрэв боломжтой бол бага насны тохиолдлоосоо хэрхэн ах эгч нар тань тусалж байсан тухай ярь. Хүүхдүүдэд ах эгч дүүдээ туслахад тэдэндээ хайраа үзүүлж байгаа хэрэг гэдгийг сануул. Бидэнд энэ сайхан гэр бүлүүдийг өгснийх нь төлөө Тэнгэрлэг Эцэгт маш их талархалтай байдгаа хэл.</p>

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдүүдэд цаас харандаа юмуу өнгийн харандаа өг. Тэднийг ах эгч дүүсийнхээ зургийг зурахыг хүс. Хүүхэд бүрийг зурсны дараа зургаа үзүүлэн өөрсдийн ах эгч дүүсийнхээ талаар ээлжлэн ярихыг урь. Өөрсдийн ах эгч дүүстэйгээ хамтдаа хийх дуртай зүйлээсээ хэлэхийг хүс.
2. Хүүхдүүдийн багынх нь зурагнуудыг олж ав. Тэгээд зургийг үзүүлэн хэн болохыг таалга. (Зурагнуудыг эргүүлэн аав ээжид нь гэмтээлгүйгээр буцааж өгөхөө бүү март.) Хүүхдүүдэд тэднийг бага байхад нь ах эгч нар нь хэрхэн тусалж, тэднийг асарч халамжилж байсан талаар сануул.
3. “Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, р. 253) дууг “Хүүхэд бүүвэйлэх гоё шүү” эсвэл “Эгчдээ туслах сайхан шүү.” Үгийн дагуу үйлдийг хий.
4. “Аз жаргалтай гэр бүл” (*Children’s Songbook*, р. 198) дууны хоёрдугаар бадгийг дуул.
5. Гэр бүлийнхээ зургийг авчирч ах эгч нарынхаа тухай хүүхдүүдэд ярь. Хамтдаа хийдэг байсан зарим хөгжилтэй түүхээсээ хуваалцаж болно.
6. Хүүхэлдэй, жижиг хайрцаг юм уу сагс, алчуур ашиглан Мириам ба Мосе зэгсэн дунд түүхээр жүжигчилсэн тоглолт хий.



---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Том оймсонд юм уу уутанд хүүхдүүд амар таньж чадах нялх хүүхдийн хэрэглэдэг зүйлсийг хий. Хүүхдүүдийг уутанд гараа хийж, харалгүйгээр тэмтрэн барьж үзээд, юу болохыг таахыг хүс.
2. “Аз жаргалтай гэр бүл” (*Children’s Songbook*, р. 198) дууны хоёр бадгийг дуулах юмуу үгийг нь хэл. Дуунд тохирох үйлдлийг хийх эсвэл гараасаа барилцан тойрон эргэлдэн алх.
3. Дараах хуруун тоглоом тоглуул:  
Эдгээрийг бяцхан хүүхэд хийдэг:  
Алгаа таш – алгаа таш – алгаа таш – алгаа таш (*алгаа таш*)!  
Үүнийг бяцхан хүүхдүүд хийдэг:  
Пиикабүү, би чамайг харж байна (*гараараа нүүрээ таглан нуугдаж тоглох*)!  
Үүнийг бяцхан хүүхдүүд хийдэг:  
Мөлхөх – мөлхөх – мөлхөх – мөлхөх (*хуруугаараа агаарт “алх”*).  
Үүнийг бяцхан хүүхдүүд хийдэг:  
Унтах – унтах – унтах – унтах (*толгойгоо хажуу тийш гудайлган нийлүүлсэн хоёр гар дээрээ тавь*).
4. Таныг үгээ хэлэхэд хүүхдүүд дараах үйлдлийг хийнэ:  
Бяцхан хүү Мосе  
Бяцхан хүү Мосегийн ор завь болон сэлж (*нэг гараа аяга мэт болгон нөгөө гарын долоовор хуруугаа түүн дээр тавь*).  
Түүний хайртай эгч зэгсний араар нуугдан түүнийг харна (*хуруун завсраар хар*).  
Нэгэн өдөр гүнж түүнийг олж (*доош тонгойн хар*) өөрийн гар дээр авлаа (*хүүхэд тэврэн авах мэт бол*);  
Тэр “Би энэ хүүхдийг авч аюулаас хамгаалах болно” гэж хэллээ (*гартаа хүүхдийг тэврэх хөдөлгөөн хий*).  
(Eleanor Doan-ий *Fascinating Finger Fun* номноос. © 1951.  
Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

# Би гэр бүлийнхэндээ бүгдэд нь хайртай

Хичээл  
25

---

## Зорилго

Гэр бүлийнхээ бүх гишүүдийг хайрлах мэдрэмж олоход туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Лук 1:36–44, 56-г уншиж судал.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи
    - б. Зураг 1-7, Хайртай гэр бүл; зураг 1-18, Усаар батлагч Иохан Есүсийг усаар баталсан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 208; 62133); зураг 1-54, Солт Лейкийн Ариун Сүм (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 502; 62433), эсхүл орон нутгийн Ариун Сүмийн зураг.
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.
- 

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

“Аз жаргалтай гэр бүл” (*Children’s Songbook*, р. 198) дууг дуулах эсхүл хүүхдүүдтэй хамт үгийг нь хэл.

Би ээждээ хайртай, тэр ч надад хайртай  
Бид аавдаа хайртай, маш их хайртай  
Тэр бидэнд хайртай үүнийг харж болно  
Бид жаргалтай гэр бүл

Би эгчдээ хайртай, тэр надад хайртай  
Бид ахдаа хайртай маш их хайртай;  
Тэр бидэнд хайртай үүнийг харж болно,  
Бид жаргалтай гэр бүл.

(From *Merrily We Sing*, © 1948, 1975 by Pioneer Music Press, Inc. [a division of Jackman Music]. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

Өнгөрсөн долоо хоногт гэр бүлийнхэнтэйгээ юу хийсэн талаар яриул.  
Хүүхэд бүрийг өөрийн ах эгч, аав ээж нарынхаа нэрийг хэлэхийг хүс.

- Бидний гэр бүлд өөр хэн хэн байдаг вэ?

### **Эмээ өвөө нар, нагац болон авга ах эгч нар, үеэлүүд маань бидний гэр бүлийн чухал хэсэг**

Зураг 1-7, Хайртай гэр бүл, үзүүл.

- Танай гэр бүлтэй энэ гэр бүл юугаараа адил байна?
- Юугаараа энэ гэр бүл танай гэр бүлээс өөр байна?
- Энэ зурган дээр эмээ өвөө нар нь аль вэ?

Эмээ өвөө нар бидний аав ээжийн аав нь ээж нь гэдгийг тайлбарла. Бид бүгдэд эмээ өвөө нар бий. Гэхдээ заримдаа бид тэдний талаар сайн мэддэггүй. Учир нь тэд нас барсан юм уу алс хол амьдардаг.

- Та нарын хэд нь эмээ өвөө нараа мэдэх вэ?
- Танай эмээ өвөө нар ойр амьдардаг уу хол байдаг уу?
- Тэдэнтэй чи юу хийх дуртай вэ?

Дуу

Дараах үйлдийг хийн “Эмээ” (*Children’s Songbook*, р. 200) дууны эхний хоёр бадгийг дуул эсвэл үгийг нь хэл. Хэрэв хүсвэл бадаг бүрийн сүүлийн мөрний эмээ гэдэг үгийг өвөө гэдгээр солин давтан дуулж болно

Та намайг үнсдэг (*хуруугаа уруул дээрээ тавьж ав*).

Та намайг тэвэрдэг (*өөрийгөө тэвэр*).

Бас Та намайг хараад инээмсэглэдэг (*инээмсэглэ*).

Энэ дэлхийн бүх хүүхдүүд (*гараа дэлгэ*)

Над шиг эмээтэй болоосой гэж хүсч байна (*заа*).

Та надад ном уншиж (*ном барьж буй бол*).

Та надад дуу дуулж (*амаа дуулж буй мэт онгойлго*).

Бас надад хайртай гэж шивнэдэг (*гараа аяга болгон амандаа барь*).

Би энэ дэлхийн бүх хүүхдүүд (*гараа дэлгэ*)

Над шиг эмээтэй байгаасай гэж хүсч байна (*заа*).

- Өөр хэн танай гэр бүлд багтдаг вэ? (нагац, авга, үеэл)

Нагац, авга, үеэл гэдэг хэрхэн хамаатан болдог талаар бага зэрэг тайлбарла (жишээ нь: аав юмуу ээжийн чинь ахыг нагац болон авга ах гэж нэрлэдэг). Хүүхдүүдээр тэдний авга, нагац ах эгч нарынх нь талаар яриул.

Түүх

Ариун Библийг харуулж, хүүхдүүдэд Есүсийн амьдралын талаар энэ номноос уншиж чадна гэдгийг хэл. Лук 1:36–44, 56-г нээн уншиж, Мариа Есүсийг төрүүлэхээс өмнө мөн жирэмсэн байсан өөрийн үеэл Елизабет дээр зочилж очсон гэдгийг тайлбарла. Елизабетийн хүүхдийг Иохан гэдэг байсан ба тэр Есүсийн үеэл бөгөөд найз нь байсан. Тэд өсч том болоод Иохан Есүсийг усаар баталсан. Усаар батлагч Иохан Есүсийг усаар баталсан нь, Зураг 1-18-ыг үзүүлж Иохан болон Есүсийг хүүхдүүдээр заалга.

### **Гэр бүлийн гишүүд бидний сайн найз нар**

Бидний гэр бүлийн бүх гишүүд бидний сайн найзууд гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Өөрийн ойр байдаг хамаатныхаа талаар юу гэж боддогоо хэл.

- Яагаад бид өөрсдийн гэр бүлтэйгээ хамт байхыг хүсдэг вэ?

Дуу

“Аз жаргалтай гэр бүл” дууг хүүхдүүдтэй хамт дахин дуул. Энэ удаа авга, нагац, үеэл, эмээ, өвөө гэдэг үгийг нэм.

- Өөрийн авга, нагац, үеэл болон эмээ өвөө нартайгаа юу хийдэг вэ?

Гэр бүлийн цугларалт, юм уу онцгой баяр ёслол, үйл явдлын үед гэр бүлүүд хамтдаа цуглардаг гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Хүүхдүүдээс тэдний санаж байгаа гэр бүлийн баяр наадам, зочлолтынхоо талаар ярихыг хүс.

Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд зориулан гэр бүлүүд мөнхөд хамтдаа байхаар төлөвлөсөн. Зураг 1-54, Солт Лэйкийн Ариун Сүм эсвэл өөрсдийн орон

нутгийн Ариун Сүмийн зураг үзүүл. Ариун сүмд гэрлэж, зөв амьдарвал бид гэр бүлтэйгээ мөнхөд хамт байж чадна гэдгийг товчхон тайлбарла.

Гэрчлэл

Хүүхдүүдэд гэр бүлийнхнийгээ хайрладаг хайрынхаа талаар ярь. Гэр бүлүүд маань бидний хувьд том адислал гэдгийг тодруул. Хүүхдүүдийг өөрсдийн гэр бүлийнхээ гишүүдэд нөхөрсөг дотно байхыг хэл.

---

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр нэг хүүхдийн эмээ юмуу өвөөг ангидаа ирэхийг урь. Тэднийг өөрсдийн ач (зээ) хүүхдийнхээ талаар ярихыг хүс (эсвэл нагац, авга юм уу үеэлийг урьж гэр бүлийнхнийгээ хэрхэн хайрладаг талаар нь яриул).
2. Өөрийн гэр бүлийнхээ зургийг (эхнэр нөхөр, хүүхдүүд зэрэг) ялангуяа эмээ өвөө, авга, нагац, үеэл нартайгаа хамт авахуулсан нэг юм уу хоёр зураг авчир. Зурган дээрээс өөрийгөө болон тэдний мэддэг бусад хүмүүсийг хүүхдүүдээр олуул. Хүүхдүүдэд зурган дээрх хүмүүсийн талаар ярьж өг.
3. Хүүхэд бүрт гэр бүлийн гишүүнийг “Ээж”, “Аав”, “Эгч”, “Ах”, “Эмээ”, “Өвөө”, “Авга”, “Нагац”, “Үеэл” гэж бичсэн энгэрийн тэмдэг өг (хэрэв ангид цөөхөн хүүхэд байвал эдгээрээс заримыг нь хэрэглэ. Хэрэв олон хүүхэд байвал давтагдсан нэр байж болно.) Бичигдсэн үгийг дуудахад тухайн нэртэй энгэрийн тэмдэгтэй хүүхэд ангийн өмнө гарч ирнэ. Гэр бүлийн гишүүн бүр хамтдаа байх нь чухал гэдгийг тайлбарла. Хүүхдүүд тойрог болон гар гараасаа барилцана. Гар гараасаа барилцаж байхдаа гараа савлах, тойргоор алхах болон “Жаргалтай гэр бүл” дууг дуулна.
4. Хүүхэд бүрээр өөрсдийн эмээ өвөө, юм уу бусад хамаатных нь зураг зуруул. *Миний эмээ өвөө* гэж зураг бүр дээр бич. Хэрэв гэр бүлийн өөр хүнийг зурсан бол тохиромжтойг нь бич.

---

### Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа

1. Хайрыг илэрхийлсэн зүрхэн хэлбэр хийн, хайрцаг юм уу уутан дээр наа. Түрүүчийн зурсан гэр бүлийнхэн болон хамаатныхаа зургийг хайчил. Хүүхдүүдээс “Хэн чамд хайртай вэ?” гэж асуу. Хүүхэд хариултаа өгөхөд тухайн хэлсэн хүний зургийг уут юм уу хайрцгандаа хий. Бүх зургийг хайрцаг юм уу уутанд хийсний дараа түүнийг өргөж бариад хүүхдүүдэд “Эдгээр хүмүүс бүгд чамд маш их хайртай” гэж хэл.
2. Гэр бүлийн гишүүдийн зурагтай хайчилбарыг (дээрх үйл ажиллагаа 1-ийг үз) ширээн дээрээ эсвэл шалан дээр тавь. Хүүхдүүдийг дороо нэг эргэх эсвэл нүдээ анихыг хүсээд хайчилбараас нэгийг нь сугалан ав. Хүүхдүүдээр хэний хайчилбар байхгүй байгааг таалга. Хүссэнээрээ давтан хий. Бүх хайчилбаруудыг эргүүлэн хийж, Тэнгэрлэг Эцэг бидний гэр бүлийг бүгд хамтдаа байхыг хүсдэг гэдгийг хэл.

3. Хүүхдүүдийг гэр бүлийнх нь нэгэн хэсэг болсон хамаатнуудынхаа нэрсийг хэлэхийг хүс. Жишээ нь: авга ах, нагац, үеэл, эмээ гэх мэт. Гэр бүлийн эдгээр гишүүддээ яаж тусалж чадахаа хөдөлгөөнөөр дүрслэн үзүүлэхийг хүс.

# Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна

Хичээл  
**26**

---

## Зорилго

Хүүхдүүдэд Ариун Сүм нь гэр бүлүүд мөнхийн холболт хийлгэдэг ариун газар бөгөөд бид орохоор бэлтгэх ёстой гэдгийг ойлгоход нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Сургаал ба Гэрээ 97:15–17, 124:37–41-ийг уншиж судал. Мөн Сургаалын зарчмууд (31110)-ын бүлэг 36 болон “Bible Dictionary” дэх “Ариун сүм”-ийг үз.
2. Шаардлагатай зүйлс
  - а. Сургаал ба Гэрээ
  - б. Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл (62307); зураг 1-7, Хайртай гэр бүл; зураг 1-54, Солт Лейкийн Ариун Сүм (Сайн мэдээний уран зургийн цуглууллага 502; 62433); бусад Ариун Сүмийн зурагнууд (Сайн мэдээний уран зургийн цуглууллага 505; 62434–62448, 62566–62569, 62583–62601, 62613–62619); хичээлийн төгсгөлд байгаа зурсан зураг.
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглахыг хүсч буй бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ

Зураг 1-54, Солт Лейкийн Лэйкийн Ариун Сүм болон бусад Ариун Сүмүүдийн зурагнуудыг үзүүл. Хүүхдүүдээр Ариун Сүмийн талаар юу мэддэгийг нь чөлөөтэй яриул.

- Та нар ариун сүм харж байсан уу?
- Ариун Сүмийг харахад ямар сэтгэгдэл төрсөн бэ?

Ариун Сүмийн шовх орой, цонх болон хаалгануудын үзэсгэлэнт байдлын талаар ярилц. Мөн бүх Ариун Сүмийн гадна ханан дээр *Их Эзэний Өргөө* гэж бичсэн байдаг гэдгийг хэл. Сүмийн гишүүд Ариун Сүмд очиж, Тэнгэрлэг Эцэг ба Есүс, тэдний хайрын талаар суралцдаг.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг толгойн дээрээ гараа тавьж Ариун Сүмийн оройг төсөөлөн хийхийг урь. Тэднийг эгцхэн тэгш зогсож үзэсгэлэнт Ариун Сүм болохыг хүс. Дараа нь чимээгүй доош суудалдаа суухыг урь.

### Ариун Сүм нь ариун газар юм

Ариун Сүм нь ариун газар гэдгийг тайлбарла (С ба Г 97:15–17-г үз). Хүүхдүүдийг *ариун* гэдэг үгийг давтан хэлэхийг хүс. Энэ нь Ариун Сүмийн бүх зүйл нь Тэнгэрлэг Эцэг, Есүсийг мэдрүүлсэн онцгой ариун газар гэсэн үг юм.

Хэрэв тэд Тэнгэрлэг Эцэгийн тушаалуудыг дуулгавартайгаар дагах юм бол том болоод Ариун Сүмд орох боломжтой гэдгийг хүүхдүүдэд тайлбарла. Мөн Ариун Сүмд бид Тэнгэрлэг Эцэгтэй Түүний тушаалуудыг дагах онцгой гэрээ хийж, амлалт авдаг. Бид Ариун Сүмд гэрлэж, энэ

амьдралдаа баптисм хийлгэж амжаагүй хүмүүсийн төлөө баптисм хийж чадна гэдгийг тайлбарла.

Хүүхдүүдийг гурван хуруугаа өргөхийг хүс. Тэд том болоод Ариун Сүмд хийж чадах гурван зүйлийг нэрлэхийг хүс.

“Ариун Сүмд Тэнгэрлэг Эцэгтэй онцгой амлалт хийж чадна.”

“Ариун Сүмд гэрлэж чадна.”

“Ариун Сүмд бусдын төлөө баптисм хүртэж чадна.”

Дуу

Хүүхдүүдийг босгож зогсоогоод дараах үйлдлийг хийлгэн “Би Ариун Сүмийг харах дуртай” (*Children’s Songbook*, р. 95) дууны эхний бадгийг дуулах буюу үгийг хэлүүл.

Би Ариун Сүм харах дуртай (*гараа дээш өргөн хуруунуудынхаа үзүүрүүдийг нийлүүлэн сүмийн орой хий*).

Ариун Сүмийг мэдэрч (*зүрхэн дээрээ гараа тавь*),

Сонсож, залбирахаар (*чихэн дээрээ гараа тавь, дараа нь гараа зөрүүлэн нугал*).

Би нэгэн цагт тэнд очно (*дороо алх*)

(© 1980 by Janice Kapp Perry. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

Ариун Сүм ариун бишрэлийн газар тул бид тэнд дотор нь бүгд цагаан хувцас өмсдөг. Цагаан хувцас нь Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг цэвэр ариун байж үргэлж зөвийг хийгээсэй гэж хүсдэгийн бэлэг тэмдэг юм.

- Өнөөдөр чи ямар өнгийн хувцас өмссөн байна?
- Ариун Сүм дотор ямар өнгийн хувцас өмсдөг вэ?

Ариун Сүм нь ариун газар учир дотор нь байхдаа бид хүндэтгэл бишрэлтэй байдаг гэдгийг тайлбарла. Бид шивнэн намуухан ярьдаг. Хүүхдүүдээр “Би Тэнгэрлэг Эцэг, Есүст хайртай” хэмээн шивэгнэн хэлүүл. Бид Тэнгэрлэг Эцэг, Есүстэй ойр болдог тул аз жаргал, амар амгаланг Ариун Сүм дотор мэдэрдэг гэдгийг тайлбарла.

Түүх

Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн дараах түүхийг өөрийн үгээр ярьж өг:

Лорензо Снөү удахгүй Сүмийн бошиглогч болно гэдгээ мэдэж байсан. Тэгээд цагаан хувцсаа өмсөн тусгай өрөөнд өвдөг сөхрөн сууж залбирал хийжээ. Тэр Тэнгэрлэг Эцэг түүнд Сүмийг удирдахын тул юу хийх хэрэгтэйг хэлж өгөхийг хүсчээ. Тэр залбирсаар л байж гэвч ямар ч хариулт хүлээн авсангүй гэнэ. Залбирал хийж байсан өрөөг орхин гарах үедээ Ерөнхийлөгч Снөү Есүсийг харжээ. Есүс үзэсгэлэнтэй сайхан, цагаан нөмрөг нөмөрсөн гэрэл цацруулан гэрэлтэж байсан тул Ерөнхийлөгч Снөү арай ядан түүн рүү харжээ. Есүс түүн рүү харан хатуу алтан дээр зогсож буй мэт байв. Есүс Ерөнхийлөгч Снөүд түүний залбиран мэдэхийг хүссэн бүхнийг хариулжээ (LeRoi C. Snow, “An Experience of My Father’s,” -ийг үз. *Improvement Era*, 1933 оны есдүгээр сар, хуудас 677).

- Ерөнхийлөгч Снөү яагаад Ариун Сүм дотор залбирсан гэж бодож байна? (Ариун Сүм дотор Тэнгэрлэг Эцэг, Есүс нартай илүү ойр байж чадах учир.)

## Ариун Сүмүүд гэр бүлүүдэд мөнхөд хамтдаа байхад тусалдаг

Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл, зураг 1-7, Хайртай гэр бүл зурагнуудыг үзүүл. Ариун Сүмүүд гэр бүлүүдийг мөнхөд хамтдаа байхад тусалж чадна гэдгийг тайлбарла. Ариун Сүмд эрэгтэй эмэгтэй хүмүүс эхнэр нөхөр болон гэрлэж, тушаалуудыг дуулгавартай дагахад Тэнгэрлэг Эцэг тэд үр хүүхдүүдтэйгээ хамтдаа мөнхөд байж чадна гэдэг амлалтыг тэдэнд өгдөг. Үүнийг бид гэр бүлээрээ *мөнхөд лацлагдан холбогдох* хэмээн нэрлэдэг.

- Бидний гэр бүлийн хүмүүс гэдэг хэн бэ?
- Гэр бүлийнхэнтэйгээ хамт байхад чамд ямар байдаг вэ?
- Гэр бүлүүд яаж мөнхөд хамтдаа байж чадах вэ?

Тэнгэрлэг Эцэг, Есүс нар гэр бүл бүрт хайртай. Тэд гэр бүл бүхэн мөнхийн холболт хийлгээсэй хэмээн хүсдэг. Ариун Сүмд мөнхийн холболт хийлгэж амжаагүй байгаа гэр бүлүүд Тэнгэрлэг Эцэгийн тушаалуудыг дуулгавартай даган өөрсдийгөө бэлтгэж болно. Тэгээд тэд Ариун Сүм рүү очиж мөнхийн холболт хийлгэж чадна.

Дуу

Хүүхдүүдтэй хамт “Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна” (*Children’s Songbook*, р. 188) дууны дахилтыг хэд хэдэн удаа дуулах буюу үгийг нь хэл.

Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөгөөний дагуу  
Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна  
Би үргэлж өөрийн гэр бүлтэйгээ хамт байхыг хүсдэг  
Их Эзэн надад хэрхэн ингэхийг харуулж өгсөн  
Их Эзэн надад үүнийг хэрхэн чадахыг үзүүлсэн

## Би Ариун Сүмд явахад бэлдэж чадна

Тэнгэрлэг Эцэгийн тушаалуудад дуулгавартай байдаг хүн бүхэн Ариун Сүмд орж чадна гэдгийг хүүхдүүдэд сануул. Хичээлийн төгсгөлд буй зурагнуудыг хүүхдүүдэд үзүүлж, зураг бүрийн илэрхийлж байгаа тушаалуудын тухай ярилц. Эдгээр тушаалуудыг дагаснаар тэд зөв зохистой байж, том болоод Ариун Сүмд орох боломжтой болно гэдгийг тайлбарла.

- Залбир.
- Эцэг эхийнхээ үгэнд ор.
- Бие биеэ хайрла.
- Сүмдээ яв.
- Аравны нэгээ төл.
- Эрүүл хүнс хэрэглэ (Мэргэн Ухааны Үгийг сахь).
- Шударга бай.

Гэрчлэл

Ариун Сүмийн адислалуудын тухай, гэр бүлүүд мөнхөд хамтдаа байхын чухлын талаар гэрчлэлээ хуваалц. Эх эцгийнхээ болон Тэнгэрлэг Эцэгийн тушаалуудад дуулгавартай байх нь Ариун Сүмд орохдоо бэлтгэж байгаа чухал арга зам гэдгийг сануул.



---

**Баяжуулах үйл  
ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Мөнхөд гэдэг нь маш удаан цаг хугацаа гэсэн үг гэдгийг ойлгоход нь тусал. Тэдэнд энэ нь төрсөн өдөр болон дараагийн баярыг хүлээхээс илүү урт хугацаа эсвэл настай болтлоо амьдрахаас ч илүү урт; Адам Евагийн амьдарч байсан цаг хугацаанд хүрэхээс ч урт хугацаа гэдгийг тайлбарла. *Мөнхөд гэдэг үг хэзээ ч төгсөхгүй, дуусашгүй гэсэн үг гэдгийг тайлбарла.*

Та үгийг нь хэлж байх зуур хүүхдүүдээр дараах үйлдлийг хийлгэ:

Мөнхөд гэдэг нь хэр урт хугацаа вэ?

Мөнхөд гэдэг хэр урт хугацаа вэ (*юм бодож байгаа мэт толгой руугаа заа*)?

Энэ нь жилээс ч илүү урт (*атгасан гараа эрүүн дороо барьж, нөгөө гарынхаа алган дээр тохойгоо тавь*).

Энэ нь Христийн мэндэлсний баярыг хүлээх

Хамаагүй урт юм. (*нөгөө атгасан гараа эрүүн дороо барьж, нөгөө гарынхаа алган дээр тохойгоо тавь*).

Мөнх гэдэг хэр урт хугацаа вэ (*бодол болж байгаа мэт толгой руугаа заа*)?

Хайртай гэр бүлтэйгээ хамт байхад (*өөрийгөө тэвэр*),

Энэ нь тийм ч урт биш (*долоовор хуруугаа гозойлгож байгаад урагш хойш хөдөлгө*)

Хэзээ ч төгсөшгүй үүрд хамт!

2. Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр нэг хүүхдийн эх эцгийг урин Ариун Сүмд мөнхийн холболт хийлгэхийн чухлын талаар сэтгэгдлээ хуваалцахыг хүс.
3. Хичээлийн төгсгөлд буй зурагтай хуудсыг хүүхэд бүрт хувилж өг. Хүүхэд бүрээр зургийг өнгөөр ялган будуул.
4. Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр саяхан Ариун Сүм явж мөнхийн холболт хийлгэсэн гэр бүлийг урьж, өөрсдийн сэтгэгдлийг хүүхдүүдтэй хуваалцахыг хүс.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдийг дараах үгсийг хэлэхэд даган үйлдлийг хийхийг хүс:

Би Туслагч

Би одоо өндөр том болсон (*өлмий дээрээ зогсож гараа дээш сунга*),

Би сайн туслагч байж чадна.

Элэгсэг, нөхөрсөг сайн

Аавынхаа туслагч (*эхний хуруугаа гозойлго*),

Хийх ёстой зүйлсийг хийж

Би ээждээ бас туслах болно (*хоёр дахь хуруугаа гозойлго*)

Би эгчийнхээ туслагч (*гурав дахь хуруугаа гозойлго*),

Ахынхаа ч бас (*дөрөв дэх хуруугаа гозойлго*);

Бас өөрийн бүх найз нарынхаа туслагч (*эрхий хуруугаа гозойлго*).

Мөн Бурханы туслагч байхаар хичээх болно  
 Тэр надад хайртай шиг бусдыг хайрлаж (*гараа зөрүүлэн нугал*).  
 Одоо би том өндөр болсон болохоор (*өлмийн дээрээ бос, гараа дээш сунга*),  
 Би бүгдийн туслагч байхыг хүсч байна (*гараа өргөн дэлгэ.*)

2. Таныг дараах үйл хөдлөлт шүлгийг уншиж байх зуур хүүхдүүд хөдөлгөөнийг нь хийнэ. Өөрийн хүссэнээр давтан хий.

*Бүгд босон, гар гараасаа барилцан, тойрог болон зогс. Үйлдлийг хийж дуустал гараасаа барь.*

Бид бүгд Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарч байсан (*гараа урагш болгон тойргийн дотогш бол*).

Тэр биднийг дэлхийд амьдруулахаар доош илгээсэн (*дэлгэгдэн том тойрог бол*).

Тэр биднийг хайрлаж сургах гэр бүлүүдийг бидэнд өгсөн (*дахин дотогш хумигд*).

Гэр бүлүүд маань биднийг Түүнтэй дахин хамт амьдрахад тусална (*дахин эргэж том тойрог бол*).

3. Цаасан дээр Ариун Сүмийн хялбархан дүрс гарга. Тэгээд хүүхдүүдээр өнгөөр ялгуулан будуул.

# Би Ариун Сүмд ороход бэлдэж чадна




ЗАЛБИРАЛ




ЭХ ЭЦЭГТЭЭ  
ДУУЛГАВАРТАЙ БАЙ



БИЕ БИЕЭ  
ХАЙРЛА



СҮМДЭЭ ТОГТМОЛ ЯВ



АРАВНЫ НЭГЭЭ ТӨЛ



ЭРҮҮЛ ХҮНС ХЭРЭГЛЭ



ШУДАРГА БАЙ

# Бид гэр бүлээрээ залбирч чадна

Хичээл  
**27**

---

## Зорилго

Хүүхдүүдэд гэр бүлийн тогтмол залбирал нь биднийг Тэнгэрлэг Эцэгтэй ойр байхад тусалдаг гэдгийг ойлгоход нь тусал.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Алма 34:19–27 ба 3 Нифай 18:17–21-г уншиж судал.  
*Сургаалын зарчмууд* (31110), бүлэг 8-ийг үз.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Мормоны Ном
  - б. Хайчилбар 1-26, Эцэг; хайчилбар 1-27, Ээж; хайчилбар 1-28, Залуу охин; хайчилбар 1-29, Номлолын насны хүү (Хүүхдийн хэсгийн үзүүлэн 1-ээс төстэй бусад хайчилбаруудыг олж болно).
  - в. Зураг 1-10, Гэр бүлийн залбирал (62275); зураг 1-15, Хоолоо адисалсан нь; зураг 1-44, Есүс америк тивд сургаалыг заасан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 316; 62380).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдээс гэр бүлийнхэнтэйгээ хамт хийдэг ямар нэгэн зүйлийн талаар ярихыг хүс. Хүүхэд бүрт ярих боломжийг олго. Дараа нь зураг 1-10, Гэр бүлийн залбирал зургийг үзүүл.

- Энэ гэр бүл юу хийж байна вэ?

Гэр бүлээрээ залбирах нь Тэнгэрлэг Эцэг, Есүс биднээс хийгээсэй гэж хүсдэг зүйлийн нэг гэдгийг тайлбарла. Гэр бүлээрээ залбирахыг *гэр бүлийн залбирал* гэж нэрлэдэг.

### **Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ биднийг гэр бүлээрээ хамтдаа залбирахыг хүсдэг**

Түүх

Зураг 1-44, Есүс америк тивд сургаалыг заасан нь зургийг үзүүл. Есүс Нифайчууд дээр ирж 3 Нифай 18:17–21-д бичсэнчилэн залбирахыг хүссэн. Хүүхдүүдэд Мормоны Ном үзүүлж, 3 Нифай 18:21-г чангаар уншиж өг. Есүс биднийг гэр бүлтэйгээ хамтдаа залбирал хийхийг хүсдэг гэдгийг хэл. Нифайн хүүхдүүд гэр бүлийн залбирлын хүчээр адислагдаж байсантай адил бид ч мөн гэр бүлийн залбирлын хүчээр адислагдаж чадна.

### **Бид өдөр бүр гэр бүлийн залбирал хийж чадна**

Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг гэр бүлтэйгээ хамт өглөөний болон оройн залбирал хийхийг хүсдэг гэдгийг тайлбарла. Ихэвчлэн аав нь буюу энэ үүргийг хүлээсэн нэг хүн гэр бүлийн гишүүдээс залбирал хийхийг хэн нэгнээс хүсдэг. Гэр бүлийн хэн нь ч залбирлыг хэлж болно.

- Гэр бүлийн залбирлыг хэзээ хийдэг вэ?
- Хэн гэр бүлийн залбирал хийж болох вэ?

Дуу

Хүүхдүүдтэй хамт “Гэр бүлийн залбирал” (*Children’s Songbook*, р. 189) дууг дуулах буюу үгийг нь унш.

Бүгдээрээ тойрог болон цугларч  
Гэр бүлээрээ залбирахаар өвдөг сөхөрье  
Бидэнд өгсөн адислалуудынх нь төлөө  
Тэнгэрлэг Эцэгтээ талархъя

- Гэр бүлийн залбиралдаа бид юу хэлдэг вэ?

Бид өөрсдийн өглөөний болон оройн хувийн залбиралдаа хэлдэгтэй ижил зүйлсийг мөн гэр бүлийн залбиралдаа хэлдэг гэдгийг тайлбарла. Гэвч гэр бүлийн залбиралд бид хувийн асуудлаа хэлэхийн оронд харин гэр бүлийн асуудлаа хэлж залбирдаг.

Дуу

Залбирахдаа хэрэглэдэг үгсийг “Би итгэлтэйгээр залбирч байна” (*Children’s Songbook*, р. 14) дууны хоёрдугаар бадгийн үгсийг унших зуураа эргэн давтан.

Би “Хүндэт Тэнгэрлэг Эцэг минь” гэж эхэлдэг;  
Түүний бидэнд өгсөн олон адислалуудад талархдаг;  
Дараа нь бид даруухнаар өөрсдөд хэрэгтэй зүйлсээ гуйн,  
Есүс Христийн нэрээр, Амен хэмээн дуусгадаг.  
(© 1987 by Janice Kapp Perry. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

- Бид залбирлынхаа эхэнд юу гэж хэлдэг вэ?
- Бид залбирлынхаа төгсгөлд юу гэж хэлдэг вэ?
- Залбирал хэлж байх үед бусад нь юу хийдэг вэ?

“Амен” гэж залбирлын төгсгөлд нь хэлдэг нь залбиралд хэлсэн зүйлстэй санал нийлж, дэмжиж байна гэсэн үг гэдгийг тайлбарла.

Зураг 1-15, Хоолоо адисалсан нь зургийг үзүүл. Бид хоолоо хамтдаа идэхдээ адисалдаг адислал нь мөн гэр бүлийн залбирал гэдгийг хэл.

- Бид хоолоо адислан залбирахдаа юу гэж хэлдэг вэ? (Тэнгэрлэг эцэгт хоол өгсөнд талархан, Түүнээс хоолыг адислахыг хүсдэг)
- Хэн хоол адислах залбирлыг хийж болох вэ?

Дуу

“Би итгэлтэйгээр залбирч байна” дууны хоёрдугаар бадгийн үгийг дахин унш.

### **Бид гэр бүлээрээ хамтдаа залбирснаар олон адислалуудыг хүлээн авдаг**

Түүх

Хайчилбар 1-26-аас 1-29-г дуустал ашиглан, номлолд үйлчилж байгаа гэр бүлийнхээ гишүүнийхээ төлөө залбирч байгаа гэр бүлийн залбирлын тухай түүхийг ярьж өг. Дараах санаануудыг ашиглаж болно:

Катрин хэмээх нэгэн охин байжээ. Тэр өөрийн гэр бүлдээ хайртай бөгөөд тэднийг ч түүнд хайртай гэдгийг мэддэг байв. Заримдаа түүний ах Пол

Мормоны Номын болон Ариун Библийн түүхүүдээс ярьж өгдөг байлаа. Пол номлолд явахаар бэлтгэж байсан тул эдгээр номыг судлан уншиж мөн бусдад эдгээрийн талаар ярьж өгдөг байв.

Нэгэн өдөр Пол захидал хүлээн авав. Захидлыг нээхэд тэр маш их догдолж байлаа. “Би номлолд явна!” хэмээн тэр хэллээ. Хэдэн долоо хоногийн дараа Пол номлолд явахад бэлэн болсон байлаа. Түүнийг номлолд явахаас өмнө гэр бүлийнхэн нь хамтдаа өвдөг сөхрөн залбирав. Тэдний гэр бүлийнхэн хүлээн авсан олон адислалуудын төлөө Катрины аав нь Тэнгэрлэг Эцэгт талархлаа илэрхийллээ. Мөн Пoleyг номлолд явах боломжийг өгсөнд талархав. Тэр Тэнгэрлэг Эцэгээс түүнийг аюул ослоос хамгаалан, сайн номлогч байхад нь туслахыг хүслээ. Залбирал Катрины сэтгэлийг тайвшруулан, сайхан мэдрэмж өглөө. Тэр Тэнгэрлэг Эцэг Полд тусална гэдгийг мэдэж байв. Катрин болон түүний гэр бүл Poleyг номлолд байх хугацаанд нь өдөр бүр түүний төлөө залбирдаг байв.

Гэр бүлээрээ өвчтэй нэгний төлөө, гэр бүлийн асуудлуудыг шийдэхэд хэрэгтэй тусламж, Тэнгэрлэг Эцэгийн тусламж хэрэгтэй байгаа номлогчдын төлөө мөн бусад бидэнд хэрэгтэй олон шалтгаануудын төлөө бид залбирч болно гэдгийг тайлбарла. Бидэнд чухал болох олон зүйлүүдийн төлөө бид залбирч болно. Алма 34:19–27-г ашиглан хүүхдүүдэд хэзээ залбирал хийх хэрэгтэй талаар ойлгоход нь тусал.

3 Нифай 18:21-ийг чанга дуугаар унш. Хэрэв бид гэр бүлийн залбирал тогтмол хийвэл Есүс биднийг адислахыг амласан гэдгийг хүүхдүүдэд сануул.

Гэрчлэл

Гэр бүлийн залбирлын талаар өөрийн гэрчлэлээ хуваалц. Гэр бүлийн залбирал хэрхэн танай гэр бүлийг хүчтэй болгосон талаар ярьж болно.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдүүдтэй хамт дараах үйлдэлт шүлгийг хий:

Намайг залбирал хийхэд тусалдаг хүн бол миний ээж (*эхний хуруугаа гозойлго*);

Өдрийн турш ажилладаг хүн бол миний аав (*хоёр дахь хуруугаа гозойлго*).

Маш хүчтэй бөгөөд өндөр энэ бол миний ах (*гурав дахь хуруугаа гозойлго*);

Бөмбөгөөр тоглох дуртай энэ бол миний эгч (*дөрөв дэх хуруугаа гозойлго*).

Энэ бол би, эдгээрийг хэлэхдээ би жаргалтай байна (*эрхий хуруугаа гозойлго*)

Залбирахаар гэр бүлээрээ хамтдаа бид өвдөглөн сууна (*гараа атга*).

2. Зөөлөн эд юм уу вандуйт уутыг хүүхэд бүрт дараалан шид. Хүүхэд бөмбөгийг барьж аваад гэр бүлийн залбирлаа хэлэх үедээ Тэнгэрлэг Эцэгт талархах ямар нэгэн зүйлийг хэлэхийг хүс. Хүүхэд бүрийг хэлж дууссаны дараа гэр бүлийн залбирлын үед хүсэх зүйлийнхээ талаар хэлэхийг хүсч, үйл ажиллагааг давтан хий.

3. Хүүхэд бүрт цаас, өнгийн харандаа юмуу балын харандаа өг. Тэднийг гэр бүлийн залбирал хийж буй гэр бүлийнхээ зургийг зурахыг хүс. Зураг бүр дээр *Гэр бүл маань хамтдаа залбирахад би жаргалтай байдаг* гэж бич.
  4. “Талархлын дуу” (*Children’s Songbook*, р. 20) дууг зургуудын “Залбирлын дуу” (*Children’s Songbook*, р. 22) дууг дуулах буюу үгийг нь унш.
- 

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Мөр мөрөөр давтан хэлэхийг хүс:  
Бид Тэнгэрлэг Эцэгт хайртай;  
Бид залбирахдаа Түүнд талархдаг.  
Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай;  
Тэр бидний үгсийг сонсдог.
2. Гэр бүл хамтдаа залбиран хэрэгцээтэй зөвлөмжийг хүлээн авсан тухай түүхийг ярьж өг. Жишээ нь: Гэр бүлээрээ төөрч, дараа нь замаа олж болно; Тэд ямар нэгэн юмаа гээчихээд, дараа нь түүнийгээ олж болно. Эсвэл хэн нэг нь өвдөж дараа нь эрүүл болох гэх мэт. Гэр бүлийнхэн тусламж хүсэхээс гадна хүлээн авсан адислалууддаа талархан залбирах хэрэгтэй гэдгийг хэл. Бид түүний өгсөн адислалуудад талархахад Тэнгэрлэг Эцэг баяртай байдаг гэдгийг хүүхдүүдэд сануул.
3. “Эцэгтээ талархъя” (*Children’s Songbook*, р. 20) дууны нэг болон гуравдугаар бадгийг дуулах буюу үгийг нь хэл.

# Би дуулгавартай байж чадна

Хичээл  
28

---

## Зорилго

Хүүхэд бүрийн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд дуулгавартай байх хүслийг батжуулан, өөрсдийн эх эцэгт дуулгавартай байхад туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Даниел 3; Иохан 14:15; ба Ефес 6:1-ийг уншиж судал. *Сургаалын Зарчмууд* (31110), бүлэг 35-ыг үз.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Судрууд
  - б. Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл (62307); зураг 1-8, Ариун Ёслол түгээж байгаа нь (62021); зураг 1-9, Өглөөний залбирал (62310); зураг 1-46, Хүүхэд ээждээ цэцэг өгч байгаа нь; зураг 1-55, Уулан дээрх номлол (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 212; 62166); зураг 1-56, Галтай зуухан доторх гурван хүн (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 116; 62093).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг босох, дороо эргэх, гараа дээш сунгах, хөлийн хуруундаа хүрэх, суух зэрэг хөдөлгөөнүүдийг хийхийг эелдэгээр асуу. Таны хүссэнийг хийж байгаад нь таларх. Тэд сайн дуулгавартай байлаа гэдгийг тайлбарла. Тэд таны зааврыг даган дуулгавартай байлаа.

### **Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг өөрсдийн эх эцэгтээ дуулгавартай байхыг хүсдэг**

Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл, зургийг үзүүл.

- Энэ зурган дээр юу үзүүлж байна?

Зурган дээрх бяцхан хүүхдийг зааж бид хэрхэн энэ дэлхийд бяцхан хүүхэд болон ирцгээснийг ярь. Нялх хүүхдүүд маш жижигхэн өөрсдийгөө хамгаалж арчлах чадваргүй тул тэднээс том, ахмад хүмүүс тэднийг арчлан хамгаалах ёстой гэдгийг сануул.

- Чамайг нялх байхад хэн чамайг хайрлан халамжилж байсан бэ?
- Одоо чамайг хэн арчилж байгаа вэ?

Тэднийг харж хандан байгаа эх эцэг, гэр бүлийн гишүүд нь тэдэнд хайртай бөгөөд тэднийг аюулгүй, аз жаргалтай байгаасай хэмээн хүсдэг гэдгийг тайлбарла.

- Танай эх эцэг та нарыг юу битгий хий хэмээн хүсдэг вэ?



Хүүхдүүд гудамжинд тоглох, халуун зууханд хүрэх, хурц хутга барих, өндөр уулнаас доош гүйх, эсхүл ах эгчтэйгээ зодолдох зэрэг өөрсдийгөө гэмтээх зүйлс хийж гэмтэн гунигтай болдог тухай ярилц.

- Яагаад эцэг эхчүүд чинь та нарыг эдгээр зүйлийг хийхийг хүсдэггүй вэ?

Хүүхдүүд тоглоомоороо тоглох, эх эцэгтэйгээ хамт гадуур явах, өөрсдийн ах эгч нартайгаа нөхөрсөг дотно байх зэрэг аюулгүй зүйлсийг хийж баяр хөөртэй байж болох талаар ярилц.

- Яагаад та нарын эх эцэг эдгээр зүйлсийг хийж болохыг зөвшөөрдөг вэ?
- Яагаад өөрийн эх эцэгтээ дуулгавартай байх ёстой вэ?

Бидний эх эцэг бидэнд хайртай тул биднийг аюулгүй, аз жаргалтай байлгах зүйлсийг хийгээсэй хэмээн хүсдэг гэдгийг тайлбарла.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босон дараах үйлдэлт шүлгийг уншихыг хүс:

Миний хөл гүйх дуртай (*чимээгүй дороо гүй*),

Миний гар тоглох дуртай (*гараараа дэв*),

Гэхдээ миний Ээж [эсвэл Аав] “Наашир” гэж дуудахад (*гараараа далла*),

Би маш түргэн үгэнд нь ордог.

- Эх эцгийнхээ үгэнд орон тэднийг дуудахад түргэн гүйн ирэхэд ямар санагддаг вэ?
- Эх эцгийнхээ захиснаас өөр зүйл хийхэд ямар байдаг вэ?

Бид эх эцгийнхээ үгэнд ороход аз жаргалтай байдаг. Бидний эх эцэг мөн биднийг дуулгавартай байхад аз жаргалтай.

Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг эх эцгийнхээ үгэнд дуулгавартай байгаасай хэмээн хүсдэг гэдгийг хэл. Ефес 6:1-ийг хүүхдүүдэд уншин тайлбарлаж өг.

Дуу

“Би дуулгавартай байна” (*Children’s Songbook*, p. 197) дууны гурван бадгийг дуулах буюу үгийг давтан хэл.

Миний ээж намайг дуудахад,

Би түргэн үгэнд нь ордог.

Өдөр бүхэн юм хийх бүртээ

Зөвхөн зөвийг л хийхийг би хүсдэг.

Миний аав намайг дуудахад,

Би маш түргэн үгэнд нь ордог.

Өдөр бүхэн юм хийх бүртээ

Зөвхөн зөвийг хийхийг би хүсдэг.

Тэнгэрлэг Эцэг надад хайртай,

Өдөр бүр намайг адисалдаг.

Өдөр бүхэн юм хийх бүртээ

Зөвхөн зөвийг хийхийг би хүсдэг.

### **Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг тушаалуудад дуулгавартай байхыг хүсдэг**

Зураг 1-55, Уулан дээрх номлол зургийг үзүүл.

- Энэ зурган дээр хэн байна?

Есүс дэлхий дээр амьдарч байхдаа Тэнгэрлэг Эцэгийн тэдний хийгээсэй хэмээн хүсч буй зүйлсийн талаар заадаг байсан гэдгийг тайлбарла. Эдгээр зааж байсан зүйлсийг *тушаалууд* гэж нэрлэдэг. Судрыг гартаа барь. Эдгээр тушаалууд нь сударт бичигдсэн байдаг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Үйл ажиллагаа

Ариун Библиэ нээж Иохан 14:15-ыг унш. Есүс эдгээр үгсийг хэлсэн гэдгийг тайлбарла. *Сахь* гэдэг нь *дуулгавартай байх* гэсэн үг болохыг тайлбарла. Хүүхдүүдтэй хамт хэд хэдэн удаа судрыг давтан унш.

- Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг дуулгавартай байхыг хүсдэг ямар тушаалууд байдаг вэ?

Дараах зурагнуудыг ашиглан хүүхдүүд дуулгавартай дагаж болох тушаалуудын талаар ярилц:

Зураг 1-5, Бяцхан хүүхэдтэй гэр бүл—гэр бүлээ хайрла

Зураг 1-8, Ариун Ёслол түгээж байгаа нь—Сүмийн цуглаануудад тогтмол оролц

Зураг 1-9, Өглөөний залбирал—Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбир

Зураг 1-46, Ээждээ цэцэг өгч буй хүүхэд—бусдад эелдэг бай

- Бид Түүний тушаалуудад дуулгавартай байхад Тэнгэрлэг Эцэг яадаг вэ?

### **Биднийг дуулгавартай байхад Тэнгэрлэг Эцэг адисладаг**

Түүх

Даниел 3 дээр гардаг Шадрах, Мешах, Абед-него нарын түүхийг товчхон ярь. Зураг 1-56, Галтай зуухан доторх гурван хүн, зургийг зохих үед нь үзүүл. Зөвхөн Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбир гэдэг нь Түүний тушаалуудын нэг гэдгийг тайлбарла. Бид бусад хүмүүст залбирдаггүй. Мөн хиймэл бурхан, хөшөөнд залбирдаггүй. Шадрах, Мешах, Абед-него нар Тэнгэрлэг Эцэгийн тушаалуудыг мэдэж байсан тул дуулгавартай байхыг хүссэн. Тэнгэрлэг Эцэг эдгээр хүмүүсийг Түүний тушаалд дуулгавартай байсан тул тэднийг хамгаалсан. Тэд галд шатаагүй.

- Яагаад Шадрах, Мешах, Абед-него нар галд шатаагүй вэ?
- Тэнгэрлэг Эцэг тэднийг галаас хамгаалахад Шадрах, Мешах, Абед-него нарт ямар байсан гэж та нар бодож байна?

Гэрчлэл

Өөрсдийн эх эцэгтээ болон Тэнгэрлэг Эцэг, Есүст дуулгавартай байх нь ямар чухал болох тухай өөрийн гэрчлэлийг хуваалц. Тушаалуудад дуулгавартай байх нь бидэнд ямар их аз жаргал авчирдгийг хүүхдүүдэд хэл.

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхэд бүрийг ээлжлэн ангид “бос”, “гараа толгой дээрээ тавь” гэх зэрэг заавруудыг өгөхийг хүс. Бусад хүүхдүүд түүний зааврыг дагах ёстой.
2. Хичээл 11-д ашиглаж байсан загасны дэгээг ашиглан “Гараа атга,” “Хэрэв та нар намайг хайрладаг бол миний тушаалуудыг дага” гэж Есүс хэлсэн үгийг давт “Өрөөн дотор чимээгүй алх,” “Бусад хүүхэд рүү харан инээмсэглэ,” зэрэг заавруудыг бичсэн цаасан загаснууд бэлтгэ. Мөн

“Би Бурханы хүүхэд” дууг ангиараа дуулахад тусал. Хүүхэд бүрээр загасны дэгээгээр зааврыг дэгээдэн авахуулж загасан дээр бичигдсэн зааварт дуулгавартай байлга.

3. Ноа тушаалуудад дуулгавартай байсан тул гэр бүлээрээ их үерээс аврагдсан түүхийг сануулан ярь.
4. Хүүхэд бүрт аз жаргалтай нүүрний дүрс болон “Би дуулгавартай байхдаа жаргалтай” гэж бичсэн хуудас цаас өг. Хүүхдүүдээр нүүрний дүрснүүдийг будуул.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Дараах хуруун тоглоомыг тоглуул:  
Завгүй бяцхан хуруунууд (*гараа атга*),  
Хэн бидэнд дуулгавартай байхад туслах вэ?  
“Би” “Би.” “Би.” “Би.” “Би” (“Би” гэж хэлэх бүртээ таван хуруугаа нэг нэгээр нь *гозойлго*), гэж  
завгүй хурууд хэлэв.
2. Гутал, малгай, бээлий зэрэг хамгаалахад зориулсан зарим зүйлсийг авчир. Эдгээр нь ямар хамгаалалт үзүүлдгийг асуу (Жишээ нь: Гутал бидний хөлийг хамгаалдаг. Малгай бидний толгойг хүйтнээс болон нарнаас бидний нүдийг хамгаалдаг). Бид эх эцэгтээ дуулгавартай байснаар мөн хамгаалагддаг гэдгийг хүүхдүүдэд хэл. Биднийг хамгаалдаг зарим нэгэн дүрэм журмуудын талаар ярилц.
3. Гараа өргөн хуруунуудаа яаж хөдөлгөж байгаагаа хүүхдүүдэд харуул. Хүүхдүүдийг гараа өргөн хуруунуудаа хөдөлгөж, гараа нээж хаахыг хүс. Бид зөвхөн хуруу гараа хөдөлгөж чадна. Харин бусдын гар хурууг хөдөлгөж чадахгүй гэдгийг тайлбарла. Биднийг ямар нэгэн зүйл хийхийг хэн нэг хүн асуухад бид хуруунуудаа дуулгавартай байлгаж чадна гэдгийг тайлбарла. Эдгээрийг хийхэд бид баяртай болдог.
4. буй үгсийг хэлэхэд үйлдлийг даган хийхийг хүс:  
Би гарандаа дуртай  
Би өөрийн гартаа дуртай, тэд миний найзууд (*гараа урдаа барин хар*).  
Өдрийн турш тэд завгүй тусалдаг (*гараараа ажиллаж байгаа дүрслэл хий*).  
Тэд чимээгүй нугарч (*гараа нугал*) эсвэл чангаар алга ташдаг (*алгаа таш*)!  
Тэд зөвийг хийхэд надад бахархах сэтгэл төрдөг!

# Би “Намайг уучлаарай” гэж хэлж чадна

Хичээл  
29

---

## Зорилго

Тэд буруу зүйл хийсэн үедээ уучлалт гуйж, буруугаа засахыг хичээх хэрэгтэй гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Мозая 27:8–37-г уншиж, суралц.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Мормоны Ном.
  - б. Халаасанд багтах жижиг тоглоом.
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг ангид орж ирэхэд нь эсвэл хичээлд цугларах үед нь санаатайгаар нэгэн алдаа хий. Та ....

- Шалан дээр юм унагах.
- Сандлаа буруу харуулан тавь.
- Зургаа уруу нь харуулан тавь.
- Самбар дээр юм уу цаасан дээр юм бичээд буцаж арилга.

Алдаа хийх бүртээ, “Уучлаарай би буруу зүйл хийлээ” гэж хэл. Дараа нь алдаагаа зас.

Хүүхдүүдээс түүний хийсэн алдаа бүрийг анзаарсан эсэхийг асуу. Хүн бүр алдаа гаргадаг гэдгийг хэл.

### Бид заримдаа буруу зүйлс хийдэг

Бид зөвийг сонгохоор суралцах үедээ заримдаа буруу зүйл хийдэг. Энэ нь зураг буруу харуулж тавихтай адил биш эдгээр нь Тэнгэрлэг Эцэг, Есүс болон өөрсдийн эх эцгийн биднийг бүү хийгээсэй гэсэн зүйлсийг хийсэн алдааг хэлж буй хэрэг. Буруу сонголт хийснээр өөрсдийгөө болон бусдыг аз жаргалгүй болгодог.

Түүх

Жижиг тоглоомоо ашиглан дараах түүхийг өөрийн үгээр ярьж өг:

Травис Майт нар Майтын гэрт тоглон баясацгааж байв. Травист Майтын тоглоомнууд таалагдаж байлаа. Эдгээр нь түүнийх байсан ч болоосой гэж бодож байв. Травис Майтаас асуулгүйгээр хэсэг тоглоомыг зээлье гэж бодон Майтаас асуулгүйгээр халаасандаа хийв.

Травис тоглоомыг гэртээ авчран тоглоход тийм ч их хөгжилтэй биш байлаа. Түүний ээж түүнээс яагаад тэр уйтгартай байгааг асуув. Травис ээждээ Майтын тоглоомыг асуулгүйгээр авсан тул эвгүй байгаагаа хэллээ.

Трависын ээж бусдын зүйлийг авах нь буруу гэдгийг хэлэв. Тэр Трависаас алдаагаа засахын тул яах хэрэгтэйг асуулаа. Травис тоглоомыг эргүүлж өгөхийг хүссэн боловч Майт уурлах байх гэдгээс айж байв. Майт ууртай байсан ч тоглоомыг буцааж өгөх нь зөв зүйл гэдгийг ээж нь хэлэв. Тэр мөн Травист Майтаас уучлалт гуйхад буруу зүйл хийсэн алдааг засахад нь тусалж эвгүй сэтгэгдлийг нь арилгах болно гэдгийг хэллээ.

Травис Майтын тоглоомыг буцаан өгөв. Тэр түүнд тоглоомыг нь асуулгүйгээр авсандаа харамсаж байгаагаа хэлэн уучлалт гуйгаад, дахин ийм зүйл хийхгүй гэдгээ амлав. Майт Трависыг түүний тоглоомыг буцаан өгсөнд баяртай байв. Травис үнэнээ хэлж, зөв зүйл хийсэндээ баяртай байлаа. (Pat Graham, "Travis Repents," *Friend*, 3-р сар. 1987, хуудас 40–41).

- Травис ямар буруу зүйл хийсэн бэ?
- Майтын тоглоомыг авсандаа Травис ямар сэтгэгдэлтэй байсан бэ?

Бид заримдаа буруу зүйл хийхэд уйтгар гунигтай болдог. Энэ нь Тэнгэрлэг Эцэг бидэнд буруу зүйл хийснийг маань мэдүүлдэг нэг арга зам юм.

- Травис өөрийн муухай зан аашаа засахын тул юу хийсэн бэ?
- Травис Майтын тоглоомыг буцаан өгч, уучлалт гуйхад түүнд ямар байсан бэ?

### **Бид уучлаарай гэж хэлэх хэрэгтэй**

- Ямар нэгэн буруу зүйл хийхэд чамд ямар байдаг вэ?
- Муухай мэдрэмжээс хэрхэн салах вэ?

Бид өөрсдийгөө буруу зүйл хийлээ гэдгээ мэдэх үед буруу зүйл хийснээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг ойлгоход нь тусал. Тэгээд бид "Намайг уучлаарай" гэж хэлэх хэрэгтэй. Мөн бид алдаагаа засч, дахин давтахгүй байхыг амлах хэрэгтэй.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босч зогсоод дараах үйл ажиллагааг хамтдаа хийхийг хүс:

Би буруу зүйл хийсэн үедээ (*долоовор хуруугаа хоёр тийш хөдөлгө*),  
"Намайг уучлаарай," гэж би хэлэх болно.

Би өнөөдөр хийсэн зүйлдээ

Би аз жаргалгүй боллоо (*уйтгартай царай үзүүлэн хуруугаараа амныхаа хажууг доош болго*)

Би илүү сайн хийх болно (*гараа ташаандаа авч, толгойгоо дохь*);

Би маш сайн хичээх болно.

Би зөвийг хийх юм бол (*гараа зөрүүлэн нугалаад толгойгоо дохь*).

Би аз жаргалтай байх болно (*инээмсэглэ*).

### **Бид алдаагаа засахын тул чадах бүхнээ хийх ёстой**

Түүх

Хүүхдүүдэд Мормоны Ном үзүүл. Мормоны Номонд буруу зүйл хийсэн нэгэн хүний тухай гардаг гэдгийг хэл.

Мормоны Номоо нээж Мозая 27:8–37-д гардаг Алмагийн тухай түүхийг ярь. Алма өөрийн эцгийг сонсохгүй байсан тухай тайлбарла. Тэр Тэнгэрлэг Эцэг ба Есүст дуулгаваргүй байлаа. Тэр маш олон буруу зүйлсийг хийдэг

байв. Сүмийн тухай худал зүйлсийг тэр хүмүүст хэлж байлаа. Олон хүмүүс түүнд итгэж Сүмийн удирдагчдыг сонсохгүй байв.

Алма буруу зүйл хийхээ больж зөв зүйлийг хийж эхэлсэн гэдгийг тайлбарла. Тэрээр хүмүүст үнэнийг зааж эхэлснээр өөрийн алдааг засахыг хичээж эхэлсэн.

- Алма өөрийгөө буруу зүйл хийж байгаагаа ойлгох үед түүнд ямар санагдсан гэж та нар бодож байна? (Мозая 27:29-ийг үз.)
- Алма өөрийн хийсэн буруу зүйлээ хэрхэн засахыг хичээсэн бэ? (Мозая 27:32, 35–36-г үз.)
- Хүмүүст зөвийг зааж эхлэхэд Алмад ямар байсан бэ?
- Буруу зүйл хийснээ яагаад засах хэрэгтэй вэ?

Өөрийн хийсэн алдаандаа харамсаж байсан тухай энгийн тохиолдоос хуваалц. Тэр үед юу мэдэрч, өөрийн хийсэн алдаагаа хэрхэн засахыг хичээсэн тухайгаа ярь.

Буруу зүйл хийснээ мэдсэн үедээ хийх ёстой зүйлсийн талаар ярилц:

1. Буруу зүйл хийснээ хүлээн зөвшөөрөх.
2. “Намайг уучлаарай” гэж хэлэх.
3. Дахин хийхгүй байхыг амлах.
4. Буруу зүйл хийснээ засахын тул өөрийн чадах бүхнээ хий.

Эдгээр үе шатнуудыг *наманчлал* гэдэг. Бид буруу зүйл хийснээ наманчлахад Тэнгэрлэг Эцэг, Есүс баярладаг гэдгийг тайлбарла.

Дараах нөхцөлд наманчлалын үе шатуудыг хэрхэн хийх талаар ярилц:

- Хэрэв хүний юмыг авсан бол яах ёстой вэ?
- Хэн нэгэнд эелдэг бус үг хэлсэн бол яах вэ?
- Хэрэв өөрийн эх эцэгтээ үнэнээ хэлээгүй бол яах вэ?
- Хэрэв хэн нэгнийг доош түлхсэн бол яах вэ?

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг буруу зүйл хийсэн ч байсан бидэнд хайртай байдаг талаар гэрчлэлээ хуваалц. Хэрэв бид буруу хийсэн зүйлдээ харамсаж байгаагаа хэлэн, дахин буруу зүйл хийхгүй байхыг хичээх юм бол Тэд их баяртай байх болно гэдгийг хүүхдүүдэд хэл.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхэд бүрт хэсэг баримлын шавар өг. Хүүхдүүдэд шаврыг хэрхэн бөөрөнхий болгон дараа нь хавтгайлахыг харуул. Тэднийг “Намайг уучлаарай” гэж хэлэхэд тэд сайхан мэдрэмжтэй байх болно гэдгийг сануулахын тулд эдгээр бөөрөнхий дээрээ инээмсэглэсэн царай хий. (Баримлын шавар хийх аргыг энэ гарын авлагын хix хуудаснаас харж болно.)

2. Хүүхэд бүрт цаас, өнгийн харандаа болон балын харандаа өг. Тэднээр инээмсэглэсэн царай зуруул. Цаасан дээр *Намайг уучлаарай гэж хэлснээр би баяртай байж чадна* гэж бичүүл.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. “Санамсаргүйгээр” шалан дээр өнгийн харандаатай хайрцгийг унагаж асга. Хүүхдүүдээс шалан дээр өнгийн харандаа тараасандаа харамсаж буйгаа хэлэн уучлалт гуй. Тэгээд энэ алдаагаа яаж засах вэ гэдгийг хүүхдүүдээс асуу. Цэвэрлэж байх үедээ хүүхдүүдэд шалан дээрх зүйлсийг цэвэрлэн шал эргээд цэвэр цэмцгэр болоход би баяртай байх болно гэдгийг хэл. Хүүхдүүдийг шалан дээрх өнгийн харандааг цуглуулахад туслахыг хүс.

Заримдаа бид өөрсдийгөө болон бусад хүмүүсийг гунигтай болгох зүйл хийдэг гэдгийг тайлбарла. Ийм зүйл тохиолдоход “Намайг уучлаарай” гэж хэлэн байдлыг илүү сайжруулахыг хичээх хэрэгтэй. Хүүхдүүдэд шалан дээрх өнгийн харандааг цуглуулахад тусалсанд талархан, бусдад туслахад бид баяр баясгалантай болдог гэдгийг сануул.

2. “Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” (*Children’s Songbook*, р. 61) дууг дуулах буюу үгийг хэл.
3. Хүүхдүүдээр урт, хэцүү ерөнхийлөгч гэх мэт үг хэлүүл. Зарим үгнүүд хэлэхэд маш хэцүү байдаг гэдгийг хэл. Бид ямар нэгэн буруу зүйл хийсэн ч “Намайг уучлаарай” гэж хэлэхэд заримдаа бас хэцүү байдаг гэдгийг тайлбарла. Хэдийгээр “Намайг уучлаарай” гэж хэлэх нь хэцүү байсан ч тэд үүнийг хэлснээр гунигтай байдлыг жаргалтай болгож болно гэдгийг хэл.
4. Хамтдаа тоглож буй хоёр хүүхдийн тухай товч түүх ярь. Нэг нь нөгөөгөө мөргөх үед “Намайг уучлаарай” гэж хэлэн найзынхаа өвдөлтийг мартахад нь туслан өөдрөг болгож болно. Гунигтай мэдрэмжийг баяр хөөртэй мэдрэмжээр солих өөр зарим жишээ хуваалц. Хичээл 21 дээрх инээмсэглэсэн, уурласан царай дүрсийг ашиглаж болно. Хүүхдүүдээр дүрсийг бариулж түүхэнд гарах хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн дүрсийг үзүүлэхийг хүс.

---

**Зорилго**

Хүүхдүүдийг уучилж сурахад нь дэмжин туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Эхлэл 37:12–28; 41:38–43; 42:1–8; 45:1–15; Матай 18:21–22; ба Лук 23:33–34-ийг уншиж, судал.
  2. Жижиг цааснууд дээр дараах үгсийг бич:
    - Хэн нэгэн чамайг цохиж, түлхэн доош унагавал.
    - Хэн нэгэн чамтай тоглохыг хүсэхгүй бол.
    - Хэн нэгэн чиний юмыг эвдэлбэл.
    - Хэн нэгэн чамайг муухайгаар хэлбэл.
    - Хэн нэгэн чиний тоглож байсан зүйлийг авч хуваалцахыг хүсэхгүй бол.

Ангийн хүүхэд бүрт цаас бэлтгэ (шаардлагатай бол өөр нөхцөл байдлуудыг бодож ол). Цаас бүрийг “Уучлалын хайрцаг” нэртэй хайрцаганд хий.
  3. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи
    - б. Зураг 1-47, Хэрэлдэж буй хүүхдүүд; зураг 1-57, Иосефыг ах нар нь худалдсан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 109; 62525); зураг 1-58, Иосеф ах нартаа өөрийгөө таниулсан нь; зураг 1-59, Цовдлолт (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 230; 62505).
  4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.
- 

**Суралцах үйл  
ажиллагаа**

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Зураг 1-47, Хэрэлдэж буй хүүхдүүд зургийг үзүүл.

- Эдгээр хүүхдүүд юу хийж байна вэ?
- Тэд яагаад маргалдаж байна гэж бодож байна вэ?
- Тэдэнд ямар байгаа бол?
- Эдгээр хэрүүлийг зогсоохын тул тэд бие биендээ юу гэж хэлэх хэрэгтэй вэ?

Өмнөх хичээлээс бид “Намайг уучлаарай” гэдэг үг ямар чухал болохын тухай суралцсан гэдгийг давт. Хүүхдүүдэд бие биеэсээ уучлалт гуйсны дараа тэд бие биеэ “уучлах” ёстой гэдгийг тайлбарла. Энэ нь тэд цаашид бие биедээ уурлахгүй харин найзууд байна гэсэн үг. Өнгөрсөн хичээл дээр ярьсан Травис Майт нарын тухай түүхийг сануул. Майт Трависыг өөрийн тоглоомыг авсныг нь уучилсан. Тэд найз хэвээр үлдсэн.



## **Иосеф өөрийн ах нарыг уучилсан**

Түүх

Зураг 1-57, Иосефыг ах нар нь худалдсан нь, зургийг үзүүл. Эхлэл 37:12–28-д байдаг Иосеф Египет руу худалдагдсан тухай түүхийг ярьж өг.

- Ах нар нь Иосефыг Египет руу боол болгон худалдахад түүнд ямар байсан бол?

Иосеф Египетэд чухал хүн болсон тухай тайлбарла (Эхлэл 41:38–43-ийг үз). Олон жилийн дараа Иосефын ах нар нь өөрсдийнх нь нутагт хангалттай хүнс байхгүй байсан тул Египет рүү хоол хүнс олохоор очсон. Тэд Иосеф амьд, түүгээр ч барахгүй Египетийн чухал хүмүүсийн нэг болсон байсныг олж мэдсэн. (Эхлэл 42:1–8; 45:1–15-ыг үз)

Зураг 1-58, Иосеф ах нартаа өөрийгаа таниулсан нь, зургийг үзүүл.

- Иосеф өөрийн ах нартайгаа эргэн хамт байх нь ямар байсан бол? (Эхлэл 45:14–15-ыг үз.)
- Иосеф өөрийн ах нартаа уурлаж байсан уу? (Эхлэл 45:5-ийг үз.)
- Иосефын ах нар нь түүний тухай юу гэж бодож байсан бол?
- Иосеф өөрийн ах нараа үнэнээсээ уучилснаа яаж харуулсан бэ? (Эхлэл 45:5–15-ыг үз.)

Үйл ажиллагаа

Нэг хүүхдийг Иосеф, бусдыг нь Иосефын ах нар болго. Хүүхдүүдээр Иосеф дахин өөрийн ах нартайгаа эргэн нийлж уучилж байгаа түүхээр жүжигчилсэн тоглолт хийлгэ.

## **Есүс бидэнд уучлах хэрэгтэй хэмээн хэлсэн**

Ариун Библийг гартаа өргө. Ариун Библи дээр Есүс бид уучлах хэрэгтэй тухай хэлсэн гэдгийг тайлбарла. Есүсийн нэг төлөөлөгч түүнээс бусдыг уучлах тухай асуусан (Матай 18:21–22-ыг үз). Есүс түүнд бид үргэлж уучлах ёстой тухай хэлсэн. Ариун Библи дээр мөн Есүс үргэлж уучилж байсан тухай гардаг гэдгийг тайлбарла.

Зураг 1-59, Цовдлолт, зургийг үзүүл. Цэргүүд Есүст маш их харгис хандаж байсан гэдгийг тайлбарла. Тэд түүнийг зодож занчин, түүн рүү нулимж байлаа. Цэргүүд Есүсийн гар хөл рүү нь хадаас зоон загалмай дээр цовдлон алсан. Есүс цэргүүдийг уучилсан гэдгийг тайлбарла. Тэр тэдгээр цэргүүдэд уурлаагүй бөгөөд харин тэдний хийсэн бүхнийг уучилсан. (Түүхийг хэтэрхий эмгэнэлт болгохоос болгоомжил. Зарим хүүхдүүд Есүсийг зовоож байсан гэдэгт их мэдрэмтгий байж болно.)

Лук 23:34-ийг нээж хүүхдүүдэд Есүс нас барахынхаа өмнө Тэнгэрлэг Эцэгтээ хандан хэрхэн залбирсан тухай хэл: “Аав аа тэднийг уучлаарай.” Хүүхдүүдээр энэ үгийг хэд хэдэн удаа давтуулан хэлүүл.

- Цэргүүд Есүсийг өвтгөж байсан ч Тэр юу хийсэн бэ?
- Хэн нэгэн биднийг уурлуулж, аз жаргалгүй болгоход Есүс биднийг юу хийхийг хүссэн бэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг өөрийнхөө хийсэн бүхнийг даган хийхийг хүс. Тэд таныг босоход босч, суниахад суниаж, инээхэд инээж, доош суухад сууж, гараа атгахад мөн гараа атга. Тэд таны хийсэн үйлдэл бүрийг хийсэн тул энэ нь

таныг дагасан гэсэн үг гэдгийг тайлбарла. Хэрэв чи хэн нэгнийг дагаж байгаа бол тэр хүний хийж буй бүхнийг дуурайн хийнэ гэсэн үг. Бид бусдыг уучлах нь бид Есүсийг дагаж байна гэсэн үг. Бид Түүний хийснийг хийсэн. Есүс биднийг уйтгартай болгож, уурлуулж байгаа тэдгээрийг уучил хэмээн хүсдэг.

### Бид бусдыг уучилж чадна

Үйл ажиллагаа

“Уучлалын хайрцаг”-аа үзүүл. Хүүхдүүдээр нэг нэгээр нь хайрцаган дахь цаасыг сугалуул.

Цаасан дээрх үгсийг уншин дараах асуултуудыг асуу:

- Ийм зүйл чамтай тохиолдож байсан уу?
- Энэ нь чамд ямар байсан бэ?
- Чамайг уйтгартай жаргалгүй болгосон хүн чамд юу гэж хэлэх ёстой вэ?
- Чамайг уурлуулж, жаргалгүй болгон, эелдэг биш байсан хүнд чи юу гэж хэлэх эсвэл юу хийх хэрэгтэй вэ?

Бусдыг уучлахад чамд ямар байсан тухайгаа ярь. Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг уучилж чаддаг байхыг хүсдэг талаар тайлбарла.

Дуу

“Хайрт Аав минь надад туслаач” (*Children’s Songbook*, р. 99) дууг дуулах буюу үгийг хэл.

Надад эелдэг биш байгаа бүгдийг  
Хайрт Аав минь, амархан уучлахад надад туслаач  
Ааваа, өдөр бүр надад туслаач би залбиран гуйж байна  
Тандаа ойр, бүр ойрхон байхад минь туслаач.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг уучилж байхыг хүсдэг тухай гэрчлэлээ хуваалц. Тэнгэрлэг Эцэгтээ хандан бусдыг уучилж байхад туслахыг хүсэн залбирч байхыг хүүхдүүдэд хэлж зоригжуул.

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Лук 15:11–32-д гардаг Үрэлгэн хүүгийн тухай түүхийг ярь. Зураг 1-49, Үрэлгэн Хүү зургийг ашигла. Хүүхдүүдэд эцэг нь хүүдээ хайртай байсан тул түүнийг уучилсан гэдгийг тайлбарла.
2. Дараах хуруун тоглоомыг тогло. Хүүхдүүдийг хамтдаа үйлдийг хийн тоглохыг урь.

Хоёр жижигхэн найзууд нэг нь баруун, нөгөөдөх нь зүүн тал (*хоёр гараа атган өргө*),

Маргалдаж бүр зодолдож эхлэв (*атгасан гараа мөргөлдүүл*).

Тэдгээр жижигхэн найзууд энэ өдөр жаргалгүй байлаа,

Тэд зөв тоглохыг заалгасан байсан тул

Дараа нь нэг жижиг найз нь ичин толгойгоо гудайлгаж (*баруун атгасан гараа бугуйгаар нь нугалан эргүүл*);

Нөгөөдөх нь мөн адил буруугаа ойлгон ичиж (*зүүн атгаа мөн ижил хий*).

Эхний жижиг найз “Би юу хийхээ мэдэж байна (*алгаа таш*).  
Чамаас уучлалт гуйх болно.”  
“Намайг бас уучлаарай” гэж нөгөө найз нь хэлэв  
“Үүнээс хойш хамтдаа тоглон жаргалтай байя” (*гараа нугалан доош суу*).

3. Хүүхэд бүрт гэрлүүгээ зүүж явж болох энгийн энгэрийн зүүлт хий. Түүн дээр *Би уучилж чадна* гэж бич.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хичээл 29 дээрх хоёр хүүхэд хамтдаа тоглож буй түүхийг давтан ярь (Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа 4-г хар). Гомдсон хүүхэд хэрхэн нөгөөдөхөө өршөөж буй тухай хэл.
2. “Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” (*Children’s Songbook*, р. 61) дууг дуулах буюу үгийг нь хэл.
3. “Хэрвээ сайхан амьдарч байвал” (*Children’s Songbook*, р. 266) дууг дуулах буюу үгийг хэл. Дууны үгийг 39-р хичээлээс харж болно. Эелдэг бус бүгдийг уучлах нь бидэнд баяр баяслыг авчирдаг.

# Надад орон гэр байгаад би талархдаг

Хичээл  
**31**

---

## Зорилго

Хүүхэд бүрийг өөрийн орон гэртээ талархалтай байж, тэднийгээ арчлан хамгаалахад туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар 1 Нифай 2:2–6; 17:7–8; ба 18:6, 23-ыг уншиж судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Мормоны Ном
  - б. Устай, шороотой, мөн мөчир хийсэн савнууд бэлтгэ. Хэрэв боломжтой бол гол мөрөн, газар шороо, моддын зурагтай зураг бэлтгэ.
  - в. Цаас, өнгийн болон балын харандаа.
  - г. Зураг 1-60, Лихай болон түүний хүмүүс амласан газарт ирсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 304; 62045); зураг 1-61, Наувугаас дүрвэсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 410; 62493).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Устай сав болон зургийг үзүүл. Ямар амьтад болон шавьж нар усаар өөрийн гэрээ хийдэг вэ гэдгийг асуу. Хүүхдүүдэд боломжоороо олныг санахад нь тусал. Шороог харуулж дараа нь мөчир үзүүл. Хүүхдүүдээр мөн газар шороонд болон модон дээр амьдарч өөрсдийн гэрээ хийдэг амьтад болон шавьжийг нэрлэхийг хүс.

- Хэрэв чиний гэр орон усанд байсан бол ямар байх байсан бэ?
- Хэрэв чиний гэр модон дээр байсан бол ямар бэ?

### Олон янзын орон гэр байдаг

Амьтад болон шавьжууд олон янзын орон гэрт амьдардаг гэдгийг тайлбарла. Хүмүүс ч мөн адил олон янзын орон гэрт амьдардаг.

Түүх

Зураг 1-60, Лихай болон түүний хүмүүс амлагдсан газарт ирсэн нь, зургийг үзүүл. Мормоны Номыг харуулж, Лихай болон түүний гэр бүлийнхэн ямар орон гэрт амьдарч байсан тухай ярьж өг (1 Нифай 2:2–6; 17:7–8; ба 18:6, 23-ыг үз). Лихайн гэр бүл Иерусалим хотод тав тухтай орон гэртэй байсан боловч Их Эзэн тэднийг Иерусалимыг орхин гарах хэрэгтэйг хэлэхэд тэд их цөл рүү аялан нүүдэллэж майханд амьдарч байсан. Олон жилийн дараа Их Эзэн Лихайн хүү Нифайд усан онгоц барихыг тушаасан. Лихай болон түүний гэр бүлийнхэн усан онгоцон дотор амьдарч Тэнгэрлэг Эцэг, Есүс нарын тэдэнд зориулан бэлтгэсэн амлагдсан нутагт аялан очсон. Амлагдсан нутагт очсоныхоо дараа Лихай болон түүний гэр бүлийнхэн байнгын оршин суух байр байшингаа барьтлаа дахин майхандаа амьдарч байлаа.

- Лихай болон түүний гэр бүлийнхэн хичнээн олон янзын орон гэрүүдэд амьдарч байсан бэ?

Түүх

Зураг 1-61, Наувугаас дүрвэсэн нь, зургийг үзүүл. Сүмийн анхны гишүүд Науву хэмээх хотыг барьж байгуулсан гэдгийг хэл. Тэд өөрсдийн орон гэрийг болон үзэсгэлэнтэй Ариун Сүм барихын тул их хөдөлмөрлөсөн. Гэхдээ Науву орчмын зарим хүмүүс Сүмийн гишүүдэд дургүй байсан тул тэднийг хүчээр хотоос явуулсан. Сүмийн гишүүд өөрсдийн жижиг гар тэргэнцэрт багтах цөөхөн зүйлсийг л өөрсөдтэйгөө хамт авч явах боломжтой байв. Учир нь тэргэнцэрүүд их жижигхэн байсан тул олон хүүхдүүд өөрсдийн тоглоомоо үлдээсэн. Зарим хүмүүс өөрсдийн тэргэнцэр дотор болон майханд удаан хугацаагаар амьдарсан.

- Тэргэнцэр болон майханд амьдрах нь яагаад хэцүү вэ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босч дараах үйлдлийг хийхийг урь:

Анхдагч хүүхдүүд алхаад л яриад л (*дороо алх*);

Дараа нь тэд тоглон наадаж, цовхрон үсэрцгээнэ (*дороо цовхрох буюу үсэр*).

Шөнө болж, одод анивчан гэрэлтэхэд (*гараа атгаж, нээ*);

Тэргэнцэр дотроо зүүдлэн унтана (*нүдээ анин, гаран дээрээ толгойгоо тавь*).

### **Орон гэр гэдэг бид хайрлагддаг газар**

Ямар маягийн орон байранд бид амьдрах нь чухал биш гэдгийг тайлбарла. Бид том сайхан байшинд, жижиг байшинд, орон сууцны байранд, майханд эсвэл усан онгоцон дээр амьдардаг байж болно. Харин хамгийн чухал нь бидний орон гэр маань гэр бүлийн гишүүд бие биеэ хайрлах газар юм. Өөрийн орон гэрийн талаар болон түүнийг хайраар дүүрэн газар болгохын тул юу хийдэг талаараа хэл.

- Гэртээ байхад яагаад сайхан байдаг вэ?
- Гэр бүлийнхэн чинь чамд хайртай гэдгийг чи яаж мэддэг вэ?
- Гэрээсээ хол өөр газар хонож үзсэн үү?
- Чи хаана хонож байсан бэ?
- Өөрийн гэртээ ирэхэд ямар байсан бэ?

Хүүхдүүдэд өөрийн орон гэрт, өөрийн орон дээр унтах ямар сайхан байдгийг сануул.

Үйл ажиллагаа

Хүүхдүүд таныг “Орон гэр минь” (*Children’s Songbook*, p. 192) дууны үгийг хэлэх үед босон зогсож сонсохыг урь. *Гэр* гэж үг хэлэх бүрт өөрсдийгөө тэврэхийг хүс. Хэрэв та хүсвэл хүүхдүүдтэй хамтдаа дахин үгийг давтан хэл.

Гэр гэдэг зүрх сэтгэл минь байдаг

Дулаан халуун хайраар дүүрэн газар.

Гэр гэдэг булан бүрт нь

Халуун тэвэр, дулаан гар байдаг газар.

(© 1975 by Sonos Music, Orem, Utah. Бүх эрх хамгаалагдсан.

Зөвшөөрөлтэйгөөр ашиглав)

## Бид гэр бүлийнхэндээ орон гэрээ өөд нь татахад тусалж чадна

Өөрсдийн орон гэрийг амьдрахад сайхан газар байлгахын тулд өөд нь татах ёстой гэдгийг тайлбарла. Гэр бүлийн гишүүн бүр гэрээ цэвэр цэмцгэр байлгахад туслах ёстой.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээр орон гэрээ цэвэрлэж байгаа, тоглоомоо хураах, шалаа шүүрдэх, хувцсаа эвхэн хураах зэрэг үйлдлийг үггүйгээр дүрслэн үзүүлэхийг хүс.

Хүүхэд бүрийг нэг нэгээр нь урин өөрийнхөө дэргэд зогсохыг урь. Хүүхэд бүр гэртээ сайн туслагч нь байж чадах нөхцөл байдлыг дүрслэн хэл. Тухайн нөхцөл байдалд тэр хүүхэд юу хийх ёстой талаар асуу. Дараах жишээнүүдийг юмуу ангийн хүүхдүүдэд тохиромжтой өөрийнхөө зохиосон нөхцөл байдлыг ашигла:

- Санамсаргүйгээр шилэн аягатай усыг шалан дээр асгажээ. Чи юу хийх хэрэгтэй вэ?
- Чи өөрийн шоогоор үдээс хойшжингоо тогложээ. Одоо хоолоо идэх цаг боллоо. Өөрийн шоогоо яах ёстой вэ?
- Ээж чинь оройн хоолоо ширээн дээрээ тавихаар сандарч байна. Гэр бүлийнхнээ ирэхээс өмнө ширээгээ засахад туслах хэн нэгэн түүнд хэрэгтэй байна. Чи юу хийж чадах вэ?
- Чиний хувцсыг угаагаад сайхан эвхсэн байна. Одоо чи тэднийг яах ёстой вэ?
- Чи гадаа тоглож байгаад гутал чинь шавартай болжээ. Гэртээ орохоос өмнө чи яах ёстой вэ?
- Өглөө орноосоо босоход чиний ор чинь замбараагүй болжээ. Чи түүнийг яах ёстой вэ?

Орон гэрээ цэвэр цэмцгэр байлгахад тэдний хийдэг зүйлсийнх нь тухай дэмжин яриул. Хүүхдүүдэд та өөрийн гэрээ хэрхэн цэвэр цэмцгэр байлгадаг талаараа ярь.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдэд цаас, харандаа, өнгийн харандаа өгч, долоо хоногийн турш гэртээ тусалж болох зүйлийг дүрслэн зуруул. Зураг бүр дээр *Би өөрийн орон гэртээ талархалтай байдаг* гэж бич.

Гэрчлэл

Өөрийн орон гэрийнхээ тухай болон Тэнгэрлэг Эцэг, Есүс нарт энэ сайхан орон гэрээр адисласанд талархалтай байдгаа хуваалц.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Том уутанд гэрт түгээмэл хэрэглэдэг зүйлээс хийж авчир (хүүхэд бүрт хүрэлцэхүйц). Уутнаас хүүхэд бүрээр нэг зүйлийг авахуулж, гэрийн ажилд тусалж байхдаа үүнийг хэрхэн хэрэглэж болохыг тайлбарла. Жишээ нь: Даавуун алчуур сав суулга арчих юм уу тоос арчихад, халбага нь ширээ засахад, тоглоом нь өрөөгөө цэвэрлэх үед хураах зэрэг.

2. “Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, р. 253) дууны “Өөрийн орыг хураах сайхан” эсвэл “Ширээ засах сайхан” зэрэг үгсийг хэлэн дуулах буюу үгийг хэлэх үед үйлдлийг дүрслэн үзүүл.
3. Хүүхэд бүрийн гарын хэлбэрийг цаасан дээр зуруулж, *Миний гар тусалж чадна* гэж бичин уруу вандуйтай нь өгч явуул. Хүүхдүүдийн гар нь хэрхэн тусалж болох талаар ярилц.
4. Хүүхэд бүрийг өөрсдийн сандлаа битүү тэргэнцэр гэж төсөөлөхийг хүс. Анхдагч нар аялах үедээ эелдэг бус хүмүүсээс болон зэрлэг амьтдаас хамгаалахын тул шөнө болоход тэргэнцрүүдээ тойрог болгодог байсан шиг сандлуудаа тойрог болгон тавиул. Тэднээр түүдэг асаан хоолоо хийж, оройн хоолныхоо дараа дуу дуулж бүжиглэн, унтахаар тэргэнцэр рүүгээ (сандагч) гарч байгаа мэт үйлдлүүдийг дүрслүүл.
5. Олон янзын орон байрны зурагнууд авчрах эсхүл тэднийг самбар дээр юм уу цаасан дээр зур. Орон байр бүхэн юугаар хийгдсэн, амьдрахад ямар байх талаар ярилц. Үүндээ майхан, түр зуурын сүүдрэвч эсвэл цас, мөсөн овоохой, орд харш, модон байшин, модны орой дээрх байр зэргийг оруулж болно.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Дараах хуруун тоглоомын үйлдлийг хийлгэн хүүхдүүдээр тоглуул:  
Завгүй бяцхан хуруунууд (*Гараа атга*),  
Хэн бидэнд дуулгавартай байхад туслах вэ?  
“Би” “Би” “Би” “Би” “Би” гэж (*“Би” гэж хэлэх бүртээ нэг хуруугаа гозойлго*),  
Гэж завгүй хурууд хэлэв

# Хоол хүнс, хувцас байгаад би талархдаг

Хичээл  
32

---

## Зорилго

Хүүхдүүдийг хоол хүнс, хувцас байгаад талархахад нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Эхлэл 1:11–12 ба Хаадын дээд 17:8–16-г уншиж судал.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи
    - б. Дотроо үртэй жимс юм уу ногоо
    - в. Вандуйт уут юм уу зөөлөн зүйл
    - г. Хайчилбар 1-5, загас; хайчилбар 1-7, гахай; хайчилбар 1-8, хонь; хайчилбар 1-9, үнээ; хайчилбар 1-22, тахиа (ижил төстэй хайчилбаруудыг Хүүхдийн хэсгийн үзүүлэн 4-өөс олж болно); эсхүл өөрийн орон нутаг дахь хоол хүнс болон хувцас хийхэд хэрэглэдэг амьтдын зургийг ол.
    - д. Зураг 1-15, Хоолоо адисалсан нь; зураг 1-50, Би хувцсаа өмсөж чадна.
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.
- 

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Түгээмэл өглөөний унданд хэрэглэдэг зүйлсийн нэрийг онгорхой зайнд орлуулан бичээд дараах заавруудыг өг:

Хэрэв чи өглөөний унданд идэх дуртай бол нэг гараа өргө

Хэрэв чи өглөөний унданд идэх дуртай бол нөгөө гараа өргө.

Хэрэв чи өглөөний унданд идэх дуртай бол бос.

Хүүхэд бүрээр дуртай зүйлийг нь хэлтлээ үргэлжлүүл. Дараа нь “Хэрэв чи Тэнгэрлэг Эцэгт өөрийн идэж буй хоол хүнсний төлөө талархаж байвал гараа зөрүүлэн нугалаад суу.”

### Бид ургамал, амьтдыг хүнсэндээ хэрэглэдэг

- Өөр ямар хүнсний зүйлс та нар идэх дуртай вэ?
- Бид өөрсдийн хүнсээ хаанаас авдаг вэ?
- Бидний хүнсэндээ хэрэглэдэг ургамал, амьтдыг хэн бүтээсэн бэ?

Өөрийн иддэг хоол хүнснийхээ тухай болон тэднийг хаанаас авдаг талаар ярь. Бид олон хоол хүнсний зүйлсээ ургамлаас гаргаж авдаг гэдгийг тайлбарла.

Өөрийн авчирсан жимс эсвэл ногоог гарган огтолж доторх үрийг нь харуул.

- Эдгээр нь юу вэ?
- Ургамалд яагаад үр байдаг вэ?



Тэнгэрлэг Эцэг ургамал бүрийг үртэй байж үржин өсч биднийг хоол хүнсээр хангахад зориулан бүтээсэн гэдгийг тайлбарла (Эхлэл 1:11–12-ыг үз). Жимс, ногоо зэрэг ургамал нь өсч улам их үрийг гаргадаг.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдтэй хамт дараах үйлдэлт үйл ажиллагааг хий:

Гүн суулгасан үр

Гүн суулгасан үрнүүд (*тонгойн гараараа шаланд хүр*).

Хөрсөндөө тайван нойрсоно (*нэг гараа нөгөө дээр нь тавьж алгаа нийлүүл*).

Шаргал нар хурцаар шарж (*гараа толгой дээрээ тавь*).

Зөөлөн бороо дусална (*хуруунуудаар бороон дусал хий*).

Намуухан салхи үлээж (*толгой дээрээ гараа ганхуул*).

Жижиг үрс ургаж эхэллээ (*хуруудаа шалнаас дээш найгуулан өргө*).

- Үр тариалахад тусалж байсан уу?
- Чи юу тарьсан бэ?
- (Ургамлаас бид ямар хүнс гаргаж авдаг вэ?)

Хүүхдүүдийг жимс, ногоо, тарианы талаар бодохыг хүс. Талх болон гурилан бүтээгдэхүүнийг үр тарианаас гаргадаг гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэгт жимс, ногоо, тариаг гаргадаг үрнүүдийг өгсөнд бид маш их талархалтай байгаагаа хэл.

Дахин үрнүүдийг харуул.

- Эдгээр үрнүүд ургаж өсөхийн тулд юу хэрэгтэй вэ?

Түүх

Хаадын дээд 17:8–16-д гардаг Елиа болон Зарифатын тухай түүхийг ярьж өг. Бороо орохгүй байсан тул тэнд хангалттай хоол хүнс байгаагүй гэдгийг хүүхдүүдэд ойлгоход нь тусал. Ус авчрах бороогүйгээр ямар ч ургамал ургахгүй.

- Ямар ч идэх хоолгүй болоход чи яах вэ?
- Бэлэвсэн эмэгтэй өөрт байсан жаахан хүнсээ Елиатай хуваалцсанаар ямар адислал хүлээн авсан бэ? (Хаадын Дээд 17:15–16-г үз.)

Бидний хүнс бүгд ургамлаас гаралтай бус гэдгийг тайлбарла.

- Сүүг хаанаас гаргаж авдаг вэ?
- Өндгийг хаанаас авдаг вэ?
- Махыг хаанаас бид гаргаж авдаг вэ?

Зарим хүнсээ бид мал амьтдаас гаргаж авдаг гэдгийг хэл. Тохирох хайчилбар болон зургийг ашиглан өөрсдийн орон нутагт хүнсэнд хэрэглэдэг амьтдын талаар ярилц.

### **Бид ургамал болон амьтдыг хувцсандаа хэрэглэдэг**

Ургамал болон амьтдаас бид зөвхөн хүнсээ бэлтгээд зогсдоггүй гэдгийг хэл. Зураг 1-50, Би хувцаслаж чадна, зургийг үзүүл.

- Энэ хүү юу хийж байна?
- Чи юу өмсдөг вэ?

Үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдийг цамц, даашинз, гутал гадуур хувцас болон малгайгаа өмсөж байгааг үйлдлээр дүрслэн үзүүлэхийг хүс.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бидэнд хувцас ямар хэрэгтэй вэ? (бидний биеийг далдлах, хамгаалах болон хүйтнээс хамгаалах)</li> <li>• Хувцсыг юугаар хийдэг вэ?</li> </ul> <p>Хэрэв хүүхдүүд хувцас хийдэг материалуудыг нэрлэж мэдэж байвал тэдгээр материал нь хаанаас гаргаж авсныг асуу. Хувцас хийдэг материалууд бид ургамал болон амьтдаас гаргаж авдаг гэдгийг тайлбарла. Өөрийн орон нутагт материал хийхэд түгээмэл хэрэглэдэг ургамал, амьтдыг нэрлэ. Жишээ нь, ноолууран цамцыг ямааны ноосоор хийдэг. Хөвөн даавууг нь ургамлаас гаргаж, торгыг хүр хорхой нэхдэг. Мөн ноосыг хониноос, ихэнх арьсан бүтээгдэхүүн үхрийн ширийг үхрээс гаргаж авдаг.</p> <p><b>Бид хоол хүнс болон хувцас байгаад талархаж чадна</b></p>
Үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдийг өөрсдийн талархалтай байдаг хоол хүнсний талаар бодохыг хүс. Хүүхэд бүр уруу вандуйтай уутаа юм уу зөөлөн зүйлээ ээлжлэн шид. Үүнийг барьсан хүүхдээр өөрийнх нь дуртай хоол хүнсний нэрийг асууж хэлүүл, тэгээд эргүүлэн шидэхийг хүс. Дараагийн хүүхэд уруу шидэхээс өмнө түрүүчийн хүүхдийн хэлсэн хоол хүнсийг хаанаас гаргаж авсан талаар ярилц. Хүүхдүүдэд ургамал, амьтад бүхнийг Тэнгэрлэг Эцэгийн заавраар Есүс бүтээсэн гэдгийг сануул.</p> <p>Үйл ажиллагааг хүүхэд бүрээр хүнсний оронд хувцас нэрлүүлэн давтан хий.</p> <p>Зураг 1-15, Хоолоо адисалсан нь, зургийг үзүүл.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Өөрсдийн хоол хүнсний төлөө хэнд бид талархах ёстой вэ?</li> <li>• Бидэнд байгаа хувцасны төлөө бид хэнд талархах ёстой вэ?</li> <li>• Тэнгэрлэг Эцэгтээ эдгээр зүйлсийн төлөө хэрхэн талархаж чадах вэ? (нэг зам нь өдөр бүрийнхээ залбиралд багтаах)</li> </ul>
Гэрчлэл	<p>Тэнгэрлэг Эцэг болон Есүс нартаа бидэнд идэх хоол, өмсөх хувцас байх боломжтой болгосных нь төлөө та өөрийн талархлаа илэрхийл.</p>

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхэд бүрт голоор нь шугам татан хоёр хэсэг хувааж *Би талархаж байна:* гэж дээд талын голд нь бичсэн цаас өг. Тэгээд тэднээр дуртай хоол хүнсийг шугамын нэг талд, нөгөө талд нь хувцас зуруул.
2. “Эцэгтээ талархъя” (*Children’s Songbook*, р. 20) дууг хүүхдүүд дуулахад юм уу үгийг хэлэхэд тусал.
3. Хүүхдүүдийг үр гэж өөрсдийгөө төсөөлөхийг урь. Тэд хөрсөнд суулгасан мэт доош нугдайж, тэдэн дээр нар шарж, зөөлөн бороо ороход тэд аажмаар өөд дээшилнэ. Хүүхдүүдийг ээлжлүүлэн нар болон бороо болго.

4. Хүүхдүүдэд идүүлж болох бага зэрэг жимс, ногоо авчир. Тухайн жимс эсхүл ногоо нь ямар төрлийн үр болоод ургамлаас ургасан болохыг тодотгон ярилц (хүүхдүүдийн эх эцэгтэй ярьж хүүхэд ямар нэгэн хүнсэнд харшилтай эсэхийг тодотго).
5. Хүүхдүүдийн мэддэг хоол хүнснийг дүрслэн хэл. Жишээ нь, “Гадна тал нь цагаан эсвэл бор. Тэр хальстай. Үүрэнд байдаг. Тэр юу вэ? (өндөг). Санаснаараа давт. Та өөрийн дүрслэх хүнсний зүйлээ авчирч болно.
6. Ноосон цамц, гадуур хувцас, малгай зэрэг хувцас авчир. Хувцас байгаад талархалтай байдаг тухай ярих үед хүүхдүүд тэдгээрийг өмсөж үзэж болно.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. “Талархлын дуу” (*Children’s Songbook*, р. 20) дууг дуулах буюу үгийг хэлэхэд тусал.
2. Дараах үгсийг хэлэх үед хүүхдүүд хувцаслаж буй мэт дүрслэн үзүүлнэ:
  - Хүүхдүүд ээ, өмдөө өмс, өмдөө өмс, өмдөө өмс.
  - Хүүхдүүд ээ, өмдөө өмс, нэг, хоёр, гурав.
  - Хүүхдүүд ээ, юбкаа өмс, юбкаа өмс, юбкаа өмс.
  - Хүүхдүүд ээ, юбкаа өмс, нэг, хоёр, гурав.
  - Хүүхдүүд ээ, цамцаа өмс, цамцаа өмс, цамцаа өмс.
  - Хүүхдүүд ээ, цамцаа өмс, нэг, хоёр, гурав.
  - Хүүхдүүд ээ, оймсоо өмс, оймсоо өмс, оймсоо өмс.
  - Хүүхдүүд ээ, оймсоо өмс, нэг, хоёр, гурав.
  - Хүүхдүүд ээ, гутлаа өмс, гутлаа өмс, гутлаа өмс.
  - Хүүхдүүд ээ, гутлаа өмс, нэг, хоёр, гурав.
  - Хүүхэд бүр одоо бүх хувцсаа өмссөн, бүгдийг өмссөн, бүгдийг өмссөн (*алгаа таш*).
  - Хүүхэд бүр одоо бүх хувцсаа өмссөн, явж тоглоцгооё!

---

**Зорилго**

Хүүхэд бүрт сайн найз байх хүсэлтэй байхад туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Иохан 6:1–13 ба 11:1–7, 17–44-ийг уншиж, суралц.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи
    - б. Зураг 1-3, Есүс бол Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572).
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.
- 

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Өөр лүүгээ заагаад “Би хэн бэ?” гэж асуу. Хүүхдүүд таны нэрийг хэлэх юмуу *багш* гэж хэлнэ. Та бас тэдний найз, тэд ч мөн таны найз гэдгийг тайлбарла. Найз гэдэг нь бие биедээ таалагддаг хүмүүсийг хэлдгийг тайлбарла.

Хүүхдүүдтэй хамт тойрог болон цуглар. Хүүхэд бүр уруу харж, “(Хүүхдийн нэр) бол миний найз гэж хэл.” Хүүхэд бүртэй үүнийг хий.

**Бидэнд олон найз бий**

- Чиний найзууд хэн бэ?

Хүүхдүүдээр тэдний найз нарынх нь тухай яриул. Найз нар нь ямар ч насны хүмүүс байж болно гэдгийг хэл. Гэр бүлийн гишүүд бидний хамгийн сайн найз нарын нэг байж чадна. Ангид буй хүүхэд бүр найз гэдгийг тодотго. Зураг 1-3, Есүс бол Христ зургийг үзүүл. Ангийн хүн бүрийн сайн найз бол энэ зурган дээр байгаа хүн гэдгийг тайлбарла.

- Энэ зурган дээрх бидний найз хэн бэ?
- Есүс бидний найз гэдгийг яаж мэдэх вэ?

Дуу

“Есүс бидний хайрт найз” (*Children’s Songbook*, р. 58) дууг дуулах буюу үгийг хэл.

Есүс бидний Хайрт Найз.  
Тэр үргэлж бидний дэргэд байдаг.  
Биднийг залбирахад Тэр биднийг хөтөлдөг  
Тэр хүүхэд бүрт хайртай.

Түүх

Иохан 11:1–7, 17–44-д байдаг Есүс Лазарыг үхлээс амилуулдаг түүхийг ярьж өг. Лазар болон түүний эгч дүүс нар Есүсийн найзууд байсан гэдгийг тодруулан хэл. Есүс Бетанд байхдаа тэдний гэрт очиж, оройн зоог хамтдаа иддэг байсан.

- Есүс Лазарт ямар ханддаг байсан бэ? (Иохан 11:3, 35–36-г үз.)
- Лазарын төлөө Есүс юу хийсэн бэ? (Иохан 11:43–44-г үз.)
- Лазар, Мариа, Марта нар Есүсийн талаар ямар сэтгэгдэлтэй байсан гэж бодож байна?

### **Бид сайн найзууд байж чадна**

- Бид найз нартаа яаж хандах ёстой вэ?

Бид сайн найзууд байхын тул бусдыг сайн зүйл хийхэд нь туслах ёстой гэдгийг тайлбарла. Бид найз нарыгаа халамжилж, тэднийгээ аз жаргалтай байгаасай гэж хүсдэг. Бусад хүмүүс чамд яаж хандаасай гэж хүсдэг шиг тэдэнд тийнхүү хандахын чухлын тухай ярилц. Дараах нөхцөлүүдэд хүүхдүүд хэрхэн сайн найзууд байж болох талаар асуу:

- Чи найзтайгаа тоглож байхад өөр нэг хүүхэд ирээд та нартай тоглохыг хүсвэл.
- Шинэ хүүхэд анхны удаа ангид ирэхдээ ичиж зовон, айсан байлаа.
- Хүүхдийг дооглон шоглоход тэр гомджээ.

Дуу

“Эелдэг байдал надаас эхэлнэ” (*Children’s Songbook*, р. 145) дууг дуулах буюу үгийг хэл.

Би хүн бүртэй эелдэг байхыг хүсч байна,  
Энэ нь зөв гэдгийг чи мэдэх болно.  
Тиймээс би өөртөө, “Үүнийг сана:  
Эелдэг байдал надаас эхэлнэ” гэж хэлдэг.

- Найзууд чинь чамтай эелдэг дотно байхад чамд ямар байдаг вэ?
- Чи тэдэнтэй эелдэг байвал тэдэнд ямар байна гэж чи бодож байна?

Хүүхдүүдэд хэрэв тэд сайн найзтай байхыг хүсч байвал өөрсдөө сайн найз нар байх хэрэгтэй гэдгийг ойлгоход нь тусал.

### **Найзууд юмаа хуваалцдаг**

- Хэрэв чи (тоглоомын нэр эсвэл онцгой нэгэн өөр зүйл) тоглож байхад, найз чинь чамтай тоглохоор ирвэл, чи яах вэ?

Бид өөр хэн нэгнийг бидэнтэй тоглохыг зөвшөөрөх эсвэл өөрт байгаа зүйлээсээ бусдад өгч буй нь хуваалцаж байгаа хэрэг юм. Заримдаа өөрт байгаа зүйлийг хувааж таллах боломжгүй тиймээс ээлжлэн хэрэглэж болно. Үүнийг бас хуваалцах гэж хэлдэг.

- Хэрэв чиний нэг найз өлсөж, чамд идэх зүйл байвал чи яах ёстой вэ?

Түүх

Ариун Библийг харуулаад Иохан 6:1–13-д Есүс таван мянган хүнийг хооллодог түүхийг ярьж өг. Залуу хүү өөрт байсан хоолоо бусадтай хуваалцсан тул, Есүс өөрийн хүчээ ашиглан түүгээр нь бүх хүмүүст хүрэлцэхээр хангалттай хоол хийсэн.

Хүүхдүүдэд Елиа болон бэлэвсэн эмэгтэй Зарефатын тухай түүхийг сануул (хичээл 32 дээр яригдсан). Бэлэвсэн эмэгтэй өөрт нь хангалттай хоол байхгүй байсан ч хоолоо хуваалцсан тул адислагдсан.

- Бид өөрсдийн найз нартай юу хуваалцаж болох вэ?
- Бид өөрсдийн гэр бүлтэйгээ юу хуваалцаж болох вэ?

Дуу

Хүүхдүүдийг босгон зогсоогоод “Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, р. 253) дууг “Өөрийн (тоглоом, ном хүүхдийн санал болгох бусад зүйлсийг) зүйлийг хуваалцах нь сайхан” гэдэг үгсийг орлуулан хамтдаа дуул. Хүүхдүүдээр үгийн дагуу үйлдэл зохион хийлгэ.

Өөрийн тоглоомоо хуваалцах сайхан,  
Хуваалцах сайхан, хуваалцах сайхан!  
Өөрийн тоглоомоо хуваалцах сайхан,  
Хуваалцах сайхан, хуваалцах сайхан!

(© 1963 by D. C. Heath and Company. Зөвшөөрөлтэйгөөр дахин хэвлэв.)

Хүүхдүүдэд найз нар бие биедээ тусалдаг гэдгийг сануулж, хэрэгтэй бол тэднийг ангиа цэмцгэр болгохыг дэмжин туслуул.

Гэрчлэл

Сайн найз байхын чухлын талаар өөрийн гэрчлэлээ хуваалц. Өөрийн найзын талаар хувийн гэрчлэлээ хуваалцаж болно. Тэнгэрлэг Эцэг, Есүс бидний найз, тэд бидэнд хайртай гэдгийг хэл. Хүүхдүүдийг энэ долоо хоногт өөрсдийн найз нартайгаа эелдэг байхыг уриал.

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. “Есүс хүн бүрт хайртай” (*Children’s Songbook*, р. 61), дууг дуулах буюу үгийг нь хэл.
2. Хүүхдүүдийг босгон “Дотны бяцхан найз” дууны үйлдлийг хийлгэ:
 

Надад дотнын бяцхан найз бий (өөрийгөө тэвэр);  
Би түүнийг өдөр бүр харж чадна.  
Би өөрийн нөхөрсөг найздаа хайртай.  
Бид ингэж тоглодог:  
Бид хүүхэлдэйгээр тоглодог (*гартаа хүүхэлдэй тэвэрч буй бол*);  
Бид бөмбөгөөр тоглодог (*бөмбөг шидэх мэт бол*);  
Бид цэрэг мэт алхдаг (*дороо чимээгүйхэн алх*).  
Бид савлуур дээр тоглодог (*савлуур дээр буй мэт бол*);  
Бид ярилцаж бас дуулдаг;  
Бүх сайн найзуудын адил (*гараа зөрүүлэн нугалаад толгойгоо дохь*).
3. Ангид бага зэрэг идэх зүйл авчир (хүүхдүүдийн эх эцгээс хүүхэд ямар нэгэн харшилтай эсэхийг тодруул). Хүүхдүүдэд харагдах газарт идэх зүйлээ тавь. Тэдгээр нь хэчнээн сайхан харагдаж байгааг хэл. Тэдгээрийг хуваалцаасай гэж хүсч байгаа эсэхийг хүүхдүүдээс асуу. Мөн идэх зүйлээ хэрэв зөвхөн цөөхөн хэдтэй нь л хуваалцах юм бол ямар байх вэ гэдгийг асуу. Үүнээс хүртээгүй бусдад нь ямар санагдах талаар ярилц. Хүүхдүүдтэй идэх зүйлээ хуваалц.
4. Хүүхдүүдээр найз нартайгаа хуваалцаж байгаа өөрсдийнх нь зургийг зуруул. Зураг бүр дээр *Би өөрийн найз нартайгаа хуваалцаж чадна* гэж бич.

## 5. Өөрийн үгээр дараах түүхийг ярьж өг:

Хуруу нь гарсан гутал

Анхдагчид Ютад амьдрахаар ирэх үед тэдний ихэнх нь ядуу байлаа. Тэд мөнгөө урт аялалд зориулж эд зүйлс авах болон байшин барих, цэцэрлэг ногоо тариалах багаж хэрэгсэл авахад зарцуулсан байв. Хүмүүст хангалттай мөнгө байгаагүй тул олон хүүхэд зөвхөн Ням гарагт л өмсдөг ганц хос гуталтай байлаа. Тэд долоо хоногийн бусад өдөр хөл нүцгэн явдаг байв.

Анхдагчдын нэг Мэлинда охин өвлийн турш өмссөн хүнд, муухай, хуруу нь гарсан цоорхой гуталтай байлаа. Зун болоход гэр бүлийнхэн нь түүнд хөлд эвтэйхэн Ням гарагт өмсдөг гоёмсог гутал авч өгчээ. Тэр үүнийгээ баярын жагсаалд өмсөхөөр бэлтгэж байв.

Мэлиндагийн сайн найз Аманда огт гуталгүй байв. Мэлинда Амандагийн төлөө санаа зовж ээжээсээ хоёр гутлынхаа нэгийг Амандад зээлдүүлэн жагсаал үзэх зөвшөөрөл асуув. Мэлинда найз руугаа очихоор өөрийн хуучин, хүнд, цоорсон гутлаа авахад ээж нь түүнд “Хэрэв чи хуваалцахаар явж байгаа бол өөрийн дуртай гутлаа өгөх хэрэгтэй” гэж хэлжээ.

Мэлинда хэсэг хугацаанд маш сайн бодлоо. Тэр Есүс байсан бол юу хийх байсан талаар боджээ. Тэр аль гутлаа өмсөхийг илүү их хүсэх байсан бэ гэж бодоод яах ёстойгоо ойлгов. Тэр шинэ гутлаа найддаа өмсүүлэхээр аван өөрөө жагсаалд хуучин, хуруу нь гарсан гутлаа өмсөн явав. Гэхдээ Мэлинда маш аз жаргалтай байлаа! Тэр Есүс түүнээс хүсэх байсан зүйлийг хийж хуваалцсан гэдгээ мэдэж байв.

---

### **Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдэд тоглох хэдэн тоглоом гаргаж тавь. Тэдэнтэй “тэгнэ үү, ингэнэ үү” гэж эелдэг гуйх болон “баярлалаа” гэдэг үгсийн чухлын талаар ярилц. Хүүхдүүдийг тоглохдоо тоглоомоо хуваалцах, тоглож дууссаныхаа дараа тэдгээрийг хамтдаа хураахад туслах хэрэгтэйг хэл.
2. Дараах үгсийг хэлж хүүхдүүдээр үйлдлийг хийлгэ. Хүүхдүүд хүсвэл давтан хий.

Өдрийг жаргалтай болго

Сайхан бүгдийг харах хоёр нүд (*нүдээ заа*),  
Өдрийн турш инээмсэглэх хоёр уруул (*нүүр дүүрэн инээ*).  
Бусдын хэлэхийг сонсох хоёр чих (*гараа аяга болгон чихэндээ барь*),  
Тоглоомоо хураах хоёр гар (*тоглоомоо цуглуулж, хурааж байгаа дүрслэл хий*).

Өдөр бүр нөхөрсөг үгс хэлэх хэл (*ам руугаа заа*),  
Ажиллаж тоглох хайраар дүүрэн зүрх (*зүрхэн дээрээ гараа тавь*).  
Баяртайгаар гуйх хоёр хөл (*хоёр хөлөө заа*)—  
Өдрөө бүгдээрээ жаргалтай болгоё.

---

**Зорилго** Хүүхэд бүрийг сайхан үг болон үйлдлээрээ бусдад хайраа илэрхийлэхийг урамшуулан дэмжих.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Матай 7:12; Марк 10:13–16; Лук 10:30–37; ба Иохан 13:34-ийг суралц.
2. Хичээл 19 дээр гардаг Есүс хараагүй хүнийг эдгээсэн түүхийг сануул. (Иохан 9:1–7-ийг үз).
3. Ангийн хүүхэд бүрт цаасаар зүрхэн дүрс хий. Түүн дээрээ *Би чамд хайртай* гэж бич.
4. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Зураг 1-3, Есүс бол Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572); зураг 1-43, Есүс хараагүй хүнийг эдгээсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 213; 62145); зураг 1-48, Шоогоор тоглож буй хүүхдүүд; зураг 1-62, Сайн санаат Самари хүн (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 218; 62156).
5. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Зураг 1-48, Шоогоор тоглож буй хүүхдүүд, зургийг үзүүл.

- Эдгээр хүүхдүүд юу хийж байна?
- Чи эдгээр хүүхдүүдийг найз нар гэж бодож байна уу?
- Найзууд бие биедээ яаж ханддаг вэ?

Хүүхдүүдэд найз нар бие биетэйгээ эелдэг харьцдаг гэдгийг хэл. Бусадтай элэгсэг байхад тэдэнд өөрсдийн хайраа үзүүлж байна гэсэн үг.

Дуу

Хүүхдүүдтэй хамт “Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” (*Children’s Songbook*, р. 61) дууг дуулах буюу үгийг хэлж, үйлдлийг хий:

Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн (*гараа том дэлгэ*);  
Бас тэдэнд эелдэг ханд гэж хэлсэн (*толгойгоо дохь*).  
Чиний зүрх хайраар дүүрэхэд (*гараа зүрхэн дээрээ тавь*),  
Бусад хүмүүс чамайг хайрлах болно (*өөрийгөө тэвэр*).

**Есүс бусдад эелдэг байж хайраа үзүүлсэн**

Зураг 1-3, Есүс бол Христ, зургийг үзүүл. Хүүхдүүдэд өөртөө бусдыг яаж хандаасай гэж хүсч байгаагаар бусдад ханд гэж Есүс найз нь гэдгийг хэл.



Ариун Библи харуулж, Матай 7:12 өөрсдөө ч тийнхүү тэдэнд ханд хүртэл унш. Энэ судар дээр хэрэв бусдыг бидэнд эелдэг хандаасай хэмээн хүсч байвал тэдэнд эелдэг хандах ёстой гэсэн үг гэдгийг тайлбарла.

Түүх

Зураг 1-43, Есүс хараагүй хүнийг эдгээсэн нь, зургийг үзүүл. Хүүхдүүдээр зурган дээрх түүхийг ярихад өөртөө туслуул (Иохан 9:1–7-г үз).

- Есүс хараагүй хүнд хэрхэн эелдэг байсан бэ?

Түүх

Марк 10:13–16-д гардаг Есүс бяцхан хүүхдүүдийг адислаж байгаа түүхийг ярь.

- Есүс хүүхдүүдэд хэрхэн эелдэг байсан бэ?

Есүс өөрийн амьдралаа бусад хүмүүст туслахын төлөө зориулсан гэдгийг хэл. Эелдэг байснаар Есүс бусдад өөрийн хайраа үзүүлж байлаа. Есүс бидэнд бие биеэ хайрла хэмээн тушаасан гэдгийг тайлбарла. Иохан 13:34-ийг уншиж өг. Хүүхдүүдээр “Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрла” гэж хэд хэдэн удаа давтуулан хэлүүл.

Дуу

Хүүхдүүдтэй хамт “Бие биеэ хайрла” (*Children’s Songbook*, p. 136) дууг дуулах буюу үгийг хэл.

Миний нэг адилаар,

Бие биеэ хайрла.

Энэ шинэ тушаалаар

Бие биеэ хайрла.

Энэ шинэ тушаалаар

Та нар бие биеэ хайрлаж чадвал хүмүүс,

Та нарыг миний шавь гэх болно

(© 1961, 1989 by Luacine C. Fox. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

### **Би бусдад эелдэг байж хайраа харуулж чадна**

Түүх

Зураг 1-62, Сайн санаат Самари хүн, зургийг үзүүл. Лук 10:30–37-д гардаг сайн Самари хүний тухай түүхийг ярьж өг.

- Энэ түүхэнд хэн нь эелдэг байсан бэ?
- Гэмтсэн хүнд туслахын тулд Самари хүн юу хийсэн бэ?

Хүүхдүүдэд бусдад эелдэг байж чадах замуудыг бодоход нь тусал.

Тэднийг ангийнхаа хүүхдүүдтэй өөрийн бодлоо хуваалцахыг хүс.

Нөгөө хүн эелдэг биш байхад бид өөрсдөө эелдэг байх нь заримдаа хэцүү байдаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд хүн бүр өөрт нь хүмүүс эелдэг хандахыг хүсдэг гэдгийг ойлгоход нь тусал. Хүмүүс эелдэг биш, биднээс өөр байсан ч (жишээ нь, өөр арьсны өнгөтэй эсвэл тахир дутуу), бид тэдэнд эелдэг хандах ёстой.

Гэр бүлдээ эелдэг дотно байдал, хайраа харуулах нь чухал гэдгийг хэл.

- Аавдаа хайраа яаж үзүүлэх вэ? ээждээ? ах эгч нартаа?

Гэр бүлийнхэндээ эелдэг байснаар зөвхөн бидний гэр бүлийнхэн биш мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс бас баярладаг гэдгийг хэл.

Заримдаа жаахан хүүхдүүд бидний юмыг эвдэж гэмтээдэг. Хүүхдүүдэд жаахан хүүхдүүд өөрсдөө юу хийж байгаагаа ойлгож мэддэггүй гэдгийг ойлгоход нь тусал. Бид тэдэнд эелдэг хандах хэрэгтэй бөгөөд уурлах хэрэггүй. Хэрэв бидэнд эвдэрч болох зүйлс байвал тэднийгээ жаахан хүүхдүүд хүрч чадахгүй газарт хадгалах хэрэгтэй.

- Бид Тэнгэрлэг Эцэг ба Есүст өөрсдийн хайраа яаж үзүүлж чадах вэ?

Бид Тэнгэрлэг Эцэг ба Есүст тэдний тушаалуудыг дагаж, сүм дээрээ хүндэтгэлтэй байж, эргэн тойрныхоо хүмүүст эелдэг хандсанаар тэдэнд хайраа үзүүлж чадна гэдгийг хэл.

### **Бид эелдэг үг хэлээр ярьж хайраа үзүүлж чадна**

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээс дараах заавруудыг дагахыг хүс. Хүүхдүүдийг үйлдэл бүрийг хийсний дараа зааврыг дагасанд нь таларх.

1. Босно уу.
2. Доош сууна уу.
3. Босоод дороо эргэнэ үү. Доош сууна уу. Дахин босно уу.
4. Гараа дээш өргөж өндөр сунана уу.
5. Чимээгүй доош сууна уу.

- Би ямар эелдэг үгс хэрэглэсэн бэ?
- Хэн нэгэн чамд “тэгнэ үү ингэнэ үү” гэж нөхөрсгөөр асуух буюу “баярлалаа” гэж хэлэхэд ямар байдаг вэ?

Хүүхдүүдэд хэрэв бид бусдыг өөртэйгөө эелдэг ярихыг хүсч байвал бид тэдэнтэй эелдэг ярих ёстой гэдгийг ойлгоход нь тусал.

Хүүхдүүдэд “Намайг уучлаарай” ба “Намайг өршөөгөөрэй” гэдэг үгсийг ямар нөхцөлд хэлдэг талаар ярилц. Дараах асуултуудыг эсвэл танай ахуй соёлд хэрэглэхэд зохистой төстэй асуултуудыг асуу:

- Ус уухыг хүсэх үед яаж эелдгээр асуух вэ?
- Хэн нэгэн чамд бэлэг өгвөл чи юу гэж хэлэх хэрэгтэй вэ?
- Хэн нэгнийг гомдоовол юу гэж хэлэх вэ?
- Хэн нэгний анхаарлыг татахын тулд эелдгээр юу гэж хэлэх вэ?

Бидэнтэй заримдаа хүмүүс эелдэг бус харьцдаг ч бид хариуд нь эелдгээр харьцах ёстой гэдгийг тайлбарла.

Дуу

Хүүхдүүдтэй “Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” дууг ахин хамтдаа дуул.

Гэрчлэл

Эелдэг байгааг нь анзаарсан хүүхдүүдийг магтан сайшаа. Тэнгэрлэг Эцэг, Есүс хүн бүрт хайртай ба биднийг бие биедээ элэгсэг дотно байхад баярлан талархдаг гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг эелдэг байхыг хүсдэг тухай гэрчлэлээ хуваалц. Хүүхэд бүрт зүрхэн хэлбэртэй хайчилбараа өг. Зүрхэн дүрсэн дээр бичсэн үгийг хүүхдүүдэд уншин өгч, хайраа тэдэнд илэрхийл.

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Дараах жишээнүүдийг уншиж (эсвэл өөрийн зохиосон), хэрэв тухайн үйлдэл эелдэг байдал, хайрыг илэрхийлж байвал зүрхэн дүрсээ өргөхийг хүс. Харин үйлдэл эелдэг бус, хайрыг үзүүлээгүй бол зүрхээ өвдгөн дээрээ тавихыг хүс.

- Тоглоомоороо ээлжилж тоглох.
- Муухай ааштай байх.
- Гомдсон хүүхдэд туслах.
- Уурлуулсан нэгнийг цохих.
- Цуглааны байранд үймүүлэхгүй, хүндэтгэлтэй байх.
- Тэгнэ үү, ингэнэ үү ба “баярлалаа” гэж хэлэх.
- Хэн нэгэнд хаалга онгойлгон барьж өгөх.
- Сүм дээр үймүүлэх.
- Цэвэрлэгээ хийхэд туслах.

Бусдад эелдэг хандсанаар бид хайраа үзүүлж, Тэнгэрлэг Эцэг, Есүс нар бидэнтэй хамт баярладаг гэдгийг хэл.

2. Дээрхтэй төстэй нэлээд хэдэн эелдэг байдал болон хайраа үзүүлэх нөхцлүүдийг бодож ол. Тэдгээрийг цаасан дээр бичиж, хүүхэд бүрээр суглуул. Сугласан хүүхдэд бичсэн нөхцлийг уншиж, тухайн байдалд яах ёстойг хэл. Дараах жишээнүүдийг ашиглаж болно:

- Чи найзтайгаа хамт тоглож байхад өөр хүүхэд ирэхэд чи яах ёстой вэ?
- Чиний тоглож байсан тоглоомоор охин дүү чинь тоглохыг хүсчээ. Чи яах вэ?
- Чиний бяцхан дүү чиний юмыг авчээ. Чи яах вэ?

3. Өөрийн хэсгийн болон орон нутгийн байдалд тохирсон дээрх жишээнүүдтэй төстэй нөхцөлүүдийг жишээ болгон эелдэг байдал, хайраа тахир дутуу хүмүүст хэрхэн үзүүлэхийг олж хэлэлц. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах онцгой аргуудыг бодож олоход нь хүүхдүүдэд тусал.

- Хараагүй хүнд хайраа хэрхэн үзүүлж чадах вэ?
- Сонсголгүй хүнд бид хэрхэн хайраа үзүүлж чадах вэ?
- Тэргэнцэртэй болон таягтай хүнд хайраа хэрхэн үзүүлж чадах вэ?

4. Зарим хүмүүс өөр хэлээр ярьж, өөр арьсны өнгөтэй байдаг боловч бүгд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд гэдгийг ойлгоход нь хүүхдүүдэд тусал. Бид бүгдээрээ бие биедээ эелдэг байх ёстой. Бусад хүмүүс бидэнтэй хэрхэн харьцаасай гэж хүсч байна яг тийм маягаар бид бусадтай харьцах ёстой. Хүн бүр ямар нэгэн байдлаар бие биеэсээ өөр байдаг гэдгийг тайлбарла.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. “Эелдэг байдал надаас эхэлнэ” (*Children’s Songbook*, р. 145) дууг дуулах буюу үгийг хэл.

2. Хүүхдүүдээр дараах үйлдлийг хийлгэ:

Инээд нь түргэн тархдаг (*уруулынхаа хоёр ирмэгийг дээш болго*),  
Бид уйтгартай байхдаа (*уруулынхаа хоёр ирмэгийг уйтгартай болго*),  
Би инээмсэглэхийг хичээдэг (*уруулынхаа хоёр ирмэгийг дээш болго*),  
Би удалгүй баяртай болдог (*хоёр гараа зүрхэн дээрээ тавь*)!  
(Pat Graham-ийн “Feeling Glad,” *Friend*, 1990 он, 3 сар, хуудас 21.)

---

**Зорилго**

Хүүхдүүдэд амьтдад эелдэг байхын чухлыг ойлгоход нь туслах.

---

**Бэлтгэл**

- Залбиралтайгаар Эхлэл 2:19–20; 6–8-ыг уншиж, суралц.
  - Шаардлагатай зүйлс:
    - Ариун Библи.
    - Зураг 1-28, Бүтээлт—Амьд бүтээлүүд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 100; 62483); зураг 1-30, Ноа ба Амьтадтай хөвөгч авдар (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 103; 62305).
  - Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.
- 

**Суралцах үйл  
ажиллагаа**

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийн мэдэх амьтныг дүрслэн үзүүл. Ямар амьтан болохыг хүүхдүүдээр таалга. Хүүхэд бүрээр ямар нэгэн амьтныг дүрслэн үзүүлж, бусдаар нь таалгуул.

**Адам амьтдад нэр өгсөн**

Тэнгэрлэг Эцэг төлөвлөж, Есүс дэлхий дээр загас, шувууд, болон шавьж хорхой хамаг амьтдыг бүтээсэн гэдгийг хэл. Ариун Библи харуулж, судар дээр Адам бүх амьтдад нэр өгсөн гэж бичсэн байдаг гэдгийг тайлбарла (Эхлэл 2:19–20-ийг үз). Зураг 1-28, Бүтээлт—Амьд бүтээлүүд зургийг үзүүл.

- Энэ зурган дээр ямар амьтад байна вэ? (хүүхдүүдээр зурган дээрх амьтныг заан, нэрийг нь хэлүүл.

**Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг амьтдад эелдэг хандахыг хүсдэг**

Түүх

Зураг 1-30, Ноа ба Амьтадтай хөвөгч авдар, зургийг үзүүл. Эхлэл 6–8-д гардаг Ноа ба хөвөгч авдрын тухай түүхийг ярьж өг. Төрөл бүрийн амьтдаас хос хосыг авч үерээс аварсан гэдгийг тодруулан хэл. Тэнгэрлэг Эцэг, Есүс амьтдад хайртай, тэднийг дэлхий дээр байгаасай гэж хүсдэг.

- Ноа амьтдыг яагаад авдарт хийсэн бэ?
- Ноа ямар амьтныг авдарт хийсэнд чи талархдаг вэ?
- Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг амьтдад хэрхэн хандахыг хүсдэг вэ?

Түүх

Сүмийн арван хоёр дахь Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын тухай түүхийг өөрийн үгээр ярьж өг:

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын жаахан хүү байхдаа үнээнүүдийг гэрээсээ нэг километр хагасын зайтай бэлчээр уруу туудаг ажилтай байжээ. Нэгэн өдөр тэр өөртөө чулуугаар хашаа болон модны гол уруу

харвах чавх хийжээ. Чавх нь маш сайн болж, мод болон хашааг холоос онож байв.

Үнээнүүдээ туун явдаг замд нь өндөр моднууд ургадаг байв. Спенсер моднууд дээр олон жижиг шувууд байхыг анзаарчээ. Тэр шувуудыг хараад тэднийг чавхдан онож өөрийгөө мундаг харваач гэдгээ харуулмаар санагджээ. Гэхдээ тэр Хүүхдийн Хэсэг дээрээ дуулдаг дууг санав. Тэр дуунд “Бяцхан шувуудыг бүү ал. . . . Дэлхийн юмс Бурханых, Тэр жижиг, том бүгдийг хоол хүнсээр хангадаг.” Спенсер дуулдаг дууны үгсээ санав. Тэр шувууд Тэнгэрлэг Эцэгт чухал учир тэднийг алах нь буруу гэж боджээ. Тэгээд тэр шувуудыг онохгүйг хичээж болгоомжтойгоор чавхаараа харвадаг байжээ. (Ерөнхий Чуулган, 4-р сар. 1978, хуудас 71; эсхүл *Ensign*, 5-р сар 1978, хуудас 47).

- Спенсер В.Кимбалл шувуудад өөрийн эелдэг байдлаа хэрхэн харуулсан бэ?

Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг бүх амьтдад эелдэг байхыг хүсдэг гэдгийг хүүхдүүдэд хэл.

Дуу

“Эелдэг байдал надаас эхэлдэг” (*Children’s Songbook*, p. 145).

Би хүн бүхэнд эелдэг байхыг хүснэ

Энэ нь зөв гэдгийг мэднэ.

Тиймээс би өөртөө, “Үүнийг сана:

Эелдэг байдал надаас эхэлнэ” гэж хэлдэг.

- Чамд ямар нэгэн тэжээвэр амьтан байгаа юу?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг тэжээвэр амьтныхаа талаар болон тэдэндээ хэрхэн ханддаг талаар ярихыг урь. Дараах өгүүлбэрүүдийг уншиж, хүүхдүүдийг гэрийн амьтадтай эелдэг байгаа тохиолдолд эрхий хуруугаа өргөхийг хүс. Харин эелдэг бус байвал эрхий хуруугаа уруу нь харуул.

- Өдөр бүр тэдэнд сайн хоол өгөх.
- Тэднийг хооллохоо мартаx.
- Тэдэнд ус өгөхөө мартаx.
- Тэдэнд ууж болох цэвэр ус өгөх.
- Тэднийг аюулгүй, тав тухтай унтах газраар хангах.
- Өдөржин халуун газар хорих.
- Тэдэнд анхаарал халамж тавих.

Гэрчлэл

Амьтдыг Есүс бүтээсэн бөгөөд энэ нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг байсан гэдгийг хүүхдүүдэд хэл. Тэнгэрлэг Эцэг, Есүс нар биднийг амьтдад эелдэг байхыг хүсдэг. Өөрийн гэрийн амьтан болон бусад амьтдын тухай сэтгэгдлээ хуваалц.

---

**Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хичээлийн төгсгөлд буй туулайн зургийг хувиран хүүхэд бүрт өгч, будуул. Туулай бүрийн сүүлэн дээр нь бөөрөнхийлсөн хөвөн нааж хөвсгөр сүүлтэй болго.
2. “Миний Тэнгэрлэг Эцэг надад хайртай” (*Children’s Songbook*, р. 228) дууг дуулах буюу үгийг хэл.
3. Хичээл 11-ийн загасны уурга болон гарын авлага дахь амьтдын хайчилбаруудыг ашиглан хүүхдүүдээр амьтдыг “уургаар” бариул. Хүүхэд бүр ямар нэгэн амьтан уургалан авсны дараа тэднээр барьсан амьтныг харуулж, түүний талаар мэддэг зүйлээ хэлэхийг хүс.
4. *Би амьтдад эелдэг байна* гэсэн бичигтэй тэмдэг хүүхэд бүрт хийн зүүж өг. Хүүхдүүд гэр лүүгээ зүүж явж болно.
5. Хүүхдүүдээр дараах хуруун тоглоом тоглуул:

Миний бяцхан муужгай

Миний бяцхан муужгай модон дээр гүйн гарлаа (“гүйн” баруун гарын хуруунуудаараа зүүн гар дээрээ гүйлгэ)

Мөчир дээр суун над руу харлаа (*баруун гараа зүүн мөрөн дээрээ тавь*).

Би түүнд “Наашир, муужгай минь” гэхэд тэр доош гүйн (*хуруугаараа буцаж доош гүй*)

Тэгээд миний тавьсан бүх хоолыг идлээ (*зүүн гараа аяга хэлбэртэй болгож, баруун гараа хоол идэж буй муужгай мэт болго*).

6. Хүүхдүүдийг босгож, дараах үйлдлийг хамтдаа хий:

Ноа

Ноа асар том авдар хийв (*гараа гадагш тэл*);

Тэр зөвхөн юу хийх ёстойгоо л мэдэж байсан (*долоовор хуруугаа чамархайндаа хүргэ*).

Тэр алхаар балбаж, хөрөөдөж, хэмжилт хийж (*эдгээр үйлдлүүдийг хий*)

Түүнд тушаасны дагуу бүгдийг хийв (*толгойгоо дохь*).

Ноа өөрийн гэр бүлээ дуудаж (*гараараа далла*)

Завинд суухаар алхацгаав (*дороо алх*)—

Мөн хос, хос амьтад (*хоёр хуруугаа гозойлго*)

Завины тавцан дээр гарч ирэв (*хоёр гараараа завиар сэлэх хөдөлгөөн хий*).

Хар үүлс гарч (*толгойгоо гараараа тагла*),

Бороо дусалж эхэллээ (*бороо орж буй мэт хуруугаараа хөдөлгө*)—

Дэлхий усаар бүрхэгдэж (*гар хуруугаараа бүрхэж буй хөдөлгөөн хий*);

Хуурай газар үлдсэнгүй (*толгойгоо тал тал тийшээ эргүүл*).

Дахин нар гарч (*толгой дээрээ гараараа тойрог хий*)

Шарж, дулаацуулах хүртэл.

Олон өдөр шөнө (*хоёр гараа толгойн хажуудаа авчир*),

Авдар аюулгүй хөвөв (*гараараа хөвөх хөдөлгөөн хий*)

Бүх ус татарч (*гараараа хүзүүгээ барь*);

Хуурай газар харагдаж эхэллээ (*гараа тэлж, гараа сунга*).

Бурхан үргэлж дэргэд нь байсны төлөө

Ноагийн гэр бүлийнхэн талархлаа илэрхийллээ (*мэхийж, гараа цээжиндээ барь*)


(Beverly Spencer-ийн зохиолыг өөрчлөн ашиглав.)

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдээр өөрсдийнх нь гэрийн тэжээмэл амьтад болон дуртай гэрийн тэжээмэл амьтдынх тухай яриул. Тэдэнтэй хэрхэн гэрийн амьтнаа арчлах тухай ярилц.
2. “Дэлхий маш том” (*Children’s Songbook*, р. 235) дууг дуулах буюу үгийг хэл. Өгүүлэх үгсийн дагуу үйлдлийг хий:
 

Дэлхий маш том өө, дув дугуй (*гараараа том дугуй хий*),  
Энд Бурханы Бүтээлүүд байдаг;  
Уулс (*толгой дээрээ уулын орой хий*)  
Толгод (*алгаа доош харуулан урдаа барь*)  
Өндөр модод (*гараа дээш сунга*),  
Том амьтад (*дээш суна*)  
Мөн жижиг амьтад (*доош бол*).  
Дэлхий маш том өө, дув дугуй (*гараараа том дугуй хий*),  
Бурхан бид бүгдэд нь хайртай, бидний адислал агуу их (*гараа атгаж өөрийгөө тэвэр*).
3. Хэдэн амьтдын хайчилбарыг нэг нэгээр нь ээлжлэн үзүүлж, хүүхдүүдээр тухайн амьтны талаар тэр хаана амьдардаг, ямар дуу авиа гаргадаг, тэд юунд дуртай зэрэг энэ амьтны талаар юу мэддэгийг нь яриул.





# Би сайн үлгэр жишээ болж чадна

Хичээл  
36

---

**Зорилго** Хүүхэд бүрт Есүсийн жишээг дагаж, бусдад үлгэр жишээ болоход нь туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Матай 4:19; Лук 19:1–10; Иохан 13:15; ба 3 Нифай 17:11–24-ийг уншиж, судал.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи ба Мормоны Ном.
  - б. Цаасаар хэдэн ширхэг хөлийн мөр хайчилж бэлтгэ.
  - в. Зураг 1-3, Есүс бол Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572); зураг 1-63, Модон дээрх Закхай; зураг 1-64, Нифайчуудтай залбирч буй Есүс (62542).
3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

“Намайг дагаад хий” (*Children’s Songbook*, р. 276) дууг хүүхдүүдтэй хамт дуулах буюу үгийг хэл. Хүүхдүүдийг гараа эргүүлэх, алга таших, шувуу мэт нисэх зэрэг таны хийсэн хөдөлгөөн бүрийг дагаж хийхийг хүс.

Намайг дуурайгаад;  
Дагаад хийгээрэй,  
Намайг дуурайгаад;  
Дагаад хийгээрэй!  
Дээшээ доошоо болгосон ч,  
Хурдан бас удаан хийсэн ч,  
Намайг дуурайгаад  
Дагаад хийгээрэй!  
Намайг дуурайгаад  
Дагаад хийгээрэй!

(© 1963 by D. C. Heath and Company. Зөвшөөрөлтэйгөөр дахин хэвлэв.)

Хүүхдүүд бүгдээрээ хийсэн хөдөлгөөн бүрийг даган хийхэд тэд таны жишээг дагаж байсан гэдгийг тайлбарла. Бид хэн нэгний үлгэр жишээг дагана гэдэг нь яг л түүний хийснийг хийнэ гэсэн үг. Хүүхдүүдэд Есүс “Намайг дага” (Матай 4:19-ийг үз) гэж хэлсэн гэдгийг хэл.

**Тэнгэрлэг Эцэг бидэнд үлгэр жишээ болгохоор Есүсийг дэлхий рүү илгээсэн**

Зураг 1-3, Есүс бол Христ зургийг үзүүл. Есүс дэлхий рүү ирсний нэг шалтгаан нь бидэнд хэрхэн амьдрахыг үзүүлж, бидний үлгэр жишээ болохоор ирсэн гэдгийг тайлбарла. Есүс төгс төгөлдөр байсан. Энэ нь Тэр бүх зүйлийг зөв хийдэг байсан гэсэн үг. Дэлхий дээр байхдаа Түүний амьдарсан үлгэр жишээгээр бид амьдрахыг хичээх хэрэгтэй.

Ариун Библи нээж Иохан 13:15-ыг хүүхдүүдэд уншиж өг. Хүүхдүүдэд эдгээр нь Есүсийн үгс гэдгийг хэл. Бид Есүстэй адил болж, Түүний жишээг дагахыг хүсдэг гэдгийг онцлон хэл.

Дуу “Би Есүстэй адил болохыг хичээж байна” (*Children’s Songbook*, р. 78) дууны эхний бадгийн дуулах буюу үгсийг хэл.

Би Есүстэй адил болохыг хичээж байна  
Би Түүний замыг дагаж байна  
Өөрийн бүх үйлдэл, үг хэлээрээ  
Би Түүнтэй адил бусдыг хайрлахыг хичээж байна.  
(© 1980 by Janice Karp Perry. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

- Хэрэв бид Есүстэй адил болохыг хүсч байвал ямар зүйлс хийх ёстой вэ?

Түүх Зураг 1-63, Модон дээрх Закхай, зургийг үзүүл. Тэгээд Лук 19:1–10-д гардаг Есүс болон Закхайгийн тухай түүхийг ярьж өг. Есүс Закхайд эелдэг байж, бидэнд үлгэр жишээ үзүүлсэн. Хэдийгээр бусад хүмүүс Закхайд дургүй байсан ч Есүс түүний гэрт очиж, найз нь байхыг хүссэн.

- Есүс Закхайд хэрхэн эелдэг байсан бэ? (Лук 19:5-ыг үз.)
- Есүс түүнд эелдэг байхад Закхайд ямар байсан бол?

Дуу “Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” (*Children’s Songbook*, р. 61) дууг, үйлдлүүдийг хийн дуул эсхүл үгсийг хэл:

Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн (*гараа том дэлгэ*);  
Бас тэдэнд эелдэг ханд гэж хэлсэн (*толгойгоо дохь*).  
Чиний зүрх хайраар дүүрэхэд (*гараа зүрхэн дээрээ тавь*),  
Бусад хүмүүс чамайг хайрлах болно (*өөрийгөө тэвэр*).

Түүх Зураг 1-64, Есүс Нифайчуудтай хамт залбирсан нь, зургийг үзүүл. Тэгээд 3 Нифай 17:11–24-д гардаг Есүс Нифайчуудын хүүхдүүдийн төлөө залбирсан түүхийг ярьж өг. Есүс бидэнд бусдын төлөө залбирах ёстой гэсэн үлгэр жишээг үзүүлсэн гэдгийг тайлбарла.

- Есүс хэний төлөө залбирсан бэ? (3 Нифай 17:21-ийг үз.)
- Есүс тэдний төлөө залбирахад хүүхдүүдэд ямар байсан бол?
- Бид хэний төлөө залбирч болох вэ?

Бид хэний төлөө залбирч болох тухай ярилц. Бид гэр бүл, өвчтэй хүмүүс, номлогчдын төлөө болон болон Сүмийн удирдагчдын төлөө залбирч болно.

Үйл ажиллагаа Зураг 1-63, Модон дээрх Закхай, мөн зураг 1-64, Есүс Нифайчуудтай хамт залбирсан нь, зурагнуудыг өрөөний өөр өөр буланд тавьж, зураг бүр уруу хүрэх хөлийн мөртэй хайчилбарыг шалан дээр байрлуул. Хүүхдүүд “Би Есүстэй адил болохыг хичээнэ” дууны эхний бадгийг дуулах буюу үгийг хэлэн хөлний мөрийг даган явна.

Зурган дээр очин түүн дээр гарч буй түүхийг мэдэх хэмжээгээрээ ярих. Хүүхдүүдэд түүх бүр дээр гарах Есүсийн жишээг дагахыг хичээх талаар бодохыг хүс. Жишээ нь, тэд тоглоомоо хэн нэгэнтэй хуваалцаж, найз хэрэгтэй хэн нэгэнтэй хамт тоглох (Закхай), мөн тэд өвчтэй байгаа болон

онцгой тусламж хэрэгтэй хэн нэгний төлөө залбирах (Нифайчуудын хүүхдүүдийн төлөө залбирсан нь).

Тэд хүмүүстэй эелдэг байж, тэдний төлөө залбиран хайраа үзүүлэх нь хүүхдүүд Есүсийн жишээг дагаж байна гэсэн үг гэдгийг ойлгоход нь тусал.

Дуу

“Би Есүстэй адил болохыг хичээнэ” (*Children’s Songbook*, p. 78) дууны дахилтыг үйлдлийг хийн дуулах буюу үгийг хэл:

Есүс чамайг хайрладаг шиг бие биеэ хайрла (өөрийгөө тэвэр).

Хийж байгаа бүх зүйлдээ эелдэг ханд (хүнтэй гар барь).

Бодол, үйлсээрээ хайрлаж, нөхөрсөг бай (нэг гараа амьтан мэт болгож нөгөө гараа түүнийг энхрийл),

Эдгээр зүйлсийг Есүс бидэнд заасан (гарын алгануудаа нийлүүлэн, судар ном мэт болго).

(© 1980 by Janice Karp Perry. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

### **Бид бусдад сайн үлгэр жишээ байж чадна**

Хүүхдүүд Есүсийн жишээг дагаж байгаа шиг бусад хүмүүс тэднийг харан бас дагах болно гэдгийг тайлбарла.

Үйл ажиллагаа

Нэг хүүхдийг ангийн өмнө гаргаж удирдагч болохыг хүс. Түүнийг ангиа удирдан алгаа таших, дороо эргэх, үсрэх зэрэг хөдөлгөөнүүдийг хийхийг хүс. Хүүхэд бүрт удирдагч байх боломжийг олго.

Биеийн хөдөлгөөнийг дагахаас илүү өөр олон чухал дагах ёстой үлгэр жишээнүүд байдаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд тэд үнэнч байх, ээж аавынхаа үгэнд орох, тоглоомоо бусадтай хуваалцах, сүм дээр хүндэтгэлтэй байх, гэр бүлдээ туслах зэрэг сайн үйлс хийснээр сайн үлгэр жишээ байж чадна гэдгийг хэл.

- Бусдад сайн үлгэр жишээ байхын тул юу хийж болох вэ?

Хүүхэд бүрийг түүний хийж чадах сайн үлгэр жишээний тухай бодож, ангийнхандаа хэлэхийг хүс.

Гэрчлэл

Хэн нэгний сайн жишээг дагаж байсан тухай өөрийн тохиолдлоо ярь. Есүсийн жишээг дагахын чухлын талаар гэрчлэлээ хуваалц. Хүүхдүүдийг Есүс байсан бол хийх байсан зүйлсийг хийж, бусдад сайн үлгэр жишээ болохыг зоригжуулан дэмж.

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхэд бүрт энгийн титэм болон малгай цаасаар хийж өг. Тэгээд титэм болон малгайн дээрээ *Би сайн үлгэр жишээ байж чадна* гэж бич. Долоо хоногийн турш сайн үлгэр жишээ байж болох замуудын талаар тэдэнтэй ярилц.
2. Гар чийдэнгийн юм уу өөр нэгэн жижиг гэрэл харуул. Гар чийдэнгийн гэрлийг асааж энэ гэрэл хүмүүст хэрхэн тусалж байгаа талаар ярилц. 3 Нифай 12:16-ийн эхний өгүүлбэрийг чангаар унш. Хүүхдүүдэд тэд сайн үлгэр жишээ болоход яг л энэ жижигхэн гэрэл шиг байдаг. Учир

нь бусад хүмүүс тэднийг дагадаг гэдгийг тайлбарла. Нэг хүүхдээр гар чийдэнг бариулж, анги дотор бусдыг дагуулан явахыг хүс. Хүссэн хүүхэд бүрт удирдан явах боломжийг олго.

3. Хүүхдүүдийг бүгд босч дараах үйлдлийг хийхийг хүс:

Есүс бяцхан хүүхдүүдэд хайртай

Зарим хүүхдүүд шороотой зам уруудан гүйнэ (*дороо гүй*),  
Өөрсдийн жижиг хөлөөр хурдан гүйнэ (*хөлөө заа*),  
Олны дунд байраа олохоор (*олны дунд түлхэлцэн буй үйлдэл хий*)  
Есүстэй ойр очиж Түүний царайг харахаар (*өлмий дээрээ зогсон эргэн тойрныг хар*).

Зарим томчууд “Тэднийг холдуул” (*гараараа “зогс” гэх мэт бол*).

“Тэр өнөөдөр хүүхдүүдтэй уулзах завгүй байна” гэж хэлнэ (*хөмсөгөө зангидан толгойгоо сэгсэр*).

Харин Есүс, “Тэднийг над дээр авчир” гээд (*гар, толгойгоо дохь*).

“Тэд надад чухал би тэдэнд хайртай” гэж хэлнэ (*өөрийгөө тэвэр*).

(Adapted from Margareta Harmon in *Bible Story Finger Plays and Action Rhymes* [Cincinnati: Standard Publishing, 1964], p. 27.)

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдэд *үлгэр жишээ* гэдэг үгийг давтан хэлж, юу гэсэн үг болохыг асуу. Тэдэнд сайн үлгэр жишээ гэдэг нь том болоод яг түүн шиг байхыг хүсэх хэн нэгэн гэдгийг хэл. Эцэг эхчүүд маань бидний үлгэр жишээ байж болно. Хүүхдүүдийг эх эцгүүд нь тэднийг арчлан халамжилж, тэднийг аз жаргалтай болгохын тулд хийдэг зүйлсийг нэрлэн хэлэхийг хүс.
2. “Удирдагчийг дага” тоглоомыг хүүхдүүдтэй хамт тогло. Хүүхдүүд босч эгнэн зогсоно. Эхний хүүхэд гүйх, цовхцох, үсрэх зэрэг янз бүрийн ямар нэгэн хөдөлгөөн хийгээд өрөөний эсрэг талд очно. Бусад нь түүнийг даган хийцгээнэ. Эхний хүүхэд эгнээний сүүлд очиж, дараагийн хүүхэд шинэ удирдагч болно. Хүүхэд бүрийг удирдагч болтол үргэлжлүүл.

---

**Зорилго**

Хүүхэд бүрийн үнэнч шударга байх гэсэн хүслийг хүчирхэгжүүлэх.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Египетээс гарсан нь 20:15–16; Алма 53:16–22; 56:44–57; ба Итгэлийн Тунхаг 1:13. Мөн *Сургаалын Зарчмууд* (31110), бүлэг 31-ийг үз.
  2. Цаасаар юмуу даавуугаар хүүхэд бүрт энгийн толгойн боолт хий. Толгойн боолт бүр дээр *Би шударга байна* гэж бич.
  3. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи болон Мормоны Ном.
    - б. Товч эсвэл өөр жижиг зүйл.
    - в. Зураг 1-13, Иосеф Смит (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 400; 62449); зураг 1-65, Хоёр мянган залуу дайчид (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 313; 62050).
  4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ
- 

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Нэг хүүхдийг ангийн өмнө урин гарга. Алгандаа товч буюу өөр жижиг зүйл хийж барь. Бусад хүүхдүүдийг мөн алгаа нийлүүлэн барихыг хүс. Хүүхэд бүр дээр очиж, өөрийн гараа тэдний гар дундуур өнгөрүүл. Нэг хүүхдийн гарт товчоо орхи. Хүүхэд бүр алгаа нийлүүлэн барьсан хэвээр байгаа мэт байлга. Тэгээд “Товч, товч хэнд товч байна?” гэж хэл. Ангийн өмнө гарсан хүүхэд “(Нэр), чамд товч байна уу?” гэж хэлэн хэнд товч байгааг таана. Хүүхдүүд үнэнчээр “Үгүй, надад товч байхгүй” эсвэл “Тийм, надад товч байна” гэж хэлэхийг хүс.

Өөр өөр хүүхэд ээлжлэн урьж, хэнд товч байгааг таах тоглоомыг тогло. Хүүхдүүдийг үнэнч байгаад таларх.

**Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг үнэнч шударга байхыг хүсдэг**

Зураг 1-13, Иосеф Смит үзүүл. Хүүхдүүдэд Бошиглогч Иосеф Смит “Бид шударга байхад итгэдэг” гэж итгэлийн тунхагийн арвангуравт хэлснийг хэл. Хүүхдүүдэд үүнийг цээжлүүл.

- Шударга байна гэдэг юу гэсэн үг вэ?

Шударга байна гэдэг нь үнэнийг хэлдэг, бусдын юмыг хэлэхгүйгээр авдаггүй, бусдыг ялгалгүй харьцдаг байхыг хэлж буй гэдгийг тайлбарла.

Ариун Библи харуулан, хүүхдүүдэд Мосе өөрийн ард түмэндээ Арван Хуулийг өгсөн гэдгийг хэл (Египетээс гарсан нь 20). Тэнгэрлэг Эцэг, Есүс нь Мосед шударга ёсны тухай хоёр тушаалыг өгсөн: “Чи бүү хулгайл” ба

“Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил.” Египетээс гарсан нь 20:15–16 -г чанга дуугаар унш.

- Хулгайлах гэдэг юу гэсэн үг вэ?

Худал гэрчлэл гэдэг нь худал хэлэхийг хэлнэ гэдгийг тайлбарла.

Дуу

“Би шударга ёсонд итгэдэг” (*Children’s Songbook*, р. 149) дууны эхний бадгийг дуулах буюу үгийг хэл.

Би шударга байхад итгэдэг;  
Би үнэнч байхад итгэдэг,  
Хэлж буй үгсээр, хийж буй үйлээр  
Шударга байдал надаас эхэлнэ.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдэд зарим үйлдлийг хэлж өг. Тэдний үйлдэл шударга байвал босч, харин шударга бус бол суухыг хүс. Доорх жишээг ашигла эсвэл өөрөө зохио:

- Ээжийгээ битгий ав гэж сануулсан байхад идэх юм авах.
- Өөрийн хийсэн зүйлээ үнэнээр хэлэх.
- Бусдын юмыг хэлэлгүй авах.
- Буруу зүйл хийснээ хүлээн зөвшөөрөх.
- Өөрийн хийсэн буруу зүйлийг бусад руу чихэх.
- Мөнгө юм уу бусад ямар нэгэн зүйлийг олоод эзэнд нь буцааж өгөх.

Хүүхдүүдийг шударга байсан туршлагаасаа ярихыг хүс.

- Шударга байхад ямар санагддаг вэ?
- Шударга бус байхад чамд ямар байдаг вэ?
- Заримдаа шударга байхаас яагаад айдаг вэ? (Шийтгүүлэхээс эсвэл хэн нэгнийг аз жаргалгүй болгохоос айх)

Хэдий заримдаа энэ нь хэцүү ч шударга байхад бидэнд сайхан байдаг гэдгийг ойлгоход нь тусал.

### **Бид шударга байснаар адислагдана**

Түүх

Зураг 1-65, Хоёр мянган залуу дайчид зургийг үзүүл. Алма 53:16–22 ба 56:44–57, ялангуяа Алма 53:20–21-д гардаг хоёр мянган залуу дайчдын тухай түүхийг ярьж өг. Эдгээр залуу дайчид шилдэг байсан шалтгаан нь тэд шударга үнэнч байсан гэдгийг тайлбарла. Алма 53:20-ийг чангаар унш (цаг ямагт үнэнч эрс байлаа гэдгээс). Үнэнч байна гэдэг нь шударга байна гэсэн үг гэдгийг тайлбарла. Эдгээр залуу дайчид үнэнч байсан тул тэд дайны туршид хамгаалагдсан. Тэд өөрсдийн шударга байдал, итгэл, зоригийн төлөө адислагдсан. Хэрэв бид шударга байвал мөн адислагдах болно.

- Залуу дайчид үнэнч байснаар хэрхэн адислагдсан бэ? (Алма 56:54–56-г үз.)

Үйл ажиллагаа	Хүүхдүүдэд толгойн боолтыг өмсгө. Тэднийг хоёр мянган залуу дайчид хэмээн өөрсдийгөө төсөөлөн өрөөгөөр алга ташилтын хэмнэлээр маршлан алхахыг урь. Алгаа ташихаа болиход тэд зогсож, хэрхэн шударга байж чадахыг хэлэхийг хүс. Дахин алгаа ташиж, хүүхэд бүрийг асуултанд хариулах боломжтой болтол үргэлжлүүл.
Гэрчлэл	Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг шударга байхыг хүсдэг бөгөөд бид шударга байснаар аз жаргалтай байдаг тухай гэрчлэлээ хуваалц.

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

#### 1. Иаков Хамблины тухай дараах түүхийг ярьж өг:

Иаков Хамблин нь өмнөд Юта руу нүүсэн анхдагчдын нэг байжээ. Тэр тухайн нутагт амьдардаг Индианчуудад хайртай байсан ба тэдний хэлийг мэддэг байв. Тэр Индианчуудтай үргэлж шударга байсан тул тэд түүнд итгэдэг байв. Нэгэн өдөр Иаков өөрийн хүүгээ одой морио Индианчуудын хөнжилнүүдээр солилцох худалдаа хийлгэхээр явуулжээ. Индиан одой морийг хараад бөөн овоолгоотой хөнжил өгөв. Иаков хүү “Хангалттай биш” хэмээн хэлэхэд Индиан овоолго дээр хөнжил нэмсээр байв. Иаковын хүү өөрөө одоо хангалттай гэж үзсэн үедээ, одой мориороо сольж авсан зүйлдээ бахархалтайгаар гэрийн зүг давхин явав. Иаков хүүгийнхээ авчирсан хөнжилнүүдийг хараад баярласангүй. Одой морь ийм их хөнжил хүрэх учиргүй байв. Иаков хүүгээ Индианд хөнжлүүдийг буцааж өгүүлэхээр явуулав. Хүү хөнжлүүдийг аван буцаж ирэхэд, Индиан инээд алдан, “Иаков чамайг буцааж явуулна гэдгийг би мэдэж байсан юм” хэмээн хэлжээ. (Jacob Hamblin Jr., Louise Lee Udall, in *A Story to Tell* [Salt Lake City: Deseret Book Co., 1945], 359–60).

Индиан, Иаков Хамблиныг шударга хүн илүү хөнжлүүдийг эргүүлэн өгнө гэдгийг мэдэж байсан гэдгийг тайлбарла. Индиан Иаковыг үргэлж шударга байсан тул түүнд итгэдэг байв. Хүүхдүүдээр түүхийг эргэн ярих эсвэл жүжигчлэн үзүүлэхийг хүс.

#### 2. Оймс болон цаасан уутыг гартаа угладаг хүүхэлдэй болгон ашиглаж шударга байдал болон шударга бус хоёрын хооронд сонголт хийх үйлдэл хий. Өөрийн зохиосон болон доорх жишээнүүдийг хэрэглэ:

- Чи аяга хагалжээ, хэн хагалсныг ээж чинь асуухад.
- Газарт унасан мөнгөнүүдээ түүхэд нь тусалж байх үедээ заримыг нь өөртөө үлдээхийг чи хүсвэл.
- Аавыгаа болохгүй гэж хэлээд байхад хоёр жигнэмэг илүү иджээ. Аав чинь жигнэмэг идсэн эсэхийг чамаас асуухад.

Хүүхэд бүрээр хүүхэлдэйг гарт нь углуулан дээрх нөхцөлүүдэд яах ёстойг хэлүүл.



---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдээс ангид морь байгаа эсэхийг асуу. Хэчнээн сайн эрээд ч тэд ангид морь олохгүй учир нь ангид тэр байхгүй. Ангид морь байна гэж хэлбэл шударга бус болно. Тэднээс (хүүхдүүд амархан харж болох зүйлээс нэрлэ) харж байгаа эсэхийг асуу. Нэрлэсэн зүйлс ангид байна гэдгийг хэлэх нь шударга гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд үнэн бөгөөд бодит зүйлийг хэлэх нь шударга явдал гэдгийг хэл.
2. Үнэн зүйлийг хэлэхэд хоёр гараа өргөж, худал зүйл хэлэхэд хоёр гараа буулгахыг хүс. Энгийн бөгөөд тодорхой “Миний үсэнд цэцэг хатгаастай байна,” “Би даашинз өмссөн байна,” “Жон улаан өмд өмсчээ” эсвэл “Та нар сандал дээр сууж байна” зэрэг зүйлсийг хэл.

---

**Зорилго**

Хүндэтгэлтэй байж Тэнгэрлэг Эцэг, Есүст хайраа үзүүлэхэд туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Египетээс гарсан нь 3:1–10-ыг уншиж, суралц.
  2. Шаардлагатай зүйлс:
    - а. Ариун Библи
    - б. Зураг 1-19, Христ ба Хүүхдүүд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 216; 62467); зураг 1-66, Мосе ба шатаж буй бут (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 107; 62239); зураг 1-67, Хүндэтгэлтэй анги.
  3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.
- 

**Суралцах үйл ажиллагаа**

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг гараа нугалан чимээгүй сууж “Хүндэтгэлтэйгээр, намуухнаар” (*Children’s Songbook*, р. 26) дууг намуун дуугаар дуулах буюу үгийг хэлэхийг хүс. Хэрэв хүүхэд дууны үгийг мэддэг бол тэднээр дуулуул.

Таны тухай бид хүндэтгэлтэйгээр, намуухнаар, хайрлан санан бодож байна;

Хүндэтгэлтэйгээр, намуухнаар, зөөлөн бидний аяг дуулаач.

Таны Ариун Сүнс өнөөдөр бидний зүрх сэтгэлд байг хэмээн

Хүндэтгэлтэйгээр, намуухнаар, дуулгавартайгаар бид залбирч байна,

Дуулж дуусаад хүүхдүүдийг томоотой суусанд таларх.

**Бид Сүм дээр хүндэтгэлтэй байж чадна**

Зураг 1-67, Хүндэтгэлтэй анги, зургийг үзүүл.

- Эдгээр хүүхдүүд хаана байна вэ?
- Тэд юу хийж байна вэ?
- Тэд юун тухай бодож байна гэж та нар бодож байна?
- Хүүхдийн ангид ирээд ямар байх ёстой вэ?

Бид сүм дээр тодорхой байдлаар биеэ авч явах ёстой гэдгийг тайлбарла. Үүнийг хүндэтгэлтэй байх гэдэг.

Хүүхдүүдээр *хүндэтгэлтэй байх* гэж хэд хэдэн удаа давтан хэлүүл.

- Хүндэтгэлтэй байх гэдэг юу гэсэн үг вэ?

Хүндэтгэлтэй байна гэдэг нь Тэнгэрлэг Эцэг, Есүс нарыг хүндэтгэн, өөрсдийн хайрыг үзүүлэх зүйлсийг хийхийг хэлдэг гэдгийг тайлбарла. Бид хай-

раа дараах замуудаар харуулж болно (таныг ярьж байхад заримыг нь хүүхдүүдийг дүрслэн үзүүлэхийг хүс):

- Чимээгүй алхаж, зөөлөн ярих.
- Томоотой сууж залбирал, хичээлээ сонсох.
- Ямар нэгэн зүйл хэлэхийг хүсвэл гараа өргөх.
- Гараа нугалан суух.
- Цуглааны байрыг цэвэр байлгах.

Бид эдгээр зүйлсийг хийхэд Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг Тэдэнд хайртай бөгөөд бид сүм дээрээ баяртай байдаг гэдгийг мэддэг.

Дуу

Хүүхдүүдтэй хамт “Би хүндэтгэлтэй байхыг хүснэ” (*Children’s Songbook*, р. 28) дууг дуулах буюу үгийг хэл. Хүссэнээрээ давтан дуул.

Тандаа хайраа харуулахаар  
Би хүндэтгэлтэй байхыг хүснэ,  
Би чимээгүй сонсох болно,  
Надаас хүндэтгэл эхэлнэ.

- Яагаад бид Хүүхдийн ангид хүндэтгэлтэй байх ёстой вэ?

Бид хүндэтгэлтэй байснаар багшийнхаа зааж буй хичээлийг сонсож, Тэнгэрлэг Эцэг ба Есүсийн талаар суралцаж чадна. Бид хүндэтгэлтэй байснаараа бусдад мөн хүндэтгэлтэй байхад нь тусалдаг.

- Одоо бид ямар байранд байна вэ?
- Энэ хэний байр вэ?

Цуглааны байрууд нь Тэнгэрлэг Эцэг, Есүсийнх гэдгийг тайлбарла. Энэ нь Тэдний талаар болон Тэд биднийг ямар байхыг хүсдэг талаар суралцах газар.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдтэй хамт дараах хуруун тоглоомыг тогло. Цуглааны байрын зарим хэсгийг гараараа үзүүл.

Цуглааны Байр

Эдгээр нь сайхан байшингийн хана;

Энэ өндөр шовх орой нь.

Эдгээр нь гэрэл оруулах цонх

Бүгдэд онгорхой хаалга.

Энэ байр Бурханд хайртай хүмүүсээр баригдсан

Гараа нугалан, толгойгоо бөхийлгөн (*гараа нугалан, толгойгоо бөхийлгө*),

Дуулж залбирал хэлэх газар

Өнөөдөр энэ байранд талархлаа хэлье.

- Цуглааны байруудад юу хийх ёстой вэ?
- Цуглааны байруудад юу хийх ёсгүй вэ?

Цуглааны байруудын зарим хэсэгт зарим цагт гүйж, тоглож харайх үе байдаг ч Ням гарагийн ихэнх цагт цуглааны байранд хүндэтгэлтэй байх

ёстой гэдгийг ойлгоход нь тусал. Бид Хүүхдийн анги, ариун ёслол дээр чимээгүй суухаас гадна байрны хонгилоор явахдаа мөн чимээгүй ярьж, явах ёстой гэдгийг хэлж өг.

Түүх

Хүүхдийн ангид ирж байгаа хүүхдүүдийн тухай түүхийг ярьж өг. Тэд гэрээсээ сүм рүү ирэх замдаа сэтгэл нь хөдлөн баярлаж, үсэрч цовхчин байдаг. Байранд орж ирээд дотор нь ороход чимээгүй хүндэтгэлтэйгээр ярьж, алхаж Ариун ёслол болон Хүүхдийн ангийн хичээлүүдийн үед мөн дараа нь хичээл тарж хонгилоор явах үедээ ч хүндэтгэлтэй, намуухан томоотой байх талаар ярь. Сүм дээр ирсэн хүүхдүүд хэрхэн хүндэтгэлтэй байх талаар тодотгон хэл.

Үйл ажиллагаа

“Жаргалтай хоёр хөл” (*Children’s Songbook*, р. 270) дууны үгийг хэл. Хүүхдүүд өрөөгөөр чимээгүй, томоотой алхах үед тэдний гутал нь ямар нэгэн дуу чимээ гаргах ёсгүй.

Намайг хүрэх газарт минь аваачдаг  
Жаргалтай жижигхэн хоёр хөл надад бий  
Тэд намайг үсэргэж, алхуулж,  
Мөн чимээ гаргадгийг би мэднэ.  
Гэхдээ Тэнгэрлэг Эцэгийн минь гэрт  
Тэд маш чимээгүй алхдаг болдог  
Тиймээс, миний жижигхэн хөлийн  
Явж байгааг та нар сонсдоггүй.

- Сүмийн хонгилоор явахдаа чиний хөл ямар байх ёстой вэ? ариун ёслолын танхимд? ангид?
- Гар чинь ямар байх ёстой вэ?
- Өөрийн дуу хоолойгоо ямар байлгах ёстой вэ?

### **Бид хүндэтгэлтэй байх мэдрэмжийг авч чадна**

Зураг 1-19, Христ ба Хүүхдүүд, зургийг үзүүлж Есүс Христийн тухай бодоход ямар сэтгэгдэл төрдөг, Тэр бидэнд ямар их хайртайг хэл. Эдгээр мэдрэмж нь хүндэтгэлтэй байх мэдрэмжүүд ном гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг Есүсийн талаарх мэдрэмжээсээ хуваалцахыг хүс.

Түүх

Зураг 1-66, Мосе ба шатаж буй бут, зургийг үзүүлж, Египетээс гарсан нь 3:1–10-т буй түүхийг ярьж өг. Их Эзэн Мосетэй шатаж буй бутан дундаас ярьж, түүнийг Израилын хүүхдүүдийг Египетээс удирдан гаргахаар дуудах үед тэр маш их хүндэтгэлтэй байсан гэдгийг хэл. Ариун Библиэс чанга дуугаар уншиж, шүлэг 5-ын: “Чиний зогсож байгаа газар бол ариун газар учраас чи хөлөөсөө шаахайгаа тайл” гэсэн хэсгийг тайлбарлаж өг.

- Мосе яагаад шаахайгаа тайлсан бэ?

Энэ нь хүндэтгэлтэй байх нэг арга зам байсан гэдгийг тайлбарла. Бид хүндэтгэлтэй байхын тул гутлаа тайлах шаардлагагүй гэдгийг хүүхдүүдэд ойлгоход нь тусал. Бидэнд хүндэтгэлтэй байх өөр олон арга замууд бий.

- Хэрхэн хүндэтгэлтэй байх вэ?

## Бид гэртээ хүндэтгэлтэй байж чадна

Цуглааны байр нь хүндэтгэлтэй байх ганц газар биш гэдгийг хүүхдүүдэд хэл.

- Хэн нэгэн гэрт залбирал хийж байхад бид ямар байх ёстой вэ?
- Гэр бүлийн үдшийн үед бид гэртээ ямар байх ёстой вэ?

Гэртээ бид хичээл заах, залбирал хэлэх үед чимээгүй сонсож хүндэтгэлтэй байж чадна гэдгийг тайлбарла. Үүгээрээ бид Тэнгэрлэг Эцэг, Есүст хайртайгаа харуулдаг.

Гэрчлэл

Тэнгэрлэг Эцэг, Есүст хайр хүндэтгэлтэй байснаар хайр, хүндэтгэлээ харуулж болох боломжиндоо талархалтай байгаагаа хуваалц. Хүүхдүүдийг хайр хүндэтгэлээ Тэнгэрлэг Эцэг, Есүст Хүүхдийн ангидаа, Ариун Ёслолд, залбирлын үед, гэр бүлийн үдшийн үед гэртээ хүндэтгэлтэй байснаар харуулахад нь зоригжуулан дэмж.

---

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагаагаа дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Цуглааны байрын хонгилоор хүүхдүүдийг хүндэтгэлтэйгээр чимээгүй явуул. Хэрэв боломжтой бол бол ариун ёслолын өрөөнд оруул. Ангидаа буцаж ирээд хүүхдүүдийг хүндэтгэлтэй байсанд нь магтан сайшаа. Ийм байснаар тэд бусдад өөрсдийн ангиудад хүндэтгэлтэй байхад нь хэрхэн тусалсан талаар хэл.
2. Хүүхэд бүрийн хөлийн хэвийг цаасан дээр буулгаж, “Жаргалтай хоёр хөл” гэж бич (хуудас 161-г хар). Хүүхэд бүрээр уг хэвийг будуулж гэрт нь өгч явуул.
3. Хүүхэд бүрээр ангидаа гараа нугалан, чимээгүй сууж, юм хэлэхийг хүсэх үедээ гараа өргөн асуух үйлдлүүдийг хийлгэ. Тэнгэрлэг Эцэгийн гэрт бид яагаад хүндэтгэлтэй байх ёстой талаар ярилц.
4. Дараах шүлгийн нэг юм уу хоёр бадгийг хүүхдүүдийг хэлэхэд нь тусал. Хэлж байгаа үгийн үйлдлийг хий.

Нээ, Хаа [Гар]

Гараа нээ, гараа хаа;  
Гараа нээ, гараа хаа;  
Одоо алгаа ташаарай.  
Гараа нээ, гараа хаа;  
Гараа нээ, гараа хаа;  
Алгаа нийлүүлээрэй.

Би гараа сэгсэрч байна  
Би гараа сэгсэрч байна  
Би хоёр гараа мушгиж байна  
Би алгаа ташиж байна  
Би гараа өргөж байна,  
Одоо доош нь болгож байна  
Алгаа нийлүүлээрэй

Би номхон зогсож байна  
Би хөлөө амрааж байна  
Би суудал дээрээ тэгш сууж байна  
Би толгойгоо бөхийлгөж байна  
Би нүдээ аньж байна  
Би одоо залбирал хэлэхэд бэлэн боллоо.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдийг нүдээ анихыг урь. Шалан дээр задгай мөнгө юм уу товч унагахыг сонссон хүүхдүүдийг гараа дээш өргөхийг хүс. Задгай мөнгө юм уу товчоо шалан дээр юм уу ширээн дээр унагаа. Дараа нь товч юм уу задгай мөнгөө даавуунд ороо. Хүүхдүүдийг нүдээ анисан хэвээр байхыг хүс. Тэгээд зөөлөн даавуунд боосон товч юм уу задгай мөнгөө унагаж тэднийг анхааралтайгаар сайн сонсохыг хүсч, тэд ямар нэгэн чимээ сонсож байгаа эсэхийг асуу. Хэрэв бид сайн сонсох юм бол олон зүйлс сонсогдоно гэдгийг ойлгоход нь тусал.

# Хөгжим намайг жаргалтай болгодог

---

## Зорилго

Хүүхэд бүрт сайхан хөгжим биднийг аз жаргалтай болгож, Тэнгэрлэг Эцэг, Есүсийг санахад тусалдаг гэдгийг ойлгоход нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар 1 Самуел 16:19–23; Ифер 6:2–12; ба Сургаал ба Гэрээ 25:12-ыг уншиж, суралц.

2. Шаардлагатай зүйлс:

а. Ариун Библи, Мормоны Ном, СбаГ.

б. Зураг 1-61, Наувугаас дүрвэсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 410; 62493); зураг 1-68, Давид Саул хааны төлөө тоглосон нь; зураг 1-69, Жаредын усан онгоц.

3. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

Багшид анхааруулах нь: Хүүхдийн ангийн хөгжмийн багшийг энэ хичээлд оролцоход урьж болно.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг тойрог болгон зогсоож, “Хэрвээ сайхан амьдарч байвал” (*Children’s Songbook*, р. 266) дууны хэд хэдэн удаа “алгаа таш” “хөлөө товш” ба “нүдээ ань” зэрэг үгсийг хэлэн дуул. Дууны үгийн дагуу үйлдлийг хий.

Хэрвээ сайхан амьдарч байвал алгаа таш,  
Хэрвээ сайхан амьдарч байвал алгаа таш  
Хэрвээ сайхан амьдарч байвал,  
Бие бие рүүгээ инэмсэглээд.  
Хэрвээ сайхан амьдарч байвал алгаа таш.

- Энэ дууг дуулах үед чамд ямар байсан бэ?

### Сайхан хөгжим биднийг жаргалтай болоход тусалдаг

Баяр хөөртэй, сайхан эсвэл амар амгалан хөгжим бидний сэтгэл санааг сайхан болгодог. Бид уйтгартай, ууртай эсвэл айсан байхад сайхан хөгжим биднийг эргэн жаргалтай болгодог.

Түүх

Зураг 1-68, Давид Саул хааны төлөө тоглосон нь, зургийг үзүүл. 1 Самуел 16:19–23-д гардаг Давид Саул хааныг сэтгэлээр унасан үед босоо ятгаар тоглодог байсан түүхийг ярьж өг.

- Яагаад Давидын хөгжим хаан Саулын сэтгэлийг засдаг байсан бэ?
- Та нар ямар хөгжмийн зэмсгээр тоглохыг сонсох дуртай вэ?

Дор нэрлэгдэх хөгжмийн зэмсгийг дүрслэн харуул.

Үйл ажиллагаа Таныг Хүүхдийн Хэсгийн дуу эсвэл сүмийн танил дууг аялах зуур хүүхэд бүрийг төгөлдөр хуур, хийл, гитар, лимбэ болон босоо ятга зэрэг хөгжмийн зэмсгүүдээр тоглож байгаа мэт болохыг урь.

Дуу Дуу дуулах нь биднийг жаргалтай болгодог гэдгийг тайлбарла.  
“Жаргалтай дуу” (*Children’s Songbook*, р. 264) дууг дуулах буюу үгийг хэлж үйлдлийг хий :

Усан сан дахь нугаснууд баяртайгаар гуаглаж (*эрхий болон бусад хуруунуудаа нээж хаа*).

Өдрийн турш ээж тахианууд донгодно (*гараараа далавч хий*).

Шувууд өөрсдийн үүрэндээ (*үүр хий*) модны орой дахь салхи (*гараа толгой дээрээ авч, салхи үлээх мэт найган ганх*)

Энэ бүхэн нийлж аз жаргалын дууг бий болгоно.

(© 1963 by D. C. Heath and Company. Зөвшөөрөлтэйгөөр ашиглав.)

- Та нар хүүхдийн Хэсгийн ямар дуунд дуртай вэ?

Дуу Хүүхдүүдээр дуртай дууг нь сонгуулж хамтдаа дуул.

Түүх Зураг 1-61, Наувугаас дүрвэсэн нь, зургийг үзүүлж өөрийн үгээр дараах түүхийг ярьж өг:

Анхдагчид Науву дахь орон гэрээ орхин баруун зүгт нүүхэд өөрсдийн гар тэргэнцэр болон тээшиндээ багтах зүйлсийг л авч явжээ. Тэд олон зүйлсийг ардаа орхих шаардлагатай байлаа. Учир нь авч явах зай байсангүй. Аялал маш хүнд хэцүү байлаа. Анхдагчид орой болоход маш их ядарсан байдаг байв.

Орой болоход тэд өөрсдийн мал, гар тэргэнцрүүдээ тойруулан нийлүүлж, том тойргийн голд түүдэг асаадаг байлаа. Бошиглогч Бригам Янг хэрэв хүмүүс дуу хөгжимтэй байвал аялал нь илүү баяртай болно гэж мэдэж байлаа. Тэр тэднийг дуулж бүжиглэхийг дэмждэг байв. Анхдагчид хийл бөмбөр, бүрээгээр тоглодог байв. Хүн бүхэн түүдэг галаа тойрон дуу дуулж, бүжиглэдэг байлаа. Тэдний дуртай дууны нэг нь “Ирцгээ, ирцгээ Гэгээнтнүүдээ”. Уг хөгжим анхдагчдад урам зориг, эрч хүчийг өгдөг байв. Тэд дуулж бүжиглэснийхээ дараа жаргалтайгаар орондоо ордог байлаа.

Дуу Хүүхдүүдийг анхдагчид шиг тойрон суулга. Хүүхдийн Хэсгийн дуртай дуунаас нь тэдэнтэй хамтдаа дуул.

### **Хөгжим бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүсийг санахад тусалдаг**

Сүмийн хөгжим бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүсийг дурсан санахад тусалдаг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдийг нүдээ анин Ариун Ёслолын өмнөх хөгжим тоглохыг сонсож буй мэт болохыг хүс.

- Сүм дээр хүндэтгэлтэй байхад хөгжим хэрхэн тусалдаг вэ?

Тэнгэрлэг Эцэг, Есүс бидний дуулахыг сонсох дуртай гэдгийг тайлбарла. Сургаал ба Гэрээ 25:12-ын эхний хоёр өгүүлбэрийг чанга дуугаар унш (*дуу нь надад хандсан залбирал гэдгийг дуустал*). Сүмийн дуу дуулах нь Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахтай адил гэдгийг тайлбарла. Бид Тэнгэрлэг Эцэгтээ Түүний бидэнд өгдөг олон адислалд талархдаг. Тэнгэрлэг Эцэг, Есүсийн тухай дуулах нь Тэд бидэнд хайртай, бидэнд



туслахыг хүсч байгааг сануулдаг. Ариун Ёслол дээр дуулдаг дууг бид *сүмийн дуулал* гэж нэрлэдэг.

- Бид яагаад сүм дээр сүмийн дуу, дуоллууд дуулдаг вэ?

Түүх

Зураг 1-69, Жаредын усан онгоц, зургийг үзүүлж Ифер 6:2–12-д Жаредчууд амлагдсан газар ирж буй тухай гардаг түүхийг ярьж өг. Жаредчууд усан онгоцон дотроо явахдаа Тэнгэрлэг Эцэг, Есүсийг магтан дуулдаг байсныг тайлбарла.

- Жаредчууд усан онгоцонд байхдаа яагаад дуулдаг байсан бэ?
- Салхи болон далайн давалгаа тэдний онгоцыг цохиход Жаредчуудад ямар байсан бол ?
- Тэднийг айх үед дуу тэдэнд хэрхэн тусалсан бэ?
- Та нар айсан үедээ дуу дуулж байсан уу? Энэ нь яаж тусалсан бэ?

Гэрчлэл

Хөгжим чамайг жаргалтай болгосон гэрчлэлээсээ хуваалц. Хүүхдүүдэд Тэнгэрлэг Эцэг, Есүс хүүхдүүдийг сайхан дуу дуулахыг сонсох дуртай гэдгийг хэл. Хүүхдүүд дуулснаар баяр хөөр, жаргалтай болж Тэнгэрлэг Эцэг болоод Есүс тэдэнд хайртай гэдгийг санадаг.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. “Хийхэд хөгжилтэй” (*Children’s Songbook*, p. 253) дууг дуул.
2. Ангид цөөхөн хүүхэд байвал тэдний дуртай Хүүхдийн Хэсгийн дуунаас сонгон, хамтдаа дуул.
3. Цаасан аягаар шагшурга хөгжим хий. Бага зэрэг цагаан будаа юм уу элс цаасан аяган дотор хий. Нөгөө цаасан аягаар эхний аягаа таглан углаж, цагаан будаа эсвэл элс асгарахгүй болтол таглан тогтоо. Хүүхдүүд шагшурга хөгжмөөрөө тоглон хамтдаа Хүүхдийн Хэсгийн дуу дуул. Мөн хонх, иргүй (хурц үзүүргүй) савх, эсвэл модон шоо зэрэг зүйлсээр хэмнэлт хөгжмийн зэмсэг болгон хэрэглэ.
4. Хүүхдийн Хэсэгт тохиромжтой хөгжмийг тоглон хүүхдүүдийг даган дуулах юм уу хөдөлгөөнийг хийхийг урь.
5. Өөрийн үгээр Бошиглогч Иосеф Смит болон бусад Сүмийн удирдагчид Картейжийн шоронд байсан түүхийг ярьж өг. Хэдий тэд ямар ч гэм зэмгүй байсан ч муу хүмүүс тэднийг шоронд хийжээ. Бошиглогч өөрийн амьдрал аюулд байгааг мэдэж байсан тул их санаа зовж уйтгартай байлаа. Тэр өөрийн найз Жон Тейлор дуу дуулахыг хүсэв. Жон бас маш их уйтгартай байсан тул “надад дуу дуулах хүсэл байхгүй байнаа” гэхэд Иосеф түүнийг дуулахыг зоригжуулав. Жон Есүсийн тухай дууг дуулахад хүн бүхэн шоронд байсан ч сэтгэл санаа нь дээшилжээ. Дуу тэдэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс тэдэнд хайртай гэдгийг сануулав. Энэ нь тэдэнд хүч тэнхээ, урам зоригийг өгчээ.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдийн дуртай дуунаас хамтдаа дуул. Дуулахдаа аажуухан алгаа ташихыг хүс. Хүүхдүүдтэй хөгжим хэрхэн жаргалтай болгож байгаа талаар ярилц.
2. Хүүхдүүдэд өөр өөр төрлийн хөгжмийг сонсохоор бэлтгэ. Харин Хүндэтгэлийн өдөр сонсоход зохистой байхыг анхаарна уу.
3. Тэнгэрлэг Эцэг бидэнд олон төрлийн хөгжмийг өгсөн гэдгийг хэл. Зарим хөгжмийг хүмүүс зохиодог, зарим хөгжмийн аялгууг бидний эргэн тойрон байгаа дэлхий дээрх юмс бий болгодог. Хөгжим мэт аялгуу эгшиглэх салхи, бороо, шувууд, зөгий болон аянга зэрэг байгалийн зүйлсийг нэрлэж олно. Хүүхдүүдээр эдгээр аялгууг гаргуул.

# Ариун Ёслол надад Есүсийн тухай дурсахад тусалдаг

---

## Зорилго

Ариун Ёслолын үеэр хүүхдүүдийг Есүс Христийн тухай бодоход нь дэмжин туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Лук 22:19–20 ба 3 Нифай 18:1–11-ийг уншиж, суралц. *Сургаалын Зарчмууд* (31110), бүлэг 23-ыг үз.
2. Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр хичээлийн эхэнд санваартны чуулгын нэг ахыг ангид урь. Тэр ариун ёслолын үйл ажиллагаа болон өөрийн үүрэг хариуцлагын талаар мөн энэхүү ариун ёслолын талаарх өөрийн сэтгэгдлийг хуваалцахыг урь.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи, Мормоны Ном
  - б. Есүсийн амьдралын тухай зураг 1-16, Есүс мэндэлсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 201; 62495); зураг 1-17, Есүс хүү Ариун Сүмд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 205; 62500); зураг 1-19, Христ ба хүүхдүүд (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 216; 62467); зураг 1-43, Есүс хараагүй хүнийг эдгээсэн нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 213; 62145); бусад өөрийн сонгосон зургаа авчир.
  - в. Зураг 1-3, Есүс бол Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572); зураг 1-8, Ариун ёслол түгээсэн нь (62021); зураг 1-44, Есүс Америк тивд сургаалыг заасан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 316; 62380); зураг 1-70, Сүүлчийн зоог (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 225; 62174).
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Зураг 1-8, Ариун ёслол түгээсэн нь зургийг үзүүл. Гэр бүл шиг хамтдаа цугларан Ням гарагт хийдэг цуглааныг Ариун Ёслолын цуглаан гэж нэрлэдгийг хэл.

- Яагаад бид үүнийг Ариун ёслолын цуглаан гэж нэрлэдэг вэ?

Хүүхдүүдийг санваартны чуулганы ахтай танилцуул. Түүнийг ариун ёслол дахь Аароны санваарын үүрэг хариуцлагын талаар ярихыг хүс. Мөн түүнийг ариун ёслол дахь өөрийн үүрэг хариуцлагын талаарх сэтгэгдлээ хуваалцахыг хүс. Түүнийг ирсэнд талархаж, Ням гарагийн хичээл болон санваартны ангидаа очихыг хүс.

## **Түүнийг үргэлж дурсан санаж байхад зориулан Есүс бидэнд ариун ёслолын цуглааныг өгсөн.**

Зураг 1-3, Есүс бол Христ зургийг үзүүл. Хүүхдүүдэд Есүс Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэдгийг сануул. Учир нь Есүс бидэнд маш их хайртай тул дэлхийд бидний Аврагч байхаар ирсэн. Тэр өвчтөнийг эдгээж, сайн мэдээг зааж, амьдрах төгс жишээг үзүүлсэн. Тэгээд бидний төлөө нас барсан.

Түүх

Зураг 1-70, Сүүлчийн зоог зургийг үзүүл. Лук 22:19–20 дахь Сүүлчийн зоогийн тухай түүхийг ярьж өг. Шүлэг 19: “Энэ бол та нарын төлөө өгөх Миний бие” гэдгээс чангаар унш. Есүс өөрийн Төлөөлөгч нарт Хүндэтгэлийн өдөр хамтдаа цугларан, ариун ёслолоос хүртэж Түүнийг дурсан санаж байхыг хэлсэн гэдгийг тайлбарла.

Зураг 1-44, Есүс Америк Тивд сургаалыг заасан нь зургийг үзүүл. Есүс Нифайчууд дээр айлчилж, тэдэнд Хүндэтгэлийн өдөр хамтдаа цугларч, ариун ёслолоос хүртэн, Түүний тухай дурсан санахыг бас хэлсэн гэдгийг тайлбарла (3 Нифай 18:1–11-ийг үз).

- Төлөөлөгчид ариун ёслолоос хүртэн хэний тухай дурсан санах ёстой вэ?
- Нифайчууд ариун ёслолоос хүртэхдээ хэний тухай дурсан санах ёстой байсан бэ?
- Бид ариун ёслолоос хүртэхдээ хэний талаар дурсан санах ёстой вэ?
- Хэзээ бид ариун ёслол хүртдэг вэ ?

Үйл ажиллагаа

Хүүхдүүдтэй хамт дараах үйл ажиллагааг хий:

Өнөөдөр би Сүмдээ ирсэндээ баяртай байна

Би өнөөдөр сүмдээ ирсэндээ баяртай байна (*эрхий ба долоовор хуруунуудаа нийлүүлэн цагираг хийгээд үлдсэн хуруунуудынхаа үзүүрийг нийлүүлэн сүмийн орой хий*).

Би сонсож сурдаг (*чихэн дээрээ гараа дэлгэн барь*)

Бас залбирч (*гараа нугалан толгойгоо бөхийлгө*)

Би өндөр дээд Есүсээс суралцдаг (*дээш заа*)

Би Есүс болон Түүний хайрын тухай боддог (*өөрийгөө тэвэр*).

Түүхүүд

Нэг нэгээр нь Есүсийн амьдралаас үзүүлсэн зурагнуудаа үзүүл. Хүүхэд зурган дээрх үйл явдлыг мэдэж байвал түүгээр түүхийг яриул. Хэрэв тэд түүхийг мэдэхгүй бол тэдэнтэй товчхон хуваалц. Олон хүүхдийг түүх яриулахад хамруулахыг хичээ.

- Ариун ёслолын үед Есүсийн тухай ямар түүхийг бодож болох вэ?

Ариун ёслолын үеэр Есүсийн тухай дурсан санах бусад түүхүүдийг хэлж өг. Хэрэв тэд өөр түүхүүдийг санахгүй байвал та өөрөө ариун ёслолын үед санадаг Есүсийн тухай нэг юм уу хоёр түүхийг тэдэнд ярьж өг.

## **Бид Ариун ёслолын үеэр хүндэтгэлтэй байж чадна**

Үйл ажиллагаа	<p>Дараах шүлгийг хэлүүлж үйлдлийг хүүхдүүдээр хийлгэ:</p> <p>Би гараа зөрүүлэн нугалж (<i>гараа нугал</i>) Толгойгоо доош гудайлгана (<i>толгойгоо гудайлга</i>) Тэгээд чимээгүй болж (<i>энэ мөрийг шивнэн хэл</i>) Ариун ёслол адислах үед, Таныгаа дурсан санах болно.</p> <p>Есүс бидэнд ариун ёслолыг Түүнийг дурсан санахад зориулан өгсөн учраас Есүсийн тухай бодох нь чухал бөгөөд мөн бусдад Түүний тухай бодоход туслах нь бас чухал. Ариун ёслолын үеэр хүндэтгэлтэй байснаар бид тэгж чадна.</p>
Үйл ажиллагаа	<p>Дараах мэдэгдлүүдээс нэг хүүхдэд шивнэн хэлж, түүнийг ангид чангаар юу гэж хэлснийг хэлэхийг хүс. Хүүхэд бүрээр үүнийг хийтэл үргэлжлүүл.</p> <ol style="list-style-type: none"><li>1. Бид Есүсийн тухай сүмийн дууллыг дуулж ариун ёслолоо эхэлдэг.</li><li>2. Бид талх адислах залбирал хэлэх үгсийг анхааралтайгаар сонсдог.</li><li>3. Адисалсан талхыг түгээх үед бид зөвхөн ганцханыг авч хүртдэг.</li><li>4. Ус адислах залбирал хэлэх үед бид анхааралтайгаар сонсдог.</li><li>5. Хүндэтгэлтэйгээр уснаас хүртэж, жижиг савыг эргүүлэн хийдэг.</li><li>6. Бид хэзээ ч талх болон ариун ёслолын усны саваар тоглодоггүй.</li></ol> <p>Эдгээр зүйлсийг хийснээр бид ариун ёслолд хүндэтгэлтэй байгаагаа харуулдаг.</p> <ul style="list-style-type: none"><li>• Ариун ёслолд бид хэрхэн хүндэтгэлтэй байх вэ?</li></ul>
Үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдийг таны хэлэх үйлдлүүдийг анхааралтай сонсохыг хүс. Тэднийг хэрэв ариун ёслолын үеэр бодох юм уу хийх ёстой зүйлсийг хэлэхэд босч, харин ариун ёслолын үед бодох болон хийх ёсгүй зүйлсийг хэлэхэд доош суухыг хэл. Өөрийн зохиосон болон дараах жишээнүүдийг хэрэглэ:</p> <ul style="list-style-type: none"><li>• Ариун ёслол адислах залбирал хэлэх үед анхааралтай сонсох.</li><li>• Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд хайртай гэдгийг санах.</li><li>• Зугаалгаар явах тухайгаа бодох.</li><li>• Есүс өвчтөнийг эдгээсэн тухай санах.</li><li>• Ах эгчтэйгээ ярих.</li><li>• Хөдөлж, биеэ сэгсчих.</li><li>• Есүс хүүхдүүдийг адисалсан тухай бодох.</li></ul>
Гэрчлэл	<p>Есүс Христ болон Түүний бидний төлөө хийсэн зүйлсийн тухай бодоход тусалдаг ариун ёслолоос хүртэх боломжтойдоо маш их талархалтай байдаг талаараа гэрчлэлээ хуваалц. Ялангуяа ариун ёслолын үеэр хүн бүхэн хүндэтгэлтэй байснаар бодол санаагаа төвлөрүүлэн Есүсийн тухай бодоход чинь тусалдагт бүр ч талархалтай байдаг тухай тайлбарла.</p>

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхэд бүрээр ариун ёслол хүртэж байгаа өөрийнхөө зургийг зурахыг хүс. Зурган дээр *Ариун Ёслолоос хүртэх үедээ би Есүсийн тухай бодож чадна* гэж бич.
2. Ангид ариун ёслолын талх, ус хийдэг хоосон савыг авчир. Хүүхэд бүрт бариулж ойроос харуул. Хүүхдүүдээр ариун ёслолыг адислан түгээх үед юу хийдгийг дүрслэн үзүүлүүл.
4. Есүсийн амьдралын дуртай хэсгээсээ хүүхдүүдийг жүжигчлэн үзүүлэхийг хүс.

## Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа

1. Ариун ёслолын ажиллагааг энгийнээр дүрслэн тайлбарла: Есүсийн зураг үзүүлж, Няг гарагт бид Есүсийг санах онцгой цаг байдаг гэдгийг хэл. Энэ нь ариун ёслолын үед бид жижиг хэрчим талх, аягатай уснаас хүртэх ёслол юм. Ариун ёслолын үеэр Есүс бидэнд хэчнээн их хайртай тухай санаж, биднийг аз жаргалтай болгохын төлөө хийсэн олон зүйлсийнх нь талаар боддог.
2. “Надад Есүсийн тухай түүхийг яриач” (*Children’s Songbook*, p. 57) дууг дуулах буюу үгийг хэл.
3. Таныг үгийг нь хэлж байх зуур хүүхдүүдийг дараах үйлдлийг хийхийг хүс:

Бүтээлт

Есүс нар мандаг (*гараараа том тойрог толгой дээрээ хий*),  
 Бороо орог (*хуруунуудаа хөдөлгөн гараа доош хөдөлгө*),  
 Цэцэгс ургаг хэмээн хэлэв (*гарын алгаа дээш харуулан аяга мэт болго*),  
 Мөн Есүс шувууд жиргэг (*шувууны хошуу мэт гарын хуруугаа хөдөлгө*),  
 Хэмээн хэлэхэд бүгд түүний хэлснээр болов (*гараа урдаа зөрүүлэн нугал*).  
 (Johnie B. Wood, in *Sing, Look, Do, Action Songs for Children*, ed. Dorothy M. Peterson [Cincinnati: Standard Publishing Co., 1965].)

Хүүхдүүдэд Есүс биднийг жаргалтай байлгахын төлөө бидэнд олон зүйлсийг өгсөн гэдгийг сануул. Ариун ёслолын үед Есүсийн тухай бодож Түүнд талархаж байгаагаа харуулж болно.

# Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд судруудыг өгсөн

## Зорилго

Судрууд нь Тэнгэрлэг Эцэг, Есүсийн үгсийг агуулдаг бөгөөд судруудыг судалснаар Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн тухай бид суралцаж чадна гэдгийг хүүхэд бүрийг ойлгоход нь туслах.

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Лук 22:19–20; 3Нифай 18:21; Сургаал ба Гэрээ 59:6; ба Мосе 7:11-ийг уншиж, суралц. *Сургаалын Зарчмууд* (31110), бүлэг 10-ыг үз.
2. Зураг ашиглан өөрийн дуртай судрын нэг түүхийг ярьж өг.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Судрууд (Библи, Мормоны Ном, Агуу Үнэт Сувд).
  - б. Судруудыг бүтээх даавуу буюу ороох цаас.
  - в. Зураг 1-3, Есүс бол Христ (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 240; 62572); зураг 1-18, Усаар батлагч Иохан Есүсийг усаар баталсан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 208; 62133); зураг 1-44, Есүс Америк тивд сургаалыг заасан нь (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 316; 62380); зураг 1-70, Сүүлчийн зоог (Сайн мэдээний уран зургийн цуглуулага 225; 62174).
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Анги эхлэхээс өмнө судруудыг даавуугаар бүтээх юм уу цаасанд ороо. Тэдгээр судруудыг ширээн дээр юм уу сандал дээр хүүхдүүдэд харагдах газарт байрлуул. Хүн бүхэнд болон өөрт тань чухал нэгэн зүйлийг тавьсан байгаа гэдгээ тайлбарла. Хүүхдүүдээр юу байгааг таалга.

Хэсэг хугацаанд хүүхдүүдээр таалгуулсны дараа бүтээсэн даавуу юм уу боосон цаасыг авахыг зөвшөөр. Хэрэв хүүхдүүд ном гэж таавал хүүхдүүдэд энэ зөв гэдгийг хэлж номнуудыг гарга. Эдгээр номнуудыг судрууд гэж нэрлэдгийг хэл. *Судрууд* гэж хэд хэдэн удаа давтан хэлүүл.

### Судрууд нь ариун ном

Судрууд нь бусад номнуудаас ялгаатай чухал ном гэдгийг тайлбарла. Тэдгээр нь ариун ном. Хүүхдүүдэд ариун зүйлс бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүсийн тухай бодоход тусалдаг гэдгийг хэл. Судрууд нь Тэнгэрлэг Эцэг, Есүсийн талаар болон Тэд бидэнд хэчнээн их хайртай талаар хэлдэг гэдгийг тайлбарла. Тэдгээр нь мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд жаргалтай байхын тул юу хийхийг хэлж өгдөг.

Нэг нэгээр нь судруудыг харуулж нэрийг нь хэл. Хэрэв заримыг нь нэг ном болгон товхинуулсан бол судар бүрийн нэртэй гадна хавтсыг харуулан нэрийг хэл эсвэл судрын эхний хуудсыг гарган нэртэй хуудсуудыг эргүүлэн үзүүл.

Үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдэд бид судрыг гамнан хайрлаж хуудаснуудыг болгоомжтой эргүүлэх хэрэгтэй гэдгийг хэл. Хүүхдийг ангийн өмнө нэг нэгээр нь гарган тэд хэрхэн болгоомжтойгоор судрын хуудаснуудыг эргүүлж болохыг үзүүлэхийг хүс.</p> <p>Судруудад бодит үнэн түүхүүд байдаг гэдгийг тайлбарла. Эдгээр түүхүүд нь Тэнгэрлэг Эцэг, Есүс биднээс юу хийхийг хүсч буйг мэдэж авахад тусалдаг. Бидний амьдралд судрын түүхүүд тусалж чадна.</p>
Түүх	<p>Хэрэв боломжтой бол зураг ашиглан өөрийн дуртай судрын түүхийг ярьж өг. Судрын түүх дээр заасан зүйлс хэрхэн таны амьдралд тусалсан тухай хэл. Судрын түүхүүдийг унших дуртайгаа хуваалц.</p>
Дуу	<p>Хүүхдүүдэд “Надад Есүсийн тухай түүхийг яриач” (<i>Children’s Songbook</i>, р. 57) дууг дуулах буюу үгийг хэлэхэд тусал. Хүүхдийн Хэсэгт суралцдаг судрын түүхүүд нь бүгд үнэн, болсон түүхүүд гэдгийг хэл.</p> <p>Хэрэв Тэр энд байсан бол миний асуух зүйлст хариулахаар Есүсийн тухай түүхийг надад ярьж өгөөч, би үүнийг сонсох дуртай. Далайн тухай, замын хажууд болсон үйл явдлын тухай, Есүсийн түүхийг, бүгдийг надад ярьж өгөөч.</p>

### **Судрууд Есүсийн сургаалуудыг агуулдаг**

Зарим судруудыг Есүсийн үед амьдарч байсан, Түүний хийснийг мэддэг байсан хүмүүс бичсэн гэдгийг тайлбарла. Тэд Есүсийг харсан бас Түүний сургаал заахыг сонссон. Хүн бүхэн Есүсийн тухай, Түүний сургаалаас суралцаж, Тэр Тэнгэрлэг Эцэгийн Хүү байсан гэдгийг мэдэж болохын тул тэдгээр хүмүүс судруудыг бичсэн.

Зураг 1-70, Сүүлчийн зоог зургийг үзүүл. Хүүхдүүдээс зурган дахь түүхийн талаар юу мэдэхийг нь асуу. Библи харуулж, нэрийг нь хэлүүл. Лук 22-ыг гарга. Библи дээр ариун ёслолоос хүртэж, Түүнийг дурсан санах тухай Есүс бидэнд заасан гэдгийг тайлбарла. Есүс талх авч адислан, өөрийн шавь нартаа (туслахууд) өгсөн. Тэр аягатай усыг авч тэдэнд уулгасан. 19-р шүлгээс, “Намайг дурсаж үүнийг үйлд” гэсэн хэсгээс унш. Эдгээр үгс нь Есүсийн үгс гэдгийг онцлон хэл.

Зураг 1-44, Есүс Америк тивд сургаалыг заасан нь, зургийг үзүүлж зурган дээрх үйл явдлыг ярьж өг. Мормоны Ном харуулж нэрийг нь давтан хэлүүл. Мормоны Номын 3 Нифай 18-ыг нээ. Есүс хүмүүст олон зүйлийг заасан гэдгийг тайлбарла. Шүлэг 21-д Есүсийн хэлсэн “Гэр бүлдээ Эцэгт хандан миний нэрээр үргэлж залбир” гэснийг унш.

- Гэр бүлээрээ юу хийхийг Есүс заасан бэ?

Зураг 1-3, Есүс бол Христ зургийг үзүүл. Сургаал ба Гэрээ судрыг харуулж нэрийг нь хэлүүл. Сургаал ба Гэрээ 59-р хэсгийг нээ. Биднийг бие биеэ хайрлахыг Есүс заасан. Есүсийн хэлсэн 6-р шүлгийн, “Чи хөршөө өөр шигээ хайрлах ёстой” гэснийг унш.

- Есүс юу хий гэж хэлсэн бэ?
- Хэн чиний хөрш вэ?
- Бусдад эелдэг байж хайраа үзүүлэхэд чамд ямар байдаг вэ?



Дуу

“Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” (*Children’s Songbook*, р. 61) дууг дараах үйлдлийг хийн дуулах буюу үгийг хэл:

Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн (*гараа том дэлгэ*)  
Бас тэдэнд эелдэг ханд гэж хэлсэн (*толгойгоо дохь*).  
Чиний зүрх хайраар дүүрэхэд (*гараа зүрхэн дээрээ тавь*),  
Бусад хүмүүс чамайг хайрлах болно (*өөрийгөө тэвэр*).

Зураг 1-18, Усаар батлагч Иохан Есүсийг усаар баталсан нь зургийг үзүүл. Хүүхдүүдээр зургийн тухай, үйл явдлыг яриул. Есүс усан баталгаа хийлгэсэн бөгөөд хүн бүрийг мөн усан баталгаа хийлгэхийг хүсдэг гэдгийг хэл. Агуу Үнэт Сувд судрыг харуулж нэрийг нь хэлүүл. Мосе 7-г нээж, Есүс Енох хэмээх хүнд хүмүүс дээр очиж тэднийг усаар батлахыг заасан тухай хэл. Шүлэг 11 дээрх Есүсийн хэлсэн, “Мөн Эцэг... мөн Хүүгийн нэрээр, мөн Ариун Сүнсээр баптисм хүртээх” гэсэн хэсгийг унш.

Дөрвөн судрыг өргөж барь. Эдгээрт бүгдэд нь Есүсийн сургаалууд бичигдсэн байгаа гэдгийг хэл.

- Эдгээр ном ямар ном бэ?
- Судрууд дээр хэний сургаалууд байдаг вэ?
- Яагаад судрууд бичигдсэн бэ?
- Тэнгэрлэг Эцэг, Есүс бидэнд хайртай, Тэд бидэнд судруудыг өгсөн гэдгийг мэдэхэд ямар санагддаг вэ?

Гэрчлэл

Судруудад хайртай тухайгаа болон өөрийн талархалаа хуваалц. Судрууд нь Тэнгэрлэг Эцэг ба Есүсийн үгс, судруудыг судалж суралцсанаар бид Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг хийгээсэй гэж хүсч буй зүйлсийн талаар суралцаж чадна гэсэн гэрчлэлээ хуваалц.

---

## Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. Хүүхэд бүрт хүрэлцэхээр судруудын нүүрэн хавтас хийх жижиг цааснуудыг дундуур нь нугал. Хавтас бүр дээр судрын нэрийг бич. Хүүхдүүдийн хийсэн хавтас бүрийн буланд нүх гарган, утас ашиглан дөрвөн судрын хавтсыг хамтад нь холбо.

Хавтас бүрийн дотор талд нь хичээлд суралцсан судруудыг бич:

Библи: *Есүс бидэнд ариун ёслолын тухай заасан (Лук 22:19).*

Мормоны Ном: *Есүс биднийг гэр бүлээрээ залбирахыг заасан (3 Нифай 18:21).*

Сургаал ба Гэрээ: *Есүс биднийг хөршөө хайрлахыг заасан (СбаГ 59:6).*

Агуу Үнэт Сувд: *Есүс усан баталгаа хийлгэхийг бидэнд заасан (Мосе 7:11).*

Хүүхэд бүрт жижиг хавтсуудыг гэр лүүгээ авч явахад нь зориулан өг. Хүүхэд бүрт өгөхдөө хичээлд суралцсан Есүсийн сургаал бүрийг давтан ярилц.

2. Хүүхдүүдэд Итгэлийн Тунхагийн 8-аас цээжлэхэд нь тусал: “Библи . . . Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг” ба “гэрчлэн Мормоны Ном бол Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг”.

3. Энэ гарын авлагын болон Сүмийн номын сангаас Мормоны Номын түүхийг үзүүлсэн зураг бэлтгэ. Зураг бүрийг нэг нэгээр нь үзүүлж, гарч буй түүхийг товчхон ярилц. Судруудад үнэн түүхийг өгүүлдэг гэдгийг хүүхдүүдэд хэл.
4. Судрууд таны амьдралд онцгой байр суурь эзэлж байсан тохиолдлуудаас ярь. Судрууд хэрхэн танд тусалсан болон танд ямар сэтгэгдэл төрүүлсэн талаар хэлж өг.
5. Энэ хичээлд гарсан шиг Есүсийн хэлсэн үг орсон богино судрын хэсгийг ол. Судар бүрийг *Есүс хэлэхдээ* гэж эхлэн дахин унш. Жишээ нь, “Есүс хэлэхдээ, ‘Намайг дага’ ” Вандуйт уут юм уу зөөлөн эд ашиглан хүүхэд бүрт шидэн өгч түүнийг авсан хүүхдийг хэлсэн судрыг таныг хэлсэний дараа давтан хэлэхийг хүс. Тэгээд уутыг юм уу зөөлөн эдийг эргүүлэн шид. Үүнийг хүүхэд бүрээр хийлгэтэл давт.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Библийг гартаа өргөн “Надад Есүсийн тухай түүхийг яриач” (*Children’s Songbook*, p. 57) дууг дуулах буюу үгийг хэл.
2. Уяман өвчтэй арван хүний тухай (Лук17:11–19-ийг үз) түүхийг товчхон ярьж өг. Тэгээд дараах хуруун тоглоомыг хамтдаа тогло:
 

Өвчтэй арван хүн байжээ (*арван хуруугаа өргө*);  
Христ тэднийг нэг өдөрт эдгээв.  
Тэр энгийнээр хэлэхэд, тэдний өвчин үгүй болов (*гараараа дохь*)!  
Энэ сонин биш гэж үү? Энэ хачирхалтай биш гэж үү (*долоовор хуруунуудаа толгойндоо барьж гайхсан дүр үзүүл*)  
Зөвхөн ганцхан хүн л (*нэг хуруугаа гозойлго*)  
Түүнд талархал илэрхийлж  
Бурханыг магтан дуулав (*хоёр гараа өргө*)  
(Adapted from Jean Shannon in *Bible Story Finger Plays and Action Rhymes* [Cincinnati: Standard Publishing Co., 1964], p. 27.)

Энэ түүх Библи дээр хаана байдгийг хүүхдүүдэд зааж өг.
3. Хүүхдүүдээс тэдний дуртай судрын түүхүүдийг асуу. Хэрэв боломжтой бол тэдгээр нь сударт хаана байдгийг хэлж өг.

# Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Гишүүн

---

## Зорилго

Хүүхэд бүрт Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг гэдгийг ойлгоход нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Марк 1:9–11; Сургаал ба Гэрээ 115:4; ба Иосеф Смит—Түүх 1:5, 10–19. *Сургаалын Зарчмууд* (31110), бүлэг 17-г үз.
2. Том цаас эсхүл нимгэн картон цаасыг аль болох томхон анги дахь хүн бүрийн тоогоор (хүүхдүүд ба багш) эвлүүлдэг тоглоом маягаар хайчил. Хайчилсан хэрчим бүр дээр анги дахь хүмүүсийн нэрийг бич.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Судрууд
  - б. Зураг 1-4, Анхны үзэгдэл (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 403; 62470); зураг 1-8, Ариун ёслол түгээсэн нь (62021); зураг 1-12, Ариун Сүнсний бэлэг хүртэж буй охин (62020); зураг 1-18, Усаар батлагч Иохан Есүсийг усаар баталсан нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 208; 62133); зураг 1-39, Бяцхан хүүхдийг адисласан нь; зураг 1-40, Өвчтөнийг адисласан нь (62342); Амьд Бошиглогчийн зураг.
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Өөрийн нэртэй эвлүүлдэг цаасыг гартаа өргө. Хүүхдүүдэд энэ нь эвлүүлдэг тоглоомын нэг хэсэг гэдгийг хэл. Бусад хэсгүүдийг хүүхдүүдэд нэрийнх нь дагуу тараан өг. Эвлүүлдэг тоглоомын цаасан дээрх нэрийг уншиж өг. Эвлүүлдэг тоглоомын цаасны хэсэг бүр энэ тоглоомын нэгэн хэсэг болж байгаа шиг хүүхэд бүр энэ ангийн нэгэн хэсэг гэдгийг тайлбарла. Нэг зүйлийн хэсэг болно гэдэг нь түүнд харьяалагддаг болно гэсэн үг гэдгийг тайлбарла.

- Чи өөр юунд харьяалагддаг вэ?

Бид мөн гэр бүл болон хөршүүдийнхээ нэгэн хэсэг болдог гэдгийг тайлбарла. Бид мөн Есүсийн сүмийн нэг хэсэг.

Зураг 1-39, Бяцхан хүүхдийг адисалсан нь зургийг үзүүл.

- Энэ зурган дээр юу болж байна вэ?

Хүүхдүүдэд тэд бяцхан байхдаа нэрийн адислалыг хүртсэн гэдгийг хэл. Нэрийн адислалаар тэдний нэр сүмийн бүртгэлд бүртгэгдсэн тул тэд өөрсдийгөө “Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийнх” гэж болно.

Хүүхдүүдээр “Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийнх” гэж хэд хэдэн удаа давтан хэлүүл.

Үйл ажиллагаа

“Өнөөдөр би сүмдээ ирсэндээ баяртай байна” шүлгийг хамтдаа уншиж хөдөлгөөнийг хий:

Би өнөөдөр сүмдээ ирсэндээ баяртай байна (*эрхий ба долоовор хуруунуудаа нийлүүлэн цагираг хийгээд үлдсэн хуруунуудынхаа үзүүрийг нийлүүлэн сүмийн орой хий*).

Би сонсож сурдаг (*чихэн дээрээ гараа дэлгэн барь*).

Бас залбирч (*гараа нугалан толгойгоо бөхийлгө*).

Би өндөр дээд Есүсээс суралцдаг (*дээш заа*);

Би Есүс болон Түүний хайрын тухай боддог (*өөрийгөө тэвэр*).

Хүүхдүүдэд бид сүмийн цуглаануудад Есүсийн тухай, Тэр биднийг юу хийхийг хүсч байгааг суралцахын тул ирдэг гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд тэд энэ хичээл дээр Есүсийн сүмийн зарим нэгэн чухал зүйлсийн тухай суралцах болно гэдгийг хэл.

### **Есүсийн сүмд санваар байдаг**

Зураг 1-8, Ариун ёслол түгээсэн нь; зураг 1-12, Ариун сүнсний бэлэг хүртэж буй охин; ба зураг 1-40, Өвчтөнийг адисалсан нь зурагнуудыг үзүүл. Зураг бүр дээр юу болж буйг хэлэхийг хүүхдүүдээс хүс. Эдгээр зүйлсийг хийхэд санваартан хэрэгтэй гэдгийг тайлбарла. Санваар гэдэг нь Тэнгэрлэг Эцэг, Есүст байдаг хүч юм. Дэлхий дээр Тэнгэрлэг Эцэг, Есүсийн ажил хийгдэж байхын тул, Тэд зөв зохистой ах нарт өөрсдийн хүчнээсээ өгсөн. Зураг бүр дээрх санваартан ах нарыг заа. Хүүхдүүдээр *санваартан* гэж хэд хэдэн удаа давтан хэлүүл.

- Санваар хэнд байдгийг хэн хэлэх вэ?

Санваартан ах нар Ариун ёслол түгээх, баптисм хүртээх, хүмүүст адислал өгөх, мөн бусад олон чухал зүйлсийг хийж чадна гэдгийг хүүхдүүд ойлгоход нь тусал. Дахин зураг 1-39, Бяцхан хүүхдийг адисалсан нь зургийг үзүүл. хүүхдүүдэд бяцхан хүүхэд санваарын зэрэгтэй ах нараар адислагдаж байна гэдгийг хэл.

Түүх

Зураг 1-18, Усаар батлагч Иохан Есүсийг усаар баталсан нь, зургийг үзүүл. Хүүхдүүдээр зурган дээрх түүхээс санаж байгаа зүйлийг нь яриул. Марк 1:9–11-д гардаг түүхийг товчхон ярьж өг.

- Есүст хэн баптисм хүртээсэн бэ? (Марк 1:9-ийг үз.)
- Есүст баптисм хүртээхийн тулд Иоханд ямар хүч хэрэгтэй байсан бэ? (Санваарын)

Санваарын хүчтэй хэн нэгнээс баптисм хүртэх нь Есүсийн сүмийнхний чухал хэсгийн нэг гэдгийг хүүхдүүдэд тайлбарлаж өг. Хүүхдүүдэд тэд найман нас хүрээд Есүсийн сүмийн гишүүн болж баптисм хүртэж чадна гэдгийг хэл.

### **Есүсийн сүмд Бошиглогч байдаг**

Түүх

Зураг 1-4, Анхны үзэгдэл, зургийг үзүүл. Иосеф Смит—Түүх 1:5, 10–19 –д гардаг Иосеф Смитийн анхны үзэгдлийн тухай түүхийг ярьж өг.

- Төгөлд Иосеф Смиттэй ярихаар хэн ирсэн бэ? (Иосеф Смит—Түүх1:17-г үз.)

Тэнгэрлэг Эцэг, Есүс нар Иосеф Смиттэй ярилцсан учраас Иосеф Смитийг бид Бошиглогч гэж нэрлэдэг гэдгийг тайлбарла. Бошиглогч бидэнд Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг мэдээсэй хэмээн хүсдэг зүйлсийг хэлж өгдөг.

- Бошиглогч гэж хэн бэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүстэй ярих онцгой дуудлага хүлээсэн, Тэдний биднийг хийгээсэй хэмээн хүсч буй зүйлсийг хэлж өгдөг хүн)

Амьд Бошиглогчийн зургийг үзүүл. Түүний талаар хүүхдүүдэд ярьж өг. Есүсийн сүмд Амьд Бошиглогч үргэлж байж, Тэнгэрлэг Эцэг, Есүс биднээс юу мэдэж юуг хийх ёстойг заадаг гэдгийг тайлбарла.

Дуу

“Бошиглогчийг дага” (*Children’s Songbook*, р. 110) дууг дуулах буюу үгийг хэлэхэд тусал. Төөрөх гэдэг нь буруу зүйл хийнэ гэсэн үг гэдгийг тайлбарла. Хүүхдүүд дууг дуулах үед Амьд Бошиглогчийн зургийг нэг хүүхэд өөд нь барьж байхыг хүс.

Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, бүү төөрч яв. Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, тэр замыг мэднэ.

### **Есүсийн сүмд судрууд бий**

Судруудыг харуулан барь.

- Би юу барьж байна?

Хүүхдүүдээр судруудын талаар юу мэдэхийг нь яриул. Судруудад Тэнгэрлэг Эцэг, Есүсийн сургаалууд байдаг гэдгийг хэл. Судруудад Есүсийн тухай, Бошиглогчид болон бусад хүмүүсийн тухай олон үнэн түүхүүдийг өгүүлдэг. Судрууд нь Есүсийн сүмийн чухал хэсэг.

### **Бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийнх**

- Бид хэний сүмд харьяалагддаг вэ?
- Бидний харьяалагддаг сүмийн нэр юу вэ?

Сургаал ба Гэрээ 115:4 чангаар хүүхдүүдэд уншиж өг. Сүмийн нэр нь одоо бидний амьдарч буй энэ цаг үеийн Есүсийн сүм гэсэн утгатай гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд энэ дэлхийд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг олон хүн бий гэдгийг ойлгоход нь тусал.

Өнөөдөр дэлхий дээр Есүсийн талаар зааж, сайн сайхан амьдрах тухай заадаг бусад олон сүм байдаг ч тэдэнд санваарын зэрэг, амьд бошиглогч болон бүх судрууд байдаггүй гэдгийг тайлбарлаж болно.

Үйл ажиллагаа

Есүсийн сүмд харьяалагддаг хүн бүрийг босохыг урь. Хүүхэд бүрийг босох хэрэгтэйг сануул. Хүүхдүүдээр “Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийнх” гэж хэд хэдэн удаа давтан хэлүүл.

Зурагнууд болон судруудыг ашиглан санваартан, амьд бошиглогч, болон судрууд нь Есүсийн сүмийн чухал хэсэг гэдгийг товчхон ярь.

Гэрчлэл

Сайн мэдээний төгс үнэний тухай гэрчлэлээ хуваалц. Хүүхдүүдэд Есүсийн үнэн сүмийн нэгэн хэсэг байх нь ямар чухал мөн гайхамшигтай болохыг мэдрэхэд нь тусал.

### Баяжуулах үйл ажиллагаа

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. *Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийнх* гэсэн энгэрийн зүүлт хий. Хүүхэд бүр өөрсдийн зүүлтээ будаж чимэн зүүн гэртээ харина.
2. Хүүхдүүдтэй хамт дараах хуруун тоглоомыг тогло:
 

Энэ бол сүм

Энэ бол сүм (*гараараа сүмийн орой хий*),  
Энэ сүмийн орой байна (*долоовор хуруугаараа шовх орой хий*)  
Хаалга онгойж (*алгаа нээ*)  
Бүх хүмүүсийг харж байна (*хуруугаараа дохь*).  
Хаалгаа хааж, тэдний залбирлыг сонсьё (*алгаа нийлүүлэн чихэндээ барь*).  
Хаалга онгойж, бүгд гаран явлаа (*алгаа нээж, хуруугаараа "алх"*).
3. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хүүхдийн тухай түүхийг ярьж өг. Ангийн хүүхдүүдийн оролцдог өөрсдийн гэр бүлтэйгээ Ариун ёслолоос хүртэх, Хүүхдийн хэсэгт хүндэтгэлтэй суух, залбирах, дуулах зэрэг үйл ажиллагаануудыг хамруулан ярь.
 

Хүүхдүүдээс “Сүмийн хүүхэд Ням гарагт юу хийх ёстой вэ?” “Тэд Ариун ёслолын цуглаанд юу хийх ёстой вэ?” “Ням гарагт тэд гэртээ болон хүүхдийн хэсэг дээр юу хийх хэрэгтэй вэ?” “Гэр бүлийн үдэш тэд юу хийх ёстой вэ?” “Тэд гэр бүлдээ хэрхэн хандах ёстой вэ? Бас өөрсдийн найз нартаа?” зэрэг асуултуудыг асууж, эдгээр нөхцөлүүдэд юу хийх ёстойг хүүхдүүд бодон санахад тусал. Хүүхдүүдэд Есүсийн сүмийнхэн юу хийх ёстойг ойлгоход нь тусал.
4. Хүүхдүүдэд гэр бүл, хүүхдүүд өөр өөр хэсэгт харьяалагддаг тухай ойлгоход тусал. Хүүхдүүдээр тэдгээр хэсгүүдийн нэгэн хэсэг байхын юу нь тэдэнд таалагдаж байгаа эсэхийг асуу. Энэ яриаг тэд (та ч бас) Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийнх байхын юу нь таалагддаг талаар ярилцаж дуусга.

### Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа

1. Анги эхлэхээс өмнө нүд, гар, чих, ам эрхтэн тус бүрийг тусд нь дөрвөн цаасан дээр зурж бэлтгэ.
 

Хүүхдүүдэд сүм дээр бид олон янзын зүйлс хийдэг гэдгийг хэл. (Нүдний зураг үзүүл). Бид судрын түүхүүдийг уншдаг. (Гарын зургийг гаргаж үзүүл). Бид өөрсдийн найз нартайгаа нөхөрсгөөр хамтдаа тоглодог. (Чихний зураг үзүүл). Бид өөрсдийн багш нараа анхааралтай сонсож чадна. (Амны зураг үзүүл). Бид сүм дээр намуухан шивнэн ярьж чадна. Нэг нэгээр нь хүүхэд бүрийг урин, аль нэгэн зургийг сонгон заахыг хүс. Заасан зураг аль үйлдэлд тохирохыг хүүхдээр хэлүүл.

---

**Зорилго**

Бид амьд бошиглогчийг дагаснаар адислагддаг гэдгийг ойлгоход нь хүүхэд бүрт туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар 1 Самуел 3:1–10, 19–20-ийг уншиж, суралц. *Сургаалын зарчмууд* (31110), бүлэг 9-ийг үз.
2. Амьд Бошиглогчийн ерөнхий чуулган, Сүмийн сэтгүүлүүд дээр заасан сургаалаас цаасан дээр бичиж авчир. Ангийн хүүхэд бүрт хүрэх тоогоор бэлтгэ. Цаасыг нугалж, сагсанд юм уу том аяганд хий. Дараах сургаалуудыг бичсэн байж болно:
  - Өдөр бүр судраас суралц.
  - Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгал.
  - Өдөр бүр залбир.
  - Ариун ёслол болон Хүүхдийн ангидаа оролц.
  - Шударга бай.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Ариун Библи
  - б. Зураг 1-4, Анхны Үзэгдэл (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 403; 62470); зураг 1-29, Хөвөгч авдар барьсан нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 102; 62053); зураг 1-42, Их Эзэн Самуел хүүг дуудсан нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 111; 62498); зураг 1-66, Мосе ба шатаж буй бут (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 107; 62239); Амьд Бошиглогчийн зураг
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл  
ажиллагаа**

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Нэг нэгээр нь Ноа (зураг 1-29), Мосе (зураг 1-66) ба Иосеф Смит (зураг 1-4) –ийг үзүүл. Хүүхдүүдээр зураг бүр дээр болж буй үйл явдлуудыг яриул.

Хүүхдүүд зурган дээрх үйл явдлын талаар мэдэж байгаа зүйлээ ярьсны дараа Есүс Ноад өөрийн гэр бүлээ үерээс аврах хөвөгч авдар барихыг хэлсэн. Есүс Мосед Израилчуудыг боолчлолоос чөлөөлөхийг хэлсэн. Есүс Иосеф Смитэд дэлхий дээрх аль ч сүмд нэгдэх ёсгүй гэж хэлсэн гэдгийг товчхон ярьж өг.

**Бошиглогчид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ нартай ярьдаг**

Ноа, Мосе ба Иосеф Смит нар бошиглогчид гэдгийг тайлбарла. Бошиглогч нь Тэнгэрлэг Эцэг, Есүстэй ярьдаг. Тэнгэрлэг Эцэг, Есүс энэ дэлхий дээр бидэнд заах боломжгүй болсноос хойш, тэдэнд туслах бошиглогчидтой болсон. Тэнгэрлэг Эцэг, Есүс бошиглогчдод зааж, бошиглогч бидэнд жаргалтай адислагдсан байхын тул бид юу хийх хэрэгтэйг заадаг.

Түүх

Зураг 1-42, Их Эзэн Самуел хүүг дуудсан нь, зургийг үзүүл. 1 Самуел 3:1–10, 19–20-д гардаг Их Эзэн Самуелыг бошиглогч байхаар дууддаг түүхийг ярьж өг. 1 Самуел 3:10-ийг хүүхдүүдэд уншиж өг.

- Хэн Самуелыг орондоо байхад нь дуудсан бэ? (Есүс. 1 Самуел 3:4-ийг үз)
- Самуел өөрийг нь хэн дуудаж байна гэж бодсон бэ? (1 Самуел 3:5-ыг үз.)
- Ели Самуелд юу хий гэж хэлсэн бэ? (1 Самуел 3:9-ийг үз.)
- Самуел Есүст юу гэж хэлсэн бэ? (1 Самуел 3:10-ыг үз.)

Анх Есүс Самуелтэй ярих үед тэр жаахан хүү байсан гэдгийг хэл. Тэр өсөн том болж, хүмүүст Тэнгэрлэг Эцэг, Есүс тэднийг юу хийхийг хүсч буй сургаалыг заасан.

Үйл ажиллагаа

Гурван хүүхдийг урин нэг нь Ели, нөгөө хоёр нь Самуел болон Есүс Есүс болохыг хүсэн жүжигчилсэн тоглолт хийлгэ. Дараа нь хүүхдүүдийг хүссэн дүрд сонгон түүхийг давтан тоглуул.

### **Өнөөдөр дэлхий дээр бидэнд Бошиглогч бий**

Амьд Бошиглогчийн зургийг үзүүл. Бошиглогчдын талаар өөрийн мэддэг зүйлсийг хүүхдүүдэд ярьж өг.

Хүүхдүүдийг босгон, “(Амьд Бошиглогчийн нэр) бол Бурханы бошиглогч” гэж хэлүүл.

- Бидэнд яагаад амьд бошиглогч хэрэгтэй вэ? (Тэнгэрлэг Эцэг, Есүс биднээр юу хийлгэхийг хүсч буйг мэдэхийн тул)

Бошиглогч бидэнд ерөнхий чуулганаар дамжуулан сургадаг гэдгийг тайлбарла. Ерөнхий чуулганууд нь маш олон хүмүүс оролцдог том хурлууд юм. Бид бошиглогчийг зурагт радиогаар, эсвэл бичлэгт хуурцагаар сонсож болно. Түүний үгс сүмийн сэтгүүлүүд дээр бичигдсэн байдаг тул бидэнд аав ээж болон бусад хүмүүс уншиж өгч болно.

Үйл ажиллагаа

Хүүхэд бүрээр сагсан дахь юм уу том аяганд хийсэн цааснаас сугалуул. Бичсэн үгсийг уншиж, хүүхдүүдтэй түүний талаар товчхон ярилц. Эдгээр үгс нь амьд бошиглогч биднийг хийхийг хүсч буй зүйл гэдгийг хэл.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдээс бошиглогчийг дагах арга замуудын талаар бодохыг хүс. Вандуйт уут юм уу зөөлөн эдийг хүүхэд рүү шидэн, “Би бошиглогчийг \_\_\_\_\_-ээр дагана” гэж хэл. Бошиглогчийг дагах арга замыг хоосон зайд хүүхэд бүрээр нөхөж хэлүүл.

### **Бид Амьд Бошиглогчийг дагаснаар адислагдана**

Дахин Ноа, Мосе ба Иосеф Смит болон амьд бошиглогчийн зургийг үзүүл. Ноагийн гэр бүл түүнийг дагаснаар үерээс аврагдсан гэдгийг тайлбарла. Израилчууд Мосег дагасан тул Египетээс гарч илүү сайхан газарт очсон. Хүмүүс Иосеф Смитийг дагасан учраас тэд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд болсон.

Эдгээр хүмүүс бошиглогчийг дагасан тул адислагдсан. Бид ч мөн бошиглогчийг дагаснаар адислагддаг гэдгийг тайлбарла.



Дуу “Бошиглогчийг дага” (*Children’s Songbook*, р. 110) дууг дуулах буюу үгийг хэл. Төөрөх гэдэг нь буруу зүйл хийх гэсэн үг гэдгийг тайлбарла. Дуулахдаа бошиглогчийн зургийг нэг хүүхдээр өргөн бариул.

Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, төөрч бүү яв. Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, Бошиглогчийг дага, тэр замыг мэднэ.

Гэрчлэл Амьд бошиглогчийн тухай гэрчлэлээ хуваалц. Хүүхдүүдэд бид бошиглогчийг дагаснаар адислагддаг гэдгийг мэддэгээ хэл.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдүүдэд үзүүлэх Амьд бошиглогчийн дуут болон дүрст хуурцагнууд эсвэл сүмийн сэтгүүлүүд дээрх зурагнуудыг үзүүл.
2. Хүүхдүүдэд “Бурхан минь Бошиглогч илгээсэн танд талархъя” (*Сүмийн дуулал*, 36) дууг дуулах буюу үгийг нь хэлж өг.
3. Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн Аврагчийг харсан түүхийг дахин ярьж өг (хичээл 26). Есүс Ерөнхийлөгч Снөүд сүмийг хэрхэн удирдах талаар заахаар үзэгдсэн гэдгийг тайлбарла. Есүс Ерөнхийлөгч Снөүд сүмийн гишүүдэд юу заах талаар хэлсэн.
4. Хүүхдүүд Бошиглогчийн сургаалыг дагаж болох нөхцөлүүдийн талаар бод. Ангид тэдгээрийн талаар хэлэлцэж, хүүхдүүдээр бошиглогчийг хэрхэн дагахыг хэлүүлэх юм уу дүрслэн үзүүлэхийг хүс. Жишээ нь: “Гал тогооны өрөөнд мөнгө байхыг харжээ. Тэдгээрийг чи өөртөө авахыг хүсэвч, эдгээр нь ээжийн мөнгө гэдгийг чи мэднэ. Бошиглогчийн шударга байхыг заасан сургамжийг дагаж чи юу хийх вэ?”

---

### **Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа**

1. Амьд бошиглогчийн зургийг хичээлийн туршид ангид ил тавь. Цаг гарган энэ хүн хэн болохыг хүүхдүүдэд хэлж өг. Тэр тэдэнд хайртай, Тэнгэрлэг Эцэг, Есүстээ эргэн очиход нь туслахыг хүсдэг гэдгийг тайлбарла. Хичээлийн турш үүнийг хоёр гурван удаа давт.
  2. “Удирдагчийг дага” тоглоомыг хүүхдүүдтэй хамт тогло. Хүүхдүүдийг нэг эгнээ болгон зогсоо. Эгнээний эхний хүүхэд гүйх, үсрэх, цовхцох, зэрэг хөдөлгөөнийг хийн өрөөний нөгөө булан уруу очно. Бусад хүүхдүүд түүнийг дагаж, хийсэн бүгдийг хийнэ. Эхний хүүхэд эгнээний сүүлд очиж дараагийн хүүхэд шинэ удирдагч болно. Хүүхэд бүрийг удирдагч болох боломж олдтол үргэлжлүүл.
- Тоглоомын дараа бошиглогч гэдэг Сүмийн удирдагч гэдгийг тайлбарла. Хэрэв бид түүний хэлсэн бүрийг дагах юм бол тэр биднийг Тэнгэрлэг Эцэг, Есүст буцан очиход хөтлөн удирдана.

# Бид бүгд сүмдээ тусалж чадна

Хичээл  
44

---

## Зорилго

Хүүхдүүдэд салбар, дүүргийн гишүүн бүр сүмдээ тусалж чадна гэдгийг ойлгоход нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар 1 Нифай 17:7–15; 18:1–4-ийг уншиж, суралц.
2. Хүүхэд бүрээр будуулан Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгч юм уу өөр хэн нэгэнд өгөх энгийн талархлын ил захидал бэлтгэн хий. Та нугалсан цаасны нүүрэн дээр цэцэг зураад дотор талд нь “Баярлалаа” гэж бичиж болно.
3. Шаардлагатай зүйлс:
  - а. Мормоны Ном
  - б. Хичээл 11-д хийсэн загасны уурга болон загас. Загас бүр дээр салбарын ерөнхийлөгч эсвэл бишопын талаар “Сүмийн цуглаанд тэр тэр индэр дээр суудаг”, “Тэр тойргийн [салбарын] хүмүүст тусалдаг,” эсвэл “Бид түүнд өөрсдийн аравны нэгийн өргөлөө өгдөг” гэсэн үгсийг бич.
  - в. Балын болон өнгийн харандаа.
  - г. Зураг 1-8, Ариун ёслол түгээсэн нь (62021); зураг 1-67, Хүндэтгэлтэй анги; зураг 1-71, Онгоц барьсан нь.
4. Баяжуулах үйл ажиллагаандаа ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Өрөөний голд сандал тавьж, нэг хөлнөөс нь дээш өргөхийг хичээ. Хамтдаа хийхгүй бол хийж чадахааргүй олон зүйлс байдаг гэдгийг тайлбарла. Гурван хүүхдийг урьж үлдсэн гурван хөлнөөс нь бариулан хамтдаа сандлыг шалнаас бага зэрэг дээш өргө. Хамтдаа нэг зэрэг ажиллахад ганцаараа хийж чадахгүй олон зүйлийг хийх боломжтой гэдгийг тайлбарла.

### Тэнгэрлэг Эцэг, Есүс биднийг хамтдаа ажиллаасай гэж хүсдэг

Түүх

Зураг 1-71, Онгоц барьсан нь, зургийг үзүүл. Нифайн гэр бүлийн тухай түүхийг (1 Нифай 17:7–15 ба 18:1–4) товчхон ярьж өг. Онгоцыг барихад Нифайд Их Эзэн (Есүс)-ний болон гэрийнхэнийх нь тусламж хэрэгтэй байсан гэдгийг тодотгон хэл.

- Яагаад Нифай тусламж авахгүйгээр онгоц барьж чадахгүй байсан бэ?
- Их Эзэн яаж Нифайд тусалсан бэ? (1 Нифай 17:8–10; 18:1-ийг үз.)
- Нифайн гэр бүлийнхэн яаж тусалсан бэ? (1 Нифай 18:1-ийг үз.)
- Бүгд хамтдаа ажиллах үед юу болсон бэ? (1 Нифай 18:4-ийг үз.)

Бусад хүмүүстэй хамтран ажиллаж байсан тохиолдлоос нь хүүхдүүдээр яриул.

Үйл ажиллагаа

Бид мөн сүм дээрээ хамтран ажилладаг гэдгийг тайлбарла. Тойргийн (юм уу салбарын) хүн бүр бие биедээ тусалдаг. Долоо хоног бүр сүм дээр гишүүдэд тусалдаг дууны удирдаач, төгөлдөр хуурч, багш, эсвэл хүүхдийн хэсгийн ерөнхийлөгч болон төлөөлж, үгээр болон дүрслэн үзүүл. Хүүхдүүдээр хэнийг дүрслэн үзүүлж буйг таалга. Хэн болохыг хүүхдүүд таасны дараа, тухайн хүний дуудлагын үүрэг хариуцлагын талаар тайлбарла.

Зураг 1-8, Ариун ёслол түгээсэн нь, зургийг үзүүл.

- Энэ дикон юу хийж байна вэ?
- Ариун ёслол түгээдэг хэн нэгнийг чи таних уу?

Аароны санваар хүртсэн залуу эрэгтэйчүүд ариун ёслолыг бэлтгэж, адисалж, түгээж болно гэдгийг тайлбарла. Ийм замаар тэдгээр хөвгүүд сүмдээ тусалдаг.

Үйл ажиллагаа

Танай салбар болон тойрогт хүн болгонд тусалдаг хэн нэгэн байдаг гэдгийг тайлбарла. Тэнгэрлэг Эцэг энэ хүнд хийх хэрэгтэй чухал ажлыг өгсөн. Хүүхдүүдээр уургаар түлхүүр үгсийг бичсэн загас бариул. Загасан дээрх үгсийг чангаар унш. Байгаа загас бүрийг уншиж дуустал үргэлжлүүл. Тэгээд энэ хүн хэн болохыг таалга.

- Манай бишопын нэрийг хэн гэдэг вэ (салбарын ерөнхийлөгчийн)?
- Тэр бидэнд туслахаар ямар чухал ажил хийдэг вэ?

Өөрийн салбар болон тойргийн гэр бүлийн багш, айлчлагч багш нар юу хийдэг талаар ярилц. Хүүхдүүдийн гэр бүлийн гишүүд ямар дуудлагатай талаар ярилцаж болно.

### **Бид сүмдээ тусалж чадна**

Үйл ажиллагаа

Савтай балын болон өнгийн харандааг шалан дээр асга. Нэг хүүхдийг тэдгээрийг ямар хугацаанд түүхийг хар. Дахин асга. Ангиараа тэдгээрийг түүж, ямар хугацаанд дуусгахыг хар. Хүн бүр хамтдаа ажиллах үед ажлаа илүү сайн хийж чадна гэдгийг тайлбарла.

- Сүмдээ чи яаж тусалж чадах вэ?

Хүүхдүүдийг цуглааны байрыг цэвэр байлгаж, бие биедээ нөхөрсөг эелдэг байж, айсан болон уйтгартай байгаа хэн нэгэнд туслах, цуглаануудын үед хүндэтгэлтэй байх зэрэг сүмдээ тусалж чадах арга замуудын талаар бодохыг хүс.

- Бид анги, цуглааны байраа цэвэр байлгахад хэрхэн тусалж чадах вэ?
- Бид сүмийн бусад хүмүүст яаж тусалж чадах вэ?

Зураг 1-67, Хүндэтгэлтэй анги зургийг үзүүл.

- Эдгээр хүүхдүүд сүмдээ яаж тусалж байна вэ?
- Бид хүндэтгэлтэй байснаар ангийнханд маань ямар тустай вэ?
- Хүн бүхэн хүндэтгэлтэй байснаар багшдаа яаж туслах вэ?
- Хүн бүхэн хүндэтгэлтэй байхад бидэнд ямар тустай байх вэ?

Үйл ажиллагаа	Сүмдээ туслах бас нэгэн зам нь “Баярлалаа” гэж бидний төлөө бүхнийг хийдэг хүмүүст хэлэх. Хүүхдүүдээр бэлтгэсэн талархлын ил захидлыг буудуулж, боломжтой бол хичээлийн цагтаа багтаан тарааж өг.
Гэрчлэл	Өөрийн салбар, тойрогт тусалдаг олон хүмүүст талархаж байдаг тухай гэрчлэлээ хуваалц. Хүүхдийн хэсгийн багш байж Тэнгэрлэг Эцэгийн ажлыг хийж байгаадаа ямар сэтгэгдэлтэй байдгаа хүүхдүүдтэй хуваалц.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго

1. Хэрэв боломжтой бол хүүхдүүдийг дагуулан Ариун ёслолын танхимд орж, бишопын зөвлөлийнхөн (салбарын ерөхийлөгчийн зөвлөлийнхөн) ариун ёслолын цуглааны үед хаана суудгийг үзүүл. Дараа нь тэдний ажлын өрөөнүүдийг үзүүл.
2. Вандуйтай уут болон зөөлөн эдийг хүүхдийн гарт өгч, түүнд сүм дээр хэн, яаж тусалдаг талаар асуу. Дараа нь уут эсвэл зөөлөн эдийг эргүүлэн шидэхийг хүс. Хүүхэд бүрт боломж олготол үргэлжлүүл.
3. Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр, тойрог болон салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийнхөнөөс нэг хүнийг эсвэл өөр нэг удирдагчийг урьж хүүхдүүдэд сүмдээ тэр юу хийдэг болон хэрхэн тусалдаг талаар ярихыг хүс.
4. Цаасан таваг юмуу дугуй хэлбэртэй цаасан дээр хүний нүүрний дүрс зурж хүүхэд бүрт өг. Хүүхдүүдэд өнгийн харандаа өгч, үс нэмэн зурж яг өөрийн үсний өнгөөр будахыг хүс. Хүүхдүүдэд сүмдээ яаж тусалж болох тухай үнэн зүйлийг хэлэхэд нүүрний дүрсээ дээш өргөж, харин худал зүйл хэлбэл нүүрний дүрсийг гартаа нуухыг хүс. Дараах үгсийг ашигла:
  - Би сандал дороо цаасаа шидэх хэрэгтэй.
  - Сүм дээр тусалсан хүмүүст би талархлаа илэрхийлэх хэрэгтэй.
  - Би анги руугаа гүйх хэрэгтэй.
  - Би сүм дээрээ хүндэтгэлтэй байх ёстой.

---

### **Бага насны хүүхдүүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа**

1. “Удирдагчийг дага” тоглоомыг хүүхдүүдтэй хамт тогло. Хүүхдүүдийг нэг эгнээ болгон зогсоо. Эгнээний эхний хүүхэд гүйх, үсрэх, цовхцох, зэрэг хөдөлгөөнийг хийн өрөөний нөгөө булан уруу очно. Бусад хүүхдүүд түүнийг дагаж, хийсэн бүгдийг хийнэ. Эхний хүүхэд эгнээний сүүлд очиж дараагийн хүүхэд шинэ удирдагч болно. Хүүхэд бүрийг удирдагч болох боломж олдтол үргэлжлүүл.

Тоглоомын дараа хүүхдүүдэд бишоп нь тойргийн удирдагч гэдгийг хэл. Тэр биднийг Тэнгэрлэг Эцэг рүүгээ буцах зам руу хөтлөх зүйлсийг хийгээсэй хэмээн хүсдэг.

2. “Намайг дагаад хий” (*Children’s Songbook*, р. 276) дууг ангийн нэг хүүхдийн удирдлага дор даган хийж дуулах буюу үгийг хэл. Хүүхэд бүрийг удирдагч болох боломж олготол үргэлжлүүл.

# Есүс Христийн Амилуулалт (Улаан өндөгний баяр)

Хичээл  
**45**

---

**Зорилго**

Хүүхдүүдэд Есүс Христ үхлээс амилсан гэдгийг ойлгоход туслах.

---

**Бэлтгэл**

1. Залбиралтайгаар Лук 23:33–24:12, 36–40, 51-ийг уншиж, суралц. Сургаалын зарчмууд (31110), бүлэг 12-ыг үз.
2. Шаардлагатай зүйлс:
  - а. Библи
  - б. Зураг 1-3, Есүс бол Христ (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 240; 62572); зураг 1-16, Есүс мэндэлсэн нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 201; 62495); зураг 1-55, Уулан дээрх номлол (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 212; 62166); зураг 1-59, Цовдлолт (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 05); зураг 1-72, Есүс Гетсеманид залбирсан нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 227; 62175); зураг 1-73, Есүсийг оршуулсан нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 231; 62180); зураг 1-74, Есүс шархаа үзүүлсэн нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 234; 62503).
3. Баяжуулах үйл ажиллагаанд ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.

---

**Суралцах үйл  
ажиллагаа**

Анхаарал татах  
үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Зураг 1-3, Есүс бол Христ, зургийг өвдгөн дээрээ доош нь харуулан тавь. Хүүхдүүдэд нэгэн чухал хүний тухай ярих гэж байгаагаа хэл. Хүүхдүүдэд дараах таамаглалуудыг өгсний дараа тэр хэн гэдгийг таалга:

1. Тэр хүн бүрт маш их хайртай.
2. Олон жилийн өмнө Тэр дэлхий дээр амьдарч өөрийн сүмээ байгуулсан.
3. Тэр бидэнд хэрхэн жаргалтай амьдрах талаар заасан.
4. Тэр хүмүүсийг адисалж, эелдэг, хайрладаг байхыг заасан.

Хүүхдүүд түүнийг таахад (эсвэл хэн болохыг хэлээд) Есүс гэдгийг хэлж зургийг үзүүл.

**Есүс бидэнд хайртай**

Хүүхдүүдэд Есүс бол Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэдгийг хэл. Тэнгэрлэг Эцэг чухал зорилгын улмаас Есүсийг дэлхий рүү илгээсэн.

Түүх

Зураг 1-16, Есүс мэндэлсэн нь зургийг үзүүл. Товчхон Есүс мэндэлсэн түүхийг ярь. Хүүхдүүдээр түүхийг яриулж болно. Есүс онцгой хүүхэд байсан гэдгийг хэл.

Зураг 1-55, Уулан дээрх номлол зургийг үзүүл. Есүс өсөж том болоод тэр өөрийн сүмээ зохион байгуулж, хүмүүст хэрхэн амьдрах ба бие биеэ хайрлахыг заасан.

Дуу

Хүүхдүүдийг босгон “Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” (*Children’s Songbook*, р. 61) дууг Гетсеманид үйлдлүүдийг хийн дуулах буюу үгийг хэл:

Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн (*гараа том дэлгэ*);  
Бас тэдэнд эелдэг ханд гэж хэлсэн (*толгойгоо дохь*).  
Чиний зүрх хайраар дүүрэхэд (*гараа зүрхэн дээрээ тавь*),  
Бусад хүмүүс чамайг хайрлах болно (*өөрийгөө тэвэр*).

Зураг 1-72, Есүс Гетсеманид залбирсан нь зургийг үзүүл.

- Энэ зурган дээр Есүс юу хийж байна?

Есүс нас барахаасаа өмнө Гетсемани хэмээх цэцэрлэгт очин залбирал хийсэн гэдгийг тайлбарла. Бид өөрсдийн буруу үйлдлүүдийн төлөө нүглээ наманчлан гуйваас өршөөгдөн уучлагдаж болохын тул бидний нүглийн өмнөөс Есүс зовсон. Есүс бидний төлөө үүнийг хийж чадах хүчийг агуулсан цорын ганц хүн байлаа. Тэр үүнийг бидэнд маш их хайртай учраас хийсэн.

### **Есүс амилсан**

Есүсийн үед амьдарч байсан олон хүн Түүнд хайртай байсан гэдгийг тайлбарла. Гэвч зарим хүмүүс Есүст дургүй байлаа. Тэд түүнийг Тэнгэрлэг Эцэгийн Хүү гэдэгт итгэхгүй байсан.

Түүх

Зураг 1-59, Цовдлолт зургийг үзүүл. Цовдлолтын талаар хялбар үгээр Лук 23:33–46 дээр гардаг түүхээс тайлбарла. Есүст дургүй байсан хүмүүс түүнд их харгис хэрцгий хандаж байсан гэдгийг хэл. Цэргүүд Есүсийн гарт болон хөлөнд хадаас хадаж түүнийг загалмай дээр өлгөсөн. Тэд Есүсийг нас бартал загалмай дээр байлгасан. (Энэ түүхийг ярихдаа болон доорх үйл ажиллагааг хийхдээ анхааралтай бай. Зарим хүүхдүүд хүмүүс Есүсийг зовоож байгаад хэтэрхий мэдрэмтгий байж болно.)

Есүс нас барахад түүний сүнс, биеийг нь орхиж диваажинд (тэнгэрт) очсон гэдгийг тайлбарла. Хүүхдүүдэд бид бүгд сүнстэй гэдгийг хэл. Бидний сүнс харагдахгүй ч тэд биднийг амьд байлгадаг.

Зураг 1-73, Есүсийн оршуулга зургийг үзүүл. Есүст хайртай хүмүүс түүний биеийг авч, болгоомжтойгоор даавуунд ороосон гэдгийг тайлбарлан хэл. Тэд Есүсийн биеийг бунханд (агуй мэт нас барсан хүн тавьдаг газар) болгоомжтойгоор тавьсан (Лук 23:50–56-г үз).

Зураг 1-74, Есүс шархаа үзүүлсэн нь зургийг үзүүл. Тэр нас барснаасаа гурван хоногийн дараа амилсан гэдгийг тайлбарла. Тэр дахин амьд болсон. Есүсийг нас барахад сүнс нь түүний биеийг орхин гарсан. Харин тэр амилахад түүний сүнс биедээ эргэн нийлсэн. Есүс амилсан анхны хүн.

Олон хүн Есүсийг амилсан байхыг харсан (Лук 24) гэдгийг тайлбарла. Есүс өөрийн найз нартаа зааж, тэдэнд өөрийн амилсан биеэ үзүүлсэн (Лук 24:36). Тэр өөрийн найзуудыг биед нь хүрч түүний амилсан бие махбодоос бүрдэж буйг мэдэхийг хүссэн (Лук 24:39–40). Хүмүүст заасны дараа Есүс Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин амьдрахаар явсан (Лук 24:51).

- Яагаад Есүс өөрт нь хүмүүс хүрэхийг зөвшөөрсөн бэ? (Лук 24:36–40-ийг үз.)
- Есүс хүмүүсийг орхиод хаашаа явсан бэ? (Лук 24:51-ыг үз.)

Есүс амилсан тэр өдөр бол анхны “Улаан өндөгний өдөр” гэдгийг тайлбарла. Есүс амилсан гэдгийг сануулах гэж бид жил бүр “Улаан өндөгний баяр”-ыг тэмдэглэдэг.

Үйл ажиллагаа

Хүүхдүүдийг босч зогсоод дараах үйлдийг тантай хамт хийхийг урь:

Нас бараад гурав хоносны дараа (*гурван хуруугаа өргө*).

Есүс амилан дахин ирсэн

Түүний гар, хөл дээр хадаасны шарх (*хөл, гарын алгаа харуул*)

Мөн биед нь жадны шарх байлаа (*хажуугаа заа*).

Үнэн сургаалаар амьдрахыг (*гараа алдал*).

Есүс ирж бидэнд бүгдийг заасан (*гараа дэлгэн өргө*)

Есүс амилсан учраас,

Бид ч бас амилах болно (*толгойгоо дохь*).

### **Бид амилах болно**

Хүүхдүүдэд Есүс нас барсны дараагаар амьдралд буцан ирсэн гэдгийг ойлгоход тусал. Есүс одоо тэнгэрт амьд байгаа. Тэр дахин хэзээ ч үхэхгүй. Бид ч мөн түүн шиг амилах боломжтой гэдгийг тайлбарла. Бид нас барсныхаа дараа амилах болно.

- Та нар нас барсан хэн нэгнийг мэдэх үү?

Хүмүүс нас барсны дараа тэдний сүнснүүд амьд хэвээр байдаг гэдгийг тайлбарла. Нэгэн өдөр тэд дахин амилах болно. Энэ нь тэдний биес яг л Есүсийнх шиг өөрсдийн сүнстэйгээ дахин нэгдэнэ гэсэн үг. Хүүхдүүдэд бид Есүс шиг гурав хоногийн дараа дахин амилахгүй ч хэзээ нэгэн өдөр дахин амилах болно гэдгийг хэл.

Хүүхдүүдээр “амилалт” гэж хэд хэдэн удаа давтуулан хэлүүлж, юу гэсэн үг болохыг хэлж өг.

Бүх хүмүүс бидний хайртай хүн бүр бидний аав ээж, ах эгч нар, өвөө эмээ нар, мөн найзууд дахин амилах боломжтой нь ямар гайхамшигтай зүйл болохыг хэл. Бид бүгд нас барсныхаа дараа дахин амилна. Есүс үүнийг боломжтой болгосон.

Гэрчлэл

Есүс бид бүгдэд хайртай гэсэн өөрийн гэрчлэлийг хуваалц. Биднийг гэсэн агуу хайр байсан тул Тэр зовж, нас барж мөн дахин амилсан. Тиймээс бид ч дахин амилж чадна.

---

### **Баяжуулах үйл ажиллагаа**

Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдүүдийн сайн мэддэг Улаан өндөгний баярын үйл явдлууд болон уламжлалын талаар товчхон ярилц. Дэлхийн сүнслэг бус уламжлалууд хөгжилтэй гоё ч жинхэнэ Улаан өндөгний баярын утга учрыг ойлгож, дэлхийн бүхнээс салангид зөвөөр ойлгоход нь хүүхдүүдэд тусал.



2. Хүүхдүүдэд бээлий харуул. Өөрийн махан биеийг гар гэж үзээд бээлийтэй харьцуул. Гар (сүнс) бээлийг (бие) хэрхэн хөдөлгөж чадаж байгааг харуул. Бээлийгээ тайлж, энэ нь биеийн үхэл гэдгийг тайлбарла. Сүнс ба бие тусгаарлагдахад бие хөдөлж чадахгүй. Бээлийгээ эргүүлэн өмс. Энэ нь амилалттай адил гэдгийг тайлбарла. Одоо сүнс ба бие дахин нэгдлээ. Есүс Христ амилсан учраас бүх хүмүүс хэзээ нэгэн өдөр амилах болно гэдгийг хэл.
3. Хичээл 6-ийн төгсгөлд буй “Есүс бидний хайртай найз” бичгийг олшруулан хүүхдүүдэд өгөн будуул.
4. Вандуйт уут болон зөөлөн эдийг хүүхэд рүү өгч дараах асуултуудаас (эсвэл ижил төстэй) асууж хариултыг нь хэлээд уут юм уу зөөлөн эдээ эргүүлэн шидүүл. Хүүхэд бүрээс асууж дуустал үргэлжлүүл.
  - Яагаад бид Улаан өндөгний баярыг тэмдэглэдэг вэ?
  - Амилсан анхны хүн хэн бэ?
  - Амилах гэдэг юу гэсэн үг вэ?
  - Есүс нас барсны дараа түүний биеийг хаана байрлуулсан бэ?
  - Есүсийг амилсны дараа олон хүн түүнийг харсан уу?
  - Яагаад Есүс өөрийн биед хүмүүс хүрэхийг зөвшөөрсөн бэ?
  - Есүс амилсан учир өөр хэн амилах вэ?

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Та өөрөө үгийг хэлж байх зуур хүүхдүүдээр дараахь үйлдлийг хийлгэ:  
Есүс дахин амилсан!  
Энэ Есүс хэвтэж байсан газар (*заа*);  
Харж байна уу, чулууг хөдөлгөсөн байна!  
Доош тонгойн, сайн хар (*тонгойж, гараараа саравчлан хар*).  
Тэр энд байхгүй байна (*бос*)!  
Есүс Амилсан! Зоригтой бай. Би байна. Бүү ай (*алгаа таш*)!  
(Dana Eynon, in *Bible Story Finger Plays and Action Rhymes* [Cincinnati: Standard Publishing Co., 1964], p. 29.)
2. Есүс хавар цагт нас барж, тэгээд амилсан гэдгийг хэл. Хаврын цагт шинэ амьдрал эхэлдэг. Мод, цэцэгс ахин нахиалж, олон амьтад шинээр мэндэлдэг. Хүүхдүүдээр цэцэгс, амьтдын үр төл зуруул. Зураг 1-3, Есүс бол Христ зургийг үзүүлж, Есүс амилсан учраас бүх хүмүүс дахин амилах болно гэдгийг тайлбарла.

# Есүс Христийн төрөлт (Христийн мэндэлсний баяр)

Хичээл  
**46**

---

## Зорилго

Хүүхэд бүрийг Есүс Христийн төрөлтөд талархалтай байхад нь туслах.

---

## Бэлтгэл

1. Залбиралтайгаар Матай 2:1–12 ба Лук 1:26–35; 2:1–20-ийг уншиж, суралц.
  2. Ангийн хүүхдүүдийн зарим нэгнийх нь талаар хаана төрсөн, ямар өнгийн үстэй байсан, төрсний дараа эхний долоо хоногт хаана амьдарч байсан тухай мэдээллийг олж ав. Өргөмөл хүүхдүүдийн мэдрэмжинд болгоомжтой бай.
  3. Цаасаар “Зул сарын гинж” хийхэд зориулсан нарийн цааснуудыг хайчил (ойролцоогоор 20 см урт 4 см өргөн). Богино гинжин зурвас хүүхэд бүр хийхэд хүрэлцээтэй цаасан зурвас хайчил.
  4. “Зул сарын гинж” (хичээлийг хар) хийхийг хүүхэд бүрийн эх эцэгт мэдэгдэж, тэднээс хүүхдүүдээ сайн үйлс хийхэд нь дэмжин туслахыг хүс.
  5. Шаардлагатай зүйлс:
    - а. Библи.
    - б. Жижиг “Есүс мэндэлсэн нь” дүрснүүд. Жижиг хайрцганд байрлуулсан өлгийтэй жижиг хүүхэлдэй ашиглаж болно. Цаасаар одод хайчлан “Есүс мэндэлсэн нь” дүрснүүдийн дээр байрлуулж болно. Хэрэв “Есүс мэндэлсэн нь” дүрснүүд байхгүй бол зураг 1-75, Есүс мэндэлсэн нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 200; 62116) ашиглаж болно.
    - в. Өнгийн харандаанууд, цавуу.
    - г. Зураг 1-75, Есүс мэндэлсэн нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 200; 62116); зураг 1-76, Буудалд сул өрөө алга (62115); зураг 1-77, Хоньчдод Есүсийн мэндэлснийг тунхагласан нь (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 202; 62117); зураг 1-78, Мэргэд, Зурхайчид (Ариун сургаалын уран зургийн цуглуулга 203; 62120).
  6. Баяжуулах үйл ажиллагаанд ашиглах бусад зүйлсээ бэлтгэ.
- 

## Суралцах үйл ажиллагаа

Анхаарал татах үйл ажиллагаа

Хүүхдийг урьж нээлтийн залбирал хийлгэ.

Хүүхдүүдийг нэг нэгээр өөрийн дэргэд урьж түүний төрөлтийн талаар өөрийн мэдсэн зүйлээ хэл. Хүүхэд бүртэй үүнийг хий.

### Бид Есүс Христийн төрсөн өдрийг Зул сард тэмдэглэдэг

Зул сарын үе ирэхэд бид бүхэн бидний хамгийн хайртай нэгэн хүний төрсөн өдрийг тэмдэглэдэг.

- Хэний төрсөн өдрийг бид тэмдэглэдэг вэ?

Түүх	<p>Лук 1:26–35-д гардаг Мариа дээр тэнгэрийн элч ирдэг түүхийг ярьж өг. Тэнгэр элч Мариад тэр Бурханы Хүү, Есүсийн ээж болох болсныг хэлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Есүсийн ээжийн нэр хэн бэ? (Лук 1:27-г үз.)</li> <li>• Есүсийн аав нь хэн бэ? (Тэнгэрлэг эцэг. Лук 1:35-ыг үз.)</li> </ul> <p>Иосеф Есүсийн аав нь байгаагүй гэдгийг тайлбарла. Тэр Есүсийг халамжлан өсгөхөөр сонгогдсон сайн хүн байсан. Тэнгэрийн элч Иосефын зүүдэнд үзэгдэн, Мариагийн төрүүлэх чухал хүүгийн талаар хэлсэн. Тэнгэрийн элч Иосефт Мариа түүний эхнэр байх болно гэдгийг хэлсэн.</p>
Түүх	<p>Зураг 1-76, Дэн буудалд сул өрөө алга, зургийг үзүүлж, Иосеф Мариа нарын Назараас Бетлехем орох аяллын талаар Лук 2:1–7-д бичсэн түүхийг хэлж өг. Лук 2:7-г чангаар уншаад хүүхдүүдийн мэдэхгүй үгсийг тайлбарлаж өг.</p>
Үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдийг “Есүс мэндэлсэн нь” дүрсний өмнө шалан дээр өвдөглөн суулга. Шалан дээр та дэвсгэр тавьж болно. Зураг 1-75, Есүс мэндэлсэн нь, зургийг тойруулан үзүүлж, хүүхэд бүрийг зурган дээр харагдаж буй нэг зүйлийг хэлэхийг хүс.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Яагаад Иосеф Мариа нар буудалд хоноогүй вэ? (Лук 2:7-г үз.)</li> <li>• Есүс хаана төрсөн бэ? (малын тэвш)</li> <li>• Мариад бяцхан Есүст зориулсан ямар ор байсан бэ? (Лук 2:7-г үз.)</li> </ul>
Дуу	<p>“Малын тэвшинд” (<i>Children’s Songbook</i>, р. 42) дууг дуулах буюу үгийг хэл. Үгийн дагуу гар хөлөө хөдөлгө.</p> <p>Малын тэвшнээс өөр унтах газаргүй, Бяцхан Эзэн Есүс нүдээ аньж хэвтэнэ, Тэнгэр дэх одод түүний дээрээс гийгүүлж Бяцхан Эзэн Есүс өвсөн дээр нойрсоно.</p>
Түүх	<p>Зураг 1-77, Хоньчдод Христийн мэндэлснийг тунхагласан нь, зургийг үзүүлж Лук 2:8–20-д гардаг хоньчид ирдэг түүхийг ярьж өг.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Яагаад хоньчид айсан бэ? (Лук 2:9-ийг үз.)</li> <li>• Тэнгэр элч хоньчдод юу гэж хэлсэн бэ? (Лук 2:10–12-ыг үз.)</li> <li>• Хоньчид бяцхан Есүс дээр ирсний дараа яасан бэ? (Лук 2:17, 20-ийг үз.)</li> </ul>
Түүх	<p>Зураг 1-78, Мэргэд, Зурхайчид, зургийг үзүүлж, Матай 2:1–12-д гардаг мэргэд ирсэн тухай түүхийг ярьж өг.</p>
Үйл ажиллагаа	<p>Хүүхдүүдийг босч тэмээ унан, бяцхан Есүсийн байгаа газрыг заах одыг даган явах мэт өрөөгөөр явахыг хүс.</p> <p>Өрөөгөөр хэдэн удаа тойрон явсны дараа хүүхдүүдийг тэмээнээсээ буун “Есүс мэндэлсэн нь” дүрснүүд дээр ирэхийг урь. Мэргэд бяцхан Есүсийг олохоор явах зуур Иосеф гэр бүлийнхэндээ арай дээр газрыг олж, хүүгээ малын тэвшнээс гаргасан байсан гэдгийг тайлбарла. Мэргэд алт, гүгэл, мирийг авчирч өгсөн гэдгийг хүүхдүүдэд хэл. Хүүхэд бүрийг бяцхан Есүст алт, гүгэл, мирийг бэлэг болгон барьж байгаа мэт дүрслэхийг хүс.</p>

## Бидний Есүст барих бэлэг бол Түүнтэй адил байх

Зул сарын баяр бүрээр Есүсийн төрсөн өдрийг тэмдэглэх үедээ бид Түүнд бэлэг барьж болно. Бид мэргэд шиг алт, гүгэр, мирийг өгч чадахгүй. Харин бид өөр бэлгийг өгч чадна. Бид Түүнтэй адилхан болохыг хичээснээр Түүнд бэлэг барьж чадна. Бид гэр бүл найз нөхөдтэйгээ эелдэг байснаар Есүстэй адил байж чадна.

Үйл ажиллагаа

Хүүхэд бүрээр нэлээд хэдэн үетэй “Зул сарын гинж” хийлгэ. Хүүхдүүдээр холбоос бүрийг будуулан, цавуудан нийлүүл (хичээлийн төгсгөлд хавсаргасан үзүүлэн зургийг хар). Хүүхдүүдэд өөрсдийн “гинжийг” Есүст барих бэлэг болгон бусдад сайн үйлс хийх талаар сануулж байхаар гэртээ харагдах ил газарт тавихыг хүс. Зул сарын баяр хүртэл хүүхдүүдийг өдөрт нэг сайн үйлс хийхийг уриал.

Хүүхдүүдэд хийж болох сайн үйлсийн талаар бодож олоход тусал. Тэдэнд сайн үйлс хийснээр Есүст бэлэг барьж байгаа гэдгийг сануул. Хүүхэд бүрийн эх эцэгт “гинж”-ний талаар тайлбарласан бичиг хүүхдээр дамжуулан өг.

Гэрчлэл

Есүс мэндэлсэн нь дэлхий дээр болсон хамгийн чухал явдлуудын нэг байсан гэдгийг тайлбарла. Есүст хайртайгаа зөвхөн Зул сарын баярын үеэр бус бүтэн жилийн туршид түүнтэй адил болох хүсэлтэй байдаг гэрчлэлээ хуваалц.

---

### Баяжуулах үйл ажиллагаа


Хичээлд хэрэглэх зарим үйл ажиллагааг дараах үйл ажиллагаануудаас сонго.

1. Хүүхдүүдээр Мариа, Иосеф, буудлын эзэн, хоньчид, мэргэд болгон тоглуулж, Есүс мэндэлсэн түүхийг дахин ярьж өг. Бяцхан хүүхэлдэй, жижиг хөнжил, хэрэв боломжтой бол толгойн алчуур зэргийг ашигла. Хүүхэд бүрийг оролцуул. Хүүхдүүдийг өөр өөр дүрд тоглуулан үйл ажиллагааг хэдэн удаа давтан хийж болно.
2. Хүүхдүүдээр од хайчлуулж энгийн чимэглэл хийлгэ. Хүүхдүүдээр хийсэн чимэглэлүүдийг будуулж утас зүүн, хүүхдүүдийг гэртээ аваачин өлгөхийг хүс.
3. Хүүхдүүдийн анзаарсан Зул сарын дэлгүүрт зардаг чимэглэлүүдийн талаар ярилц. Тэдэнд бэлэг болон баярын үдэшлэг хийх нь сайхан зүйл боловч Зул сарын баяр нь Есүс Христийн мэндэлсэн баяр учраас гол зүйлүүд Түүн дээр Түүний амьдрал дээр төвлөрөх ёстой гэдгийг хүүхдүүдийг ойлгоход тусал.
4. Христийн мэндэлсний баярт зориулсан орон нутгийн “Христэд-төвлөрсөн” баярын уламжлалуудын талаар ярилц. Хүүхдүүдийг Зул сарын баярын үеэр тэдний гэр бүл уламжлал болгон хийдэг “Христэд-төвлөрсөн” баярын үйл ажиллагаануудын тухай ярилц.

---

**Бага насны  
хүүхдүүдэд  
зориулсан нэмэлт  
үйл ажиллагаа**

1. Хүүхдүүдийг талбайд амарч буй хоньчид болохыг урь. Тэнгэрийн элч ирэхэд айж байгаа, дараа нь мэдээг сонсон баярлаж байгаа хоньчдыг хүүхдүүд жүжиглэн үзүүлэхэд тусал. Тэдэнд тэнгэрийн элч дуулж байгааг сонсон, шөнийн үзэсгэлэнт тэнгэр өөд харж оддыг харж байгааг төсөөлөхөд тусал. Хамтдаа өрөөгөөр явж бяцхан хүүхдийг хай. Тэвшинд хэвтэх бяцхан Есүсийн өмнө өвдөглөн сууж, магтан дуул.
2. Таныг дараах үгсийг хэлэх зуур хүүхдүүдээр үйлдлийг хийлгэ:  
Бяцхан хүүхэд малын тэвшинд хэвтэнэ (өлгийтэй хүүхэд тэвэрч буй мэт бол),  
Хайрт ээж нь хажууд нь байна (гараа сунга),  
Одод тэнгэрт гялалзана (тэнгэр өөд заа),  
Бурханы Хүү энд байна (баяртайгаар алгаа таш)!
3. “Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн” (*Children’s Songbook*, р. 61) дууг дуулах буюу үгийг хэл. Хүүхдүүдэд Есүсийн мэндэлсэн баярыг бид Зул сараар хийдэг гэдгийг хэл.
4. Өлгийтэй бяцхан Есүсийг цаасаар хайчлан хий. Хатсан өвс, дэрс, сүрэл өвс авчирч хүүхдүүдээр “малын тэвш” (дөрвөлжин цаас) дээр наалга. Хүүхдүүдээр бяцхан Есүсийг өвсөн дундах орон дээр нь наалга.



# Хүүхдийн хэсэг 1-ийн үйл ажиллагааны болон хөдөлгөөнт дуунуудын индекс

Нойрсож буй Бяцхан Хүү . . . . .	194	Хэрэв чи маш өндөр бол . . . . .	4, 22
Аз жаргалтай гэр бүл . . . . .	96, 103	Есүс Амилсан! . . . . .	190
Залбирлын дуу . . . . .	13	Есүс бүх хүүхдэд хайртай . . . . .	21
Инээд хурдан тархдаг . . . . .	145	Есүс бяцхан хүүхдүүдэд хайртай . . . . .	20
Талархлын дуу . . . . .	14, 83, 116	Есүс хүн бүрийг хайрла гэж хэлсэн . . . . .	128, 141, 152, 188
Адам Ева хоёр . . . . .	55	Иосеф модон дунд өвдөглөн суусан . . . . .	7
Бүх зүйлс үзэсгэлэнтэй сайхан . . . . .	47	Бяцхан Мосе хүү . . . . .	4, 102
Малын тэвшинд . . . . .	17, 192	Өдрүүдийг жаргалтай болго . . . . .	88, 140
Өнөөдөр ням гараг учир . . . . .	60	Миний гэр бүл (1) . . . . .	97
Зөгийн үүр . . . . .	51	Миний гэр бүл (2) . . . . .	97
Модон дээрх шувууд . . . . .	52, 97	Миний мэдрэмжүүд . . . . .	86
Завгүй жижиг хуруунууд . . . . .	120, 132	Миний Тэнгэрлэг Эцэг надад хайртай . . . . .	20
Хүүхдүүд ээ. Өмдөө өмс . . . . .	136	Миний хөл гүйх дуртай . . . . .	118
Алгаа таш . . . . .	71	Миний бяцхан муужгай . . . . .	148
Хуруугаа тоолцгооё . . . . .	69	Ноа . . . . .	45, 148
Дотны бяцхан найз . . . . .	139	Би бяцхан байсан . . . . .	66
Намайг дагаад хий . . . . .	65, 92, 151, 186	Нэгэн жижиг эрвээхэй . . . . .	50
Жижигхэн Аалз . . . . .	52	Нээ, хаа . . . . .	XV, 162
Таван жижиг загас . . . . .	42	Гараа бид нугална . . . . .	170
Хийхэд хөгжилтэй . . . . .	30, 32, 70, 92, 101, 132, 139, 166	Эрдэнэ шиш үсчинэ . . . . .	36
Бурханы Бүтээлт . . . . .	10, 31, 56	Гүн суулгасан үр . . . . .	134
Эмээ . . . . .	104	Инээмсэглэл . . . . .	84
Жаргалтай дуу . . . . .	165	Заримдаа би өндөр, заримдаа намхан . . . . .	XVI
Толгой, мөр, өвдөг, хөл . . . . .	62	Өвчтэй арван хүн . . . . .	175
Тэнгэрлэг Эцэг намайг мэднэ . . . . .	2, 22	Бүтээлт . . . . .	47, 60
Туслах нь намайг аз жаргалтай болгодог . . . . .	86	Алтан загас . . . . .	40
Энд сүм байна . . . . .	179	Бяцхан яст мэлхий . . . . .	41
Энд бид хамтдаа . . . . .	97	Цуглааны байрууд . . . . .	160
Орон гэр . . . . .	130	Анхдагч хүүхдүүд . . . . .	130
Мөнхөд гэдэг ямар хугацаа вэ? . . . . .	110	Борооны дусал . . . . .	34
Би туслагч . . . . .	110	Намуухан зөөлөн дуу . . . . .	26
Би нүдэндээ талархаж байна . . . . .	9, 15, 78	Дэлхий маш том . . . . .	30, 46, 51, 56, 149
Би нүх ухаж байна . . . . .	38	Энэ бол миний ээж . . . . .	115
Надад хамар бий . . . . .	82	Үүнийг бяцхан хүүхдүүд хийдэг . . . . .	102
Надад гайхамшигтай бие махбод бий . . . . .	6, 63, 75	Энэ бяцхан найз . . . . .	29
Би гарандаа дуртай . . . . .	70, 120	Нүдэндээ хүр . . . . .	76, 80, 83
Би Ариун сүм харах дуртай . . . . .	70	Баяртай хоёр хөл . . . . .	161
Би итгэлтэйгээр залбирч байна . . . . .	13	Бяцхан хоёр найз . . . . .	127
Би өндөр сунана . . . . .	70	Бяцхан хоёр дууч шувуу . . . . .	51
Би гараа сэгсэрч байна . . . . .	XVI, XX	Бид Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдарч байсан . . . . .	11, 111
Би гараа нугална . . . . .	170	Бид гараа нугалж байна . . . . .	15
Өнөөдөр би сүмд ирсэндээ баяртай байна . . . . .	59, 169, 177	Бид ямар нэгэн буруу зүйлийг хийхэд . . . . .	122
Би Есүстэй адил болохыг хичээж байна . . . . .	152	Залуу Есүс Ариун сүмд очсон нь . . . . .	17
Хэрвээ сайхан амьдарч байвал . . . . .	88, 128		

# Гарчиг

---

Хүүхдийн дууны номон дахь Нярайн ангийнханд зориулсан дуунууд

---

Хүүхдийн дууны номонд нэмэгдэл болгож, өөрийн орны хүүхдийн дуунуудаас ашиглаж болно. Дуунууд дараах хэмжүүрт тохирч буйд анхаар:

Тэдгээр нь богино, хялбар.

Тэдгээр нь нарийн нотонд багтсан (5-8 өнгөнд).

Үгнүүд нь давтагдаж болох (ижил үгнүүд хэд хэдэн удаа хэрэглэгдсэн) мөн сурахад амар.

Үгнүүд нь хүүхдүүд харж, сонсож, хүрч, үнэрлэж эсвэл мэдэрч чадах байдлыг тусган илэрхийлсэн.

Үгнүүд нь сургаалд зохицсон байх.